



MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM



Ministry of Culture,
Sports and Tourism
Republic of Korea



KOREA
TOURISM
ORGANIZATION
한국관광공사



세종대학교
SEJONG UNIVERSITY



SCHOOL OF TOURISM
MASTERY

ЖУУЛЧНЫ БААЗЫН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

01

МОНГОЛ ГЭРИЙН ТҮҮХ, ХӨГЖИЛ, ЖУУЛЧНЫ БААЗЫН ЭКО ШИЙДЭЛ, НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

1. Гэрийн гарал үүсэл
2. Монгол гэрийг жуулчны баазад ашиглаж буй өнөөгийн нөхцөл байдал
3. Нүүдэлчин амьдралд тохирсон онцлог
4. Байгаль орчинд ээлтэй байдал, нүүдэл хийх, нүүх
5. Жуулчны баазын орчныг байгальд ээлтэйгээр тохижуулах шийдлүүд
 - 5.1 Жуулчны баазын барилгын архитектурын асуудлыг хүрээлэн буй орчны зохистой байдалд нийцүүлэх арга зам
 - 5.2 Жуулчны баазын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

02

ГЭРИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Шал
2. Хана
3. Хаалга
4. Багана
5. Тооно
6. Унь
7. Өрх
8. Дээвэр
9. Туурга
10. Бүслүүр
11. Хаяавч
12. Гэрийн зайг ашиглах боломж нөхцлүүд
13. Жуулчны баазын гэрийн үйлчлэгчийн ажил үүргийн зааварчилгаа
14. Жуулчны баазын гэрийн үйлчлэгчийн өдөр тутам хийж гүйцэтгэх ажил үүрэг

03

ГЭР БАРИХ БОЛОН БУУЛГАХ

1. Гэр барих болон буулгах
2. Гэрт гарч болзошгүй аюул ослоуд болон тэдгээрээс хамгаалах аюулгүй ажиллагаа
3. Галын аюулгүй байдал
4. Хүнсний аюулгүй байдал ба жуулчдын өвчлөл
5. Осол, гэмтэл

6. Жуулчны баазад анхаарах зүйлс
7. Жуулчны баазад зочин угтах үйлчилгээ үзүүлэх

04

МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХООЛ, УНДААНЫ СОЁЛ

1. Монгол үндэсний хоол, ундааны соёл
2. Жуулчны баазын хоолны газрын үйлчилгээ
3. Жуулчдад боолтын хоолоор үйлчлэх үйлчилгээ
4. Жуулчны баазын гэр рестораны заал зохион байгуулалт
5. Жуулчны баазад урлагийн тоглолт амжилттайгаар зохион байгуулж жуулчдад хүргэх арга
6. Жуулчны бааз дээр соёлын арга хэмжээнүүд зохион байгуулах

05

ЖУУЛЧНЫ БААЗАД МОРЬ, ТЭМЭЭН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Жуулчны баазад морь унуулах
2. Жуулчны баазад тэмээ унах, тэмээ аялал зохион байгуулах тэмээ унах үед жуулчдын анхаарах зүйлс аюулгүй ажиллагаа
3. Жуулчны баазын жуулчдад үзүүлж болох нэмэлт үйлчилгээнүүд
4. Орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах, тэдгээрийг сургалтанд хамруулж жуулчдад үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах
5. Жуулчдын тусгай захиалгыг хүлээн авах, түүнийг хэрэгжүүлэх
6. Жуулчдын аюулгүй байдлыг хангах, байрлаж байх үед нь анхаарал халамж тавих
7. Жуулчны баазад мөрдөх халдвар хамгаалалын дэглэм

01

МОНГОЛ ГЭРИЙН ТҮҮХ, ХӨГЖИЛ, ЖУУЛЧНЫ БААЗЫН ЭКО ШИЙДЭЛ, НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

1. Гэрийн гарал үүсэл
2. Монгол гэрийг жуулчны баазад ашиглаж буй өнөөгийн нөхцөл байдал
3. Нүүдэлчин амьдралд тохирсон онцлог
4. Байгаль орчинд ээлтэй байдал, нүүдэл хийх, нүүх
5. Жуулчны баазын орчныг байгальд ээлтэйгээр тохижуулах шийдлүүд
 - 5.1 Жуулчны баазын барилгын архитектурын асуудлыг хүрээлэн буй орчны зохистой байдалд нийцүүлэх арга зам
 - 5.2 Жуулчны баазын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл



1

ГЭРИЙН ГАРАЛ ҮҮСЭЛ

Нүүдлийн соёлын аж ахуйн гол төрөл нь эрчимт бус мал аж ахуй байхын зэрэгцээ хүн ам, мал сүргийн ихэнх хэсэг нь үе үе нүүдэллэж байдгаараа онцлог. Нүүдлийн соёл нь ертөнцийг үзэх үзэл, соёл, ахуйн өвөрмөц хэв маягийг өөртөө тээж байдаг бүхэл бүтэн өвөрмөц ертөнц юм. Нүүдэлчид мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой хуурай тал, хагас цөл, өндөр уулсын бүсээр аж төрдөг ба газар зүйн хувьд нүүдэлчдийг зургаан гол бүсэд хуваадаг байна.

1. Евразийн тал - таван хошуу мал (адуу, том эвэрт ү хэр, хонь, ямаа тэмээ. Бид таван хошуу мал гэдэгт юу ордгийг нэг бүрчлэн мэддэг бол гадныханд энэ нь харь ойлголт юм) үржүүлэн өсгөдөг монгол, казах, түрэг, киргизүүд орно. Энэ бүс нутагт нүүдэлчид талын хүчирхэг гүрнүүдийг (скиф, хүннү, түрэг, монгол гэх мэт) үүсгэж байсан юм.
2. Ойрхи Дорнодод мухар эвэрт үхэр болон уналга эдэлгээнд адуу, тэмээ, илжгийг өргөнөөр ашигладаг Бахтияр, Бассер болон Пуштун зэрэг нүүдэлчид үүнд багтана.
3. Аравийн элсэн цөл, Сахар тэмээний аж ахуй эрхэлдэг Бэдэн, Туарег зэрэг нүүдэлчид оршин амьдрана.
4. Дорнод Африк, Сахарын өмнөх саванд том эвэрт үхэр өсгөн үржүүлдэг Нуэр, Динк, Масайчууд амьдардаг байна.
5. Өвөр азийн өндөр уулсын бүс болох Төвд, Памир ба өмнөд Америкийн Андын нуруунд сарлаг, лам гөрөөс, альпак өсгөн үржүүлдэг оршин суугчид багтана.
6. Хойд зүгийн буюу Субарктикийн бүсэд цаа бугын аж ахуй эрхэлдэг саам, чукча, эвенкүүд оршин амьдрана.

Нүүдэлчид дэлхийг нэгтгэсэн гүрнийг байгуулж, суурьшмал соёл иргэншлүүдийг захирч, тэдгээрийн хооронд зуучийн үүрэг гүйцэтгэж байсан бол өдгөө бэлчээрийн талхдал, хомсдол, цөлжилт, ядууралд улам бүр автаж, даярчлалын давалгаанд цохигдон, суурьшмал соёл иргэншил, аж үйлдвэрийн эдийн засагт улам бүр түрэгдэн шахагдсаар одоо дэлхийн хүн амын 0.5 хүрэхгүй хувь буюу нийт 35-40 сая нүүдэлчид хойд, өвөр, төв ази болон ойрхи дорнод, африкт нүүдлийн мал аж ахуйгаа үргэжлүүлэн эрхэлж байна. Зөвхөн Нигер, Сомали, Мавритани зэрэг африкийн улс орнуудад л хүн амын зонхилох хувь нь нүүдэлчид эзэлдэг байна. Нүүдлийн ахуй оршин тогтнох зайлшгүй нөхцөл гэдэгт: 1) их бага хэмжээгээр ой модгүй орон зайтай байх, 2) байнгын цасан хучлагагүй буюу эсвэл цасны зузаан нь 40 см-ээс хэтрэхгүй байх, 3) суурьшмал хот суурин, тосгонтой их бага хэмжээгээр хөршлөн амьдрах зэргийг шаарддаг байна.

Ази, Африкийн нүүдлийн соёл иргэншлийн гол шинж тэмдэг болдог гэр, түүний эхний хийц загваруудын үүсэл, хувьсалын тухай Цений (МЭӨ 146-84 он), Планко Карпини (1246 он), Вильгелм Рубрук (1253 он), А.Рона Таш (1959 он), Билл Копервайт (1960 он), Дэн Франк Күхний Монголын үүлэн сууц (Dan Frank Kuehn. Mongolian Cloud Houses: How to Make a Yurt and Live Comfortably), Дэвид Пиэрсон, Д.Майдар (1976 он), Д.Наранхүү, Б.Мягмарбаяр (2007 он) зэрэг нүүдлийн соёл судлаач, уран барилгын загвар зохиогч, аялагч, түүхч зэрэг олон талын мэргэжлийн хүмүүс судалжээ.

Схем №1 Нүүдэлчдийн ангилал



Эртний хүмүүс байгалийн жамаар бий болгосон нүх, агуй, хонхор, гуу жалганд орогнож, цаг агаарын халуун, хүйтэн араатны довтолгооноос бие хамгаалж байжээ. Тэр үед байгаль газар, зөөлөн дулаан уур амьсгалтай, жимс, ногоо элбэг үед орон сууцны хэрэглээ бага байжээ. Хүн төрөлхтөн сууц барьж байгуулахад хэд хэдэн үндсэн шалтгаан нөлөөлсөн.

1. Эрт үеийн хүмүүс ан гөрөө эрхлэн уул тал, ой мод бараадан амьдрах явцдаа орон сууцаа өөрсдөө зохион бүтээх арга замыг нээн олсон бөгөөд ой модтой газарт хэдэн мод зөрүүлж босгож, өвс ногоо, навч шилмүүс, ангийн арьс ширээр хучсан урц овоохойноос санаа авч орон сууцны загвар сэдэн бүтээсэн.
2. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл боловсронгуй болж эхэлсэн.
3. Байгаль, цаг уурын хувьсан өөрчлөгдөх явцад хойд зүгээс сэрүүн уур амьсгал орж мөстлөг бий болсон зэрэг нь орон сууцнууд бий болгох боломжийг олгожээ (Дөрөвдөгч, Кароо, Анд-Сахар, Криогеник, Гурониан 4 үе шатыг туулсан ба Дөрөвдөгчийн үе нь 2,58 сая жилийн өмнө эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл үргэлжилж байна. дөрөвдөгч галавын мөстлөгийн хүрээнд мөстлөг хоорондын үе шатанд байна).

Монгол гэр нь маш эртний хүний орогнож байсан сууцны хэлбэр агуй, оромж болон орон байрны хувьсалтай салшгүй холбоотой. Монголчууд өнөө цагт дэлхийн дээр нүүдлийн соёл иргэншлийг сонгодог утгаар тээн өвлөж яваа цөөхөн нүүдэлчдийн нэг бөгөөд нүүдэлчин Монголчуудын бүтээсэн соёлын гайхалтай үнэт зүйл бол гэр юм. Гэрийн хувьсал өөрчлөлт нь хүний ухамсартай үйл ажиллагаа, олон мянган жилийн хөгжлийн явцад хуримтлуулсан ард түмний мэдлэг туршлагаар шалгаран, хөдөлмөрийн багаж зэвсэг, амьдралын хэв маяг, эрхэлсэн аж ахуй, зан заншил, соёлын онцлог тэдгээрийн харилцан нөлөөлөөр хөгжиж ирсэн түүхтэй бөгөөд энэхүү онцлог бий болоход Төв Азийн эх газрын эрс тэс уур амьсгал, байгаль газар зүйн орчинд зохицон, эрхлэн амьдрах үйлдвэрлэл ажиллагааны хэрэгцээ шаардлагатай зохилдсон Монгол гэрийн бүтэц бүрдэл, хэлбэр төрх, эдлэл хэрэглээ нь хөгжих явцадаа өвөрмөц онцлогийг бүрэлдүүлсэн байдаг. Өвс ургамал нүүдэлчдийн хувьд нийтийнх тул улирлын онцлогт тохируулан усны тунгалаг, өвсний соргогийг даган нүүдэлдэг ажээ. Нүүдэлчдийн сууц болох эсгий гэр хэдий үеэс хэрэглэгдэж эдүгээ үеийн төрхөө олсон талаарх судалгааг археологийн судалгаа талаас харж судалж тодруулах нь бодит үнэнийг олж мэдэхэд тустай. Эртний хүмүүсийн гэр сууцны үүсэл нь модны мөчир, агуй, эрүкэ, урц, тэрэгт сууц, ханат гэр гэсэн орон сууцны хөгжлийн олон үе шатыг дамжсан хэмээн судлаачид үзсээр байна (**Монгол гэрийн өв соёл 2019**).

Монголчуудын эртний гэр, сууцны хөгжил, өөрчлөлтийг нотлох хадны сүг зураг, археологийн олдвор, түүхэн эх сурвалжийн мэдээ, гадаадын жуулчид, аялагчдын тэмдэглэл зэрэгт үлдсэн байна.

Түрүү хүрлийн үе буюу одоогоос 4000 гаруй жилийн тэртээд холбогдох Монгол Алтайн бүс нутагт тархсан Хэмцэгийн соёлын булш, Өмнөд Сибирийн Окуневийн соёлын булшны доторх хашлага чулуунд улаан зосоор ханан хээ дүрсэлсэн тохиолдлууд илэрсэн бөгөөд зарим судлаачид үүнийг тухайн цагт гэр хэрэглэж байсны нотолгоо хэмээн үзжээ (**Ч.Мөнхбаяр 2010**). ОХУ-ын Хакасын Бүгд Найрамдах улсын нутаг Тас Хазаа 2-р булшны 1-р оршуулгын хана чулуунд улаан зосоор ханан хээ дүрсэлсэн байсан 2 бөгөөд мөн Ховд аймгийн Ховд сумын нутаг Хуурай Салааны амны 1-р булшны баруун, хойд болон зүүн хойд талын дотор хашлага чулуунд гэрийн хана хэлбэртэй хээг улаан зосоор зурсан нь хадгалагдан үлдсэн байх бөгөөд үүний хойд талын нэг хашлага чулуунд гэхэд 3-4 см өргөнтэй, 14-25 см хэмжээтэй 24 дөрвөлжин нүд зурсанаас (Ч.Мөнхбаяр 2010) үзэхэд хэдийн хөгжлийн дараагийн үед орсоныг илтгэнэ. Дунд болон хожуу Хүрлийн үеийн дурсгалд гэртэй холбогдуулж үзэх баримт хэрэглэгдэхүүн одоогоор үгүй ч хиригсүүр (НТӨ 1500-700 он)-ийн овоолго дараасууд нэгэн шижмээр уг соёлыг үлдээгчдийн амьд ахуйдаа амьдарч байсныг илтгэнэ (**Монгол гэрийн өв соёл 2019**).

Гэр маягийн сууц НТӨ I мянган жилийн эхэн үед нүүдэлчдийн голлох оромж сууц болж эхэлсэн ба НТӨ 629 онд холбогдох нэгэн эх сурвалжид Умард Ди, жун нар гэр маягийн сууцанд амьдардаг талаар дурдсанаас (Г. Сүхбаатар 1980) үзэхэд хэдийнээ өнөөгийн хэлбэр дүрсээ олсон байжээ. Харин Хүннүгийн үеийн (НТӨ 209 - НТ 93 он) оршуулгын авсны ханыг ихэвчлэн төмөр, алт зэргээр хийсэн ханан хээгээр чимэглэж, дөрвөлжин нүдний голд цэцгэн чимэг байрлуулсан байдаг (Г.Эрэгзэн 2011). Дээрх уламжлал мөн Түрүү дундад зууны үед Түрэгийн хаант улс (НТ 552-745 он)-ын язгууртны тахилгын онгоны хана чулуунд илэрдэг бөгөөд дөрвөлжин хашлага чулууг ханан болон цэцгэн хээгээр чимэглэсэн байдаг. Түүнчлэн Уйгурын (НТ 745-840) бунхант булшны хэлбэр яах аргагүй нүүдэлчдийн гэрийн хэлбэрийг хадгалсан бөмбөгөр орой, дугуй хүрээтэй бүтээгдсэн байдаг нь мөн л тэдний амьд ахуйдаа сууж байсан гэрийн хэлбэр төрхийн тусгал гэлтэй. Сүүлийн үед нүүдэлчдийн бууц сууринг илрүүлж, нарийвчлан судлах болсон төдийгүй зарим тохиолдолд сууцны хэлбэр төрхийг тодорхойлох боломж бүрдэж байна.


Хүннүгийн үед холбогдох хагас нүхэн суушнууд Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур сумдын зааг нутагт орших Бороогийн суурин, ОХУ-ын Буриадын нутаг Ивлэг, Дөрөө зэрэг газраас илэрч олдсон байдаг. Эдгээр сууринд тогтмол хүн амьдардаг байсан бөгөөд харьцангуй суурьшмал хүмүүсийн сууц байжээ (**Ц.Төрбат 2016**). Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Их Баян уулын Бичигтийн амны хаданд эртний хүмүүс олон зуун хүн, амьтан, тамга тэмдгийн зураг цоолборлон сийлж үлдээжээ. Бичигтийн амны орчим хүн нутаглахад одооныхоос илүү тохиромжтой, байгаль газарзүй, цаг уурын нөхцөл бүрэлдсэн нутаг байсан нь тодорхой. Наад зах нь хүрэл зэвсгийн үеэс буюу ойролцоогоор НТӨ 3000 жилийн тэртээгээс гэрийг хөгжүүлж ирсэн бодит дүрслэлийг Хүннүгийн үеийн олдворт сийлж үлдээснээр тодорхой харж болно. Тухайлбал, ОХУ-ын, Буриадын Бүгд Найрамдах Улсын Царамын Хөндийн 7-р булшнаас илэрсэн үйсэн саван дээрх гэр болон бусад зүйлсийг тэмдэглэсэн нь тэднийг эсгий гэрт амьдардаг байсан болохыг тодорхой өгүүлжээ.

Өөр нэг сонирхолтой дүрслэл бол 1986 онд БНХАУ-ын Ганьсу мужийн Юймэнь хот дахь Хан, Вэй улсын үеийн хотын ойролцоогоос түүвэр байдлаар олдсон авсны модон дээрх дүрслэл юм. Уг зурагт гэр бүхий хоёр тэрэг дүрсэлсэн ба зүүн гар талд байх тэргийг нэг үхэрт хөллөсөн бол баруун гар талд байх тэргийг үхэрт хөллөөгүй харин гэрт нэг хүн зогсож байгааг нээлттэй хаалгаар харагдах байдлаар дүрсэлжээ. Мөн тэдгээрийн дунд хэсэгт үхэр тэргийг хөтөлсөн бололтой хоорондоо хөтлөлцсөн хоёр хүнийг зурсан байна. Уг авсны модонд радиокарбоны аргаар он цаг тогтоох шинжилгээ хийхэд 4-5 дугаар зууны үед холбогдох нь тогтоогджээ.


Уг тэргэн дээр байрласан гэр нь бөмбөгөр орой, өндөр дөрвөлжин цамхраа бүхий тооно, өндөр хана туурга, хаалга зэргийг тодорхой дүрсэлсэн нь өнөө цагийн нүүдэлчдийн эсгий гэрээс төдий л их ялгарах зүйлгүй харагдана. Түүнчлэн Юймэнь хот нь Монгол улсын хилээс холгүй зайд Өвөр Монгол болон Шинжааны дунд хэсэгт оршино. Тиймээс энэ нь эртний нүүдэлчдийн нутаглаж байсан бүс нутагт зүй ёсоор тооцогдоно. Монгол газар нутаг дээр оршин суугчдын дунд мал аж ахуй хөгжиж, түүний дагуу нүүдлийн амьдрал зонхилж байсан учраас хялбар энгийн хийцтэй, зөөж барихад тохиромжтой цаг агаарын хатуу нөхцөлд зохицсон сууц шаардагдсан тодорхой. Энэ бүх шаарлагад тохирсон сууц амархан бүтээгүй нь мэдээж. Эхлээд овоохой, дугуй хэлбэртэй нүхэн гэрт суудаг байв. Хүмүүсийн оюун ухаан, хөдөлмөрийн багаж зэвсэг сайжирч, улмаар нүхэн гэрээ газар дээр барьдаг болж өнөөгийн гэртэй төстэй хийдэг болжээ. Түүгээр ч үл барам зарим үед Монголчууд гэрээ тэргэн дээр барьдаг болжээ.




Зураг №1 Агуйн хонгилд амьдарч байсан үе



Зураг №2 Хүний гараар бүтсэн анхны орон сууцууд



Зураг №3 Монгол гэр хэлбэрээ олсон үеийн зураг



Зураг №4 Товгор ханатай гэрүүд үүссэн үе

Улмаар мал аж ахуйтны хэрэгцээг хангаж чадахуйц амархан задалж угсардаг одоогийн гэр гарч иржээ. Аажимдаа янз бүрийн хэлбэртэй сууц цашар асар, майхан, жодгор буй болжээ. Монголын орон сууц ийм замаар олон мянган жилийн турш хувьсал өөрчлөлтүүдийг туулжээ. Судлаач Ч.Сонгино «Монголын нүүдэлчдийн орон сууцны түүхэн хөгжил» хэмээх нэгэн сэдэвт зохиолдоо Монголын нүүдэлчдийн амьдарч ирсэн орон сууцны хөгжлийг:

- Байгалийн жамаар бий болсон оромжинд хоргодож байсан үе
- Хүний ур ухаанаар бүтсэн сууцны анхны хэлбэрүүд
- Сууц боловсронгуй гэр төрхтэй болсон үе буюу хүзүүт гэр
- Орчин үеийн гэр сууц гэж 4 ангилан үзсэн байна.

Хүмүүсийн орон сууц нь овог үндэстнүүдийн оршин тогтносон цагаас хойшхи түүхэн хөгжлийг тусган харуулахаас гадна тэдгээр үндэстнүүдийн эдийн засаг, соёлын өвөрмөц онцлог шинж чанарыг мөн нэгэн адил тодорхойлдог.

Төв Азийн нүүдэлчдийн соёлтой, мал малладаг алтайн хэлтэн Монгол, түрэг, хамниган үндэстнүүдийн сууцыг эсгий туургатны гэр гэх ба төрлөөр нь Түрэг гэр, Монгол гэр хэмээн ангилна. Онцлог ялгааны хувьд араг яс модны хийц нь өөр боловч бүрдэл нь ижил, эсгий хийх арга нь ондоо боловч бүрээс нь ижил, оосор бүч татах хэв заншил нь өвөрмөц боловч дээс шидэмсээр томж хийсэн хийц нь адилханыг үзвээс нүүдэлчдийн урт хугацаанд бий болгосон том соёл бололтой. XIX зууны эцэс гэхэд дэлхий дээр 100 гаруй ястан үндэстэн ханат гэрийг хэрэглэж байжээ. Мөн ханат гэрийн үүсэл гарлыг овоохой-шовоохой буюу урснаас эх сурвалжтай гэдэгт санал нэгтэй байдаг. Харин хана, тооно, унь, хаалганы гарал үүслийн талаар тодорхой зүйл дурдаагүй байна. Монгол угсаатан үндэстнүүдийн хэрэглэж байгаа гэр нь хоорондоо загвар, хийц, материалаараа бүс нутгийн онцлогтой уялдан ялгаатай байдаг ч зарчим нь нэг юм.

Хүснэгт №1 Гэрийн төрөл

Монгол гэр	Түрэг гэр
<ul style="list-style-type: none"> • Барга гэр • Буриад гэр • Баяд гэр • Дөрвөд гэр • Дарьганга гэр • Ордос гэр • Өөлд гэр • Урианхай гэр • Үзэмчин гэр • Торгууд гэр • Халх гэр • Хамниган гэр • Хорчин гэр • Хотон гэр • Хошууд гэр • Дархад гэр 	<ul style="list-style-type: none"> • Казах гэр • Киргиз гэр • Туркмен гэр • Башкир гэр • Узбек гэр • Каракалпак

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО-оос 2013 онд “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэжээ.

Орчин үед Монгол гэрийг зориулалтаар: Ердийн сууцны гэр, Тусгай зориулалтын хэрэгцээний гэр гэж ангилах ба ердийн сууцны гэрийг ханын тоогоор нь 3, 4, 5, их 5 ханат, 6, 8, 10, 12 ханатай гэж ангилдаг. Тусгай зориулалтын хэрэгцээний гэр нь дараах төрөлтэй байна. Үүнд:

Хүснэгт №2 Гэрийн зориулалт

№	Гэрийн төрөл	Зориулалт
1	Отрын гэр	Дөрвөн цагийн эргэлтэнд мал аж ахуй эрхлэн нүүдэллэж явахад тохиромжтой ачиж тээвэрлэх, буулгах зөөж барихад хялбар (овор багатай бага дөрвөн ханат) гэрийг отор нүүдэлд голдуу хэрэглэнэ.
2	Ёслол хүндэтгэлийн гэр	Гэрийн хийцлэл, эд хэрэгсэл нь үндэсний уламжлалт өв соёл, ёс заншил түүхэнд тулгуурласан байх бөгөөд бэлэгдэлт хээ угалз, дүрс дүрслэлээр чимэглэн урласан байна. Томоохон хүлээн авалт зохион байгуулах, шагнал гардуулах зэрэг ёслол хүндэтгэл үзүүлэхэд зориулагдана.
3	Аялал жуулчлалын гэр	Монгол гэрийн уламжлалт хэв маягийг хадгалсан орчин үеийн хийцлэлтэй жуулчид, аялагчдын анхаарал сонирхолыг татахуйц гэрийг хэлнэ.
4	Аяны жижиг эвхмэл гэр	Эвхэгдэж дэлгэгддэг барьж буулгах ажлыг хялбар дөхөм болгосон, тээвэрлэхэд овор хэмжээ багатай богино хугацаанд гүйцэтгэх боломжтой, аян, рашаан ус, аялал зугаалга, амралтанд зориулагдсан гэрийг хэлнэ.
5	Амралт, сувиллын гэр	Төв суурин, амралт сувилалын газарт зориулан суурьшин амьдрах, тохилог тав тухтай байх, сувилуулах зориулалтаар монгол гэрийн хэв шинжийг хадгалсан монгол үндэсний архитектурын сонгодог хэлбэрийг, барилга байгууламжийн архитектуртай хослуулсан хийцлэл, бүтээцтэй гэрийг хэлнэ.
6	Экспортын тусгай хэрэгцээний захиалгат гэр	Гадаад улс орнуудын захиалгаар уламжлалт ердийн гэр сууцыг нийлүүлэх эсвэл тусгай хэрэгцээгээр захиалагчийн хүсэл сонирхол зориулалтаар урлаач, захиалагч нарын хоорондын саналын дагуу гүйцэтгэгдэнэ.

Эко системийн хямралт үзэгдэл, нэг үндэстэн, нэг тивийн хүрээнээс хальж дэлхий дахины хамтын хүчин чармайлтаар тогтвортой амьжиргаанд хүрч болох нь бодит хүчин зүйл болсон бөгөөд энэхүү үзэл баримтлалтай холбогдуулан аялал жуулчлал, зочлох үйлчилгээний хүрээнд амрагч, аялагчдын байр сууцны ууган төрөл болох эсгий /ханан/ гэрийг экологийн аялал жуулчлалын сонгодог сууц болгон ашиглаж байна. Монголын төдийгүй дэлхийн олон улсад Монгол гэрийг аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хэрэглэж байна. Тухайлбал АНУ, Австрали, Швейцарь, Швед, Дани, БНЧех улсад ашиглаж байна. Монголын аялал жуулчлалын салбарт Монгол гэр (халх), казак гэрийг ихэвчлэн ашиглаж байна.



Зураг №05 БН Чех улсад аялал жуулчлалын чиглэлээр ашиглаж буй гэрийн байдал.

Австралийн Брисбани хот дахь Монгол гэр үйлдвэрлэлийн төсөл. Гэрийн бүх зүйлийг Монгол аргаар хийдэг, дээс, хошлон, бүслүүрийг дээс томж хийдэг байна.



Зураг №06 Австрали улсад Монгол гэрийг жуулчны бааз хэлбэрээр ашиглаж буй нь

Монголчууд Европын орнуудад сүүлийн 7-10 жил эсгий гэр дамжуулан борлуулалт сайн хийгдсэн. 2017 онтой харьцуулахад хилийн чанадыг чиглэсэн монгол гэрийн тоо 2018 онд 70 хувиар дээшилж, 2500-д хүрснийг статистикийн мэдээлэлд дурджээ. Монгол Улс жилд 2000 гаруй иж бүрэн монгол гэр экспортолж, 6000 орчим гэрийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна. Монгол гэр үйлдвэрлэлийн чиглэлээр “Хангай гэр” ХХК, “Дээдсийн гэр” ХХК, “Халх гэр хужирт” ХХК, “Монгол гэр хужирт” ХХК, “Зүүн сайн” ХХК, “Тэнгэрлэг өргөө” ХХК, “Өвөг дээдсийн гэр” ХХК, “Хорол өргөө” ХХК, “Их өргөө” ХХК, “Монгол гэр” ХХК, “Өнө монгол гэр” ХХК, “Батдэлгэрэх” ХХК, “Мөнгөн гэр” ХХК “Уянгын гурван эрдэнэ” ХХК, “Удунвара эрдэнэ” ХХК, “Уянга хийц” ХХК, “Сэлэнэ” ХХК зэрэг 150 гаруй аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр компани, хувь хүн аяны, отрын, малчдын, уул уурхай, зам барилгын ажилчдын, жуулчны баазын, хот суурин газрын, ресторан хүлээн авалт, хүндэтгэлийн, экспортын, тоглоом-бэлэг дурсгалын гэсэн 10 төрлөөр, 1,9-40 м хүртэл диаметртай, 3 ханатаас 32 ханатай олон төрлийн зориулалтын гэр үйлдвэрлэж байгаа юм. Бидний үндэсний уламжлалт сууц болох МОНГОЛ ГЭРИЙГ монгол хүн хамгийн олноор суурьшсан АНУ, Япон, БНСУ, Австри, Их Британи, ӨМӨЗО болон мөн Европын зарим орны иргэд монгол гэр худалдан авах нь түгээмэл байдаг ба зөвхөн Монголд ирж гэрт хоноглох шаардлагагүйгээр дэлхийн өнцөг булан бүрт тархсан байгаа учраас бид жуулчны үйлчилгээг үзүүлэхдээ онцгой анхаарах шаардлагатай байна.

Цаашид гэрийн үйлдвэрүүдэд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, өөр материалаар орлуулан хийх, суурин болон нүүдлийн шинж байдалд тохирсон гэрийн шинэ загвар, хэрэглээний шинэ шийдлийг бий болгох, монгол гэрийн өвөрмөц хэв шинжийг олон улсад

сурталчилах замаар жуулчдыг татах боломжтой. Мөн өнгө дизайны шийдэл, талбайн зай ашиглалтыг гайхалтайгаар хийсэн олон суралцах жишээ байна. Монгол гэр амралт нээсэн Австрали залуус байдаг ба өөрийн гараар хийсэн гэгдэх Монгол Юүт амралтын газар хоногийн 170AUD байдаг юм байна.



Зураг №7

Прага хотын захад Монгол гэр



Зураг №8 Швейцарьт байгаа Монгол гэр

Шигтгээ:

2012 онд Копенхагенд болсон уур амьсгалын өөрчлөлтийн хурлын үеэр монгол гэрийн хэлбэртэй эсгий дулаалгатай сууцыг “XXI зууны сор бүтээл” хэмээн тодорхойлжээ. Дэлхийн хүн ам эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүнийг илүүд үзэж, аль болох байгальтайгаа ойр байхыг эрмэлздэг болсноор Монгол гэрийг сонирхдог болж аль хэдийн олон чиглэлээр ашиглаад эхэлсэн байна. Урлаг соёлын арга хэмжээ, загварын шоу, үзэсгэлэн худалдаа, байгаль хамгаалагчийн сууц, загасчлах аяллын отог, ресторан, кафе, жуулчны баазын зориулалтаар ашиглаж байна. Парис хотод дуу бичлэгийн студийг Монгол гэрт хийдэг болжээ. Дуучин дуулахад тархах шууд долгион, хананаас ойсон долгионтой нийлэхэд үүсдэг авианы гажилт шуугиан зэргийг багасгах зорилгоор дуу бичлэгийн студийн дотор ханыг зөөлөвчтэй дуу шингээгч материалаар доторлодог. Дөрвөлжин өрөөнд хана, тааз, шал болон өрөөний булан хүртэл долгион харилцан адилгүй хэмжээний зайг туулах тул зөөлөвчтэй тохиолдолд ч гажилт үүснэ. Гэтэл дугуй хана дээвэртэй, эсгий бүрээстэй гэр аль ч талаараа дуу бичлэгийн студи хийхэд хамгийн оновчтой байр болох нь ойлгомжтой.



Зураг №9 Австралид Монгол технологиор барьсан гэр

Орчин үеийн сууц барих, түүнд аж төрөхөд хүн төрөлхтөн ашиглаж байгаа нөөцийн 30 хүртэл хувийг зарцуулахын зэрэгцээ орон сууцны дэд бүтэц, түүний ашиглалт нь экологийн хямралын 30 орчим хувийг нөхцөлдүүлэгч эх үүсвэр болдог байна. (С. Билэгсайхан 2008)

Жуулчин байрлуулах хэрэгслийн тухай ойлголт, үндсэн төрөл хэлбэрүүд

Шинэ газар орноор аялан яваа гадаад, дотоодын жуулчдын хувьд тэдгээрийг хүлээн авч байрлуулан хоол унд болон бусад бүх төрлийн шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг жуулчны байгууллагуудыг ерөнхийд нь жуулчны хүлээн авах ба дамжин өнгөрүүлэх байгууллага буюу жуулчин байрлуулах хэрэгсэл гэж нэрлэдэг. Жуулчин байрлуулах хэрэгслийн үүслийг эртний Ромын эзэнт гүрэн байгуулагдаж, улс орнуудын харилцаа харьцангуй тогтворжиж ирсэн үеэс эхлэн авч үздэг. Энэ үеэс худалдаачид, мөргөлчид хийгээд янз бүрийн зорилгоор аялж яваа жуулчдад байр, хоолоор үйлчлэх таверн / Tavern/ хэмээн нэрлэгдэж байсан голдуу дан модон байшин бүхий үйлчилгээний газрууд гол замын дагууд байгуулагдах болжээ. Ромын эзэнт гүрэн мөхсөний дараа жуулчны хүлээн авах ба дамжин өнгөрүүлэх байгууллагын хөгжил үндсэндээ 400-500 жил бараг зогсонги байдалтай байгаад хожим худалдаа арилжаа сэргэж эхлэхэд хөгжлийн шинэ шат эхэлсэн гэж болно. Энэ үед Ази болон Ойрхи дорнодын орнуудад худалдааны аян замын дагуу каравансари /Caravansary/, Америкт инн /Inn/ гэж нэрлэгдэж байсан дэн буудлууд байгуулагдах болсон байна. Эдгээр дэн буудлуудын өмнөх тавернаас ялгагдах онцлог нь байр, хоолны үйлчилгээнээс гадна жуулчид, гийчдийн морь, малыг арчилж торддог, ачаа, тээшийг гадны ямарваа халдлагаас хамгаалдаг, тусгай зориулалтын саравч, хашаатай байжээ.

Жуулчин байрлуулах хэрэгслийн хөгжил ийнхүү тухайн бүс нутгийн хөгжлийн байдлаас шалтгаалан газар орнуудад ялгавартайгаар хөгжсөөр XVIII зууны дунд үеэс томоохон хотуудад зочид буудал /Hotel/ байгуулагдах болов. Энэ үеэс өнөөдрийг хүртэл зочид буудлууд нь үйлчилгээний онцлог ба чиглэл, зориулалт зэргээрээ ялгаа бүхий олон төрөлтэй болж хөгжиж эхэлсэн байна. Тухайлбал, 19-р зууны эхэн үеэс амралт, цэнгээний зориулалттай Resort Hotel олноор байгуулагдах болсон бол 1950-аад оноос автомашины хөгжилтэй уялдан авто аялагчдад зориулагдсан Moto Hotel буюу Motel хэлбэрийн буудлууд байгуулагдаж эхэлсэн байна. 1960-аад оноос агаарын тээврийн эрчимтэй хөгжлийг дагаад нисэх онгоцны буудлуудыг түшиглэсэн томоохон зочид буудлууд байгуулагдаж эхэлсэн нь улмаар дэлхийн хэмжээний зочид буудлуудын сүлжээ байгуулагдах эхлэлийг тавьж өгчээ.

Ийнхүү он цагийн уртад олон тооны аянчин жуулчин, хэрэн хэсэгчид өөр өөрийн бэл бэнчинд тааруулж янз бүрийн зэрэглэлийн орон байр, үйлчилгээг шаардах, сонгох, санал болгох үзэгдэл газар авсаар үүнтэй уялдан янз бүрийн зэрэг зиндааны хүмүүст тохирсон олон төрлийн зэрэглэлтэй, тэрхүү зэрэглэлээрээ ялгаатай өөрийн өнгө аяс, зэрэг дэвийг харуулсан олон төрлийн жуулчин байрлуулах хэрэгсэл хөгжсөөр өдийг хүрсэн байна. Эдгээр нь голдуу манай дэлхийд аялаж жуулчилж яваа ихэнх хүмүүсийн

хэрэглэдэг нийтлэг хэл болсон англи хэлээр нэрлэгдсэн байдаг. Тухайлбал: Hotel, Motel, Flotel, Rotel, Boatel, Flotel, Inn, Lodge, Guest house, Camp ground, Resort, Youth hostel гэх мэт. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас /World Tourism Organization/ жуулчин байрлуулах хэрэгслүүдийг дараах байдлаар 4 бүлэгт ангилсан байдаг:

1. Зочид буудал, түүнтэй адилтгах байрлуулах хэрэгсэл
2. Арилжааны болон нийгмийн зориулалттай байрлуулах хэрэгсэл
3. Жуулчин байрлуулах төрөлжсөн хэрэгсэл
4. Жуулчин байрлуулах хувийн өмчийн хэрэгсэл

Дээрхи ангиллаар зочид буудал, түүнтэй адилтгах байрлуулах хэрэгсэлд: зочид буудал, мотель, амралт сувиллын газар, наран шарлагын газар бүхий зочид буудал зэргийг, арилжааны болон нийгмийн зориулалттай байрлуулах хэрэгсэлд: жуулчны бааз, жуулчдын хотхон буюу тосгон зэргийг, жуулчин байрлуулах төрөлжсөн хэрэгсэлд: эмчилгээний зориулалттай зочид буудал, хөдөлмөр амралтын зуслан, тээврийн хэрэгсэлд байрлуулсан зочид буудлууд /rotel, flytel, flotel г.м/, жуулчин байрлуулах хувийн өмчийн хэрэгсэлд: хувийн орон сууц, жуулчны байгууллагын түрээсийн байр, найз нөхдийн байр зэргийг ялгасан байна. Эдгээр бүх төрлийн орон байрнууд нь хэдийгээр нэрийн хувьд маш олон янзаар хэлэгдэх боловч үндсэн үүрэг нь аянчин жуулчдыг ая тухтай байрлуулж, тэдгээрт сайн үйлчилгээ үзүүлэх нэг л үндсэн зорилготой байна. Гагцхүү үнэ өртөг, үйлчилгээний хэлбэр, агуулга зэргээсээ шалтгаалан өөр өөрийн өнгө аястай байдаг.

Жуулчны бааз анх 1936 онд Англи улсад байгуулагдсан ба жуулчны бааз гэдэг нь "Аялал жуулчлалын бүс нутагт жуулчид амрагчдыг түр хугацаагаар байрлуулж тэдэнд эрэлт хэрэгцээний нь дагуу хангамж үйлчилгээ үзүүлж чадах цогцолбор газрыг хэлнэ". Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ ая тухтай байдалд нийцүүлэн жуулчны баазыг хэд хэдэн төрлөөр төрөлжүүлэн хөгжүүлдэг. (Г.Болормаа 2004) Үүнд:

Хүснэгт 3 Жуулчны баазын төрөл

№	Төрөл	Зориулалт
1	Дамжин өнгөрөх бааз	48 цагаас илүүгүй хугацаагаар байрлах зориулалттай.
2	Өдрийн амралтын бааз	Ихэвчлэн 1 хоног амрах ба эсвэл өдрийг өнгөрүүлэхээр зохион байгуулагдсан.
3	Амралтын бааз	Бямба Ням гаригийн амралтын өдрүүдийг өнгөрүүлж болно. Амралтын өдрөөрөө хотоос зайдуу чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүхий байхаас ихэвчлэн хүүхдийн тоглоомын талбайтай байдаг.
4	Оршин суух бааз	Амралтын баазыг бодвол нилээд урт хугацаагаар байрладаг. Түрээсээр хөлсөлж эсвэл бүр худалдан авч байрлаж болно.
5	Амралтын бааз	Гол төлөв далайд сэлэх, ой модоор зугаалах, гулгах зэрэг аялын тал руу давамгайлсан амралтын газар байх ба өвлийн цагт ажиллаж болно.
6	Holiday camp	Хүүхдэд зориулсан тоглоомын өрөөнүүд ба үйлчилгээтэй байдаг.
7	Ойн бааз	Ой мод бүхий бүсэд 2 байрны хооронд 35 метрээс багагүй зайтай байрлах 25 байртай зөвхөн гэр бүлээрээ амрахад зориулагдсан
8	Аялал жуулчлалын бааз.	Жуулчдын олон талт эрэлт хэрэгцээний стандартад нийцсэн хангамж үйлчилгээ бүхий аялал зохион байгуулдаг амралтын бааз юм. Мөн ийм жуулчны баазыг орон нутгийн тур оператор гэж нэрлэдэг
9	Эко гэр	Малчин өрх, нөхөрлөлүүд өөрийн гэрийн дэргэд жуулчинд үйлчлэх зорилгоор уламжлалт Монгол гэрийг зочин хүлээж авахаар тохижуулсан байна.

Түүнчлэн жуулчин байрлуулах хэрэгслүүдийн ялгагдах бас нэг чухал нөхцөл нь тухайн жуулчин байрлуулах хэрэгслийн оршин байгаа газар нутгийн байгаль цаг уурын болоод хүн ардын амьдрал, соёл иргэншил, ахуйгаас шалтгаалах онцлог нөлөөлөл байдаг юм. Үүний тод жишээ бол жуулчны гэр бааз болно. Монголын нүүдэлчин ард түмний олон зуун жилийн турш улам бүр боловсронгуй болгон ашиглаж ирсэн сууц төдийгүй оюуны үнэт өв, угсаатны түүхэн дурсгал болох тухай судлаачид тэмдэглэн үлдээсэн байдаг (Д. Майдар 1971, Ж. Өлзий 1992). Энэ бүх онцлог хийгээд давуу талууд нь дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн, хөдөө орон нутгийн бие даан хөгжих чадвар сул манай орны хувьд жуулчин байрлуулах үндсэн хэлбэр нь хөдөө орон нутгийн хувьд жуулчны гэр баазууд байгуулагдах үндэс болжээ гэж дүгнэх боломжтой.

Монгол оронд аялал жуулчлал өнөөгийн дүр төрхөө олж хөгжих болсон үе нь яах аргагүй манай улсад анхны “Жуулчдад үйлчлэх товчоо” байгуулагдсантай холбоотой. 1954 оны 10-р сарын 2-ны өдрийн Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар манай улсад анхны аялал жуулчлалын байгууллага байгуулагдсан нь энэ салбарын шинэ хөгжлийн эхлэл гэлтэй. Энэ үеэс гадаадын жуулчид гийчдийг төлбөртэйгээр авч үйлчилж эхэлсэн нь шинэ дэвшил, ирээдүйн Монгол орны аялал жуулчлалын маршрут, үзмэрийн чиг хандлагыг гарган ирж чадсан гэж ойлгож болох юм. 1956 онд тэр үеийн ЗСБНХУ-ын 15 гийчнийг хүлээн авч үйлчилсэн нь манай орны анхны албан ёсны жуулчид байсан бөгөөд анхны жуулчны бааз Өмнөговь аймаг, Тэрэлжид байгуулагджээ. Анхны жуулчны баазууд байгуулагдахаас өмнө рашаан сувиллын газрууд ч гэр хүрээ, хуаран хэлбэртэй байв. Тухайлбал, Монголын нэрд гарсан Хужирт, (1930-иад оноос) Шаргалжуут зэрэг рашаанд түшиглэсэн амралт, сувиллын газрууд эхэн үедээ гэрүүдэд амрагчдаа хүлээн авч байсан бол Ерөө, Ононгийн рашаан сувиллын газрууд ч гэсэн үндсэндээ гэр бааз хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж иржээ. (Г. Баатарцоож 1999)

Монгол орны аялал жуулчлал улирлын чанартай нь Монгол гэрийг жуулчин хүрэлцэн ирэх тааламжтай үед ашиглахад хүргэсэн. Өргөн уудам газар нутаг, дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалан аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах өргөн боломжийг Монгол гэр нээж өгсөн. Байгалийн нөхцөлд тохируулан нүүдэллэдэг сууц учраас хаврын салхи, зуны халуун, намрын сэрүүн, өвлийн хүйтнээс сэргийлж байршлаа өөрчлөх боломжтой юм. Мөн Монгол гэр нь Монголчуудын аж байдал, зан заншил уламжлалын арвин баялаг туршлагыг өөртөө хадгалсан жуулчинд онцгой дурсамжийг үлдээх боломжтой учраас үндэсний уламжлалт хэв маягийг жуулчны гэр баазад шингээж үйлчилгээнд зориулан тохируулан ашиглах боломжтой юм.

Тухайлбал:

- Монгол гэрийн аж байдал, ахуйгаа хөтлөн амьдрах орон зай орчин нь болдог.
- Монгол гэр үндэсний баяр ёслол, зан үйл, ёслолыг хэрэгжүүлэх анхдагч гол нөхцөлийг бүрдүүлдэг.
- Мал аж ахуйгаа өсгөн үржүүлэх, эдийн засгийн нөхцөлөө бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бичил орчин бол Монгол гэр юм.

Ийнхүү жуулчны гэр бааз нь хөгжих явцдаа дараах давуу болон сул талыг бий болгожээ.

Жуулчны гэр баазын давуу тал

- Гэр бааз нь Монгол орны хувьд эдийн засгийн үр ашигтай нөхцөл байдалд сайн зохицсон ашиглагдах хэлбэр бөгөөд илүүц зүйлсийг шаардахгүй.
- Монгол орны аль ч бүс нутагт байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицох чадвартай Монголчуудын соёл, ёс заншилд тохирсон, удаан хугацаанд хэрэглэж дадсан

- учир монгол гэрийг арчлах, барьж байгуулахад мэдлэг, туршлага дутагдахгүй.
- Эдийн засгийн хөрөнгө оруулалт бага шаарддаг.
 - Жуулчдад Монгол гэрт амьдарч түр хугацаанд ч болов нүүдлийн амьдралыг биеэр мэдрэх боломжийг шууд олгодог.

Жуулчны баазын сул тал

- Төвлөрсөн газар болон хотын гадна байрладаг учир дэд бүтцийн боломж хязгаарлагдмал байдаг.
- Зарим тохиолдолд жуулчны баазын байршил муу, байгаль газарзүйн олон сөрөг нөлөөллийг үзүүлдэг.
- Зарим жуулчны баазын дүр төрх нь цэргийн баазын хэв маягийг агуулсан.
- Жуулчны баазууд тэдгээрийн дизайн нь нэгэн хэвийн хэв загварт хүлэгдсэн ая тух болон тохилог байдлын түвшингээр олон улсын үйлчилгээний түвшинд хүрэхгүй байдаг.
- Жуулчны баазууд Монгол гэрийг голлон ашигласаар ирсэн боловч гэрийн наад захын ахуйн хэрэгцээнээс эхлээд үндэсний соёлын өвөрмөц онцлог болон гоо зүйн хэрэгцээг хангах боломжийг нь бүрэн ашиглахгүй.
- Ядмагхан дизайн, зохиомж бүхий модон болон шавар сууцыг жуулчны баазад ашиглах нь төв Азийн нүүдэлчдийн өвийг үзэж сонирхохоор ирсэн жуулчдын эрэлт хэрэгцээг хангахгүй байгаагийн зэрэгцээ үндэсний соёлын өвд сөргөөр хандаж байгаагийн илрэл ажиглагддаг.
- Монгол гэр нь олон зууны турш хөгжихдөө тойрог суурьтай нэг эзлэхүүнт загвараас өөр шийдэлд хүрээгүй.
- Одоогоор үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны баазуудыг ерөнхийд нь байрлах болон дамжин өнгөрөх гэж хувааж болох бөгөөд ихэнх нь дамжин өнгөрч 1-2 хоногийг л өнгөрөөж байна.

Жуулчны баазуудыг ангилах

Байрлах жуулчны бааз:

- Жуулчны баазууд нь жуулчдын ая тухыг хангаж чадсан боловч түүхийн үнэт зүйлсийг алдагдуулж хэт орчин үежсэн байдаг.
- Жуулчдын сонирхол нь монгол гэрт хоноглож үзэх төдийгүй монгол гэрийн үүсэл хөгжлийг сонирхдог бөгөөд эдгээрийг илтгэж чадахаар түүхийн дурсгалт сонирхох зүйлүүд нь маш хязгаарлагдмал байдаг.
- Тухайн жуулчны аяллын хөтөлбөрт малчин айлд зочлохыг оруулсан хэдий ч эдгээр нь төлөвлөгдсөн, жуулчдыг ирэхэд цагаан идээгээр дайлах, морь уургалах гэх мэт үзүүлбэрийг зохиомлоор агуулсан байдаг.
- Цагаан идээгээ хэрхэн боловсруулах арга технологийг үзүүлж жуулчдыг оролцуулах, морь бугуйлаар бугуйлдуулж үзүүлэх нь ямар эрсдэлтэй болон ямар их ур чадвар шаардлагатай зэргийг биеэр нь мэдрүүлбэл жуулчдын сонирхлыг ихээр татах юм.

Дамжин өнгөрөх жуулчны бааз нь:

- Жуулчныг сонирхсон цэгтээ хүрэхэд нь зам дагуу байрлаж тэдэнд хоолоор үйлчлэх үүрэг гүйцэтгэж байна.
- Монгол орны зорин очих газрын сэтгэл татах үзмэрийн зай хол байдагтай холбоотой боловч эдгээрт ирсэн жуулчид зөвхөн хоол идэх, түр алжаал тайлах байдлаар явагдаж байна.

Цомцог гэрийг аялал жуулчлалд ашиглаж буй нь

Өвөр монголын эрдэмтэн Мансан чорхан гэрийг тайлбарлахдаа «Эртний монголын тогтсон хугацаанд наймаа арилжаа хийх байшингийн нэр», Элдэндэй Ардажав нар түрэг хэлний «чорган», «цурган» гэх нь бүтээлэг нөмрөг гэнэ. Чурхаль түрэг үг, гэр нь монгол үг гэхийн дээр энэ үгийн утгыг Мансаны адил худалдаа арилжаа хийх тогтмол гэрийг чорхан гэр гэнэ гэж тайлбарласан байна.

Гэр, орон сууцаар дагнан судалгаа хийсэн Д.Майдар, Л.Дарьсүрэн нар «Гэр» хэмээх бүтээлдээ: «Дундад зууны монгол хэлэнд байсан чорхан, ХХ зууны монгол хэлэнд байсан цомцог гэдэг үгс дуудлагаараа ондоо боловч язгуур ба утгаараа ижил юм... XIII зууны мэргэдүүд сууцны нэг төрлийг чорхан гэдэг байсан нь угтаа сууц тэрэг гэсэн хоршоо үг байжээ. Үүнээс үзвэл чорхан бол гэр тэрэг болох нь илэрхий. Ордост байгаа хүзүүвчин тоонотой гэрийг цомцог гэсний учир тэр гэрийг тэрэгнээс салгаж газар барьсан явдалтай холбоотой байж магадгүй» гэх зэргээр чорхан гэрийг цомцогтой холбон тайлбарлажээ.

XVII зууны үеэс Монголын уран барилгад Монгол гэр хэлбэрийн байгууламжууд нэлээд баригдаж эхэлсэн ажээ. Энэ нь шарын шашны хөгжилттэй холбоотойгоор төлөвшсөн уран барилгын Монголын үндэсний хэв загвар бөгөөд энгийн гэрийн талбайн хязгаарлагдмал байдлыг нэмэгдүүлэх зорилготойгоор баригдаж эхэлжээ. Тухайлбал, энгийн 5 ханат гэрийн өндөр нь 2 метр орчим, диаметр нь 4-5 метр байдаг бол гэр хэлбэрийн байгууламжуудын диаметр нь 20-25 метр хүрдэг байна. Энэхүү байгууламж нь энгийн гэрийн адил жирийн унь, эвхмэл хана ашиглах боломжгүй болж, ханыг нь модон араг ясаар хөдөлгөөнгүй босгож, битүүлдэг болжээ. Ингэснээр гэр хэлбэрийн барилга заавал дугуй хэлбэртэй байх албагүй болж, дөрөв ба олон талт хэлбэртэй баригдах болсон жуулчны баазуудад тусгалаа олсон байна.



Зураг №10 Цомцог гэр

Цомцог гэр нь энгийн гэрийг бодвол уужим саруул зайтай, баганыг гадна карказанд шилжүүлж өгсөн тул ашигтай талбай ихтэй. Өрхийг шилэн хийцээр хийсэн тул байгалийн гэрэл асуудалгүй тусдаг, автоматаар онгойлгож хааж болох тул ашиглахад хялбар.

Мөн Цомцог гэр нь энгийн Монгол гэрийг бодвол эдэлгээ удаантай, мөн гэрийн буурь нь хотын хэв маягт тохирсон тоосгон тул илүү эмх цэгцтэй, тоос шороогүй цэвэрхэн байхаар шийдэж өгсөн. Шалны халаалт, өрхийг нээж хаах автомат удирдлагатай, гэрийн бууринд инженерийн цогц шийдлийг хийж өгснөөр ариун цэврийн өрөөний асуудал шийдэгдсэн зэрэг олон зүйлээрээ энгийн Монгол гэрээс ялгаатай.



Зураг №11 Цомцог гэрийн дотор тал

Цомцог гэр байгальд ээлтэй, эко хэв маягыг хадгалан үлдсэн ба Монгол гэрийн байгальд ээлтэй, нүүж суухад хялбар, эко хэв маягыг цомцог гэрт шингээн үлдээсэн. Гэрийн модыг эко үнэргүй будгаар будсан нь оршин суугчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байдаг.

Цомцог гэр энгийн Монгол гэрээс ялгарах хэд хэдэн онцлогууд байна.

- Уужим саруул зай талбайтай
- Ашигтай талбай ихтэй
- Байгалийн гэрэл илүү тусдаг
- Эдэлгээ удаантай, баталгаа өгдөг
- Гэрийн автоматжуулалтын системээс ашигласан
- Илүү цэвэр тохилог буурьтай
- Байгалийн элдэв үзэгдэлд тогтвор сайтай
- Шалны халаалтын системтэй
- Инженерийн цогц шийдэлтэй
- Гэрийн үүдэнд terrace буюу нарлагааны талбайтай
- Эко байгальд ээлтэй
- Том шилэн цонх, хаалгатай

Казак гэрийн аялал жуулчлын зориулалт

Казак гэр нь энгийн гэрийг бодвол уужим саруул зайтай, Казак гэр тооно, хана, унь гэх гурван үндсэн хэсгээс бүрддэг. Матмал уньтай, бага тоонотой гэр бөгөөд гадна талыг эсгийгээр бүрж, дотор талыг хивс хивсэнцрээр бүрж, гоёдог. Гэрийн зай талбай ихтэй, Гэрийн дотоод засал орчлон ертөнц, байгаль дэлхийн уялдаа холбоог илтгэдэг. Хивсэн дээр цэцгэн хээг дүрсэлж, гэрийг тойруулан чимсэн цацаг дээр сансар огторгуйн хийсвэр хээ угалзыг дүрсэлж, гэрийн тавилгуудыг нарийн хийцтэй сийлсэн байдаг нь Казак нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл бөгөөд, амьдралын гоо зүйн баримтлалыг харуулдаг ба ихэнхдээ Казак гэрийг жуулчны үйлчилгээнд ашиглах зорилгоор Баян-Өлгий аймагт хэрэглэж байна.

- Казак гэрийг аялал жуулчлалын зориулалтаар ашиглахад угсаатны зүйн онцлогыг бүрэн харуулдаг.
- Нүүдэлчдийн гэрийн өөр нэгэн хэв шинжийг харах бүрэн боломжтой.
- Уужим саруул зай талбайтай, өндөр хүн толгой тулахгүй.
- Ашигтай талбай ихтэй, дотор зохион байгуулалтыг өвөрмөцөөр зохиомжлох боломжтой.
- Байгалийн элдэв үзэгдэлд тогтвор сайн.
- Эко байгальд ээлтэйгээр шийдлүүдийг хийх боломжтой.
- Гэрийн гадна, дотно талд өвөрмөц онцлог бүхий гар урлалаар чимэглэж үзэмж нэмсэн, зураг авах сонирхолыг нь төрүүлдэг (Жуулчид буцахдаа гар урлалын зүйлс ихээр авах сэдлийг төрүүлдэг).
- Агааржуулалт сайтай, удаан суухад тохиромжтой.
- Баганагүй учраас групп жуулчдыг суулгахад зай талбай ихтэй.

Зураг №12 Казак гэрийн гадна, дотор тал

Казак гэрийн дотор талаас харагдах байдал



Гэрийн унь өндөр, тооно монгол гэрт байдгаас өөр учир жуулчинд өвөрмөц сэтгэгдэлийг төрүүлдэг.

Казак гэрийн гадна талаас харагдах байдал.



Гэрийн хээ чимэглэл, хаяавч зэрэг нь амрагчдад таатай сэтгэгдлийг үлдээнэ.

Өнөөгийн байдлаар жуулчны баазууд нь ихэвчлэн Монгол гэр, казак гэр, цомцог гэрийг аялал жуулчлалын зориулалтаар түгээмэл ашиглаж байна.

Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөрөгийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой.

Монгол орны жилийн дундаж температур 0.2°C (32°F),

- Өвлийн улирлын дундаж температур -10°...-30°C (14°...22°F),
- Зуны улирлынх нь 10°...27°C (50°...80°F) байна.
- Жилийн дундаж агаарын температур Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутгаар -4°C (24.8°F)-аас хүйтэн,
- Уулс хоорондын хотгор, томоохон голын хөндийгөөр -6°C -аас -7.40C (21.2...18.7°F) хүйтэн,
- Цөлөрхөг хээрийн бүсэнд 2°C (35.6°F)-аас дулаан,
- Өмнөд говьд 6°C (42.8°F) -аас дулаан байна.

Агаарын жилийн дундаж температурын 0°C-ын шугам нь

- Монгол орны цөлөрхөг хээрийн, /говийн/ бүсийн хойд хилээр дунджаар хойд өргөргийн 46 градусын дагуу байрлана.
- Агаарын жилийн дундаж температур -2°C (28.4°F)-аас хүйтэн нутагт мөнх цэвдэгт хөрс тархсан байдаг.
- Өвлийн улиралд үнэмлэхүй бага температур -28°C-аас -54°C (-18.4°...-65.2°F) хүрч хүйтэрдэг.
- Зуны улиралд үнэмлэхүй их температур 30°C-аас 45°C (86°...113°F) хүрч халдаг.

Монгол оронд хур тунадасны нийт хэмжээ бага боловч уул нуруудын байршил, тэдгээрийн өндөршил зэрэгтэй уялдан жилд орох тунадасны хэмжээ газар нутаг бүхэнд харилцан адилгүй байна. Тухайлбал:

- Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, томоохон голын хөндий нутгаар жилдээ 250-390 мм тунадас ордог.
- Алтайн уулархаг нутгаар 90-130 мм болон тал хээрийн нутгаар 180-280 мм орчим тунадас ордог.
- Хур тунадасны хэмжээ хойноосоо урагшлах тусам багасаж говийн нутгаар хамгийн бага жилдээ 70-150 мм тунадас орно.

- Алтайн өвөр говь болон өмнөд хил орчмоор 40-60 мм түүнээс ч бага хур тунадас орох тохиолдол байдаг.

Ийм онцлогоос шалтгаалан Монголчууд ойрын зайн нүүдлээс, урт холын отрын аянд явж нүүдэллэх зайлшгүй шаардлага урган гарсан. Улмаар тархай бутархай, цөөн тоогоор тархан сууршсан, дайн байлдаантай Монголчуудын хувьд гэрийг олон нүүх, суухад эвдрэхгүйн дээр чанартай, малын гаралтай экологид ээлтэй орон нутгийн материал ашиглан өөрсдөө хийж ирсэн уламжлалтай. Эдийн засгийн аливаа асуудлыг байгаль орчинтой уялдаатай авч үзэхийг улам их шаардах болсон дэлхийн хөгжлийн хандлага нь байгаль орчны нэгэн бүрдэл болсон эсгий гэрийг нийгмийн ач холбогдолтой гэхээс гадна байгаль орчинд харьцангуй бага халгаатай гэж үзэж өргөн ашиглах болжээ.

Схем №2 Гэрийн давуу тал



Монгол гэр бол түрэг үндэстний гэрээс хэлбэр ба хийцээрээ ялгагдана. Түрэг гэр нь бүнхгэр бөгөөд жижигхэн тоонотой, унь нь урт, сагалдрагатай тал нь тахир, хана нь намхан байдаг бол монгол гэр нь том тоонотой, богинохон шулуун уньтай, хана нь өндөрдүү байдаг.

- Монгол гэр дугуй хэлбэртэй байдаг нь сууцны талбайг бүрэн эзэмшихэд ашигтай, намхан, дугуй хэлбэртэй учраас салхины нөөлөгний хүчийг сарниулан бууруулдаг онцлогтой байдаг нь салхинд тогтвортой.

- Гэрээс гарахгүйгээр ойр орчмыг ажиглах, одод, нар, сар, уулсын оройг ч ажиглах, харах боломжтой.
- Эсгийгээр бүрдэг нь дулаан, тоононы цамхраа нь салхи оруулах, гэрэлтүүлэх¹ ач холбогдолтой.
- Монгол гэрийн доторх гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, агааржуулалтыг сайжруулах.
- Гэрийг хэрэглээнийхээ хэрээр том, багаар бүтээж, хүйтний улиралд дулаалах, сэрүүнд бүрээсийг нимгэлэх зэргээр халуун хүйтний тохируулга хийж өөртөө ашигтайгаар өөрчилж (зуны халуунд дан эсгий бүрээстэй барьдаг нь гэрийн сэрүүнийг дотроо хадгалан, өвлийн хүйтэнд давхар эсгий бүрээсээр бүрж, гэрийн дулааныг хадгалдаг.) болдог.
- Эсгий туурга нь цагт 500 удаа агаар солилцож чаддаг ажээ. Түүнчлэн хаяа тооны зай завсраар агаарын урсгал шилждэг учраас агааржуулагчийн энгийн системтэй, гэрт агаарын солилцол сайн явагдаж гэр дотор хуралдсан нүүрс хүчлийн хий цэвэрлэгдэж хүчилтөрөгч хуралддаг болохоор ариун цэвэр, эрүүл ахуйд ихээхэн чухал нөлөөтэй².
- Гэрийн бүрээс болон дэвсгэр зөөлөн эсгийгээр хийгддэг тул шавар, чулуун сууштай адил цуурай, дуу чимээ гардаггүй учир гэрт оршин суугчид ядаргаа багатай байдаг нь эрүүл мэндэд чухал ач холбогдолтой төдийгүй гэрийн модон бүтэц нь салхи шуурга,³ газар хөдлөлт, үер усны аюулд (бороо хуртайд давхарлага, хөлтөрөг татаж хамгаалах бөгөөд буулгаж хатаахад хялбар, үер усны аюул тулгарахад дугуй хэлбэртэй хана нь газарт сууж өгдөг бөгөөд хаяаг дээш шуувал гэрийг үерт автуулахгүй байх боломжтой) тэсвэртэй гэдгээр олон зууны турш хэрэглэгдсээр ирсэн сонгодог сууц юм.
- Мод, эсгий зэрэг “амьд” эдээс бүрдэг нь Төв Азийн эрс тэрс уур амьсгалд зохицох чадвартай болгожээ. Энэ чадвар нь хонины ноосны микронтой холбоотой. Халуунд хонины ноосны микрон тэлж, агаарыг чөлөөтэй оруулдаг учир сэрүүн шинэ чанартай. Харин хүйтэнд эсрэгээрээ микрон нь агшиж, дулаанаа сайн хадгалдаг. Тэрчлэн эсгий бүрээс нь дуу чимээ нэвтрүүлэхэд сайн, шөнө орой гэрийн гаднах мал сүргийн дуу чимээ, гадны чимээ сонсогддог тул малчдын амьдралд ихэд зохицно.
- Монгол гэрийг барьж босгоход хөрс шороо эвдрэхгүй, өвс ногоо гэмтээхгүй, мөн нүүсний дараа хөрс, ургамал удалгүй сэргэдэг учир байгальд ээлтэй сууц юм.
- Монгол гэр хамгийн зөв байрлалтай сууц бөгөөд Монголчууд гэрийнхээ хаалгыг ямагт өмнө зүгт харуулж барьдаг, унтахдаа хойроо, хаалганыхаа эсрэг зүгт тэргүүнээ хандуулдаг. Монгол орны хувьд хойд зүг бол дэлхийн соронзон орны төв цэг. дэлхийн соронзон орны дагуу байрлах учир зүрх судасны өвчлөлд бага нэрвэгдэнэ.

1 Монголчууд эрт үеэс тооноор туссан нарны байдлаар өдрийн цагийг тодорхойлдог байжээ. Жишээ нь, өглөөний нар хананы толгойд тусах тул үдээс өмнө цаг мөчийг хананы толгойгоор тоолж гаргадаг бөгөөд үдээс хойш гэрийн зүүн хоймор дэвссэн ширмэл ширдгэн дээр туссан байрлалаар үдэш хүртэлх цагийг баримжаагаар гаргадаг. Мөн үүнтэй холбогдуулан дурдахад сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн зарим урчууд хоймрын тал дугуй ширмэл ширдгийг нарны цагийн хуваариар ширж байсан гэдэг.

2 Дэлхий нийтээрээ цар тахлын дараа хүн ам олноор суурьшаагүй, онгон дагшин байгальтай цөөхөн жуулчин очих газрыг сонгож, үйлчилгээ нь гадаа орчинд явагддаг аялын хэлбэрийг сонгох, хүнтэй уулзахаас аль болох зайлсхийж буй өнөөгийн нөхцөлд Монгол гэр жуулчдын сонирхолыг татах байршуулах хэрэгсэл байж болох юм.

3 Олон зуун жилийн туршид 18-26 м/с хурдатай салхийг тэсвэрлэх чадвартайгаар хийсэн бөгөөд ихэндээ гэрийн ар талд аргал, түлш овоолох, тогоогоо хөмөрч салхины урсгалыг ярдаг байжээ.

- Монгол гэр нь багтаамж сайтай, явж суух, хоол унд бэлтгэх, шөнөдөө унтаж амрах, өдөр тутмын хэрэглээний эдлэл хэрэгслээ тавих, зочин гийчин дайлах, найр цуглаан хийх зэрэг хүний ахуй амьдралын хэрэгцээг бүрэн хангасан.
- Дотор талбайг нэмэгдүүлэх зорилгоор гэрийн хоёр ханын залгаас хооронд ханын цонх байрлуулж жуулчны баазад ашиглаж гэрэлтүүлгийг нэмэгдүүлж байна.
- Хэрэгцээтэй үед гэрийг угсруулан барьж зайг нь ихэсгэх бөгөөд эдлэл тавилга нь ч гэрийн дугуй хэлбэрт зохицсон байдаг онцлогтой.

Хот суурин газарт айлын гэр нь тохилог, гоёмсог байдлыг эрхэмлэдэг учраас гэрийн хийц хэсгүүд маш нарийн ажиллагаатай хөгжлийн үе шатуудыг туулжээ. Хот суурин газрын хүмүүс гэрийг бороо, цаснаас хамгаалж саравч барих, шалан дээр барих мөн хатавчинд гэгээвч хийх зэргээр гэрийн хийцийн хэсгүүдийг өөрчилж иржээ. Гэр нь түүхийн эртний үеэс л гэр бүлийн гишүүдийг халуун дулаан уур амьсгал дунд байхад зориулагдсан, гэр бүл төвтэй сууц байсаар ирсэн билээ.

Төв Азийн нүүдэлчин амьдралын хэв маяг дунд гэр бүлийн гишүүн бүр эв найрамдалтай аж төрөх нь чухал байсан нь зүйн хэрэг. Орчин үеийн гэрүүд ч мөн адил энэхүү хэв маягийг хадгалж, гэр бүлээрээ чанартай цагийг өнгөрүүлэн, хамтдаа тоглож наадах, хамтдаа хооллох боломжтой, гэр бүлийн гишүүдийг бие биетэйгээ ойр дотно байж, хамтдаа ажиллаж, амарч, хөгжилдөхөд гэрийн үндсэн дугуй хэлбэр нь ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. 2019 онд жуулчдын дунд явуулсан судалгаагаар Монголд аялаж байхдаа хийсэн зүйлсээс хамгийн их сэтгэлд таалагдсан зүйлсийг асуухад

- гэрт байрлах,
- байгальд аялах,
- морь унах,
- Монгол хоол идэх зэргийг онцолжээ



Зураг №13 Алунгоо Жуулчны баазын гадаа од ажиглаж буй жуулчин



Зураг №14 Гэрийн эд хэрэглэлийг ашиглаж буй амрагчид



Зураг №15 Жуулчны баазын гэрийн зохион байгуулалт

Хүснэгт 4. Жуулчдын Монголд хийхийг хүсдэг зүйлс

Жуулчдын үзэх зүйлс	Монголд ирэхээс өмнө хийхийг хүсч байсан	Хийж үзээд сэтгэл хангалуун байна	Дараа ирэхдээ хийж үзнэ
Зэрлэг, онгон байгаль	256	290	254
Байгальд алхах	188	207	207
Морь унах	243	253	204
Монгол хоол идэх	237	271	161
Дэлгүүр	174	201	120
Музей, үзвэр	141	173	135
Соёл	218	209	170
Наадам	144	80	236
Спорт	90	73	174
Гэр	234	300	175
Дуу	174	218	156
Чингис Хаан	146	111	121
Бусад	22	18	19

2002 онд хийсэн судалгаагаар жуулчдын 75% анх удаа Монгол гэрт байрласан ба Монголын талаарх шинэ төсөөлөл, ойлголт, амьдралын туршлагыг өгдөг гэж хариулжээ. Гэр баазууд нэг талаасаа нүүдэлчдийн амьдрал, ёс заншлыг танилцуулж сонирхолтой зүйлс хийх, танин мэдэх боломжийг хангасан мэдээллээр хангаж холбогдох үйлчилгээг санал болгодог нөгөө талаас байрлах орон байр учраас тохилог, цэвэрхэн, ая тухтай угсаатны зүйн онцлогыг бүрэн харуулсан байх шаардлагатай.

Шигтгээ: Монгол гэрийн домог

Монголын дээд өвөг хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан өнө эртний үед юм гэнээ. Хөх цэнхэр дээвэртэй, хөрст ногоон дэвсгэртэй орчлон дэлхий хэмээх оосор бүчгүй нэгэн их гэрт хүн амьтан цөмөөрөө л эвтэй сайхан амьдарч байжээ. Тэгтэл юунаас болсныг бүү мэд, нэг л мэдэхэд хоорондоо муудалцан уралцаж, хүчтэй нь хүчгүйгээ барьж идэхэд хүрэв гэнэ. Амьтад мөр мөрөө хөөн салж, зарим нь газар нүхлэн шургаж, нэг хэсэг нь усны гүнд, нөгөө хэсэг нь модны оройд гэртэй болжээ. Газар харин хүссэн бүхнээ хийж чадах ухаан гэгчийг хүнд заяажээ. Тэр цагт насан өндөр болтлоо ухаанаас ондоо өв хөрөнгө хураагаагүй нэгэн өвгөн байж гэнэ. Нэгэн өдөр долоон хүүдээ, «Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно» гэхэд хөвгүүд нь бодоод бодоод учрыг үл ухав гэнэ. Өвгөн ханаран хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв.

Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг өмнийн тооно, тал тал тийш урссан алтан цацрагнаас нь унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. Түшилдэн ханхайсан уул нуруудын араар сансрын хүрдэн салхи эрчлэн эргэж байгаа даа гэж бодуутаа хялгас томж бүслүүр хийв ээ. Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож тооноо өргөж, уния

өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ. Нарны гэрлийг наашлуулж татдаг, салхины хүчийг цаашлуулж хорьдог, нүүе гэвэл эвхээд ч ачдаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр хийсэн өвгөн буурал эшгийнхээ ухаанд хөвгүүд нь биширч аятай тавтай аж төрөх болжээ. Гэвч үлгэр үүгээр дууссангүй. Урт насалж удаан жаргасан өвгөн аав нь нэг өдөр хэвтэр орж, хөвгүүдээ тойруулан суулгаж, -Төрөх нэг өдөр байхад, төгсөх нэг өдөр бий. Ханан гэрээсээ аав нь хадан гэртээ буцах боллоо. Яаж аж төрөхийг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү бүслүүрээ л чангалж яваарай гээд насан өөд болжээ. Хөвгүүд нь урьдын адил мөн л учрыг ололгүй гайхаж хоцров. Тэгтэл нэг өдөр гэрийнх нь бүслүүр суларчээ. Бие биедээ найдсаар хэн нь ч чангалж таталгүй суутал гэр нь яйжийж унав гэнэ. Ах дүү долоо чамаас боллоо, танаас боллоо гэлцэн хэрэлдэж сүүлдээ бүр таарч тохирохоо больж тарж салахдаа хүрчээ. Эцгээс үлдсэн хөрөнгийг эн тэнцүү хувааж авахаар шийдээд хана, унь хаалга, тооно, дээвэр, туургаа салган үүрч харсан зүгтээ одоход отгон дүүд нь бүслүүрээс өөр юм үлдсэнгүй. Ууган хүү нэгэн газар хүрч хаалгаа босгон хэрүүл уруулгүй амар жимэр сууж байтал өдөржин хурц нар төөнөөд арай л шатаачихсангүй. Удаах хүү сараалжин ханаа дэлгээд унтаж хэвттэл гэнэт ширүүн бороо асгаж, аянга тасхийж эгээтэй л ниргэчихсэнгүй.

Дараах хүү туургандаа хоргодон суутал уулын үер урсгаад явчихаж. Бас нэг нь дээвэр дороо амарч хэвттэл хуй салхи босч хуу татаад хаячихав гэнэ. Нөгөө нь толгой дээрээ тооноо өргөөд сууж байтал шөнө болж, араатан чоно тал талд нь архиралдаж золтой л хүү татчихсангүй. Униа боож овоохойлчихоод хоргодож суусан нэгийг нь хүйтэн жавар хойрч хөлдүүс болгох дөхөж гэнэ. Бүслүүрээс ондоо юм үлдээгүй болохоор отгон дүү нь бүр ч хэцүү байсан нь мэдээж. Тэгтэл нэг өдөр түүн дээр хана үүрсэн ах нь буцаад иржээ. Удаах ах нар нь удалгүй хаалга, тооно, унь, дээвэр, туургаа үүрсээр ар араасаа цувран айсуй. Тийнхүү долоон хүү өвгөн буурал эшгийнхээ гэрээс үгний учрыг сая л ухаарч түүнээс хойш үеийн үед сургаалтай өргөө цагаан гэрээ эвийн сүлд болгон дээдэлсээр амар сайхандаа жаргажээ.

4

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ БАЙДАЛ, НҮҮДЭЛ ХИЙХ, НҮҮХ

Монголчууд яагаад нүүдэг вэ?

Төв Азид эрт үеэс ан гөрөө хийж, гаршуулж малжих суурийг тавьсан Монголчууд бэлчээрийн мал аж ахуйг хөтлөн хөгжүүлэхдээ түүний ашиг шим, эдэлгээ уналгаанд ашиглахдаа байгаль цаг уурын нөлөөтэй харилцан уялдаатай түүнтэй зохицон амьдрах арга ухааныг сүвэгчилж иржээ. Нүүдэл гэдэг нутаг сонгож, нэг газраас нөгөөд шилжин явах, байр бууцаа солих гэсэн утгыг агуулна. (Цэвэл, 1966)

Малчид мал аж ахуйгаа өсгөн үржүүлэх, ашиг шимийг нь улам арвижуулах зорилгоор нэг нутгаас нөгөөд сэлгэн өвс усны, аль сайныг сонгон нүүхэд зуны цагт хур бороо орохгүй, өвс ногоо, хужир усаар дутагдан газрын хөрс гандан хуурайших, өвлийн тэсгим хүйтэнд нөмөр бууштай, хаврын цагт бол нөөц хагд, хур өвс барагдах, намар бол сөл хөөх, ургамлын бүтэц малд тохиромжгүйдэх, уул нутагт ган, зуд зэрэг байгалийн гачаалд даван туулах найдваргүй нь урьдчилан мэдэгдэхээс гадна аль ч улиралд хүн малын элдэв, өвчин тахал гарах, өтөг бууц шатах, гал усны зовлон тохиолдох, цагийн их хөл үймээн, дэгдэх тэргүүтнээс болдог байна. (Гонгор, 1978)

Нүүдэл хийх эрт үеэс малчин ардын мал маллагааны арга ажиллагаанаас уламжлагдан гарч ирсэн түүхэн урт хугацаанд оршин тогтнож ирсэн танин мэдэхүйн, сүсэг бишрэл, ёс заншлын олон элементийг өөртөө багтаасан язгуур соёлын өв юм. Нүүдэлчин монголчууд тэр дундаас малчин ард түмний маань нэг эрхэмлэдэг зүйл нэг орчинд удаан суухгүйгээр өргөн уудам газар нутагт сэлгэж нүүх, өөр газар шилжиж бууж мал сүргээ өсгөн бие даасан үйлдвэрлэлийг хөгжүүлж ирсэн бөгөөд малчид ганц өрхөөр бус, хэдэн айл гэрийн жижиг нэгдлээр тодорхой хэмжээний газар нутагт нүүдэллэн амьдарч хотлон айлсаж нутаглах явдал нь юуны өмнө бэлчээр нутгийг хамтран ашиглах, малаа ээлжлэн хариулах, хүнд хүчир ажлыг олноор нийлэн гүйцэтгэхэд оршиж байв. Хот айлын нэгдэл нь зөвхөн өрхүүдийн нэгдэлээс гадна эд материал солилцох, сэтгэл санаа сонирхлын нийтлэг зорилготой байжээ. Бэлчээр усны зохилдолгоо, нэг хэвтэш дэхь бог малын тоо, толгой, улирлын онцлог зэрэгтэй уялдаж айлсаж хотлож бууж байсан байна.

Монголын нүүдэлчид бол байгалийн аясыг зүгээр нэг дагаж амьдардаг хүмүүс биш, байгальтайгаа биеэрээ нэгдэн эх газар, агаар тэнгэрийг холбодог ертөнцийн эргэлтийн нэг хэсэг юм. (1996, 1966)

Нүүдлийн амьдрал нь харин ч нарийн нямбай зохион байгуулалт, их хэмжээний ажил төрлийн амжуулахын тулд хөдөлмөрийн чадварлаг, оновчтой хувиарлалт, хариуцлага болон эрх хэмжээний нягт хослол шаарддаг (О. Латтимор 1962).

Айл гэрүүд айлсаж буухад дугуй хэлбэрээр буудаг. Энэ нь Монголчуудын эртнээс уламжилсан язгуурын заншил юм. Хүрээний голд тухайн овог аймгийн ахлагч буюу ноёны гэрийг барьж, түүнийг хүрээлэн бусад гэрүүдийг барьдаг байв. Энэ нь нэг талаас эзэн ноёноор төлөөлүүлэн төр улс, төрт ёсоо хүндэтгэх зан үйлтэй холбогдох боловч

нөгөө талаас дайснаас хамгаалах цэрэг – дайны зорилготой байсан ажээ. Нэг хотод хоёр, гурван айлаас хэтрэхгүй. Бага хүрээ буюу хот айл хэлбэрээ алдалгүй хадгалсаар иржээ. Хот айл хүрээлж буухдаа гэрийнхээ хойд биеэр саран дугуй хэлбэртэйгээр тэрэг, бараагаар дугуйлж битүүлдэг байжээ. Үүний учир нь бог малаа хотлуулж хамгаалахтай холбоотой ажээ. Айлсаад гэрээ барихад хотны ахмад юмуу хот айлын ахлагч нь хотны баруун хойд эсвэл хойд талд нь буусан бол дүүмэд айлууд нь зүүн гар талыг дагаж дараалан голдуу саран хэлбэртэйгээр бууна. Дүүмэд айл нь гэрээ барихдаа тоононыхоо ноён / баруун, зүүн тийш чиглэсэн/ хэцийг ахмад хүнтэй айлын гэрийн ноён хэцнээс зүүлдэг. Гэрээ ахмад айлтай зэрэгцүүлж барих буюу айлын хэцийг дарж буудаггүй заншилтай. Энэ нь хотныхоо айл өрх ах захыг хүндэтгэж үзсэн эрхэм сайхан ёс заншлын илрэл юм. Монголын нүүдэлчин ард түмний олон зуун жилийн турш улам бүр боловсронгуй болгон ашиглаж ирсэн сууц төдийгүй оюуны үнэт өв, угсаатны түүхэн дурсгал болох тухай судлаачид тэмдэглэн үлдээсэн байдаг.




Зураг №16 Хот айлаараа хүрээлэн буусан байдал

Нүүдэлчин Монголчууд буудаллахдаа өөрсдийн гэрүүдийг хүрээ буюу тойрог хэлбэрээр барьдаг байв. Хүрээний голд тухайн овог аймгийн ахлагч буюу ноёны гэрийг барьж, түүнийг хүрээлэн бусад гэрүүдийг барьдаг байв.



Зураг №17 1911 оны Нийслэл хүрээний хот төлөвлөлт

Энэ нь нэг талаас эзэн ноёноор төлөөлүүлэн төр улс, төрт ёсоо хүндэтгэх зан үйлтэй холбогдох боловч нөгөө талаас дайснаас хамгаалах цэрэг – дайны зорилготой байсан ажээ. Энэхүү хүрээ хэлбэр нь өөрийн үүргийн ХХ зууныг хүртэл хадгалж ирсэн гэж хэлж болох юм. Тодруулбал энэ хэлбэр нь Монголчуудын уламжлалт хот байгуулалт, төлөвлөлтийн үндэс болсон байна. Хэд хэдэн гэр бүхий хүрээг хот айл гэдэг, персийн түүхч Рашид Ад Дин Монголд 1000 орчим гэр бүхий хүрээ байсан тухай бичиж үлдээжээ. Гэр нь хэмжээний хувьд харилцан адилгүй байдаг бөгөөд тогтмол зөөж, буулгахад төвөгтэй, овор хэмжээ ихтэй хаад, ноёдын гэрийг тэргэн дээр байрлуулж, үхэр малаар чирж явдаг байсныг “гэр тэрэг” хэмээн нэрлэдэг байна. Францын жуулчин В.Рубрук “Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл” номондоо гэр тэрэгний талаар: 2 шараар чирдэг тухай, дугуй хоорондын өргөн нь 20 фут буюу 6 м гаруй байдаг тухай бичжээ. Гэр тэрэг нь дандаа шулуун дардан замаар явахгүй, бартаа саадтай газрыг туулж, мөн заримдаа гол мөрөн гаталж, уул давааг ч давах тул иймэрхүү том хэмжээний гэр тэргийг аюул осолгүй, хөнгөн болгож урлах нь инженерийн багагүй ур ухааныг шаардах нь мэдээж. Ийнхүү нүүдэлчин Монголчуудын гэр сууц, түүний хэлбэр, бүтэц, хүрээ хэлбэрийн зохион байгуулалт, мөн түүнчлэн гэр тэрэг зэрэг нь үеэс үед улам боловсронгуй болсоор Монголчуудын уламжлалт архитектур, хот байгуулалт, төлөвлөлтийн үндэс болсон байна. Эдгээр гэр, гэр тэрэг, асарын нийтлэг шинж бол маш энгийн хийцтэй боловч хялбар барьж, буулгах боломжтой байдаг оршино.



Энэ уламжлал Монголын аялал жуулчлалын гэр баазын үндсэн хэлбэрийг бий болгожээ.

Зураг №18 Хүрээлэн буусан гэрийн зохиомж

Монгол малчид бэлчээрийг ашиглахдаа байгаль цаг уурын хувьсан өөрчлөгдөх цаг үеэтэй уялдуулан жилийн 4 улирлаар хувиарлахаас гадна малын төрөл, биологийн онцлогт тохируулан газрыг ашиглаж ирсэн ба сэлбэн нүүх, нутаглах, оторлох зэргээр нарийн хувиарлаж даашын чадамжаас хэтрүүлэхгүй ашиглаж ирсэн уламжлалтай. Бэлчээрийг өвөл, хавар, намрын гэж хуваахаас гадна ойрын холын, өдрийн гэж ангилна. Тал хээр нутгийн малчид өвөлжөөний нутгаа хамгийн эрхэмд үздэг. Тиймээс өвөлжөөний бэлчээрээ чулуун овоо пайзаар тэмдэг тавин хамгаалдаг байжээ.

Монголчуудын мал ажиллагааны шилдэг арга малаа таргалуулах, хүчийг нь тогтооход анхаардаг явдал юм. Тиймээс отрыг зун намраар сайн зохион байгуулдаг. Ойт хээрийн бүсэд хонь, үхэр, адууг, тал хээрийн бүсэд таван төрлийн малыг, говьд хонь, тэмээ, ямааг голлон үржүүлж иржээ. Малын хээл томроогүй үед уулын хяр энгэрээр бэлчээх, малын хээл томорсон цагт уулын бэл, сугаар хариулдаг. Мал сүргийг өглөө орой нэгэн замаар бэлчээж хотлуулдаг. Бэлчээрийг ойрынх, холынх гэж ялган малын зүс тод танигдах хэмжээний бэлчээрийг ойрынх, түүнээс цаашхи бэлчээрийг холынх гэж тооцож түүнийг хоног хоногоор алсаас ойртуулан ашигладаг ажээ. Малчин хүн малд нь тохиромжтой өвс ургамалтай бэлчээрт малаа бэлчээрлүүлэн идээшлүүлэхийг хичээдэг.

Нүүдэлчин Монголчуудын нүүдэл хийх ёс горим их нарийн бөгөөд нүүдэл хийх нь ихээхэн хүч хөдөлмөр шаардсан байдаг тул замд тохиолдсон хэн боловч тусалдаг заншилтай. Монголчуудын дунд нүүхийн өмнө бэлчээрээ, буухын өмнө буйраа, нүүдлийн хүнээс нутаг асуу, нүүсний мал тарган, суусны бие амар хэмээн хэлэлцэж нүүхэд онцгойлон олон зүйлсийг анхаардаг байжээ. Түүнээс гадна гэрийн буйрныхаа дотор аль нэгэн хэсэгт хэдэн чулуун орхиж нүүдэг ёс бий. Гэрийн буйрны баруун өмнө хэсэгт нэг чулуу, буйрнаас гадна хоёр чулуу орхиж нүүвэл энэ нутагт эргэж ирнэ, нутаг бүү талхал гэсэн утгатай.

Нүүдэл хийхэд хамгийн чухал зүйл бол буух газраа сонгох

- Ойрад хүмүүс буух буурь, суух суурийг их чухалд үздэг тул ардын ерөөлд баатар ааваа буурьд бууж, баян эгчээ суурь сууж гэх буюу буурийн сайхнаар баяждаг. Борооны муугаар үгүйрдэг гэж хэлдэг.
- Нэн шинэ бууринд буух үедээ өвгийн цагийг өвөлжин, аавын цагийн буурь, үзэсгэлэнтэй сайхан дэлхий минь, өлзий хишигээ хайрлагтун! бууриндаа хандан шившин сан сүр тавьдаг ёс ч байдаг. Энэ нь буух буурийг аж амьдрал, өлзий буян, аз жаргал, ач үртэй холбож үзсэний илрэл болох бөгөөд олон үеэрээ нэг нутагт амьдарсан хүмүүс уламжлан ирсэн бууриа залан эзэгнэн суудаг заншилынх нь илрэл болох юм.
- Тиймээс малчин ард мал маллан нүүж буухдаа бууриа онцлон шинжиж хүн ба мал сүрэгт зохистой эсэхийг олон талаас нарийн ажиглаж шинжсэний суурь дээр өлзийтэй гэж үзсэн бууриндаа буудаг дадалтай байдаг.
- Өөрөөр хэлбэл, буурь шинжих зан үйл нь шүтлэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, соёл сэтгэлгээ, аман зохиол мэттэй олон талтай холбогдохоор барахгүй цаг улирал, орчин байгал, мал сүрэг, үр сүлжээ, аж байдал, эрүүл мэнд гэх мэтийн олон талтай холбогдох соёлын үзэгдэл болно.
- Эрт дээд үеэс байсан бөгөөд шинэ гэр барих газар сольж нутаглах байшин ордон байгуулах шинээс шинэ засаг төрийн төв тогтоох мэт байдалд буурь шинждэг.
- Өмнөө тогтоол шалбааг устай бол тэнгэрийн нулимс тогтсон муу газар барихгүй.
- Халз өмнөөс шалбааг булагтай газар байшин балгас битгий барь.
- Өмнөө улаан ширх мэт хадтай бол хүн малд өвчин хоргодох.
- Хойноо шувуу мэт ганц хадтай газар үзэгчийн өөрийн амь насанд хор өгөгч чөтгөртэй.
- Эрлэгийн ам мэт, араатан гөрөөсний гэдэс мэт ийм газрын харш, хорлол нь өвчин хийгээд ад зэтгэр олон бий.
- Хоёр араатан хэрэлдсэн мэт, хоёр шувуу улай булаалдсан мэт тийм газар уул толгод, хад их гэмтэй.
- Хар могой уруугаа гулгасан мэт, эм мангас үсээ сэгсийлгэсэн мэт, матрын ам ангайсан мэт ийм газрын хорлол маш их.
- Бас оцойж суусан нохой мэт, өмнөөс наашаа харсан уул ба хадан хоншоор бол гэм нь хүн, адгуусны амь нас ахар болох.
- Бас шувууны хумс мэт, тэмээний хоншоор мэт, яст мэлхийн шүд мэт тийм орон газрын харш гэм нь эрхтэн эвдрэх, үе гишүүнд гэм болох.
- Усны урсгалын хөндлөнгөөс тасалсан мэт, газрын хушуу мэт байгаа өнгө цайвар бөгөөд үхээр мэт бол түүнд байгч хүний буян хишиг, эд мал ууршин, сэтгэл дэнслэх

- Нутаг газрын дүр нь уулын үзүүр, хадны орой нь мэс, илдний үзүүр мэт, соёо мэт, хон хэрээний хошуу мэт бол маш их харштай.
- Зүүн зүгтээ суврага мэт уул, өмнөө гол мэт уул, баруундаа мод, хойноо устай газрын гэм их.
- Сумны онь мэт, усыг хадаар тасалсан мэт, амаа ангайсан мэт, голд бас хөндлөнгөөс гол сэлбэн ирвээс тэр газраас бага хүн барагдах аюултай, ураг садан үл зохицолдож, атаа хорсол болох гэх мэтээр газар сонгоход нарийвчлан үздэг байжээ.

Нүүхэд нь ойр орчны хүмүүс ачаалалцаж өгдөг бол нүүдэл өнгөрөхийг харсан айл цай идээ авч очиж ундаалдаг, татлагыг нь чангалж, ачааг нь засаж өгдөг. Буух газраа ирэхэд тэндхийн айл саахалтын хүмүүс ачаагийг нь буулгалцаж, гэрийг нь барилцаж өгнө. Нүүдлийн өглөө гэгээ ормогц эхэлж нар тусмагц хөдөлдөг. Монголчууд нүүх өдөр, буух газраа, өмнөөс товлож, цэлмэг сайхан өдөр нүүнэ.

Хаана буухыг өрхийн тэргүүлэгч шийдэх ба нүүхийн өмнөх өдөр орчин тойрныхоо хогийг сайтар цэвэрлээд нүүдэлд зэхнэ. Нүүхийн өмнө буух нутаг ус, газар орчноо үзэж, шав тавина. Гүүн зэл, шон гадсаа сугалж, нүхэнд нь өтөг бууц, сул шороо хийж чигждэг (байгаль хайрлах, мал амьтны хөл, хугарахаас сэргийлж). Ачаа хөтлөх морины дэлийг засдаг ба гэрийн эзэгтэй гоёлын хувцасаа өмсөөд, бүрэн хэрэглэлтэй эмээлээ тохож ачааг хөтөлдөг заншилтай байсан ба ачааны дэс дараалал нь хүүхэд ачсан тэмээ, эд хогшил ачсан тэмээ, цагаан идээ ачсан тэмээ, үхэр гэх мэт нарийн байжээ. Нүүх өглөөгөө гэргий нь эртлэн босож цайгаа чанаж, үнээ малаа саагаад өлзийгөө өгсөн нутаг хэмээн орон хангайд дээж өргөж дараа нь цайлцгаагаад нүүнэ. Шинэ бууриндаа нарнаар очсон байхыг эрхэмлэхээс нүүж очсон газраа чанасан цайныхаа дээжийг, ирсэн зүгээсээ эхлэн нар зөв тойруулан цацаж улмаар шинэ нутгийнхаа уул нуруу гол мөрөнд өргөж залбирна. Нүүдэл хөдөлсөний дараа гэрийн бууриа цэвэрлээд, араас нь гүйцэж очдог⁴.



*Зураг №9 Нүүдэлчдийн үхэр тэргэнд гэр ачихыг үзүүлсэн байдал
(Монгол Номадик жуулчны бааз)*

4 (Жуулчны баазын эргэн тойронд буй хогийг харсан Япон жуулчин гайхаад та нарын ЭХ ОРОН мөн биздээ хэмээн гайхширсан гэдэг. Жуулчны баазын эргэн тойрныг цэвэрлэх үзэмжтэй байлгах бидний үүрэг, хариуцлага)

Нүүхэд нарийн ёс горимтой гэрээ буулгахдаа нар зөв эргүүлж буулгана. Гэр барихдаа мөн нар зөв тойруулан ханаа дугуйлж туургаа ороон хошлонгоо татна. Бууриа сонгохдоо төвгөр газрыг сонгож (бороо, усны үерээс сэргийлж) тооно хаалганы голыг эгц буюу ялимгүй баруун тийш татаж барина. Гэрийн үүд тоононы харааг ямагт уулын оройг чиглүүлж барина. Харин хөтөл, хотгор чиглүүлэхээс цээрлэдэг юм. Тооныг хамгийн сүүлд ачина. Ачаалж дуустал тооныг гэртйн бууринаас гадагш гаргах ёсгүй. Ачаалж байх үед гэрийн буурь дээгүүр ачаатай, ачаагүй (тэмээ, үхэр, морь) мал гаргадаггүй. Учир нь «ачаа хазайна», «ачаа туйлна» гэж цээрлэдэг. Ачааг айлийн гэргий нь хөтлөх бөгөөд гэрийн буурийг нар зөв тойрч зам шулууддаг. Харин гэрийн эзэн хамгийн сүүлд ачааг дагаж морьдоно. Ачааны өмнө адуугаа бусад малаа ачааны араас тууж нүүдэг заншилтай.

Нүүх ёс горим

Гэрээ буулгахдаа нар зөв эргүүлж буулгана. Гэр барихдаа мөн нар зөв тойруулан ханаа дугуйлж туургаа ороон хошлонгоо татна. Бууриа сонгохдоо төвгөр газрыг сонгож тооно хаалганы голыг эгц буюу ялимгүй баруун тийш татаж барина. Гэрийн үүд тоононы харааг ямагт уулын оройг чиглүүлж барина. Харин хөтөл, хотгор чиглүүлэхээс цээрлэдэг юм. Тооныг хамгийн сүүлд ачна. Ачаалж дуустал тооныг гэрийн бууринаас гадагш гаргах ёсгүй. Ачаалж байх үед гэрийн буурь дээгүүр ачаатай, ачаагүй (тэмээ, үхэр, морь) мал гаргадаггүй. Учир нь «ачаа хазайна», «ачаа туйлна» гэж цээрлэдэг. Ачааг айлийн гэргий нь хөтлөх бөгөөд гэрийн буурийг нар зөв тойрч зам шулууддаг. Харин гэрийн эзэн хамгийн сүүлд ачааг дагаж морьдоно. Ачааны өмнө адуугаа бусад малаа ачааны араас тууж нүүдэг заншилтай.

Орчин үед гэрийн үндсэн зарчмыг алдагдуулахгүйгээр барилгын материалаар байнгын, суурин байдлаар мод, металл, бетон хийц ашиглан гэрийг барьж ашиглах боллоо. Малчид гэр хийх бүтээгдэхүүнийг байгалийн мод, мал аж ахуйгаасаа авдаг учир гэрийн эд материалын хомсдолд ордоггүй ба нэрийн модыг нутаг усныхаа ойгоос буюу ой модтой нутгаас авчирч бэлдэхээс гадна орчин үед үйлдвэрт ч бэлтгэхээс гадна гаднаас үнэт мод оруулж ирэн Ёслол хүндэтгэлийн гэрүүдийг хийж байна. Гэрийн мод дунджаар 35-50 жил, эсгий 15 жил хэрэглэгддэг ба байгальд бүрэн задрах боломжтой материалаар хийдэг.



Зураг №20 Үхэр болон тэмээн тэргэн дээр гэрээ ачаалдаг
/Монгол номадик жуулчны бааз/

Байгалийн бэлэн нөхцөл болсон бэлчээрийн олон зүйлийн өвс ургамал, ус, хужрыг мал өөрөө сонгож, зөвхөн тодорхой хувийг байгальд халгүйгээр хэрэглэж, даац, нөөцийг алдагдахгүй байдаг тул нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүний өртөг зардал хямд, байгаль орчноо жил бүр нөхөн сэргээгдэх боломжийг бүрдүүлдэг байна. Нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүн нь экологийн цэвэр бүтээгдэхүүн бөгөөд элдэв төрлийн бодис, химийн гаралтай хольцгүй эрүүл мэндэд сөрөг нөлөө багатай төдийгүй хэрэгцээг нүүдлийн мал аж ахуй бүрэн хангадаг.

Газар тариаланд ашиглах боломжгүй уулсын орой, цөлийн бүс, ойт хээрийн аглаг зэлүүд бэлчээрийг ч нүүдлээр ашиглаж чаддаг. Ган зудын давтамж, гамшиг тохиоход хурдан нүүж, шилжилт хөдөлгөөнийг түргэн хийж чаддаг.

Нүүдэл хийхэд зохицсон хувцас эдлэл ашиглаж ирсэн уламжлалтай. Малчдын нүүдэл тал хээрийн нутагт хэвтээ шугаман чиглэлтэй, харин уулархаг нутагт босоо чиглэлтэй байдаг ажээ. Өөрөөр хэлбэл тал хээрийн малчдын нүүдэл дэлхийн уртрагийн дагуу буюу хангай, тал хээр, говь гурван бүсийг дамнан тууш нүүдлийн чиглэлтэй байдаг байна. Уулархаг нутгийн малчдын нүүдэл уртраг, өргөрөг хосолсон уулын нүүдлийн чиглэлтэй байх ба уул нурууны өвөрт, нуруундаа, эсвэл уул нуруугаа даван нүүх зэргээр нутаг сонгодог. Малчдын нүүдэл зөвхөн бэлчээр дутагдсанаас буюу ган зуд болсноос зайлах арга нь мал сүргээ тэргээ авхуулах, хүрээлэн буй байгаль орчны тэнцвэрийг хадгалах, шинэ нөөц нутгийг илрүүлэн эзэмших, нутаг сэлгэн малын сүрэгт тарга авахуулах, шинэ нөөц нутгийг илрүүлэн эзэмших, нутаг сэлгэн малын эмгэгийн голомтыг арилгах, сэргийлэхэд ач холбогдолтой бүхэл бүтэн цогцолбор арга хэмжээ байжээ.

Монгол орны янз бүрийн бүс нутгийн малчдын нүүдлийн чиглэл, тоо, зайг судалсан судлаачдын бүтээлээс үзэхэд Хангайн, хээрийн, баруун Монголын, хангайн өврийн, дорнодын, говийн гэсэн 6 үндсэн хэв шинжээр ангилжээ. Нүүдэл 2 янз, уртын нүүдэл, богинын нүүдэл байх ба говь, хангай дамжин нүүнэ. Богины нүүдэл өвөлөжөө, хаваржаа, зуслан, намаржаа нь тодорхой нэгэн хүрээнд эргэлдэнэ. Монголын дорнод тал, их нууруудын хотгор, говийн бүс, баруун Монголчуудын малчдын нүүдэл 100-300 км нүүдэг, (холын нүүдэл) харин Хангайн нүүдэл ойрхон буюу дундажаар 20 км нүүдэлдэг байжээ. Нүүдэл хамгийн эхэнд орон гэрээ ойрхон зөөх буюу буйр сэлгэх, 5-8 км газар нутагт нутаг сэлгэх, хүрээгээр нүүх, хороогоор нүүх (Хүннүгийн үед нэг хороонд, хүрээнд 3000-30000 хүн) алсын нүүдэл, өртөөлөх, отор нүүдэл гэсэн олон хэлбэрийг бий болгожээ. Монгол гэрийг амралт, аяллын зориулалтаар ашиглахад ногоон шошго болон эко аяллын үзэл баримтлал, хандлагатай нийцнэ. Жишээ:

- Байгальд суурилсан нүүдлийн соёлын иргэншлийн ондоошлыг амралт, аялалтай хослуулах,
- Уламжлалт ёс заншил, зан үйлийн дэг, жаяг, арга хэмжээтэй танилцах, мэдрэх
- Орон нутгийн онцлог бүхийн ус, цахилгаан, халаалтын хэмнэлттэй хэрэглээтэй танилцаж, суралцах, мэдрэх,
- Хог хаягдлын менежментийн энгийн арга барилтай танилцаж, Монголчуудын нүүдэллэх бууриа цэвэрлэх, байгаль хамгаалах арга уламжлалаас суралцах,
- Байгальд ээлтэй тээврийн хэрэгслийн ашиглалттай танилцах, соёл ахуйг мэдрэх
- Уламжлалт гар урлалын бүтээгдэхүүн хийх аргатай танилцаж, суралцах, мэдрэх
- Нам гүм орчинд алжаал ядаргаага тайлах, олны хөлөөс зайдуу байх,

- Экологийн цэвэр, орон нутгийн, шинэ хүнсний гаралтай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэг байгалийн дагалт баялгийг ашиглах аргатай танилцаж, суралцах, мэдрэх боломжийг олгоно,
- Идэвхтэй үйл хөдөлгөөн хийх, өөрийгөө сорих, байгальд аялах бололцоог нээж өгнө,
- Зочинд тусгайлсан чин сэтгэлийн үйлчилгээ, харилцааг мэдрүүлэх,
- Жуулчин гэрийн тэжээвэр амьтантай харьцах, ан амьтан, жигүүртэнтэй танилцах,
- Орон нутгийн малчдыг амралт, аялал жуулчлалд татан оролцуулснаар орлогын нэмэлт эх үүсвэртэй болгох,
- Байгаль, соёлд нөлөөлөх таагүй хүчин зүйлийг урьдчилан сэргийлж сурах зэрэг шалгуураар ногоон бүтээгдэхүүнд нийцэж байна;
- Минималист, аж ахуйч суурь хүмүүжлийн олгох боломжтой;
- Эко соёлын тогтвортой орчныг уламжлалт соёлдоо тулгуурлан бүрдүүлэх,
- Хувь хүн байгальтай харьцах далд хүслээ биелүүлэх боломжийг Монгол гэр бүхий жуулчны баазууд олгох бүрэн боломжтой.



Зураг №21 Жуулчны баазын харагдах байдал

Монгол гэр нь Монголын нүүдэлчин ард түмний хэрэглэж заншсан уламжлалт сууц учраас зарим талаараа жуулчны баазын үйлчилгээнд үл нийцэх нөхцөл ажиглагддаг боловч зарим таатай орчин нөхцлүүдийг бий болгох бүрэн чадвартай юм. Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах үйл ажиллагаа нь тухайн нутаг дэвсгэр дээр газарзүйн болон нийгэм эдийн засгийн байдлыг тооцсон төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай юм. Энэхүү төлөвлөгөө нь байгаль хамгаалал, сөрөг нөлөөллийг багасгах үйл ажиллагааны дараахь үндсэн 4 арга хэмжээг тодорхойлно. Үүнд:

1. Хууль эрхзүйн зохицуулалт
2. Дэд бүтцийн зохион байгуулалт
3. Жуулчны нягтрал, ачааллын зохицуулалт
4. Экологийн мэдээлэл

Аялал жуулчлалыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн үйлчилгээг үзүүлэхийн тулд аялал жуулчлалын үйлчилгээнд ашиглагддаг элементүүдэд ногоон хүнс, ногоон дээвэр, сэргээгдэх эрчим хүч, хог хаягдалын зөв менежмент, ногоон хашаа зэрэг хөтөлбөрүүдийг санаачлан хөгжүүлэх хандлага өргөжиж байна. Байгаль орчинд аялал жуулчлалын үйлчилгээ, аялал нь дараах сөрөг нөлөөллүүдийг үзүүлдэг.

- Бохир усны хаягдал ихсэх, жуулчид орон нутгийн иргэдийн хэрэглээнээс давсан ус хэрэглэдэг ба гадаргын, гүний усны нөөц багатай Монгол улсын хувьд тулгамдсан асуудлыг нэг юм.
- Хуурай хог хаягдал ихсэж, байгальд хортой нөлөө үзүүлэх;
- Орчны дуу чимээ нэмэгдэж уугуул соёлд нөлөөлөх;
- Агаарын тээврийн хорт утаа ихсэх;
- Гол, нуурын эрэг, хөвөө, байгалийн гадаргын элэгдэл;
- Байгууламж барьсан газрын унаган хэв төрхийг сүйтгэгдэж, байгаль орчин доройтох;
- Ой, уулын энгэр, нуур, элсэн хурмал зэрэг байгалийн тогтоцын унаган байдал өөрчлөгдөж үзэмж буурах;
- Агаар-ус-хөрс-амьд биетний байгалийн хам бүрдлийн шинж алдагдах;
- Нутгийн иргэдийн соёлд дарамт учруулах;
- Уран барилга, түүхийн өвийг сүйтгэх, тонох;
- Амралтын суурин газрын хүн амын тоо өсөх;
- Нийгэм-эдийн засгийг ачаалалд оруулж, амжиргааны түвшинд өөрчлөлт орох;

Жуулчны баазыг байгуулахдаа хамгийн түрүүнд газар зүйн байршлаа зөв сонгох явдал юм. Жуулчны баазын байршлыг сонгон төлөвлөхөд дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- Байгалийн төрх байдал сайн харагдах (голдуу урд зүгрүү чиглэсэн)
- Орон нутгийн онгоцны буудлаас тодорхой зайд байрлах;

- Төв замаас тодорхой зайд (хамгийн бага) байрлах;
- Тусгай хамгаалалттай газрын зөвшөөрөгдсөн бүсэд байрлах;
- Топографийн саад тотгоргүй байх;
- Байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудад хүрэх боломжтой байх;
- Жил тутам бууриа сэлгэх ба сэлгээний газрыг төлөвлөсөн байдлаар хийх;
- Байгаль орчны нарийвчлалсан үнэлгээ хийсэн байх;

Дээрх байршлаас үндэслэн гэр жуулчны баазыг дараах шалгууруудаар барих хэрэгтэй. Үүнд:

- Салхины нөмөр
- Суурийн хад чулуу
- Микроклимат (аялал жуулчлал явуулахад тохирсон чийгшил, нарны энерги гэх мэт) бичил цаг уур
- Үерээс хамгаалах боломжтой эсэх
- Газрын төрх байдал онцлогыг харах боломж
- Хөрсний байдал (намаг, хад чулуу, элсэрхэг гэх мэт)
- Газрын налуу, ус гольдирул ба дрекани
- Хөрсний ус, мөнхийн цэвдэг
- Цахилгаан хангамж

Эдгээр шалгууруудыг харгалзан жуулчны бааз нь байршлаа зөв тодорхойлж болно. Дээрх шалгууруудыг мэргэжлийн өндөр түвшинд олон талаас нь хийсэн судалгаан дээр үндэслэж тогтооно.

5.1 Жуулчны баазын барилгын архитектурын асуудлыг хүрээлэн буй орчны зохистой байдалд нийцүүлэх арга зам

Жуулчны баазын архитектур, дизайныг хүрээлэн буй орчны хамгаалалтыг дараах зарчмын дагуу нийцүүлнэ.

Үүнд:

- Баазын нийт талбайг хамгийн тохиромжтойгоор шийдвэрлэх. Тухайлбал: Жуулчны баазын задгай талбайг зохистой ашиглах. Жуулчны баазын хашаан дахь задгай талбайг зүлэгжүүлэх, байнгын усалгаатай болгох, явган хүний зам, сүүдрэвч, бусад орон нутгийн болон тус жуулчны баазын онцлогийг тусгасан жуулчдын чөлөөт цагийг өнгөрүүлэх болон сонирхлыг татахад ач холбогдолтой байгууламжуудыг байгуулах хэрэгтэй.
- Ургамал, араатан жигүүртний чухал төрөл зүйлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тохируулах.
- Орон нутгийнхний онгон тахилт газрыг сонгохгүй, зөрчилдөхгүй байх.
- Топографи (хотгор, гүдгэр орчны харагдац)- ыг зөв тодорхойлох.
- Салхинаас нөмөр газрыг сонгох.
- Бичил цаг уурт нийцүүлэх.
- Үер усны аюулд өртөхөөргүй байх.

- Нийтийн зам харилцаанд ойр байх нөхцөлийг харгалзан үзэх.
- Харилцаа холбоо байх.
- Төвлөрсөн хог, бохирдсон зүйлийг ариутгах цэг хүрэх бололцоо, боломжийг харгалзан үзэх.
- Хөрсний элэгдлийг хамгаалах.
- Гүний усны нөөцийг зөв ашиглах.
- Гол мөрний ус, цас, мөс, борооны усыг ашиглах боломжтой байх.
- Нийтийн цахилгаан хангамж болон байгалийн сэргээгдэх эрчим (ус, салхи, нарны) хүчийг ашиглах боломжийг анхааран үзэж байгуулбал зохино.

Жуулчны баазын архитектур шийдэл нь тухайн газар орны үзэмж, онцлогт тохирсон байх шаардлагатай. Үүнд:

1. Баазын гаднах өнгө үзэмж
2. Барилгын материал нь байгаль орчинд хор нөлөөгүй байх
3. Өөрийн орны онцлогыг тусгасан (гэр, сүм хэлбэртэй) гэх мэт.

5.2

Жуулчны баазын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Жуулчны баазын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулсан байх бөгөөд ус ашиглалт, хог хаягдлын зохицуулалт, бохир усны асуудалыг оновчтой шийдвэрлэн нутгийн иргэдтэй хамран ажиллаж буй байдлаас нь голлон шалтгаална.

1. ЦЭВЭР УС АШИГЛАЛТ

Тухайн орчныхоо гадаргын болон газрын доорх усны нөөцийг судлан үзэж үүн дээр үндэслэн усны хэрэгцээг тогтооно. Нэг жуулчинд хоногт оногдох халуун хүйтэн болон хэрэглээний ус, ундны ус зэргийг нарийвчлан гаргах эндээс хэмнэж болох аргыг аль болохоор эрж хайхаар авсан байхаар шийдэх.

Гадаргын болон гүний ус

- Бохир ус алдагдах, халих зэргээр усан орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байнгын хяналт тавьж байх;
- Жуулчны баазын ариун цэврийн нөхцлийг дээд зэргээр хангаж, хаягдал бохир ус, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр органик хаягдлыг зайлуулах менежментийн зохистой шийдэл гаргах;
- Усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дүрмийн дагуу ажиллуулах;
- Баазад түр хугацаагаар хадгалагдаж байгаа хог хаягдал бороо, хаврын шар усны үерт урсан гол, нууранд орохоос сэргийлэх;
- Ундны усны дээж байнга авч судалгаа хийлгэж байх;
- Голд машин угаалгахгүй байх арга хэмжээ авах;

- Хаягдал ус зайлуулах цэгийг байгуулахдаа бороо хур болон хаврын шар усны үерт автахааргүй газрыг сонгох;

Ус

- Гүний усанд нөлөөлөх (ялагдас, бохир ус).
- Бохир усаар дамжин гадаргын ус бохирдол үүсэх.
- Хатуу хаягдлаар гадаргын ус бохирдох.

Ус хэмнэх аргуудыг жуулчны баазад хэрэглэх нь

- Сар бүр усны хэрэглээг бүртгэж, дундаж зардлыг тооцоолох,
- Гоожуур болон жорлонгийн хаалт, жийргэвчийг байнга шалгаж, ус гоожихгүй байлгах
- Шүршүүр, гоожуурын усны урсачын хэмжээг шалгаж, хэмнэлттэй шүршүүр хэрэглэх. Жишээ нь Шүршүүр, гал тогоондоо хэрэглэсэн усаа цэвэршүүлэн эргээд ариун цэврийн өрөөндөө хэрэглэх саарал усны технологи чухал болж Сингапурт сургууль эмнэлэг зочид буудал орон сууцандаа сүүлийн 10 жилд энэ хэрэглээг хэвшүүлжээ Хонконг мөн Сингапурын жишгээр саарал усыг ашиглах болсон. 5 хүн өдрийн турш саунд ороход 150 л ус хүрэлцдэг шүршүүр Солонгосын «Жем» брендийнх, усны дуслыг маш жижгэрүүлж, усыг хэмнэдэг. Усыг нэмэх цэнгээр цагаан мөнгөний тусламжтай ионжуулдаг.



Зураг №22 Усны хэмнэлттэй холигч болон шүршүүр

- Жорлонгийн ус хураах савны усны түвшинг тохируулах;
- Шүршүүрт биш усан ваннд орохыг сурталчилах;
- Шүршүүр, гоожуурын усыг 10 минутаас илүүгүй гоожуулах, мэдрэгчтэй гоожуур хэрэглэх;
- Халуун усны хангамжийг төвлөрүүлж, уурын халаагуурыг хэмнэлттэй ашиглах;

Баазын хог хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд салхи, үерийн ус зэргээр зөөгдөн, голын ус, түүний эрэг татам бохирдож болзошгүй. Түүнчлэн аялагчид жуулчид хог хаягдлаа голын эрэг татамд хаяж болох талтай. Ийм учраас аялагчид, жуулчдын маршрутыг тодорхой болгож, тэдний явах зам, амрах хэсэгт хогийн сав тавьж байршуулах нь тохиромжтой байна. Баазыг өргөтгөн шинэчлэх үед бохир усан санг барилга байгууламжуудын салхины доод талд буюу зүүн талд байгаа жорлонгийн орчимд хийх нь тохиромжтой байгаа бөгөөд

түүнийг “Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож, ашиглах журам”-ын шаардлагын дагуу хийхгүй бол түүний битүүмж амархан алдагдах аваас гүний болон голын усанд нөлөөлнө. Бие засах газарт нийт ус хэрэглээний 3/1 нь зарцуулагддаг. Ус хэмнэх боломжуудыг дэлхийн шилдэг эко буудал, баазууд нэвтрүүлэн ашиглаж байна.

- Бие засах газарт ус бага хэрэглэх үүднээс ус хаах товчлуурыг байрлуулах;
- Усны хоолойг байнга шалгаж, ус гоожиж буйг тогтоох;
- Усны тоолуур байрлуулах;
- Шүршүүр болон гоожуурт хязгаарлагч байрлуулах;

Бохир усны ашиглалт

- Жуулчдын болон бусад ахуй хэрэгцээнээс гарах бохир усыг нарийн тооцож гаргах;
- Бохир усны шүүн цэвэршүүлэх;
- Шууд байгальд, хөрсөнд шингэхээр хийхгүй байх;
- Үлдсэн ялзмагийг тусгай бодисоор задалж түүнийгээ хөрсөнд бордоо болгон ашиглах арга замыг хайх хэрэгтэй.

Монгол Улсын хувьд 300-1500 мм хур тунадасны ууршилттай бүс нутаг, гадаргын гүний ус нийт усны 2%-ийг эзэлдэг. Гэтэл Монгол орны жуулчны баазууд ихэвчлэн газрын гүний усыг ашигладаг. Гүний усны нөөц нь бага, нөхөн сэргээгдэх хугацаа их, нутгийн ихэнх хэсэг нь ууршилттай гэдэг нь дараах зургаас харагдаж байна. Гүний ус ихэнхдээ хур борооны ус болон цасны усаар тэжээгддэг. Нутгийн өмнөд хэсгийн ихэнх нь жилд ордог хур тунадасны хэмжээ 60-200 мм буюу маш бага учир нөхөн сэргээгдэх боломж хомс.



Зураг №23 Бохир усаа цэвэршүүлж ашиглаж буй технологийн шийдэл, Хустайн БЦГ

2.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Аялал жуулчлал өсөхийн зэрэгцээ хог хаягдал нэмэгдэж, үүнийг зайлуулах асуудал гарч ирдэг. Ил задгай гал түлэх явдал гардаг бөгөөд энэ нь хуурайшил ихтэй хавар, намрын цагт түймэр гарах үндсэн нөхцөл болохын зэрэгцээ орчныг бохирдуулах үндсэн нөхцөл болж байна. Нэг дор хэдэн мянган амрагч, аялагч бөөгнөрөх нь тухайн суурин газрыг ердийн хэвийн аж төрдөг цаг үеэс хэд дахин илүү хог хаягдлаар дарж, бохирдуулдаг. Зөвхөн жуулчны баазын хашаан дахь хог хаягдлаас гадна амрагчид тухайн орчинд хог хаягдалыг ил задгай хаядаг. Ингэснээр байгалийн үзэмж доройтох, хур хог үүсэх, эко систем алдагдах, жуулчид тухайн орон нутгийг дахин аялах сонголт хийхгүй байх, бүс нутгийн нэр хүнд унах, хүний эрүүл мэндэд хортой нөхцөл үүсэх зэрэг олон шалтгаан болж байна. Жуулчид хүлээн авч буй баазуудын удирдлагуудын танилцуулснаар хог хаягдлууд ихээр хуримтлагдана. Баазын ойролцоох хог хаягдлуудыг үр нөлөөллөөр жагсаахад:

1. Хоол хүнсний сав баглаа боодол, гялгар уут
2. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн сав баглаа боодол, ашигласан баттерей, асаагуур
3. Тамхины иш
4. Хувцас болон тэдгээрийн дагалдах гоёл чимэглэлийн хэрэгслэлүүд
5. Машин болон бусад техникийн сэлбэгүүд, тос, тосол, масло гэх мэт хортой нэгдлүүд
6. Хуванцар эдлэл
7. Архи пивоны шил, лааз
8. Хоол хүнсний үлдэгдэл


ТХГН-т үүсч буй хог хаягдлын 90-ээд хувийг орон нутгийн ажилчид болон орон нутгийн жуулчид буруу хаяснаас үүсгэвэртэй гэж үзэж байгаа ба гадны жуулчид хог хаягдлын тал дээр харьцангуй илүү ухамсартай ханддаг ба хогоо тухайн заасан цэгт эргүүлэн авчирч хаядаг байна. Оршин суугчдын буруу хаясан хаягдлын 99% нь гаднаас авчирсан хог хаягдал байдаг. Жишээ нь: Оршин суугчид сав баглаа боодолтой хүнсний бүтээгдэхүүнийг тэр болгон өөрсдөө авч хэрэглэдэггүй ба тухайн оршин суугчид, баазын ажилчид дээр ирсэн гадны гийчдийн өгсөн бэлэг сэлт нь энэхүү хаягдлыг тухайн орчинд үүсгэдэг байна. Баазууд рүү холбогдсон замын хажуу жалга судаг, замын хажуу, нуур, голын хэрэг дагуу хог хаягдал асар ихээр бий болсон. Үүнийг шийдвэрлэхийн тулд хогийг төрөлжүүлэх шаардлагатай.

- Ялзарч муудах хоолны үлдэгдэл (эдгээрийг ялзмагжуулж, бордоо хийж болно)
- Дахин ашиглаж болох зүйлс (цаас, шүлтлэг, ус, шар айрагны лааз, лонх)
- Хорт бодис (хуванцар, бензин, тос гэх мэтээр ялгаж тэмдэглэнэ)
- Органик биш хог хаягдлуудыг цуглуулж төвлөрсөн хогийн цэгт тушаах,
- Цаасанд ангилан ялгалт хийх,
- Хөрс болон бусад амьд бодистой хогийг тусд нь ангилж өгөх,
- Байгалийн хортой хогийг ашиглахгүй байх,
- Хоёрдогч түүхий эдээр хийсэн ариун цэврийн цаас ашиглах,
- Зочны өрөөнд цаас, хуванцар, шилний тусдаа хогийн сав тавих



Зураг №24 Хүнсний хуурай хог хаягдлыг бордоо болгох төхөөрөмж /Хустайн БЦГ/

Азийн сангаас хэрэгжүүлж буй Хог хаягдал ба уур амьсгалын өөрчлөлт төслийн хүрээнд гал тогооноос гарч буй хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж компост бордоо болгох ажил туршилтын үе шатанд явж байна.



Зураг №25 Гал тогооноос гарч буй хүнсний хог хаягдалын бүртгэл /Хустайн БЦГ/

Хог хаях бүх газрыг цэвэр байлгах ёстой. Хогийг өндөрлөг газарт хаяхаас гадна норж усны ундарга руу оруулахгүйн тулд бетонон тавцан хийх боломжтой.

ХУСТАЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ, ХЭРЭГ ЖУУЛЖ БУЙ АЖЛУУД

- Жуулчны баз болон 16 айлын хог хаягдлын төвлөрсөн цэг.
- НЭГ ТАЛДНЬ ҮНС, НӨГӨӨ ТАЛД БУСАД ХОГ ХАЯГДАЛ
- ЖНД 8-12 УДАА БУЮУ /100-176ТН/ХОГ АРГАЛАНТ СУМРУУ ТЭЭВЭРЛЭЖХАЯДАГ.

АХУЙН ГАЗНУУД

НООЛИЙН ЦААС ШАТААДАГ

Зураг №26 Хог хаягдлын төвлөрсөн цэг



Зураг №27 Хогыг ангилан ялгалт хийж буй байдал /Хустайн БЦГ жишээ/

Хогны савуудыг зохих шаардлагатай газруудад байрлуулсан болно. Ингэснээр хогийг эх үүсвэр дээр ангилдаг.

Хог хаягдлыг тухайн бүсийн хил хязгаараас аль болох алсуулж орон нутгийн нэгдсэн хогийн цэг дээр аваачиж хаях. Үүнд боломжийн хирээр тэр бүсэд багтах орон нутгийн сум багийн хог хаягдлыг хамруулах хэрэгтэй. Хог хаягдлыг ангилах үйл ажиллагааг хангалтгүй байна.

Жуулчны баазын хэмжээнд



Зураг №28 Хог хаягдлын урсгал /Хустай БЦГ/

Хог хаягдлыг тухайн бүсийн хил хязгаараас аль болох алслуулж орон нутгийн нэгдсэн хогийн цэг дээр аваачиж хаях. Үүнд боломжийн хирээр тэр бүсэд багтах орон нутгийн сум багийн хог хаягдлыг хамруулах хэрэгтэй. Хог хаягдлыг ангилах үйл ажиллагааг хангалтгүй хийснээс тухайн байгууллагад их хэмжээний зардал үүсгэдэг. Хог хаягдлаас зайлсхийх нь илүү үр дүнтэй тухайлбал дараах аргуудыг жуулчны баазуудад хэрэглэж байна.

- Нэг удаагийн сав боодлоос татгалзах (Хустайн жуулчны бааз);
- Дахин ашиглах зориулалттай сав боодлыг эргүүлэн авах;
- Биологийн гаралтай хог хаягдлыг эргүүлэн ашиглах;
- Хог хаягдал хүлээн авах цэг ажиллуулах, байршуулах (Хустайн жуулчны бааз);
- Мэдээлэл түгээх;

Хустайн БЦГ жуулчны баазад хог хаягдалыг ангилан ялгаж орон нутгийн хогийн цэгт хаяхаас гадна хогийг төрөлжүүлэн шил, лаазыг ангилж тушааж, хүнсний гаралтай хог хаягдалыг бордоо болгож ашиглаж байна.



Зураг №29 Хог хаягдлын ангилан ялгалт /Хустай БЦГ/

Монгол орны жуулчны баазууд ихэнх хогоо байгаль хамгаалалын хамгийн оновчгүй хэлбэр болох булах аргыг хэрэглэхээс гадна орчин тойрондоо байгаа хог хаягдалд анхаарал хандуулахгүй байгаа нь Монгол орны байгалийн хамгийн үзэсгэлэнтэй хэсэг доройтох нөхцлийг үүсгэж байна.

Оршин суугчдад байгальд нэн хортой буюу задарч хөрсөнд шингэх боломжгүй хог хаягдлыг устгах бололцоо нөхцөл дутмагаас шалтгаалан тэдгээрийг буудалласан газрынхаа ойр орчинд үлдээх, шатаах зэргээр хор хөнөөл учруулж байдаг. Хатуу хог хаягдал нь хүрээлэн байгаа орчин (ус, агаар, хөрс) –д болон хүний эрүүл мэндэд маш их сөрөг нөлөө үзүүлдэг.

Хог хаягдлаас учрах хохирол:

Хүрээлэн буй орчинд:

Агаар

Ус-булаг, шанд, гол, мөрөн,

Хөрсийг бохирдуулдаг

Хүний эрүүл мэндэд:

Гэдэсний халдварт өвчнүүд,

Сүрьеэ, боом, татран зэрэг өвчин тараах эх үүсвэр болно.

Жуулчны баазууд хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

3. ТҮЛШ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЦЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙ ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ

Эрчим хүч

Аялал жуулчлалын баазуудад цахилгаан, шатдаг хий зэрэг нь эрчим хүчний эх үүсвэр болдог. Нөөцийг гамнах, цахилгааныг нөхөн сэргээгдэх эх үүсвэрээс гарган авснаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгана.

- Орчин үеийн халаагч тоног төхөөрөмжийг нарны энергийн хуримтлуулагчтай хослуулах
- Эрчим хүч хэмнэх тоног төхөөрөмж (сүүн гэрэл)
- Цахилгаан халаагчаас татгалзах
- Дулаан шахагчийг ашиглах
- Нарны болон салхины эрчим хүчийг ашиглах
- Хаягдал түүхий эдээс цахилгаан гарган авах

Тухайн баазын оршин буй бүс нутгийн нар, салхи, шатдаг хийг ашиглан эрчим хүчний нөөцийг зөв тодорхойлж үүний үндсэн дээр эрчим хүчний нийт ашиглалтын 20 хувийг дээрх эх үүсвэрүүдээс ашиглах боломжтой.

- Өдрийн цагаар болон бусад онц шаардлагагүй үед илүүдэл эрчим хүч ашиглах үйл ажиллагаанд хязгаарлалт хяналтыг нэвтрүүлэх;
- Жуулчдын хэрэгцээ шаардлагыг хангах эрчим хүчний ашигтай зарцуулалт бүхий тоног төхөөрөмжийг ашиглах;
- Жижиг оврын цахилгаан үүсгүүрийг ашиглах тохиолдолд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө, дуу чимээ, хорт утаа зэргийг тооцож үүнийг багасгах болон бууруулах арга хэмжээ авсан байх;
- Цахилгаан үүсгүүрийн дуу чимээ нь жуулчид, болон нутгийн оршин суугчид, ан амьтанд сөрөг нөлөө, үзүүлж зөрчилдөөн үүсгэхгүйгээр зохицуулсан үр дүнтэй арга хэмжээ авах зэргийг төлөвлөх;
- Илч дулаан бага ялгаруулдаг чанаргүй нүүрс хэрэглэхгүй байх;
- Мод багатай бүс нутагт аргал, түлш, шаваг ашиглах, ач холбогдлыг ойлгуулах (Хангайн баазуудын эргэн тойрон аргал маш, хог шиг хөглөрдөг);
- Зочны өрөөнд агаарын дулаан урсгал, дулааны тохируулагын горим бий болгож зуны улиралд гал түлэхгүй байхаар шийдэх;
- Жийргэвч сайтай вакуум цонх, агааржуулалтын систем, хаалга ашиглах, хаалгаар,

хаяа хатавчаар их дулаан алдана;

- Ус, халаалтын шугам хоолойн дулаалгыг сайтар хийх;
- Цахилгаан халаагч, гар хатаагч ашиглах;
- Эрчим хүчний давхар эх үүсвэр ашиглаж байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх;
- Цахилгааны зарцуулалтын шинжилгээ хийх;
- Цахилгаан бага хэрэглэдэг тоног, төхөөрөмж хэрэглэх;
- Хоол хийх болон хоол хүнс хадгалах төхөөрөмжийн багтаамжийн ашиглалт, зарцуулалтанд хяналт тавих;
- Баазын үйл ажиллагаанд зочны өрөөний температурын тохиргоог автоматжуулах,
- Машины зогсоолыг газар доор хийж, барилгын материал хэмнэж, газрын гадаргын төрхийг хэвээр хадгалах;
- Дээвэр дээр нарны эрчим хүчний дэлгэц байрлуулж усаа халаах шийдлүүдийг түгээмэл ашиглаж байна.

Судалгаанаас үзэхэд

1. Манай улсын нэг км талбайд харгалзах нарны нийлбэр цацрагийн хэмжээ жилд 1200-1600 кВт*ц/м хүрдэг ба нийт нутгийн хэмжээгээр жилд ирэх нийлбэр цацрагийн хэмжээ 2.2*10¹² МВт-аар үнэлэгдэж байна. (Б. Мөнхтогтох 2019)
2. Нарны гийгүүлэх хугацаа Монгол орны төв, хойд хэсэгт жилд 2600 цагаас багагүй бөгөөд нэг км талбайд харгалзах нарны эрчмийн хэмжээ өдөрт 4.5 кВтц/м. Харин манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг хамарсан говь, тал хээр, цөлийн бүсэд нарны гийгүүлэх хугацаа 2900-3000 цаг бөгөөд нэг ам метр нэгж талбайд харгалзах нарны эрчмийн хэмжээ өдөрт 5.5-6.0 кВтц/м байна.
3. Манай орны говийн бүс нутагт НДЦС барихад тохиромжтой гэдэг нь цаг уурын судалгаанаас харагдаж байна. Тэр тусмаа нарны дулааны цахилгаан станцуудаас “Цамхагт НДЦС” барих бүрэн боломжтой төдийгүй жилийн турш ашиглах бүрэн боломжтой.



Зураг №30 Нарны гэрлийг ашиглаж цахилгаан үүсгэж буй нь.
Хустайн БЦГ жуулчны бааз

4. АМЬТАН

Байгалийн унаган төрхийг хадгалахад голын усыг бохирдуулахгүй байж, загас жараахай, усны амьтдыг хамгаалах, загас барих аливаа оролдлогыг харах хэрэгтэй болно. Ан амьтад жигүүртнийг аялагчдын зүгээс үргээж, дайжуулах агнах зэрэг оролдлого гарч болзошгүй тул байнгын хяналт ухуулга сурталчилгааны ажлыг хийж байх шаардлагатай болно. Дуу шуугиан их гаргах техник хэрэгсэл ажиллуулахгүй байх хэрэгтэй болно.

- Амьтдыг дүрвээх, ареалын өөрчлөлт;
- Зүйлийн бүрдлийг өөрчлөлтөд оруулах;
- Тухайн бүсийн амьтны тоо толгой цөөрөх;

5. ХӨРС, УРГАМАЛ

Үндсэн зам болон түүнээс салсан замуудыг засварлаж, шинэ салаа замууд үүсгэхгүй байх. Үүний тулд үндсэн замаас өөрийн жуулчны бааз руу зам гаргах байгууллагуудад ганцхан зам гаргаж, сайтар тэмдэгжүүлэх, замын хоёр талаар мод тарихыг санал болгох, модны тарьц, суулгачыг тарих

- Хөрс ургамлын нөмрөгийг давтан талхалж, хөрсөнд эвдрэл үүсгэх болон орчны тоосжих нөхцлийг багасгахын тулд баазын хашаанд тусгай зогсоол байгуулж, машин техник сэлгүүцэхийг хориглосон тэмдэг байрлуулж, замын хөдөлгөөнийг бүр мөсөн хаах хэрэгтэй.
- Үхэр, тэмээ, морины хөлд хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг алдралд орох аюултайг байнга анхаарч, хамгаалалтын арга хэмжээ авах, ээлж сэлгээтэй ашиглах хэрэгтэй
- Хөрс болон орчныг бохирдуулахгүй байлгах үүднээс ахуйн шингэн болон хуурай хог хаягдлын цэгийг сонгохдоо үер борооны усанд өртөгдөж судаг жалгаар дамжин голын усанд орохооргүй газарт сонгохын зэрэгцээ орон нутгийн зонхилох салхины доод талд байрлуулах шаардлагатай



*Зураг №31 Жуулчны баазын талбайн хөрсний зураг
Монгол Номадик жуулчны баазын зураг*

6. УРГАМЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Жуулчны баазын газрын ойролцоо хорт ургамал байвал зургийг нь авч амрагчидад тодорхой сайн анхааруулах хэрэгтэй. Ялангуяа жуулчны баазад ургамлын

нөхцлийг сайн анхаарч хөрсөн бүрхэвчийг хамгаалах модлог ургамалтай, ойтой газрыг түшиглэдэг нийтлэг зүй тогтолтой. Ургамал нь сийрэг юмуу хэт тачир, огт ургамалгүй газар байгуулахаас зайлсхий. Нэгэнт баригдсан бааз нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Бааз орчмын замыг янзлах

Бааз орчмын замыг сайн тэмдэгжүүлж, шинээр зам гарахаас сэргийлж ургамлын нөмрөгийг талхалж хөрс эвдэж болзошгүй байна. Мөн түүнчлэн машин техник, тос шатахууны алдагдал, хөрсөнд бохирдол үүсэхээс хамгаалж, машин техникийн зогсоолыг тусгайлан бэлтгэх хэрэгтэй болно. Баазад ирж буцаж буй автомашин нь тодорхой хөдөлгөөнийг үүсгэдэг. Байгаль орчин болон хүний сэтгэхүйн үүднээс хөдөлгөөний нөлөөллийг багасгах хэрэгтэй.

- Төв замаас бааз хүрэх замыг хатуу хучилттай болгож тэмдэгжүүлэх;
- Баазын автомашины зогсоолыг зочдын тоогоор бүх машин зогсох бололцоог хангах;
- Амрагч, жуулчдыг тус бүс нутагт аялуулах маршрут гаргаж орон нутгийн тамгын газраар батлуулан, мөрдлөгө болгон ажиллах;
- Талбайн зохион байгуулалт байгалийн бүрэлдэхүүн хэсэг байх учиртай. Баазаа байгаль орчинтой эвсэг хэлбэрээр байршуулбал зочдод таатай сэтгэгдэл төрүүлэхээс гадна амьтад амьдрах орон зайгаа олдог.
 - Ургамал, амьтныг хамгаалах
 - Эрдэс бордоо болон ургамал хамгаалах химийн бодис хэрэглэхээс татгалзах
 - Өвс хадагч машин хэрэглэхгүй байх
 - Амьтанд эвсэг гэрэлтүүлэг хэрэглэх
 - Байгаль орчны талаарх танин мэдэхүйн ном түгээх
- Байгаль орчинтой уялдсан байдал;

Амралтаараа хүмүүс шинэлэг зүйл хүлээн авах дуртай байдаг. Иймээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хөгжөөнт хэлбэрээр амралтын хөтөлбөрт оруулах хэрэгтэй.

- Байгаль орчны талаар мэргэшсэн тайлбарлагч ажиллуулах, байгаль орчны талаар мэргэжлийн хүмүүстэй уулзалт зохиох;
- Шувууны үүр баазын ойрхон байх мод, хаданд байрлуулах;
- Экологийн сэдэвтэй ном, сэтгүүл тараах;
- Байгаль орчныг хамгаалах өдрийг зохиох;

Жуулчны баазын байгаль орчныг хамгаалах

Жуулчны баазын байгаль орчныг хамгаалах менежментийн үйл ажиллагаанд нутгийн иргэдийг татан оролцуулах:

1. Хамтран ажиллах менежментийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад нутгийн хүмүүс оролцож болох;

2. Менежментийн шийдвэр гаргахад орон нутгийн хүмүүсийн саналыг авах;

Шийдвэр гаргахад нутгийн иргэдийг оролцуулах нь яагаад чухал байдаг вэ? Нутаг орныхоо байдлыг тэд хэнээс ч илүү мэдэх явдал олонтаа тохиолддог. Тэгээд ч нутгийнхны оролцоог дэмжсэнээр аялал жуулчлал болон байгаль хамгаалах үйл ажиллагаа улам бүр сайжирна. Байгаль орчноо хамгаалах уламжлалт соёлоо сэргээж буй өнөөгийн нөхцөлд хөдөөгийнхнийг аялал жуулчлалын үйл хэрэгт татан оролцуулах замаар аялал жуулчлал нь байгаль хамгааллын үлгэр дуурайлал болохыг тэдэнд ойлгуулах явдал юм. Жуулчны баазаас хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа нөлөөллийн үндсэн хэлбэрүүдийг зэрэглэх байдлаар тодорхойлоход судалгаанд хамрагдсан баазуудын хувьд ерөнхий дүнгээр газрын элэгдэл, талхагдал хамгийн гол асуудал болоод байгаа нь харагдаж байна. **(Г.Баатарцоож 2008)** Жуулчны баазуудаас хүрээлэн буй орчны чиглэлээр хийж буй ажлуудыг судалж үзвэл бааз орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэх, мод тарих, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах зэрэг үйл ажиллагаа хамгийн нийтлэг шинжтэй байна. **(Судлаачдын судалгаагаар 2022)**

Жуулчны баазын хувьд шинэлэг бөгөөд хүрээлэн буй орчны хувьд багагүй ач холбогдолтой ажлуудыг төлөвлөж хийж байна. Үүнд:

1. Эмийн, ховор ба нэн ховор ургамал тарималжуулах төсөл (Дорнод. Угтам)
2. Даавуун уут нэвтрүүлэх (Өвөрхангай. Талбиун)
3. Малын тоо толгойг хязгаарлах (Өвөрхангай. Хан тайж)
4. Эмчилгээний анхилуун цэцэрлэгээ хөгжүүлэх (Хөвсгөл. Галт)
5. Нарны эрчим хүчээр ажилладаг хүлэмж, эко цэвэрлэх байгууламж (Өвөрхангай, Хархорин, Анжа)
6. Гүүр барих, усны эх хамгаалах (Булган. Хангай дисковери)
7. Загас үржүүлэх (Баянхонгор. Шаргалжуут)
8. Байгаль хамгаалах тэмдэгжүүлэлт хийх (Сэлэнгэ. Ноён тур ЖБ)
9. Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, эрчим хүч бага зарцуулан хоол бэлдэх, халаах техник, хүлэмж, нарны хураагуур (Өвөрхангай, Хархорин, Анжа ЖБ)
10. Бага оврын, бие даасан бохир ус цэвэршүүлэх байгууламж (Төв аймгийн Аргалант Хустай ЖБ)
11. Салхин сэнсээр эрчим хүчний хэрэглээний тодорхой хувийг хангадаг, чацаргана, жимс тариалдаг. (Өмнөговь, Булган сум, Говийн 3 тэмээ)
12. Усаа нараар халаадаг шийдэл (Өмнөговийн баазууд)
13. Хуванцарын хэрэглээг бууруулах, дахин хэрэглээний хуванцар саваар орлуулсан 2017 онд 26000 ширхэг хуванцар савны хаягдал, 8000 мянган мод тарьсан, хүлэмжиндээ өргөн хэрэглээний ногоо тариалдаг (Өмнөговь, Булган сум, Говийн гурван тэмээ)
14. Нимбэгтэй ус, шилэн савтай (Өвөрхангай, Хархорин, Мөнхтэнгэр ЖБ)
15. Онгийн нууц, Торгоны замын нууц, Монголын нууц товчоо жуулчны баазуудын хог хаягдлын менежмент- Бүх салбарууд дээр хогийг дахин боловсруулах, хортой, бусад хог хаягдал гэж ялгадаг. Дахин боловсруулах хог хаягдлыг Хархорин сум, Жаргалант суманд, УБ хотод авч ирж тушаадаг. 3 бааз дээр 3 дамжлагатай бохир ус цэвэршүүлэх системээр дахин ашиглах боломжтой саарал ус гаргадаг. Усны хэмнэлтийн сургалтыг чиглүүлэх сургалтандаа тусгаж

бүх ажилчдад ордог. Эвдэрсэн, ус дусаж байгаа цорго, хоолойг цаг алдалгүй янзлуулах. Их болон бага хэмжээгээр ус гардаг даралттай 00 ын суултуурууд авч ашигладаг. Баазын хашаа гэхгүй, хашаанаас гадна ойр хавийн хог хаягдлуудыг нэгдсэн зохион байгуулалттай түүж ачуулдаг. Монголын нууц товчоо бааз дээр байгаль хамгаалагчтай хамтран хулгайн мод бэлтгэгч болон анчидтай тэмцэж ажилладаг. Сэргээгдэх эрчим хүч- Баазын зарим гадна гэрэлнүүд нарны эрчим хүчээр ажилладаг, баазууд дээр жил бүр мод тарьж арчилж ургуулдаг. 2021 болон 2022 онд Торгоны замын нууц бааз дээр 500 орчим суулгац суулгасан. Инженерийн хялбар шийдлүүд- Гэрүүдийг хавар буулгаж намар дахин барихгүйгээр байнгийн байхаар шийдвэрлэсэн. Мөн баганагүй цомцог гэрүүд нь ашиглалттай зай талбайн хувьд оновчтой. Дотроо 00, шүршүүртэй гэрүүд нь зочинд тав тухтай шийдлүүд болсон. Байнгийн гэрүүдийн дулаан алдалтыг багасгах үүднээс шинэлэг технологиор барьж хар цаасаар бүрсэн.

Хүснэгт №5 Хүрээлэн буй орчны чиглэлээр хийх ажлууд

Орчны тохижилт	Мод тарих, цэцэрлэгжүүлэлт хийх, экологийн нөхөн сэргээлт хийх, зам хязгаарлах, тэмдэгжүүлэлт хийх, орон нутгийн
Сурталчилгаа хийх	Эерэг мэдээлэл, нийгэмд түгэхдээ хурдан
Сургалт зохион байгуулах, хамтран ажиллах	Дотоодын жуулчдыг анхаарах, сургалт зохион байгуулах, аялагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, экотуризмыг дэмжих г.м
Ан амьтдыг хамгаалах	Ан амьтдыг нутагшуулах, агнуурын зөвшөөрлийг хязгаарлах, загасыг хамгаалах, Агнуурын аяллыг хязгаарлах, ТХГН-ыг дэмжиж ажиллах г.м Ан амьтдыг хамгаалах
Нөөцийг зохистой ашиглах	Жуулчны бааз, орон нутагтай нягт хамтран ажиллах нөөцийн үр ашигтай
Гамшгаас сэргийлэх	Гал түймэр гамшгаас хамгаалах төлөвлөгөө гарган ажиллах, сургалт зохион байгуулах
Хог хаягдлыг бууруулж байгаль хамгаалах	Мод тарих, голын эх, загас хамгаалах, газар олголт, ан агнуурыг хязгаарлах, ТХГН-г газар олголтыг зогсоох, хамгаалалтанд авах, цөлжилт, малын тоог хязгаарлах г.м Жуулчны баазын зүгээс орчныг цэвэр байлгаж, нөөцийн хэрэглээг хянах үүднээс замын тэмдэгжүүлэлт хийх, мод тарих, нөхөн сэргээлт хийх зэргээр орчны тохижилтод анхаарах
Хяналт тавих	Эрхзүйн орчныг сайжруулах, сөрөг үйл ажиллагаа явуулж байгаа баазууд одооноос нөхөн сэргээлт хийлгэх, түүх соёлын дурсгалыг хамгаалах г.м
Хөрөнгө оруулалт	Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтарсан хөрөнгө оруулалт хийх, тоног төхөөрөмжөө сайжруулах г.м
Дэд бүтцийг хөгжүүлэх	Зам засах, замын нөхцлийг сайжруулах г.м

Эко сууц нь улс үндэстний зан заншил, уур амьсгал, байгалийн материалын нөөц зэрэгт түшиглэн өөр өөрийн онцлогтой хөгжиж байна. Тиймээс онцлог, шинжүүдийг нэгтгэн тодорхойлох нь учир дутагдалтай юм. Эко сууцны ерөнхий тодорхойлолт нь хүрээлэн буй орчинд бага нөлөө үзүүлэх, ашиглалтын зардал, энергийн бага зарцуулалт, дахин ашиглагдах, байгалийн сэргээгдэх боломжтой материал, байгалийн шавхагдашгүй нөөц ашиглах, хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй байх гэсэн зарчмуудыг баримталдаг бөгөөд доорх шалгуураар шалгадаг байна.

Эко сууцанд тавигдах шаардлагууд:

1. Хямд төсөр үнэтэй
2. Амьдралын явцын өртөг хямд
3. Бүтээмж сайн байх бүхий л зүйлсийг агуулсан байх
4. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
5. Байгальд хор хөнөөлгүй, сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
6. Ая тухтай байх
7. Байгалийн дахин сэргээгдэх эрчим хүч ашиглах
8. Байгалийн хэрэглээний бүтээгдэхүүний хязгаараас давахгүй байх
9. Нийгмийн эдийн засаг болон экологийн зарчмуудад нийцсэн байхаар төлөвлөх зохион байгуулах шаардлагатай байна.

Жуулчны баазын эдэлбэр газар:

Жуулчны баазын эдэлбэр газар нь байгаль орчныг хамгаалах үнэлгээ дүгнэлт гаргуулж, хүрээлэн буй орчин, амьтан, ургамлын аймгийг хамгаалах, ус агаарыг бохирдуулахгүй



Зураг №32 Өвөр Монгол Шилийн голын аймаг,
жуулчны бааз

байх үүрэгтэй бөгөөд эдэлбэр газар нь аялал жуулчлалын зөвшөөрөгдсөн бүс нутагт ажил үйлчилгээ явуулах боломжтой газарт байх ба орчны тохижилтыг жуулчны ая тухтай байдалд нийцүүлэн хийсэн байна. Орчин үеийн аялал жуулчлалын үйлдвэрлэл нь олныг хамрах технологи давамгайлан бөөнөөр байрлуулах зэрэг гэрийн байгальд ээлтэй уламжлалт мөн чанар, зориулалт, тохь тухыг алдагдуулж, улмаар эсгий гэрийн байгалийн цэвэр брендийн ач холбогдлыг сулруулах боллоо.

Жуулчны бааз, амралтын газруудад гэрийг цементэн цутгамал шалан дээр

барих, синтетик эрээн хулдаас дэвсэх, евро стандартын эд хогшил байрлуулах, гэрийг бөөнөөр эгнүүлэх, синтетик гаралтай эд зүйл хэрэглэх, цуулбар унинаас татгалзах, гэр хоорондын зайг хэт шахах зэргээр ашгийн сонирхолд хөтлөгдөж орлогын арга хэрэгслээр ашиглах байна. Жишээ нь Монгол гэрийг шавраар барих, уламжлалт хэв маягийг эвдэж цутгаж барьсан гэрт хоногдосон жуулчид Монголын соёл уламжлалыг мэдрэх мэдрэмж ямар байхыг бодолцоорой.

02

ГЭРИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Шал
2. Хана
3. Хаалга
4. Багана
5. Тооно
6. Унь
7. Өрх
8. Дээвэр
9. Туурга
10. Бүслүүр
11. Хаяавч
12. Гэрийн зайг ашиглах боломж нөхцлүүд
13. Жуулчны баазын гэрийн үйлчлэгчийн ажил үүргийн зааварчилгаа
14. Жуулчны баазын гэрийн үйлчлэгчийн өдөр тутам хийж гүйцэтгэх ажил үүрэг



Монгол гэр нь оньсон аргаар бүтсэн, углуургадаж угсарч барихаар төлөвлөгдсөн учраас гэрийн бүтцэд орох шал, хана, унь, тооно, багана, хаалга, бүрээс, дээвэр, туурга зэрэг нь өөр өөрийн гэсэн үүрэгтэй байдаг.

Монгол гэрийн бүтэц нь дараах 8 зүйлээс бүрддэг. Үүнд:

- Шал
- Хана
- Унь
- Тооно
- Багана
- Хаалга
- Дээвэр
- Туурга



Зураг №33 Монгол Номадик жуулчны баазын жуулчин байрлуулах гэр

2.1

ШАЛ

Монгол гэрийг эрт үеэс зүлэг ногоон дээр шууд барьж шалны оронд малын элдэж боловсруулсан арьс, ширийг дэвсгэр болгон чийгнээс хамгаалан ашигладаг байсан ба харгана, зэгс, өвс, бутлаг ургамал дэвсэж модон шалны эх үүсвэрийг тавьжээ. (Баатархүү, 2016)

Модон шал үүсэхээс өмнө ширдэг дэвсгэр нь хүний хөл хөдөлгөөнд сэмэрч, урагдан үзэмжгүй болж, угааж цэвэрлэхэд бэрхшээлтэй байсан учраас бат бөх, цэвэр үзэмжтэй байлгахад модон шалны нөлөө өндөр байсан. (Баатархүү, 2016)

Мөн хаад ноёдын гэрийг сүйх тэргэн дээр байрлуулан барьдаг байсан ба одоо ч жуулчны баазууд үүнийг ашигласаар ирсэн.

МӨӨРӨН ШАЛ

Мөөрөн шал гэж байх ба тэрхүү шал нь байгальд ээлтэй, гэрт агаар сайн өгдөг, гэр газраас хөндий учраас чийггүй байдгаараа онцлогтой. Маш хүнд учраас суурин газар, чинээлэг айлууд хэрэглэж иржээ.

Модон шалыг тавихдаа шалны дай өө сэв нимгэн зузаан бол шал өндөр нам болж хүн дээгүүр нь явахад дуугарах, хүүхэд тээглэж ойчихоос гадна, дэвсгэр урж цоолдог тул дайг маш тэгш засаж хадна. Модон шал анх бий болохдоо эртнээс дэвсэж ирсэн ширдэг дэвсгэр хүний хөдөлгөөнд сэмэрч урагдах болон угааж цэвэрлэхэд бэрхшээлтэй байснаас шалны хүний хөдөлгөөнд амархан элэгддэг хэсгийг бат бөх байлгах зорилгоор үүд хэсэгт 4-6 банз тавьж модон шалны анхны хэлбэр бий болжээ. Үүнийг «өр шал» гэдэг. (Хишигбаяр, 2009)

Шалыг хөдөлгөөнгүй, төвөггүй байлгахын тулд дайны дотор элс, бууц мэт зөөлөн шороо чигжиж суулгана. Хэрэв дайны дотор шороо чигжээгүйгээс шалаар жавар орж

гэр хүйтэрнэ. Зарим чийглэг уур амьсгалтай газар шалны доор хайрга асгаж гэрт чийг ихдэхээс хамгаалдаг. (Баатархүү, 2016)

Гэрийн модон шалны өнгө нь цагаан, шар, цийлэн ногоон зэргээр гэрт гэгээ орох өнгөөр буддаг. (Баатархүү, 2016)

Одоо үед ихэнх жуулчны баазууд цементээр гэрийн шалыг хийдэг болсон нь чийг татах, хүйтэнг мэдрүүлэх, дулаалгын дэвсгэрийг зузаан дэвсэх шаардлага үүсээд байгаа юм. Иймээс Мөөрөн шалыг ашиглахад уламжлалт хэв маягыг хадгалахаас гадна байгальд ээлтэй гэдгээрээ авч үзэн бусдаасаа ялгарах онцлогыг бүрдүүлдэг.

Мөн модон шалыг ес хувааж хийх бөгөөд 9 -ын тооны билэгдэлтэй уялдуулан хийсэн байдаг. Монголчууд 9-ын тоог өсөж дэвжихийн билэгдэлтэй, оюун ухааны хүч, сэцэн мэргэн оюун бодол, идээ ундааны охь шим, эд баялагийн эрхэм дээдийг бэлэгддэг гэдэг утгаараа гэрийн шал, суурийг 9 хуваан ашигласаар иржээ.

Мөөрөн шалтай гэр



Зураг №34 Мөөрөн шалтай гэрүүд

Орчин үеийн шалны шийдэл



Зураг №35 Орчин үеийн мөөрөн шал

- Гаднаа тав тухтай амарч тухалхад тохиромжтой.
- Газрын хөрсийг талхлахгүй хамгаалах боломжтой.
- Байгалийн үзэмжийг харах боломжтой.
- Байгальдаа уусгасан тохижилтыг хийх боломжтой.

Шалыг арчлах технологи:

Монгол гэрийн шалыг модоор шийдэх нь байгальд ээлтэй, гэрт чийг татахгүй, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хангахаас гадна арчлахад илүү хялбар байдаг.

- Тиймээс гэрийн шалны өнгийг гэрт гэрэл гэгээ оруулах, орон зайн хувьд ашигтай талбай ихтэйгээр харагдуулах өнгөөр будна. /Хүний биед сөрөг нөлөөгүй, тогтоо сайтай, өнгөлөг будаг байна/
- Зуны улиралд шалан дээрээ ямар нэгэн дэвсгэр дэвсэхгүй байна. Өвлийн улиралд шалан дээр дулаалга шаардлагатай учраас тэгш гадаргуу бүхий дэвсгэрүүдийг үзэмтэйгээр дэсвнэ. /Хивс их шороо тоос татаж, цэвэрлэгээ хийхэд хүндрэл учирдаг, хулдаас бороо, цастай үед хальтарч аюулгүй байдал зөрчигддөг сөрөг талтай/
- Шалны дай мод байнга чийгтэй хөрсөнд байдгаас шалтгаалан амархан өмхөрөх магадалтай байдаг учир чийгнээс хамгаалсан будгаар будах, эсвэл нимгэн төмөрөөр төмөрлөх, мөн хөрсөнд хуурай элс дэвсэх хэрэгтэй.
- Шалны суурийг тавихдаа шалаа тэгшэн байхад анхаарах шаардлагатай.
- Шал руу бороо, ус орохоос хамгаалан хаяавч хийх эсвэл шуудуу татах хэрэгтэй.
- Бороо орсоны дараа хаяавчаа сөхөж шалыг хатаах хэрэгтэй.
- Гэрийн модон шалыг цэвэрлэх дараалал:
 - Хог, шороо, тоосыг шүүрдэнэ.
 - Халдваргүйжүүлэлт хийнэ.
 - Чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.
 - Тосон суурьтай, найруулдаг бодисоор өнгөлж арчина. /Тосон суурьтай бодис эдэлгээг удаашруулах, өнгөлөг байлгах үүрэгтэй/
 - Зай завсар, эвдрэл, гэмтэл бүрийг засаж янзална.



Зураг №36 Цементэн шалны халаалттай гэр, Монгол Номадик ЖБ

Шалны халаалтын тохируулгыг гэрийн баруун хатавчинд байрлуулсан байгаа нь:



Зураг №37 Шалны халаалтын тохируулга
/Монгол Номадик/



Зураг №38 Шалны халаалтын тохируулгыг
хөшигөөр хаасан байгаа нь
/Монгол Номадик/


2.2

ХАНА

Монгол гэрийн хана нь гэрийн их биеийг бүтээж тооно унийг тулж ирэх ачааллыг жигд байдлаар өөртөө хүлээн газарт дамжуулах гол үүрэгтэй юм. Нэг хана 32 мод, 144 үдээр ордог ба 3-4 жилийн эдэлгээг даадаг. (Х. Батсайхан Р. Ундрахбаяр, 2015) Монгол гэрийн хэмжээг дөрвөн ханат, таван ханат, зургаан ханат, найман ханат, арван хоёр ханат хэмээн орсон хананы тоогоор хэлж заншжээ. (Музей, 2019)

ГЭРИЙН ХАНЫН ОНЦЛОГ:

1. Тэлж сунаж агшдаг. Хана өндөр, нам болох ихсэж багасах нь хананы толгойн тоотой холбоотой байна.
2. Ханын толгой нэг бүр нь унь бүхнийг тулж дээрээс ирсэн даралтыг толгойноос хананы шийр хүртэл тулна.
3. Гэрийн хэлбэрийг дугуйруулж сайхан болгодог. (Х. Батсайхан Р. Ундрахбаяр, 2015)



Зураг №39 Ханын үдээр



Зураг №40 Ханын толгой




Зураг №41 Ханын ам



Зураг №42 Ханын шийр

Ханын төрөл:

- Хөлт хана
- Шонон хана
- Хатгуур хана
- Сараалжин хана
- Морин хана
- Хонин хана
- Хурган хана гэж ялгадаг.



Зураг №43 Ханын нүд

Ханыг хийхдээ:

- Бургас
- Шинэс,
- Нарс зэрэг материалыг ашиглан хийдэг.


Жуулчны баазуудад олон удаа барьж буулгах шаардлага гардаг учраас “Цуулбар” ханыг сонгох нь эдэлгээ удаан, зөөвөрлөхөд хөнгөн, ширхэгийн дагуу цуулсан учраас хугарч гэмтдэггүй давуу талтай.

Орчин үед ханыг хийхдээ үйлдвэрийн аргаар зүсэж хийж байгаа эдэлгээ муутай, амарч хугарч гэмтдэг.

Ханыг үндэсний онцлогт тохируулан хамгийн сайн хийдэг бүс нутагт Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Булган аймгийн Бугат сумдуудад уламжлалт аргаар цуулбар хана хийж байна.

Бургасан ханыг хийхдээ:

- Бургасаа урьдчилж бэлдэнэ.
- Бэлдсэн бургасаа азарганд оруулж зална. /Азрага гэдэг нь ханын савхан модыг майга болгон хэвэнд оруулдаг багажийг хэлнэ/
- Татуургаар өөг нь авч нэгэн жигд хэмжээтэй болгоно.
- Бөөрөнхий, дөрвөлжин 2 янзаар зорно.
- Дараа нь дотогш нь бөхийлгөн матна.
- Хэдэн толгойтой хана хийхээс шалтгаалан “Багш модоор” хэмжээ авна.
- Бэлтгэсэн моднуудаа хооронд нь тэмээний ширээр нэг үзүүрийг товчлоод нөгөө үзүүрийг ханын нүхэнд оруулан доор нь дэр мод тавиад хөлөөрөө гишгэн дарж сайтар чангална.
- Хутгаараа ширээ нүхлэн, нүхээр нь оруулан товчлон авч ширээ таслана. Энэ нь үдэхэд суналт сайтай бат бөх болдог. (Музей, 2019)



Зураг №44 Хана урлах үйл явц

Ханыг ил харагдахаар байлгахдаа ханын толгой хэсгийг үзэмжтэйгээр хөшгийг татсан байгаа цэвэрхэн, үзэмжтэй харагдана.



Зураг №45 Жуулчны баазын ханын үзэмж

Ханыг арчлах технологи:

Монгол гэрт жуулчид байрлахад тохиромжтойгоор зай багтамжийг бий болгодог гол зүйл нь хана байх ба, оньсон хийцээр бүтсэн нь жуулчдын анхаарлыг ихээхэн татдаг. Тиймээс ашиглах, арчлахдаа дараах зүйлсийг мөрдөнө. Үүнд:

- Гэрийн хана нь байгалийн аргаар хатаасан цуулбар хана байна.
- Ханыг жуулчдад ил харагдах байдлаар гэрээ барина.
- Хананы цаагуур үйлдвэрийн аргаар сайтар боловсруулсан цагаан эсгийгээр бүрнэ. Хананы наагуур дотуур хөшиг татахгүй байх. /Учир нь Монгол гэрийн ханын оньсон хийцийг харуулах, эсгийний үнэр үнэртэйхгүйгээр эсгийг сонгох, гэрийн өнгөлөг байдлыг бодолцон сонгох/

- Ханын үдээрийг муудсан тохиолдолд дахин шинэ үдээрээр үднэ.
- Ханын үдээр суларсан тохиолдолд чангална.
- Хана нь модны ширхэгийн дагуу цуурсан байвал ширээр хөдөлгөөнгүй боож бэхэлгээ хийнэ.
- Ханын мод хугарч гэмтсэн тохиолдолд шинээр сольж хийнэ.
- Ихэнхдээ ханын шийрлэх хэсэг хугардаг талтай учраас зөөж буулгах, барихдаа болгоомжтой хандах шаардлагатай.

Ханын цэвэрлэгээ хийх дараалал:

- Ханыг өдөр тутам болон их цэвэрлэгээгээр цэвэрлэдэг.
- Өдөр тутмын цэвэрлэгээ нь зочны нүдэнд ил хэсэг, өдөр тутам хүрдэг хэсгийг цэвэрлэнэ.
- Долоо хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийх ба ханын далдлагдсан хэсгийг цэвэрлэнэ.
- Чийгтэй алчуураар тоосжилт хийхдээ ханын нүд бүрээр цэвэрлэнэ.
- Тосон суурьтай бодисоор өнгөлнө. /Тосон суурьтай бодис эдэлгээг удаашруулах, өнгөлөг байлгах үүрэгтэй/

2.3

ХААЛГА

Монгол гэрт орох, гарах, салхи, жавар зэргээс хамгаалан үүд хаалга хийх болжээ. Хаалга нь жааз, эсгий үүд, самбар зэргээс бүрдэнэ.

- Тотго
- Дээд бүслүүрийн нүх
- Хаалганы хацар
- Дунд бүслүүрийн нүх
- Хаалганы самбар
- Доод бүслүүрийн нүх
- Босго

Жааз нь хоёр хавтас хатавч, босго, тотгоос бүрдэх бөгөөд өөрөөр хэлбэл ижил хэмжээтэй 2 хос модыг өөр хооронд нь угсарч хийдэг.

Жаазны хоёр хажуу талыг буюу хатавчинд гэрийн баруун зүүн жигүүрийн ханын амыг барьж бөхөлдөг. Эхэндээ жаазандаа алхан хээ, гол нь зоосон хээ ширж чимэглэсэн эсгий үүд голчлон хэрэглэж байсан бол хожим улам боловсронгуй болж (Музей, 2019)



Зураг №46 Гэрийн хаалга
Монгол Номадик ЖБ орчин үеийн
шийдэл

- Жашин хаалга
- Хавтастай хаалга
- Самбаран хаалга
- Далавчин хаалга зэрэг хийц хэлбэр, бүтцийн шинжээс өөр хоорондоо ялгаатай хаалга хэрэглэж байв.



Зураг №48 Тотгоны таван унь /Монгол Номадик/



*Зураг №47
Зургаан яс модтой хар модон
хаалга /Монгол Номадик/*

Монгол гэрийн хаалгыг 4 ба 6 яс модтой гэж ангилдаг.

Тотгоны таван тэнгэр хэмээн хаалганы дээд хэсэгт байх таван унины нүхийг хэлнэ. (Музей, 2019)

“Самбар хаалга” нугасгүй, хаалганы дээд, доод яс модонд нүх гарган углуургадаж тогтоогоод оньсоор тэвхлэн түгждэг, дотогшоо онгойдог хос самбартай байдгаараа онцлог юм.

Хаалга нь тухайн айлын буян хишиг, аз жаргал, сайн сайхныг гаргалгүй хашин тогтоодог хэмээн бэлгэддэг тул босгон /эркэн/ дээр зогсох, гишгих, хаалга алдлах, мэс хүргэх, гарахдаа бүдэрч унахыг хатуу цээрлсээр иржээ. Мөн гэрт орж байгаа хүн баруун хөлөөрөө босго даван эхэлж орох ёстой бөгөөд өр нэхэх, хэрүүл тэмцэл хийх хүн зүүн хөлөөрөө босго даван ордог гэж үздэг.

Энэхүү бэлэгдэл, ёс заншлийг жуулчны баазад ирж байрлаж буй дотоод, гадаадын жуулчдад илүүтэй сурталчилж, ойлгуулан таниулах хэрэгцээ шаардлага үүсч байна. Ялангуяа дотоодын аялагчдын хувьд хүүхдүүддээ энэ уламжлалыг таниулах нь өв уламжлалаа тээн үлдэх бүрэн боломж бүрднэ.

Монгол орны зонхилох салхины чиг нь баруун болон баруун хойноос салхилдаг учраас Монголчууд гэрийн хаалгыг өмнө ба зүүн өмнө зүгт ямар нэгэн тахилгат уул толгодын зүг харуулан барьдаг ба улаан зосон будгаар буддаг заншилтай.



*Зураг №49 Давхар хаалгаатай
Монгол хаалга
/Монгол Номадик/*

Хаалга арчлах технологи:

- Монгол гэрийн үүд хаалга нь бат бөх, аюулгүй хийгдсэн байна.
- Гэрийн хаалгыг тохирсон өнгөөр будсан байх ба хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, тогтоц сайтай будгаар будна.
- Будаг нь хууларсан тохиолдолд өнгө үзэмжийг сайжруулан сэргээж будна.
- Гэрийн хаалга намхан, зайлшгүй бөхийж ордог тул “анхааруулга” санамжийг гадна талын тотгон дээр зочны нүдэнд ил харагдахуйцаар байрлуулна.
- Гэрийн доторх тотгон дээр зөөлөвч хадна.
- Гэрийн хаалганы нугасыг дуу чимээ гаргахгүйгээр тосолсон байна.
- Хаалганы самбар нь өнгө үзэмжтэй, эвдрэл гэмтэлгүй байна.
- Жуулчдын сонирхлыг татахуйц үндэсний онцлог, бэлгэдэл бүхий өвөрмөц хээ, чимэглэл, сийлбэртэй байж болно.

Хаалганы аюулгүй байдал:

- Хаалганы самбарын гадна болон дотор талдаа бариултай байна.
- Хаалганы гадна талын яс модонд цоожны гогцоог бэхэлсэн байна.
- Гаднах цоож нь даруулгатай Монгол цоож байна.
- Хаалганы доторх цоож нь замган түгжээтэй цоож байна.
- Цоож түлхүүрээ өлгөх өлгүүрийг ханын толгойд байрлуулна.
- Хаалганы дотор хавтасанд аваарын гарцын схемийг А5-ын хэмжээтэй өнгөтөөр байрлуулна.
- Бороотой үед хаалгыг хааж бороонд норж гажихаас хамгаална.
- Хаалга эвдэрч, гэмтсэн тохиолдолд дор бүр нь засаж, янзлана.
- Халуун өдөр хаалгыг онгорхой байлгахад бүслүүрт тогтоох тогтоогчыг байрлуулна.
- Хаалганы модыг өргөсгүйгээр сайтар өнгөлж, зүлгэсэн байна.
- Хаалганы унь тогтоох хэсгийн ухлаадас нь жуулчны толгой дээрээс унахгүйгээр сайн тогтоосон байх хэрэгтэй
- Унах магадлалтай унинуудыг хооронд нь холбож байх хэрэгтэй.

Түлхүүрийн оосорт баазын нэр болон номерыг тод харагдацтай тэмдэглэнэ.



Зураг №50 Хаалганы цоож, /Монгол Номадик/




Зураг №50 Дотор замган түгжээ

Аюулгүй байдлыг хангах үүднээс энэхүү түгжээг ашиглана. Түгжих зааврыг баазын гэрийн үйлчлэгч зочдод өгнө.

- Гэрийн дугаарлалт нь гэрэлтэй, зочны нүдэнд ил харагдахуйц газар байрлалтай, том хэмжээтэй байхаар хийвэл тохиромжтой.
- Гэрийн хаалга шилэн байгаа нь орчны байгалийн харагдацыг байгаль цаг уурын ямар ч нөхцөлд харах боломжийг бүрдүүлдэг.
- Арчиж цэвэрлэх ажиллагаа нэмэгдэж байгаа нь шилэн хаалгыг өнгөлөг, тоос, шороо, хурууны хээгүй байлгах шаардлагатай.
- Эдэлгээний хувьд бат бөх, олон жил ашиглахаас гадна, олон зочдын гарын эдэлгээг даана.
- Хаалга нь өөрөөсөө цоожтой байгаа нь тусдаа цоож авч явахгүйгээр зөвхөн түлхүүрээ ашиглах боломжтой, хаалганы түлхүүрийг соронзон карттай болгох боломжтой.
- Хаалга онгойлгосон тохиолдолд хаалганы дотор хэсгийн доод талд тогтоогчийг эвхэгдэж, буудаг зориулалтаар хийсэн байгаа нь салхинд хаалга савхаас сэргийлсэн.
- Довжоо нь хаалганаас илүү их өргөн байгаа нь зочин тухтай зогсох, явах, суух боломжоор хангагдсан.



Зураг №51 Гэрийн номерын харагдах байдал



Зураг №52 Хаалга тогтоогч /Монгол номадик/

Хаалгыг цэвэрлэх дараалал:


- Хаалгын яс мод хэсгийг гадна, доторгүй чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.
- Хаалганы самбар хэсгийг гадна, дотор талуудыг чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.
- Халдваргүйжүүлэлт хийж арчина.
- Хаалганы гадна, дотно бариулыг арчина.

- Хаалганы бариулыг арчиж, халдваргүйжүүлнэ.
- Тосон суурьтай бодисоор яс мод болон хаалганы самбарыг гадна, доторгүй өнгөлнө.
- Зориулалтын алчуураар тоос үлдээхгүйгээр арчина.
- Хаалганд тогтсон хир, толбыг зориулалтын бодисоор арилгана.

2.4

БАГАНА

Монгол гэрийн багана нь гэрийн дээрээс ирэх даралтыг бууруулах, гэр барих, буулгахад тулгуур болох гол хэрэгсэл юм. Мөн гэр барьсаны дараа гэрийн харц эргэхээс хамгаална. Багана нь асан, алхан гэж хоёр янз байдаг. Эрт дээр үед гэрт хус модоор ганц аштай багана /салаа үзүүртэй/ хийж, нүүх, салхи шуургатай үед тулдаг байжээ. Хожим зүймэл тооно хэрэглэх болсоноор алхан хос багана тулах болжээ.



Зураг №52 Ацтай багана / салаа үзүүртэй багана/



Алхан хос баганыг голдуу нарс модоор хийнэ. Багана нь сээр, гол буюу иш, далбаа зэргээс бүрдэнэ. Баганаа гэр толгойгоор оруулж, хөлөөр гаргана. Баган дээгүүр алхах, тэвэрч зогсохыг цээрлэдэг.

Багана арчлах технологи:

Багана нь гэрийн тулгуур учраас бат бөх байдаг ба гэрийн хэрэглэлээс зочны нүдэнд хамгийн ойр байдаг. Тиймээс цэвэрлэгээ арчилгааг байнга хийж байх ёстой.

Зураг №53 Баганын харагдах байдал

Баганы аюулгүй байдал

- Уламжлалт ёс заншлаар тэвэрч зогсохгүй, алдалж зогсохгүй, баганы голоор цай хоол өгөхгүй байна.
- Гэрээ барихдаа баганаа сайн суулгаж, бат бөх, хөдөлгөөнгүйгээр барина.
- Баганыг сууринаас нь хөдөлгөх ямар нэгэн үйлдэл хийж болохгүй.
- Баганын хооронд хувцас хатаагч хэц татаж, савлуур хийж, өлгүүр болгож болохгүй
- Багананд хадаас, шрүф тогтоож болохгүй.
- Багананд цахилгааны утсыг суурилуулж болохгүй.
- Гал түлсэн үед багана халсан байдаг ба түүнд хүрч болохгүй гэдэг санамжийг тавина.



Зураг №53 Баганын харагдах байдал, өнгөний зохицол

Баганыг цэвэрлэх дараалал

- Цэвэрлэгээ хийхийн тулд хувинтай ус, халдваргүйжүүлэгч болон өнгөлгөөний бодис, алчуур, өдөн алчуур зэргийг бэлдсэн байна.
- Чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.
- Өдөн алчуураар нарийн завсартай хэсгээр тоосжилт хийнэ.
- Халдваргүйжүүлэлт хийнэ.
- Тосон суурьтай бодисоор өнгөлгөө хийнэ.
- Багананд өдөр тутмын цэвэрлэгээг ариутгалыг байнга хийж байна.

2.5

ТООНО

Тооно гэдэг бол гэрийн босгосон яс модны ноён орой юм. Монгол гэрийн тооно нь хийц, хэмжээгээр:

- Сархинаг
- Цамхраа
- Хүрдтэй тооно хэмээн ялгахын зэрэгцээ хийх аргаар нь:
 - Матмал
 - Зүймэл гэж хоёр ангилна.

Тооныг хусаар хийхийг эрхэмлэдэг, хусыг газар гэсээгүй хаврын цагт таван бар давхсан өдөр лам хуваргаар уул, усны сан тавиулж, байгаль дэлхийн эзэн сахиусыг аргадан тайвшруулж байгаад авдаг ёстой. (Музей, 2019) Тооно нь орон гэрийн багтаамж ихэсгэх, гэрт байгалийн гэрэлтүүлэг оруулах, утаа уурыг гаргах, унь тогтоох үүрэгтэй. Гэрийн хэмжээ тоононы хэмжээнээс шууд хамаардаг. (Музей, 2019)



Зураг №54 Тооны төрлүүд

Монгол гэрийн тооныг нараар төлөөлүүлэн улаан, улбар шар өнгөөр дүрсэлсэн нь нарны бэлгэдэлтэй холбоотой юм. Тооныг нараар төлөөлүүлэн бэлгэдснээс гэрийн унийг нарны цацраг байдлаар төсөөлөх болжээ. Өөр нэг зүйл бол Монгол гэрийн бүтэц хэсгүүдийг хүний бие эрхтнээр төсөөлөн бэлгэдэх явдал юм.

Тооно нь нарны бэлгэдэл болж байсан бол хүний бие эрхтнээр бэлгэдэхэд толгой, тэргүүнээр төсөөлөн ойлгодог байна. Гэрийн тоонон дээгүүр алхах, гишгэхийг цээрлэдэг нь угтаа тооныг гэрийн толгой тэргүүн буюу хүний тэргүүнтэй холбон үздэгтэй холбоотой юм. Тооноор нар, салхи, цас, бороо, үороо, хурц гэрэл гэгээнээс хамгаалах, нарны гэрэл гэгээг тохируулах үүрэгтэй гэрийн нэгэн зүйл бүрээс бол өрх юм.

Тооны арчилгааны технологи:

Тооно нь Монгол гэрт хамгийн дээр байрладаг тул цэвэр цэмцгэр, гэрэл гэгээтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

Тооны аюулгүй байдал:

- Тооны чагтага ширүүн салхитай үед хүндрүүлэгч зүүдэг ч бэлгэдэлийн үүднээс гал голомтын орой хэсэг гэж үзэн хадаг, арвай уядаг.
- Тооны хүрээ, хөвөө хэсэгт байрлах 4 уяаг унь дагуулан хананд бэхэлдэг нь тооно эргэж гажихаас сэргийлдэг. /тооно гажвал унь тогтворгүй унадаг аюултай./
- Гэрийн дугуй хэлбэрийг хадгална.
- Өрхийг доош цөмөрхөөс хамгаалан, гэрт гэрэл гэгээ, агааржуулалт оруулна.
- Гэрийн температурыг зохицуулна.
- Тоононд тогтоох унины толгой тооны нүх хоорондын муу тохирсон, гэрийн хэв, байршил таарамгүй үед баганыг ашиглах нь илүү тохиромжтой
- Цэвэрлэгээ хийхдээ өндөр шат эсвэл гэр дээрээ гарч цэвэрлэх, мөн сунадаг иштэй тусгайлсан багажаар их цэвэрлэгээний үед ашиглан цэвэрлэнэ.

Цэвэрлэгээ хийх дараалал:

- Цэвэрлэгээ хийх бэлтгэл ажлаа хангана.
- Өндөрт цэвэрлэгээ хийх тул аюулгүй байдлаа ханган шат, эсвэл сунадаг иштэй арчигч бэлдэнэ.
- Чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.

- Тосон суурьтай бодисоор өнгөлгөө хийнэ. /будаг болон хээг удаан хугацаанд тогтоцтой, өнгөлөг байлгахад гол үүрэг гүйцэтгэнэ./
- Тооныг их цэвэрлэгээний хуваарьт оруулан цэвэрлэдэг.
- Тооны чамга нь салхи шуурганаас хамгаалах хүндрүүлэгчийн үүргийг гүйцэтгэнэ



Зураг №55 Тооны цэвэрлэгээг гэр дээр гарч хийж байгаа нь



Зураг №56 Тооны чамга, Монгол Номадик

Гэрийн салхивчыг онгойлгох

- Салхивчыг онгойлгохдоо тоонд байрлах бариулаас барьж дээш өргөн зориулалтын ховилонд хийж тогтооно.
- Тогтоогч ховил нь бага, дунд, их хэмжээтэй онгойж болохуйцаар зориулагдсан байна.
- Бариул нь мөн хүндрүүлэгчтэй байна.
- Бариул нь модон байх ба гарын алганд багтсан, мөлгөр байна.




Зураг №57 Салхивч онгойлгох шийдлүүд



Зураг №58 Салхивч онгойсон байгаа нь гэрийн гаднаас харагдах харагдац

- Ариун цэврийн өрөөтэй том гэрт байрлах салхивч онгойлгох
- Тогтоогчийг баганад тогтоож, мөн хязгаарлагчийг зориулалтын уяанд бэлтгэж болно



Зураг №59 Тоононы салхивч онгойлгох тогтоогчийг суурилуулсан байдал /Монгол номадик/

2.6

МОНГОЛ ГЭРИЙН УНЬ

Монгол гэрийн хэлбэр унины уртаас хамаарна. Өвлийн эхэн сар “Лус унтах” үед буюу хавар бургас дорлох цагт гэрийн хана, унь хийх 5-6 см голчтой цагаан өнгөтэй бургасыг 3 метрээс хэтрэхгүй урттай тайран авч толгойгоор нь багцлан боож, дурслаад сүүдэр газар хатаана. Бургасаа бууцанд булж халаагаад азарганд нэгэн жигд шахан өөг нь авч, тахир гүдгэрийг нь тэгшлэн бөөрөнхийлөн зорж унь хийдэг уламжлалт арга юм. (Музей, 2019)



Зураг №60
Монгол гэрийн унь, унины өнгө



Зураг №61 Унийг азаргалаж буй нь /Унийг уламжлалт аргаар хэлбэрт оруулж буй нь/

- Бургасан унь нь хөнгөн авсаархан, хугарахгүй эдэлгээ удаантай
- Харгай /хар модон/ унь нь догшин, хатуу, хугарахдаа амархан, хүнд тул нүүдэлд тохиромжгүй байдаг.

Унины үзүүрт байх уяаг сагалдрага, солог хэмээн нэрлэж үхрийн хялгасаар сүлжиж хийдэг. (Музей, 2019) Монголчууд гэрийн дотор талд нарны дулаан өнгийг оруулж улбар шар өнгийг сонгосон бөгөөд тоононы улаан өнгөтэй холилдсон нарны гэрлийн хурц өнгийг бууруулах үүднээс унины толгойг ногоон өнгөөр будаж тайвшруулан өнгөний зохицыг бүрдүүлсэн байна.

Унь арчилгааны технологи:

- Чийгтэй алчуураар унины тоосжилт хийнэ.
- Тоосжилт хийхдээ уния нэг нэгээр нь дээрээс доошоо чиглэлтэй арчина.
- Тосон суурьтай бодисоо усанд найруулан зөөлөн алчуураар арчиж өнгөлнө.

Унины аюулгүй байдал

- Тохирсон унийг гэрт өлгөөгүйгээс хаалга хаах доргионд хүний толгой дээр унадаг учраас тохирсон унийг өлгөх
- Хугарч гэмтсэн унийг дор бүр нь засварласан байна.
- Унины хугархай байвал төмрөөр бөгжилнө.
- Унины сагалдрагыг зориулалтын адууны сүүлээр нь томнож хийсэн байх ба аюулгүй байдлыг хангасан байна.
- Унинаас ямар нэгэн зүйл уях, зүүх, хатгахыг хориглоно.
- Унийг бүрэн бүтэн өлгөсөн байна.
- Тоононы чагтагыг бэлгэдэлийг нь бодож 4 ходоодтой, 5 амтай байхаар унингд хавчуулна.
- Салхи шуурганаас хамгаалж хүндрүүлэгчийн үүргийг гүйцэтгэнэ.



Зураг №62 Унины цэвэрхэн үзэмжтэй харагдац



Зураг №63 Хугарсан унийг бөгжилсөн байдал



Зураг №64 Чагтага

Өрх гэдэг нэрийдэл бол айл өрх буй болсноос сая үүссэн юм. Өрх бол ам дөрвөлжин хэлбэртэй бөгөөд 4 өнцөгтөө оосортой монгол гэрийн тооныг бүтээх эсгийний нэр юм. Өрх нь монгол гэрийн бүхий л эд хэрэгслийн дотор хамгийн нандин эд болно. Иймээс тээж буулгахад хөлдоороо хаядаггүй, өмд гуталтай хамт тээдэггүй, утаа тоосыг нь цэвэр газар сэгсэрдэг. Өрхийг тэгш зулагдсан, онгорхой сэмэрхийгүй эсгийгээр хийдэг. Өрхийг тоондоо тааруулж нарийн зээгээр 4 талаар нь эмжиж оёдог. Дөрвөн өнцөгт нь бат бэх оосор хийж, татаж уяхад чанга байхыг эрхэмлэнэ.



Зураг №65 Монгол гэрийн өрх

Өглөө босмогц өрхнийхөө өмнө оосрыг тайлж, зүүн талаар нь явж өрхөө тоононы голтой чацуу болтол татаад, оосроо гэрийн ардаа чанга уяна. Орой унтахдаа мөн зүүн талаар нь өрхөө бүтээж, оосрыг нь чанга уядаг.

Бороо хур ороогүй үед өдөр ер нь өрхөө бүтээх буюу өнцгийг нь урагшлуулдаггүй. Хэрвээ ямар нэгэн айлын хүн хар нас болсон бол заавал өрхний хошуугаа урагш татаж тавьдаг. Гаднаас ирэх хүн үүнийг үзвэл энэ айлд ямар нэгэн хүн нас барсан гэж мэддэг заншилтай. (Хишигбаяр, 2009)



Зураг №66 Монгол гэрийн өрхийг даруулсан байдал

Өрхийг ашиглах технологи

- Бороо ороход өрхийг бүтээж гэрт борооны ус орохоос сэргийлнэ.
- Бороо орсоны дараа өрхийг татаж гэрт агаар оруулан, чийгийг гадагшлуулна.
- Хасах хэмтэй хүйтний улиралд гэрийн дулааныг барих үүднээс өрхийг бага зэрэг урагшлуулж хаадаг. /Халуун янданд хүргэхгүйгээр хаана/

- Цасан болон шороон шуурга шуурахад өрхийг бүтээдэг.
- Хэт халуун үед гэрийн хэмийг жигд барихаар өрхийг бүтээдэг.

Аюулгүй байдал:

- Бороо орсоны дараа өрхийг татахгүйгээр байлгавал гэрт чийг татан, эсгийний үнэр тархснаар модон эдлэлд шингэдэг.
- Яндан халуун байгаа үед өрхийг янданд хүргэж болохгүй.
- Янданд гал алдахаас сэргийлж оч баригч хийнэ.
- Өрхний оосрыг татах, бүтээх үедээ гэрийн бүслүүрт амархан хөвөрч, хурдан тайлагдах уяаны төрлөөр уяна.
- Хэт их салхилснаас болж өрхний оосор тасрах



Зураг №67 Халуун янданг өрхнөөс тусгаарлан аюулгүй байдлыг хангасан байдал



Зураг №68 Янданд оч баригч хийсэн байгаа нь гал алдахаас сэргийлсэн байдал

Өрхний арчилгаа:

- Өрх нь голдуу бор эсгий байдаг бөгөөд өнгө үзэмжийг сайжруулахын тулд гадуур нь цагаан даавуугаар бүрдэг.
- Жилдээ хоёр удаа өрхний бүрээсийг сольж угааж солино.
- Өрхний оосор тасарсан үед бат бөх оёно.
- Өрхний бүрээс урагдсан бол оёж битүүлнэ.
- Өрхний доторх харласан хэсгийг эргүүлж тавьж байх
- Янданд түлэгдэхээс хамгаалсан шатдаггүй материалыг тухайн хэсэгт буюу яндан тулах хэсэгт хийсэн байна.
- Галын аюулгүй байдлыг мөрдөнө.

Хөлтрөг гэдэг бол хөлт өрх гэсэн үг юм. Хөлтрөгийг хийхэд голдуу монгол гэрийн чимэг засал буюу зэрэг хэргэмд зориулдаг байжээ. Хөлтрөг нь 4 хөлтэй бөгөөд 4 хөлний завсарт нь 4 бага хэл (хөл)-тэй. Гэрийнхээ дээврийг тавьж, оосрыг нь уяад дараа нь хөлтрөгөө дээрээс нь нөмөргөдөг байна. Ингэхдээ мөн өрх тавьдагтай адил ар талаас нь нөмөргөнө. Ерийн айл бол олонхдоо эсгий хөлтрөг хийдгээс биш, өнгөт хөлтрөг хийдэггүй. Ван гүн,

ноёдын гэр өргөө бол цөм хөх өнгөт хөлтрөг нөмөргөж, түүнийгээ хөх халзтай өргөө, лам хувилгааны гэр өргөө бол улаан өнгөт хөлтрөг хийж, улаан халзтай өргөө гэдэг. (Хишигбаяр, 2009)



Зураг №69 Монгол гэрийн хөлтрөг Монгол Номадик

2.8

ДЭЭВЭР

Гэрийн дээвэр бол монгол гэрийн дээд биеийн гол бүрээс болно. Энэ нь унины дээр бүрэх бүрээс болох ба ар дээвэр, өмнө дээвэр гэж 2 зүйл байдаг. Ар дээвэр нь 2 хажууд хошоод оосортой, өмнө дээвэр нь харин заамны 2 өнцөгтөө нижгээд оосортой байдаг. Өмнө дээврийн оосрыг ар дээврийн заамаар сүлбэж ар өөдөө гарна. Жишээлбэл, зүүн талын заамны өнцөгний оосор нь баруун хойд арыг дарж, баруун талын оосор нь зүүн арыг дарж уяхаар гарна. Гэрийн ард гараад, 2 талын салаа оосор нь гол оосортойгоо 6 оосор болж ар талыг нь дарж уяна. Ар дээврийн 4 оосор нь өмнө дээврийн дээгүүр дарж, хошоодоор 2 тийшээ дарж уягдана. Ингэхдээ зөвөөр эргэх ёсоор зүүн талын 2 оосор нь дээврийг дарах хэрэгтэй. Мөн үүнтэй адилаар арын оосрыг нар зөвөөр эргүүлж дарж уяна.

Дээврийн зааманд оосор байхаас гадна, дээврийн доод өнцөгт цөм оосортой байх хэрэгтэй. 2 дээвэр нь гэрийн баруун зүүн талд төө хэртэй буюу алга дарам давхцаж уягдана. Ингэхдээ арын дээврийг өмнө дээврийн дээгүүр дарах хэрэгтэй. Арын 6 оосорны дээд гурвалжин зөрүүлгэ дээр өрх таарна.

Монголчуудын олонх нь жил бүр ар дээврээ шинээр хийдэг. Үүнийг гэрээ арлана гэж хэлдэг. Арын дээврээ шинэ эсгийгээр хийвэл хуучин ар дээврийг өмнө дээвэр



Зураг №70 Гэрийн дээвэр /Гүрү жуулчны бааз/

болгодог. Арын нэг дээвэр, 2 туурга, өрх зэргээ шинээр хийвэл гэрээ аралсанд тооцдог заншилтай. Баян айл бол бүгдийг шинээр бүрээсэлдэг ч буй.

Гэрийн бүрээсийг намар сольдог. Учир нь эсгий ноосоо хийж дуусаад өвлийн хүйтнээс өмнө гэрээ дулаалж байгаа учир билээ. Зун болмогц шинэ дээвэр туургаа авч хадгална. Зун бороонд эсгийгээ гамнаж утаашсан хуучин бүрээсээр гэрээ бүрдэг.

Гэрийн дээвэр туургийг арчлах технологи:

Гэрийн дээвэр туурга нь ноосоор хийсэн тул арчлах шаардлагатай.

- Хадгалахдаа цагаан эрвээхэй, хулгана, шавьжнаас хамгаалах үүднээс өндөр газарт хураах, үнэрийг нь гаргах шаардлагатай
- Мөн берзент, гадуур цагаан бүрээсийг жил бүр сольдог байх хэрэгтэй.
- Гэрийн дээвэр туургыг худалдан авахдаа үйлдвэрийн аргаар хийсэн элдэв үнэргүй, цагаан эсгийгээр хийсэнийг сонгох, гар аргаар хийсэнийг сонгохдоо сайн угаагдсан элдэв үнэргүй, сайтар давтаж хийсэн бүрээс, дээвэр, туургийг сонгоно.
- Аль болох бороо, уснаас сэргийлж, норох, чийг татахаас хамгаална.
- Бороо орсоны дараа даруй агааржуулалт хийж гэрийн чийгийг гаргаж илжрэх, үнэр орохоос хамгаална.
- Сэмэрч, урагдсан тохиолдолд эмжиж оёх болон тухайн хэсгийг засаж янзална.



Зураг №71 Гэрийн эсгий дээвэр, туурга /Монгол номадик/

2.9

ТУУРГА

Гэрийн туурга бол хананы бүрээс юм. Туурганд 2 алд илүү, 3 алдын туурга байдаг. Хэтэрхий урт байвал ачиж тээхэд хүнд, барихад нүсэр болдог. Гэрийн их багаар туурганы тоог тогтооно. Бага гэр бол 3 туурга, нилээд том гэр бол 4 туургатай юм. Туурганд дээврийн адил ар өмнө гэж тогтоосон тоо байдаггүй.

Туургыг бүрээслэхэд, хойд талын туургыг заавал гадуур нь бүрж, туурганы амыг мөн хойшоо салхи өөд хандуулдаггүй. Өвлийн улиралд хуучин туургаа давхарлаж бүрдэг ба зуны улиралд зүүн хойд талын ханаа алд хэр газрыг бүрэхгүй тавьж, сул эсгийгээр орхивч хийдэг.



Зураг №72

Эсгий дээвэр, туургийг гэрийн цагаан
бүрээсээр бүрсэн байгаа нь
/Хустай жуулчны бааз/

2.10

БҮСЛҮҮР

Гэрийн бүслүүр гэж ханыг ороож уядаг хошлон дээсийг хэлдэг. Бүслүүрт дотуур бүслүүр гэж байдаг. Бүслүүрийг адууны дэл, сүүлний хялгасаар хийдэг. Гэрийн чээжин хэсгүүд (Тооно, унь, дээвэр)-ийн шахалт, гулзайлт, түүнчлэн тэлэлт, суналтын бүх хүчийг дотуур бүслүүр голлон тойруулж байдаг.



Зураг №73 Монгол гэрийн бүслүүр

Бүслүүрийн арчилгаа:

- Салхи, бороонд суларсан тохиолдолд чангалж байх
- Муудсан бүслүүрийг сольж, шинэчлэх
- Ижил өнгийн зохицсон бүслүүртэй байх
- Хатавчны бүслүүрийг ижил зайтай, үзэмжтэй харагдхаар бүслэх
- Бүслүүрээ жигд тойруулж татах
- Бүслүүргүй тохиолдолд хүндрүүлэгч хийнэ.



Зураг №74 Монгол гэр рестораны шийдэл /Монгол Номадик/

2.11 ГЭРИЙН ХАЯАВЧ

Монгол гэрийн туурганы хормойг нийтэд нь тойруулан дарж битүүлдэг үүрэгтэй. Монгол гэрийн хаяавчийг голдуу эсгий, дэрс, зэгс, модоор хийдэг.



Зураг №75 Гэрийн хаяавч /Монгол Номадик, Алунгоо жуулчны баазууд/

Гэрийн хаяавч арчлах технологи

- Гэрт шороо, борооны ус, шавьж орохоос сэргийлэхээс гадна гэрийн дулаан алдаглаас сэргийлнэ.
- Хавар, намар дулаалгатай хаяавч хийнэ.
- Өвлийн улиралд зузаан хаяавч хийхийн зэрэгцээ хуурай хайргаар манадаг. Энэ нь дулааныг гадагшлуулдаггүй, хүйтний дотогш нэвтэрүүлдэггүй давуу талтай.
- Гэрийн хаяавч урагдаж цоорсон тохиолдолд оёж битүүлнэ.

- Гэрийн хаявчийг чийг даадаг шороогоор манадаггүй.
- Хэврэг материалаар хаявчийг хийдэггүй.
- Гэрийн хаявчийг шуухдаа туурганы хормойг бөгжилж, бүслүүрт дэгээ байрлуулан дэгээндээ туурганы хормойгоо дэгээдэн шууна.



Зураг №75 Гэрийн хаяаг шуусан байдал



Зураг №76 Гэрийн туурганд карма нэмж оён хуурай хайргаар хүндрүүлэгч хийсэн байгаа нь /Монгол Номадик/

Гэрийн буурийг цементэн суурь цутгаж хийж буй хэлбэр нь зөв шийдэл биш боловч нэгэнт хийсэн буйрыг цутгахдаа бороо, уснаас хамгаалсан шийдэлтэйгээр хийх, ус, чийг гадагшлуулах шийдлийг давхар бодолцох хэрэгтэй.



Зураг №77 Гэрийн хаяагаар хайрга татсан чийгнээс хамгаалсан шийдэл



Зураг №78 Цементэн суурьтай гэрийн агааржуулагч



Зураг №79 Гэрийн бууриндаа ус зайлуулагч хоолой суурилуулсан байгаа нь

Гэрийн доторх зохион байгуулалт

Эрэгтэйчүүд гэрийн баруун талаар, эмэгтэйчүүд зүүн талаар суух, зочлох ёсон бий. Иймээс гэрийн дотор зайг эрэгтэйнх, эмэгтэйнх, хоймор тал, гал голомт тулах хэсэг, үүдэн хэсэг гэж таван хэсэгт ангилж зааглах ёс уламжлагдсан ажээ / Монгол улсын угсаатны зүй 1 боть., 176-р талд/

Гэрийн доторх баруун зай нь тэнгэр эрхэмлэх, зүүн тал нь нар эрхэмлэх гэж хувааж байсан заншлаас үүсэлтэй. Гэрийн доторх зайн дотоод зохион байгуулалт нь хүмүүсийн аж байдал, эрхлэх аж ахуйн онцлог шинжээс шалтгаална. Гэрийн доторх зайг гэр ахуйн ба аж ахуйн буюу баруун, зүүн хэсгээр үндсэн хоёр хэсэгт хувааж болно. Гэрийн зүүн хэсэгт гэр ахуйн болон хоол хүнс хадгалах сав суулга тавих, хүний эдэлж хэрэглэх эд юмс, гэрийн баруун хэсэгт аж ахуйн холбогдол бүхий тоног хэрэгсэл байдаг ёсон эртнээс нааш уламжлан ирсэн нь эдүгээ ч хэрэгжсээр байгаа.


Монгол гэрийг жуулчны үйлчилгээнд ашиглаж байрлуулах, хонуулах, хоол, ундааны үйлчилгээ үзүүлэх зэргээр үйлчилгээ явуулж байна.

Монгол гэр нь аль ч үйлчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлж байдгаараа онцлогтой сууц юм.

Монгол гэрийн зохион байгуулалтын гол үүргүүдийг дурьдахад:

- Байрлах, амьдрах сууц
- Сууцыг дулаанаар хангах зуухтай байх
- Унтаж амрах ортой байх
- Цай, хоолоо идэж, тухлан суух ширээ, сандалтай байх
- Зохиомол гэрэлтүүлэгтэй байх
- Хувцас хэрэглэлээ хадгалах шүүгээтэй байх

Монгол гэрийн дотоод зохион байгуулалт



Зураг №80 Жуулчны баазын гэрийн дотоод зохион байгуулалт



Зураг №81 Гэрт байрлуулах орны байрлал

Сууцыг дулаанаар хангах зуухтай байх

- Зуух нь гэрийн голд тоононы харалдаа байрлана
- Зуухны доод суурийг шал ухаж тавих эсвэл шалан дээр төмөрлөсөн суурь тавина.
- Гал түлэх модоо дөрвөлжинд хийж зуухны дэргэд тавина.
- Галын хайч, сэтгүүрийг тависан байна.
- Галын хайчаар галд мод нэмж хийхэд ашиглана
- Сэтгүүр нь үнсийг доош буулгах, зуухны амыг таглахад ашиглана.
- Гал түлэх зааварчилгаа өгөх, нүдэнд ил газар байрлуулсан байна.
- Үнсийг солих журамтай байна.
- Галын аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Зуухны аманд төмөр хутгуур байрлуулна.
- Сайтар зүлгэж, өнгөлж цэвэрлэсэн байна.
- Жуулчны баазад өглөө, орой, бороотой сэрүүн өдрүүдэд гал түлэх шаардлага гардаг тул гэрийн үйлчлэгч зочны гэрүүдийг галлаж өгдөг.
- Жуулчдыг баазад буухаас өмнө аяллын хөтөч, баазад буусаны дараа баазын менежер жуулчдад өөрсдөө гал түлэхгүй байх зааварчилгааг өгнө.
- Гал түлэх захиалгаа аяллын хөтчөөрөө дамжуулан баазын менежерт өгнө.
- Жуулчны байрлахаас өмнө гэрийг галласан байх ба дулаахан өдөр галлах шаардлагагүй.
- Жуулчин байрлаж буй гэрт гэрийн үйлчлэгч орж гал түлэхдээ эхлээд хаалгыг тогшиж зочноос зөвшөөрөл авч галыг түлнэ.
- Гэрийн үйлчлэгч нь гал түлэхэд амар байдлаар модоо сайтар хатаасан байна.
- Гэрийн модны дөрвөлжинг дундарсан даруйд модоор дүүргэж тавина.



Зураг №82 Зуухны харагдах байдал



Зураг №83 Энгийн зуух /Монгол Номадик/



Зураг №84 Сайжруулсан түлшний зуух

Унтаж амрах ортой байх

Монгол гэрт байрлах жуулчдад зориулсан ор нь үндэсний уламжлалт хэв маягыг хадгалсан ор байхаас гадна жуулчдын тав тухад тохируулсан бүтэц, хэмжээ, хэрэглэгдэхүүнтэй байна.

Үндэсний уламжлалт хэв маягыг хадгалсан орны тухайд:

Үндэсний орны бүтэц:

- Суурь нь модон
- Толгой, хөл, ханын хаалттай
- Орны суурины голын тулгууртай
- Модон тавцантай
- Эсгийг даавуугаар бүрсэн байна.
- Эсгийг гудсаа модон тавцан дээр давхарлаж дэвсэнэ.
- Хөнжил, дэрийг гудсан дээрээ дэвсэж тавина.
- Ширмэл эсгийг, элдсэн мал, амьтаны арьсыг тавина.

Үндэсний орны онцлог:

- Зай бага эзлэдэг
- Хөл, толгойндоо шургуулгатай
- Үндэсний хээ угалзаар чимэглэсэн
- Өнгө үзэмжтэй
- Богинохон
- Өндөр
- Хэвтэхэд хатуу
- Хөдөлгөөнтэй



Зураг №84 Монгол хийцийн ор

Жуулчдад зориулсан орыг хэрхэн бэлдэх вэ?



- 1-рт Нэг хүний ор нь 110*200 хэмжээтэй
- 2-рт Хоёр хүний ор нь 150*200 хэмжээтэй
- 3-рт Орны бат бөх, хөнгөн суурьтай
- 4-рт 20-40 см-ын өргөнтэй матрастай
- 5-рт Матрасаа бүрсэн байна
- 6-рт Матрас хамгаалагч дэвссэн
- 7-рт Дэр нь хүний толгойнд ачаалал өгөхгүй, хөлөргөхгүй байна.

8-рт Орны дэвсгэр даавуу, хөнжлийн углаа даавуу, дэрний уут

9-рт Ор нь хөлний хаалтгүй байна.

10-рт Орны өмнө эсгий ширмэл хөлний тавиур тавина.

11-рт Орыг бүтээлгээр бүтээнэ.

Орны хэрэглэгдэхүүний үүрэг, ач холбогдол

- Орны матрас нь зөөлөн, дулаан, тав тух болон аюулгүй байдлыг мэдрүүлэхүйц байна.
- Матрасны бүрээс нь матрасыг нэгэн жигд өнгө үзэмжтэй харагдуулахаас гадна бохирдохоос сэргийлнэ.
- Матрас хамгаалагч нь гудасны үүргийг гүйцэтгэх ба зөөлөн, дулааны мэдрүүлдэг байна.
- Матрас хамгаалагч нь бохирдсон тохиолдолд угаах боломжтой байдаг.
- Орны цагаан хэрэглэл нь цэвэр даавуун материалаар хийгдсэн зөөлөн, дулааныг мэдрүүлэхүйц байна.
- Нэг хүний оронд хоёр дэр тавих ба дэр нь сэрүүцүүлэгчтэй буурцагтай дэр, гуурстай дэр, будаатай дэр, буудайн үртэй дэр, галууны өдөн дэр, нийлэг материалаар хийсэн дэр, харшил үүсгэдэггүй дэр гэх мэт төрөлжүүлсэн, сонголттой байна.

Орыг гэрт байрлуулах зохион байгуулалт

- Жуулчдыг байрлуулах гэрт орыг хоёроос илүүгүй тавихгүй байх
- Гэрийн баруун болон хоймор хэсэгт орыг байрлуулна.
- Гэрийн зүүн хэсэгт ор байрлуулахгүй байх ба галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж галын амны харалдаа ор тавихгүй байна.
- Орыг Монгол гэрт тавих зориулалт нь хананд тулгаж тавина.
- Орны ар хэсэг зайтай байдаг тул гэрт тохирсон орыг хийлгэж тавина.



Зураг №85 Орны зайн төлөвлөлт
/Монгол Номадик/

Орыг засаж, янзлах технологи

- Орны дэвсгэр даавуугаар матрасны толгой хэсгийг, хоёр хажуу хэсгийг, хамгийн сүүлд хөл хэсгийг битүү ороож дэвсэнэ.
- Хөнжлийг даавуундаа углаж онгорхой амыг хөл хэсэгт нь харуулан, хөнжлийг голоор нь нэг нугалан орны хэмжээтэй ижил болгон нугална.
- Дэрийг уутлана.
- Бүтээлгээр хөл хэсгээ битүү бүтээх ба толгой хэсэгт дэрний хэмжээтэй зай үлдээн, хөнжилны хамт эргүүлэн нугалж бүтээнэ.
- Дэрийг хөндлөн байрлалтайгаар босгож тавина.
- Дэрний уутны амыг хана руу харуулна.
- Орны хөл хэсгийн өмнө хивс, хивсэнцэр эсвэл эсгий ширмэл тавина.
- Орны дэргэдэх шүүгээг цэвэрлэнэ.
- Орны дэргэдэх шүүгээн дээр санамж, анхааруулгыг тавина. /Орон дотор тамхи татаж болохгүй, орны цагаан хэрэглээ солиулах санамж, дэрний сонголт бүхий санамж гэх мэт/

Орны бохир хураах технологи

- Бохир орны цагаан хэрэглэлийг дугтуйлж хураана.
- Бохир цагаан хэрэглээ битүү уут болон тэргэнцэрт хийнэ.
- Матрас болон матрас хамгаалагчыг сөхөж завсар нь хог хаягдал, бохирдолын зэргийг тодорхойлно.
- Орны суурь, хүрээг чийгтэй алчуураар арчиж, тоосжилт хийнэ.
- Тосон суурьтай бодисоор орны суурь, хүрээг өнгөлнө.
- Орны матрас, матрас хамгаалагчийг ариутгана.
- Орны доогуурх хогийг шүүрдэж цэвэрлэнэ.
- Цэвэрлэх явцдаа эвдрэл гэмтэл үүссэн эсэхийг давхар шалгана.



Зураг №86 Ор засалт /Монгол Номадик/



Зураг №87 Нэмэлт хөнжлөө хоёр орны голд байрлуулсан байдал /Монгол Номадик/

Цай, хоолоо идэж, тухлан суух ширээ, сандалтай байх



Зураг №88 Монгол гэрт байрлах жуулчны цайны ширээ /Хустай жуулчны бааз/

Гэрт байрлаж буй жуулчдад хоол, цайгаа тавьж идэхээс гадна ажлын ширээ зайлшгүй хэрэгтэй болдог.

- Жуулчны гэрийн тавилгыг үндэсний хийцтэй бол майга ширээ, сандал тавина.
- Сандалыг орны тоогоор тавина.
- Ширээ сандалыг гэрийн зүүн талд байрлуулна.
- Ширээний тавцан дээр хулдаас, бүтээлэг тавихгүй.

Үйлчилгээ: Жуулчин гэрт байрлахаас өмнө гэрийн үйлчлэгч дараах зүйлсийг оруулж тавина. Үүнд:

- Халуун савтай буцалсан ус /жуулчид эм уух,
- Орны тоогоор шаазан аяга, халбага
- Цай, кофе, сахар зэргийг ширээ голлуулан тавина.
- Цайны аяганы дор поднос тавьсан байна.
- Цай, кофены логог зочин руу харуулсан байна.
- Цайны халбагыг аяга тус бүрийн хажууд байрлуулна.

Цэвэрлэх технологи

- Монгол майга ширээ, сандал нь будагтай, хээтэй байдаг тул өнгийг нь алдагдуулахгүй, будгийг тогтоцтой байх талыг баримтлан цэвэрлэнэ.
- Ширээ, сандалд тоосжилт хийнэ.
- Будагтай модон эдлэлийг тосон суурьтай бодисоор өнгөлнө.
- Цайны хэрэглэлийг рестораны гал тогоонд угаана.
- Халуун усны савыг дотор гадаргүй ариутган угааж өнгөлсөн байна.

Зохиомол гэрэлтүүлэгтэй байх

Монгол гэр нь өдөртөө тооноороо байгалийн гэрэлтүүлгийг авдаг бол оройдоо зохиомол гэрэлтүүлгийн хэрэгцээ шаардлага үүсдэг.

- Гэрийн тоонд нэгдсэн гэрэлтүүлгийг байрлуулна.
 - Нэгдсэн гэрэлтүүлэгийг оройн 22:00 цаг хүртэл ашиглана.
 - Ор тус бүр гэрэл унтраалгатай байна.
 - Нэгдсэн унтраалгыг орны дэргэд байрлуулна.
 - Байрлаж буй жуулчдад гэрэлтүүлгийн талаарх мэдээллийг өгнө.
- Мөн зочны ор болгоны ханан хэсэгт гурван төрлөөр асдаг гэрлийг байрлуулна.
 - Зочин бие биеэндээ төвөг учруулахгүй үүднээс ашиглана.
 - Гэрэл ашиглах зааврыг гэрлийн дэргэд байрлуулсан байна.
- Гэрлийн цахилгааны утасны аюулгүй ажиллагааг хангаж далдалсан байна.




Зураг №89 Гэрлийн унтраалгыг орны дэргэд байрлуулсан байгаа нь

Гэрлийн цэвэрлэгээ

- Тоононд өлгөөтэй гэрлийг долоо хоногт нэг удаа цэвэрлэх
- Орны дэргэдэх гэрлийг өдөр бүр цэвэрлэхдээ хуурай алчуураар тоосжилт хийж өнгөлнө.
- Цэвэрлэж байхдаа гэрлийн утасны гэмтэл болон ажиллагааг шалгаж байна.
- Унтраалганы товчлуурыг ариутгаж, халдваргүйжүүлэлт хийнэ.
- Гэрлийн утасны цэвэрлэгээг хийнэ.

Хувцас хэрэглэлээ хадгалах шүүгээтэй байх

- Хувцасны шүүгээг гэрийн баруун хэсэгт байрлуулна
- Шүүгээ нь гэрийн өндрийн хэмжээтэй байна
- Хоёр зочны хувцасыг багтаах багтаамжтай байна
- Урт цув, хувцас өлгөх шийдэлтэй байна.
- Нэг оронд 5 мөр өлгүүр, 3 өмд, юбканы өлгүүртэй байна.
- Чемодан багтаах хэсэгтэй байна.



Зураг №90 Хувцасны өлгүүр



Зураг №91 Монгол гэрт тохирсон хувцасны шүүгээ

Хувцасны шүүгээ цэвэрлэх технологи

- Чийгтэй алчуураар тоосжилт хийнэ.
- Шүүгээний гадна, доторх тоосжилт хийнэ.
- Тосон суурьтай бодисоор өнгөлнө.
- Цэвэрлэх явцдаа шкафын эвдрэл гэмтлийг шалгана.
- Хэрэв эвдрэл гэмтэлтэй бол даруй засаж янзлуулна.

2.13.1 Ерөнхий шаардлага:

- Жуулчны баазын гэрүүдийн цоож, лац шалгах, хэрэв эвдэрсэн тохиолдолд холбогдох хүмүүст мэдэгдэж акт үйлдэнэ.
- Гал усны аюул гарахаас сэргийлж ажиллах ба гал усны аюулд өртсөн тохиолдолд баазын удирдлага болон холбогдох хүмүүст мэдэгдэж акт үйлдэнэ.
- Дүрэмт хувцас хэрэгслийг ажил гүйцэтгэх үедээ байнга хэрэглэж хэвших ба хувцасны халаас болон биедээ иртэй, хурц үзүүртэй зүйл авч явахыг хориглоно.
- Шал шатан дээр асгарсан ус, тосон дээр хальтарч унахаас болгоомжлох хэрэгтэй.
- Хог хаягдлыг шууд гараар түүж цэвэрлэхийг хориглоно.
- Цэвэрлэгээний бодис уусмалтай болгоомжтой харьцах ба зааврын дагуу хэрэглэнэ.
- Цахилгаан, сантехникийн тоног төхөөрөмжтэй зааврын дагуу ажиллах ба эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд холбогдох хүмүүст мэдэгдэж мэргэжлийн хүмүүсээр засуулна.
- Цахилгаан хэрэгсэл болон цахилгааны холболтоос гүйдэлд цохиулахаас болгоомжлох хэрэгтэй.
- Цахилгаан тоног төхөөрөмжийг цэвэрлэхдээ тэжээлээс салгасан байна.
- Механик болон цахилгаан, сантехникийн тоног төхөөрөмжийг өөрөө засварлах буюу задалж угсрахыг хориглоно.
- Ажил эхлэх, дуусах үед бүх тоног төхөөрөмжөө шалгаж цахилгаанаас салгасан байна.
- Өндөрт ажил гүйцэтгэх үедээ унаж бэртэхээс болгоомжлох, зориулалтын шат гишгүүр хэрэглэнэ.
- Ус чийг ихтэй нойтон ажлын байранд ажил гүйцэтгэхээс болгоомжлох хэрэгтэй.
- Ажлын байранд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно. Галын хорыг тогтмол бэлэн байрлуулж хяналт тавина.

2.13.2 Гэрийн цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх багаж хэрэгслүүд:

Цэвэрлэгээний алчуурууд: /Жич: Тоосжилт, цэвэрлэгээ, өнгөлгөө гэсэн 3 төрлийн алчуур тавилга хэрэгслийн гадаргуу тус бүрт байна /

- ✓ Тавилга хэрэгслийг арчих алчуур хэмжээ - 50X50 см,
- ✓ Цонх арчих алчуур - 50X50 см,
- ✓ Шил шаазан эдлэлийн алчуур - 50X50 см,
- ✓ Шалны алчуур - 80X100 см,

Багаж хэрэгсэл:

- ✓ Тоос гөвөгч,
- ✓ Хогийн сав,

- ✓ Хувин,
- ✓ Шүүр,
- ✓ Тэргэнцэр,
- ✓ Цонхны шил арчигч,
- ✓ Ариун цэврийн өрөөний суултуур цэвэрлэх сойз,
- ✓ Хивс угаах сойз.
- ✓ Цэвэр, бохир цагаан хэрэглэлийг тус бүрт нь зөөвөрлөх битүүмжилсэн уут

2.13.3 Ажлын байранд тавигдах шаардлага

- Гэрийн үйлчлэгч нь ажил эхлэхээс 20 минутын өмнө ирж хувцсаа сольж, хувийн бэлтгэл
- ханган ажлын хувцас ба хамгаалах хэрэгслийг өмсөнө.
- Менежерээс цэвэрлэх гэрийн талаарх мэдээллийг авна.
- Мэдээний дагуу тэргэнцэр болон сагсыг ажилд бэлтгэнэ. Үүнд:
- Угаалгын цехээс цагаан хэрэглэл, алчууруудыг тоо ширхэгийн дагуу хүлээн авах
- Цэвэрлэгээнд шаардлагатай бодис, материалуудыг бэлтгэх
- Нэг удаагийн (оо сойз, сам, саван г.м) хэрэгсэл, зар сурталчилгааны материалыг авах
- Цэвэрлэх гэрийн түлхүүрийг авах.

Хориглох

- Ажлын байранд тамхи татах, хооллох, согтууруулах ундаа хэрэглэх, газар суух, гал гаргах, бохь зажлах, чанга дуу чимээ гаргах, зочинтой хэт найрсаг хандахыг хориглоно.
- Өөрийн хүчнээс хэтэрсэн элдэв зүйлийг өргөх, үүрэх зэрэг хэт ачааллаас болж учрах гэмтлээс болгоомжилно.
- Ажлын байр талбай, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөө, ямагт цэвэр байлгана.
- Хөдөлмөрийн туслах багаж хэрэгслийг зөв хэрэглэх, ялангуяа үзүүр, ирмэгтэй зүйлтэй болгоомжтой харьцах.

Цэвэрлэгээний бодисыг ашиглах зааварчлага:

- 1-рт. Цэвэрлэх гадаргууг 35%-ын чийгшилтэй алчуураар тавилга хэрэгсэлийн гадаргуунд тоосжилт хийх
- 2-рт. Гэрийн тавилга хэрэгсэл нь будагтай болон лакадсан модон эдлэл байдаг учраа тосон суурьтай бодис ашиглана.
- 3-рт. Ашиглахдаа бодисоо 3 литр хүйтэн усанд 30 мл бодисыг тагаар нь хэмжиж найруулна.
- 4-рт. Найруулсан усандаа зөөлөн алчуураа хийж 35%-ын чийгшилтэй мушигаж тавилга хэрэгсэлийн ширхэгийн дагуу өнгөлнө.

Өнгөлөгч бодис хэрэглэхэд тавигдах шаардлага:

- Өнгөлөгчийг заавал гадаргууг цэвэрлэсний дараа хэрэглэнэ,
- Өнгөлөгчийг нормын дагуу хэрэглэх, хэт ихээр хэрэглэвэл гадаргуунд муу нөлөөтэй,
- Өнгөлөгч нь хамгийн сүүлийн цэвэрлэгээний үе шат юм.
- Өнгөлөгч бодис нь шингэн, зуурмаг, тосон буюу усан, тосон, спиртэн суурьтай гэж ангилагдана.
- Спиртэн суурьтай өнгөлөгч бодисоор металл эдлэл, толь, цонх, шилэн гадаргууг мөн лааны тос болсон гадарга, будагтай мод, лакадсан ба пааландсан, металл, арьс арьсан эдлэл, шалны хулдаасыг өнгөлнө.
- Тосон суурьтай өнгөлөгч бодисоор толбо, лааны тос болсон гадарга, будагтай мод, лакадсан ба пааландсан металл, арьс арьсан эдлэл, шалны хулдаас мөн тос ба давирхайн толботой синтетик материалыг өнгөлнө.
- Усан суурьтай өнгөлөгч бодисоор шалыг өнгөлнө.

2.14

ЖУУЛЧНЫ БААЗЫН ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧИЙН ӨДӨР ТУТАМ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

Хүснэгт №6 Үүрэг, хариуцлага

Үүрэг	Ажилбар /даалгавар/
Хувийн бэлтгэл хангах	<ul style="list-style-type: none"> • Хувийн ариун цэврийг сахих, усанд орох • Дүрэмт хувцсыг иж бүрдлийн дагуу цэвэр, үзэмжтэй өмсөх • Үсийг ажилд саад болохооргүй боож цэгцэлсэн байх • Гадаад төрхийг зөв зохистой бүрдүүлсэн байх • Гэрийн мэдээний дагуу тэргэнцэр болон сагсыг ажилд бэлтгэх, Гэрийн түлхүүрүүдийг менежерээс хүлээн авах • Ажлын байрны хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчлагыг мөрдөж ажиллах • Ажлын байрыг зөв зохион байгуулах • Тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг ажилд бэлтгэх /угсрах, шалгах/
Зочин ирэхийн өмнөх үеийн ерөөний цэвэрлэгээ хийх	<ul style="list-style-type: none"> • Гэрийн хаалгыг /Housekeeping/ хэмээн 3 удаа тогших • Гэрт цэвэрлэгээ хийхдээ цагийн зүүний дагуу нар зөв тойрох маягаар цэвэрлэгээг хийж гүйцэтгэнэ. • Гэрийн тавилга хэрэгсэлд хөнгөн тоосжилт хийх • Нэг удаагийн хэрэгсэл, зочны алчууруудыг шалгах • Мэдээллийн хавтасны иж бүрдлийг шалгах • Гэрийн санамж, тэмдэг тэмдэглэгээг шалгах • Ариун цэврийн өрөөнд хөнгөн тоосжилт хийхдээ нэг удаагийн хэрэгсэлийн нөхөлтийг шалгана • Гал түлэх модыг хуурай байгаа мөн дүүрэн байгааг шалгах • Ариун цэврийн өрөө болон гэрээс гарахдаа гаргасан хөлний мөрийг алчуураар арчиж гарна • Гэрийг шалгаж менежрт хүлээлгэн өгсөний дараа зочин тосоход бэлдэх • Гэрт захиалсан халуун усыг бэлдэх

<p>Зочин байрлаж байх үеийн цэвэрлэгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрийн хаалгыг /Housekeeping/ хэмээн 3 удаа тогших • Зочин гэрт орох зөвшөөрөл өгсний дараа гэрт орох • Цэвэрлэгээний сагсыг гэрт хогийн савны хэсэгт байрлуулах • Агааржуулалт хийх буюу хаалга онгойлгох, хаяавч сөхөх гэх мэт / жич: зочноос асууж, зочин зөвшөөрвөл/ • Тавилга, эд хогшлын эвдрэл гэмтлийг шалгах • Зочны орыг засах • Том хог хаягдлыг түүх • Ариун цэврийн өрөөг цэвэрлэх • Тоос соруулах • Зочны алчуур, нэг удаагийн хэрэгслийг тавих • Зочны хүсэлтийн дагуу шаардлагатай эд зүйлсийг олгох • Мэдээллийн хавтасны иж бүрдлийг шалгах • Өрөөний санамж, тэмдэг тэмдэглэгээг шалгах • Зочны гэрээс бохир хог хаягдлыг хар өнгийн уутанд хийж авч гарах • Бохир алчуур болон цагаан хэрэглэлийг бохирын уутанд хийж авч гарах • Гал түлэх модыг дүүргэж тавих ба шалгах • Гэрээс гарахдаа зочинд өдрийг сайхан өнгөрүүлээрэй хэмээн хэлэх гэх мэт
<p>Зочин гарсны дараах үеийн цэвэрлэгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> • Менежер зочноос гэр хүлээн авсаны дараа гэрийн түлхүүрийг хүлээн авна • Гэрт орох, сагсыг байрлуулах • Агааржуулалт хийх /хаалга, салхивч, хаяавчыг нээнэ/ • Тавилга, эд хогшлын эвдрэл гэмтлийг шалган засах • Зочны хаясан гэсэн зүйлийг битүүмжлэн хүлээлгэн өгөх • Зочны орыг засах, матрасын ариутгал хийх • Том хог хаягдлыг түүх • Ариун цэврийн өрөөг цэвэрлэх • Тоос соруулах, шаардлагатай тохиолдолд хивс, эсгийг угаах • Алчуур, нэг удаагийн хэрэгслийг тавих • Мэдээллийн хавтасны иж бүрдлийг нөхөх • Цэвэрлэж дууссан гэрийг менежерээр шалгуулан, түлхүүрийг хүлээлгэн өгөх • Тухайн өдрийн гэрийн цэвэрлэгээний ажил дууссан бол угаалгын цехийн ажилд туслах болон гадаа талбайн явган хүний замын хогийг цэвэрлэх, гэрийн хэрэглэлийн уранхай, цоорхой зүйлсийг нөхөж оёх гэх мэт шаардлагатай ажлуудыг хийх
<p>Улирлын болон жилийн графикт их цэвэрлэгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> • Тавилга хэрэгслийн байршлыг солих /орны матрасыг эргүүлэх, иж бүрэн цэвэрлэгээ, өнгөлгөө хийх/ • Тоононы салхивч, хаалга, унь, ханыг угаах • Хивс, хивсэнцэр, эсгийг угаах • Матрасын тоосыг соруулах, угааж, ариутгах • Хөшиг, цаваг угаах

<p>Ажлын гүйцэтгэлийг хянах</p>	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан хэрэгслийн зааварчилгааны дагуу аюулгүй байдлыг хангаж ажиллах • Ажлын байрыг хуваарийн дагуу зөв зохион байгуулж ажиллах • Цэвэрлэгээний бодисыг зааврын дагуу зарцуулах • Гэрийн тавилга хэрэгслийг цэвэрлэгээний технологийн дагуу хийх • Зочид болон хамт олонтойгоо эелдэг зөв харьцах • Гадаад хэл дээр зочдод мэдээ мэдээлэл түгээх • Ажил гүйцэтгэлийн явцад эд зүйлсд хандах • Зочны гэрт нэмэлтээр олгогдсон эд зүйлс дээр хяналт тавих • Зочдын шаардлагатай эд зүйлсийг хүргэж өгөх • Цэвэрлэсэн гэрийг менежерт мэдэгдэж тэмдэглүүлэх • Менежерээс байнга зочдын санал, хүсэлтийн талаарх мэдээлэлийг цаг тухайд нь авч гүйцэтгэж, эргэж менежерт гүйцэтгэлийн талаар мэдэгдэж байх мөн бусад албад хэсэгтэйгээ уялдаа холбоотой ажиллаж байх
<p>Бүртгэл хөтлөх</p>	<ul style="list-style-type: none"> • Зочин гарсан гэрийг борлуулалтанд бэлдсэн тухай мэдээлэл гаргах • Зочин байрлаж буй гэрт цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн, гал түлсэн тэмдэглэл хөтлөх • Зочин ирэхийн өмнөх үеийн хөнгөн цэвэрлэгээ хийсэн мэдээлэл гаргах • Нэмэлт тооцоотой зочдын тэмдэглэл • Нэг удаагийн хэрэгслийн зарцуулалтын тооцоо хийх • Эд хогшлын эвдрэл гэмтлийн жагсаалт гаргах, тохижилт, засвар хийсэн тэмдэглэл • Цэвэрлэгээний материалын жагсаалтыг гаргах • Тоног, төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг илрүүлэх • Зочны нэмэлт хүсэлт, түүнд үзүүлсэн үйлчилгээ, санал гомдолын тухай • Зочны эд зүйлс орхигдсон болон зочинд олгосон мэдээллийн тэмдэглэл хийх • Зочны гэрийн мэдээллийг дотоод бүртгэлээр хянаж, цаашид авах арга хэмжээг сайжруулж байх
<p>Ажил дуусгах</p>	<ul style="list-style-type: none"> • Цэвэрлэсэн гэрийн тухай мэдээллийн хуудсыг бөглөж менежерт өгөх • Тоос сорогчны хогийг суллаж, гадаргууг сайтар арчиж цэвэрлэж угсрах • Цэвэрлэгээний алчууруудыг зориулалтын бодисоор угааж зайлаад дэлгэж хатаах • Багаж хэрэгслийг цэвэрлэж зориулалтын тавиурт өрж байрлуулах • Тэргэнцэр болон сагсыг дараа өдрийн ажилд бэлтгэх • Цахилгаан тоног, төхөөрөмжийг цэвэрлэх • Гал түлэх модыг хагалж бэлдэх • Ажлын дүрэмт хувцсыг солих

03

ГЭР БАРИХ БОЛОН БУУЛГАХ

1. Гэр барих болон буулгах
2. Гэрт гарч болзошгүй аюул ослууд болон тэдгээрээс хамгаалах аюулгүй ажиллагаа
3. Галын аюулгүй байдал
4. Хүнсний аюулгүй байдал ба жуулчдын өвчлөл
5. Осол, гэмтэл
6. Жуулчны баазад анхаарах зүйлс
7. Жуулчны баазад зочин угтах үйлчилгээ үзүүлэх



3.1

ГЭР БАРИХ БОЛОН БУУЛГАХ

Өмнө дурдагдсан ёсоор байгалийн олон янз нөхцөлтэй, уур амьсгалын хувьд хатуу ширүүн, тогтворгүй байдлыг Монголчууд нарийн тооцож түүнд тохирсон амьдралын хэв маягийг сонгон амархан барих, хугацаа бага шаардагдах ба ачиж тээхэд авсаархан, үхэр тэрэг, тэмээнд ачихад төвөг багатайгаар шийджээ. Гэр нь араг мод, эсгий бүрээс, оосор бүслүүрээс бүрдэх ба ханхай 5 ханат гэрийн нийт жин 350-500 кг татдаг.

Улирлын онцлогийг харгалзан айл шинэ газар нүүж, урьдчилан товлон тогтсон газартаа гэрээ барьдаг. Газар тогтон, гэр барих цэгийг тодорхойлохыг шав тавих гэх бөгөөд ихэнхдээ хавар, намрын бэлчээрт буухад хэрэглэхээс гадна хаваржаа, өвөлжөөний газар анх сонгоход хэрэглэнэ. Гэрийн хаанаас ч хамаагүй оосор бүслүүрийг тайлах, дээвэр туургыг нь дайралдсан газраасаа авч хуулахгүй. Монгол гэр барих, буулгахад дагаж мөрдөх ёс заншилтай. Гэрийн үүдийг нар мандах зүг харуулан барих ёсон бий энэ нь гэрийн тооноор нарны гэрэл тусах, цаг мэдэх энгийн арга бөгөөд өмнөөс ирэх дайсны халдлага, Монгол оронд зонхилох салхины чигээс шалтгаалан өмнө зүгт харуулан барьдаг.

Гэрийг барихад 2-3 хүн 30-40 минутын дотор барьж буулгах боломжтой нүүдэлчдэд зориулсан хамгийн энгийн орон сууц юм. Монголчууд 4-6 ханатай гэрийг голчлон хэрэглэдэг. (/ Монгол улсын угсаатны зүй 1 боть., 2010) Жуулчны гэр бааз нь үндэсний онцлогтой Монгол гэрээс бүрдэх боловч аялал жуулчлалын үйлчилгээнд зориулан барьж байгуулан, ашиглахад тавих шаардлагыг улсын стандартад тодорхой тусгасан байдаг. Монгол улсын «Жуулчны баазын зэрэглэлд тавих стандарт»-д жуулчны баазыг барьж байгуулж ашиглахдаа юуны өмнө эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу баригдсан барилга байгууламжтай байхыг заасан байдаг.



Барилга байгууламж нь олон нийтийн барилга байгууламж, төлөвлөлт, барилгын норм, дүрэмд заасан шаардлагыг хангасан байх ёстой. Тиймээс жуулчны гэр баазын гэрүүд болон барилга байгууламжийг өрх айлын хэрэглээнээс илүү хэмжээнд анхааран барьж байгуулахыг шаардаж байна гэсэн үг юм. Жуулчны баазын гэрүүд /өрөө/ -ийг жирийн хүн ам оршин суудаг сууцнаас өөрөөр ашигладаг онцлогтой. Өөрөөр хэлбэл жуулчны үйлчилгээнд тохируулан тохижуулах, тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүтцийг олон улсын хүмүүст тохиромжтой хэлбэрээр зохион байгуулдаг.



Гэр барихад өрх эрхэм, буулгах, нүүхэд тооно эрхэмлэгдэх заншилтай. Гэр барихад тооно тулсан, түшсэн, өрх тавьсан хүн хамгийн хүндтэй учраас гэрээ барьсаны дараа тэр хүнийг цайлах ёсон бий. (Жуулчинд сонирхолтойгоор хийж болох) гэрийн тавилга, дотоод зохион байгуулалт нь нүүдлийн аж байдалд тохирсон байдаг.




Гэрийн хэрэгсэл	Дараалал	Гэр барих дарааллын зураг
Шал тавина	<p>Гэрийг шалыг ихэвчлэн модоор хийх бөгөөд шалны хэмжээ нь гэрийн хаяанаас 20-30 см илүү гарсан байх бороо ус орж ирэхгүй байх, хаяаг манах зэрэгт ач холбогдолтой. Шал тавихын өмнө газар сонгож хэвгий биш газарт засна. Дулаан үед шалыг дай модон дээр нь газраас хөндийвтөр тавих бөгөөд энэ нь салхи нэвтэрч, сэрүүн байлгадаг бол хүйтний улиралд хөрсөнд суулгаж, шигтгэх байдлаар байрлуулж дулааныг хадгална.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Газраа цэвэрлэж бэлтгэнэ. • Хайрга, элсээ бэлтгэнэ. • Зурагт заасны дагуу шалаа байрлуулна. 	
Хаалгаар багтахад овор ихтэй зүйлсийг оруулах	<p>Тооно, багана, их оврын зүйлсийг шалны голд оруулж тавина.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Авдар сав оруулж хөлд тээглэхгүйгээр байрлуулна. • Тооно, баганыг оруулж бэлтгэнэ. 	
Хана дугуйлах	<p>Хана дугуйлахдаа ханынхаа элгэн талаар нуруундаа үүрч ирээд боолт уяаг тайлж эвхээтэй ханыг босгож тэнийлгэн шийрээр нь алхуулж, тааруулахдаа ар нуруугаараа үүрч, хоёр гараа сарвайлган тэлж, ханын нүдийг нь дөрвөлжин болгож ханаа холбоно. Хана холбохдоо нохой амаар нийлүүлэхгүй, сайтар чангалж бооно.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Баруун хатавчны ханаас эхлэн нар дугуйлна. • Баруун хатавчны ханыг хаалгатай чашуулна. • Бусад ханын амыг тус бүрт нь нийлүүлж бооно. (Нохой амаар боохгүй) • Хаалга босгож, дотуур хошлон бүслүүр татаж, бэхэлж уяна. • Гэрийн хэлбэрийг тэгш сайхан байлгахын тулд ханыг тэгш дугуйлж ханын толгойг нь холоос харж тааруулна. 	

<p>Хаалга босгох</p>	<p>Монгол гэрийн хаалгыг босгож, ханыг дэлгэн, хатавчны хоногт оруулж үмхүүлэн баруун урд хишгийн зүгээс эхлэн дотуур бүслүүр (хошлон)-ээр хаалганы углуурганаас оруулж, хатавчны ханыг хаалгатай бэхлээд тойруулан зүүн хатавчны хоёр үдээртэй ханыг хаалгатай бэхлэн тогтоохыг хаалга барих гэнэ.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Хаалганы өндөр ханын өндөртэй ижил байхаар ханаа эрсийг гаргана. • Хатавчны ханыг сонгож аваад зүүн хатавчинд авчирч тавина. • Баруун хатавчны хананаас эхэлж угсраад, ханаа тойруулж амлаж бооно. • Тойруулсан ханын баруун урд хатавчны ханыг амаар нь хатавчны хоногт суулгаж хатавч хана хоёрыг хошлонгоор бэхэлж, хошлонгоо нар зөв тойруулаад ханины толгой руу оруулна. • Ам бүхэнд хүрмэгц ханын нүдээр гарган угсарсан амыг даруулж оруулсаар зүүн хатавчны ханыг амаар нь хатавчны хоногт суулган хаалганд бэхлэнэ. • Хошлонгоо зүүн хатавчны углуурганаас оруулж татаад, шилжүүлэхгүйгээр уяж тогтоодог заншилтай. 	 
	<p>Тооноо дээш нь өргөж, унь хатгуулж өлгүүлэхийг тооно өргөх гэнэ. Тооно нь хатгуур тооно, хэлхээ тооно гэсэн хоёр өөр байх бөгөөд өргөж босгох арга нь өөр байдаг. Хатгуур тооно нь далбаат баганатай бол хос баганыг тоонд бэхэлж уяад, баганаар нь тулж босгодог. Харин алхан баганатай бол тооно өргөмөгц хоёр баганаар тулж, оосроор нь тоонд торгоодог. Тооно өргөхдөө гурван гол (үүдний гол, тоононы гол, хойд ханын гол) -ыг чиглүүлж барьдаг. Чиглээд ирмэгц нь тоононы эргүүлгийг татаж бэхлэнэ. Голлосон хатгуур тоонд өмнө хойно, баруун зүүн дөрвөн талаас нь эгцэлж хэд хэдэн унь хатгаж өлгөөд тооно тогтоодог.</p>	

<p>Тооно өргөх</p>	<p>Хэлхээ тооныг ноён хэцээр холбож, цүүдэж чагтлаад унийг нь багцлан барьж өргөдөг. Тоононы гол хэц, тотгоны гол, хойт ханын голыг чиглүүлж өлгөнө. Тоононы хойноос урагш чиглэсэн 3 цамхрааны голыг гэрийн харц гэнэ. Гэрийн харцыг өндөр уулын орой, өндөрлөг газрыг чиглүүлэн барих уламжлал бий.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Тооны өргөхийн тулд эхлээд тооноо, баганатайгаа уяж холбоно. • Уягдаа хөдөлгөөнгүй сайтар бэхэлж уяна. • Тооноо дээш өргөнө. • Тооноо өргөхдөө хүрэхгүй бол араг шээзгий, сандал дээр гарч өргөнө. • Тоононы голыг үүдний голд чиглүүлнэ. • Тоононы эргүүлэг татаж уяна. • Унь өлгөнө. 	
<p>Багана тулах</p>	<p>Тооно орж, гарахаас сэргийлэн баганаар тулж багласныг багана тулах гэнэ. Ацтай баганаар тоононы хүрээний чанх хойд талд голлуулан тулдаг. Алхан баганыг тоононы баруун зүүн талд тулах бөгөөд алхан баганын тархи нь тоононы хүрээний өмнө хойд талд дөрвөн цэг дээр тулдаг тул тооно орно, гарна гэж байхгүй. Чагтан баганыг тоононы голд барьдаг тул чагтан тархи нь тоононы дөрвөн талыг тэгш тулдаг. Далбаат баганыг тоононы баруун, зүүн талд баглаагаар баглан тулах тул тоононы хүрээний баруун, зүүн талыг тулдаг. Далбаат баганыг тоононд багладаг тул тоонотой хамт өргөдөг. Чагтан багана, ацтай багана хоёрыг гэр барьж өрх тавьсны хойно гэрийн эзэн гэртээ орж ирээд тулдаг заншилтай. Алхан баганыг тооно өргөмөгц тулж, оосроор торгоодог.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Тооно, баганаа холбож уяна. • 2 баганаа тоонотойгоо холбоод 2 хүн тэнцвэрийг хадгалж босгоно. • Нэг хүн 2 баганаас барьж гэрийн баганыг тулж унийг өлгөхөд бэлтгэнэ. 	 

	<p>Тойруулсан ханан дотроо тооноо оруулан ганц аштай баганаар өргөж гэрийн баруун, зүүн, хойд талын тотгоны унинаас тус бүр нэгийг өлгөж гэрийн голыг босгоод зүүн, баруун хатавчны хана, хойд хоёр хананы голоос нэг нэг унь өлгөсний дараа 4 талын чагтага оосрыг чангалан гэрийн голыг тогтооно.</p>	
<p>Унь өлгөх</p>	<p>Өргөсөн тоононы углуурганд унь хатгаж, унины шилбийг ханын толгой дээр тавиад, толгойн дотуур талын турнаас сагалдаргалахыг унь өлгөх гэх ба дааган унийг эцгийнхээ гэрээс залж авчирч эгц хойд талын гурван гол чиглэсэн унины зөвтэй талд даагалан уяж тогтоодог.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Тооныг дээш өргөж, баганаар тулж, дөрвөн талаас нь хэд хэдэн унь өлгөж тогтоодог. Тэгээд бүх унийг урьд голоос эхлэн өлгөж дуусдаг. • Унинуудаа тоононд өлгөж дуусаад, тоононоос дөрвөн чагтага дөрвөн тал руу татдаг. • Унийг хаалганы хоёр хажуугаас толгой хөөн зэрэг өлгөнө. 	 
	<p>Дээвэр бол Монгол гэрийн унины дээр бүрэх дээд биеийн бүрээс бөгөөд хэдэн ханатай байсан ар, өвөр дээвэр байдаг. Бөс цавгийг унин дээгүүр нөмөргөөд, дээвэр тавьж униар олиурдаж тааруулахыг цаваг дээвэр тавих гэх ба гэрийн дээвэр ихэвчлэн гурван давхар байдаг. Дээвэр тавихад урьдаар өмнө дээвэр (оосрыг нь дотор нь хийж, тавих дэлгэхэд амархан хэлбэрээр эвхсэн байдаг)-ээ тавина. Дээвэр тавихад дээврийн голоо гэрийн өмнө, хойд хэцтэй голлуулж, тооныг өнгийлгэхгүй, бас тоононы хурууг хазайлгахгүй тоононы хүрээнд дээврийн хоолойг яг сайхан тааруулж тавина. Өмнө дээврээ тавиад дараа нь хойд дээврээрээ өмнө дээврийн ам (дээврийн сум)-ыг даруулж тавина. Өвөл гэр барихад дотор дээврээ тавимагц дараа нь туургаа нөмөргөдөг.</p>	

<p>Цаваг дээвэр тавих</p>	<p>Өвлийн цагт дээврийг урьтаж тавьдгийн учир нь дулааныг бодолцсон ба дээврийг урьтаж тавиад дээврийн хормойг туургаа даруулж барихад туурганы завсраар салхи орохгүй тул дулаан байдаг. Дээврийг урьтаж тавих нь ханын толгой, унины бөгсийг дээврийн хормойгоор дарж туургаа элэгдэж цоорохгүй.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Боож багалсан цавагийг дэлгэж бэлтгэнэ. • Цавагны оосрыг бат бөхийг шалгана. • Цавагаа гэр дээрээ шидэж дэлгэнэ. • Цавагны хоолойн оосрыг уяж бэхлэнэ. • Цавагны хормойн оосрыг уяж бэхлэнэ. 	
<p>Туурга нөмөргөх</p>	<p>Гэрийн ханыг туургаар ороож бүрхэхийг туурга нөмөргөх гэх буюу туурга барих гэж хэлдэг. Гэрийн их багаас хамаарч голчлон 3-4 туурга, туурга нь баруун хатавчны туурга, зүүн хатавчны туурга, хавхаг буюу холбогч туурга гэж ялгагдана. 4 туургатай бол хавхаг туургыг баруун хойд талд барина. Завагтай туурга, морин туурга хоёр янз туурга байх ба завагтай туурга нь ханын толгой дарах хэсэгт 20 см орчим урт нарийхан эсгийг залгаж оёдог. Морин туурга нь туурганы ханын толгой дээгүүр давах хэсэгт танаас гаргахыг хэлнэ. Баруун өмнөх, зүүн өмнөх хоёр туургыг зэрэг барьдаг. Ялангуяа өвлийн гэрийг барихад хоёр туурганы зүүн баруун зайцыг үүдний хүрээний баруун зүүн талтай тааруулж туурганы хормойг газар шүргэх хэмжээгээр барьж, туурганы дээд талаар дээврийн хормойг хоёр туурганы өмнөд хоёр үзүүрийг холбож, хоёр туургаа дэлгэж гэрийн баруун хэц, зүүн хэцийг бага өнгөрүүлсхийн бариад дараа нь заавал зүүн хойд талын туургаа нөмөргөдөг.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Туурга нөмөргөхөд салхин талынх нь туургаар салхин доорх туурганы амыг даруулж нөмөргөдөг. • Туурга нөмөргөхөд хамгийн түрүүнд баруун өмнө туурганаас эхэлнэ. • Туурганы оосрын хувьд дээд хоёр өнцөгт оосор хадах бөгөөд дунд хэсэгт нөгөө туургатай холбож уяна. 	 

<p>Бүслүүр татах</p>	<p>Хаалганы баруун хатавчинд байгаа дээд, дунд, доод гархинаас оосорлон бэхэлж, нар зөв тойруулан татаж, зүүн хатавчинд байгаа горхиноос саарахгүйгээр бэхлэн туухайчилж зангидахыг бүслүүр татах гэнэ. Бүслүүр бол гэрийн хэвийг хамгаалж, ханын гадагш тэлэгдэхийг зогсоож, чангаруулж байдаг. Туурганы доош шилжиж гулгахыг дарж тогтоодог. Бүслүүр татахад хамгийн түрүүнд дунд бүслүүрийг татна. Дараа нь дээд бүслүүрийг, сүүлд доод бүслүүрийг татна.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Тусгайлан эвхэж боосон бүслүүрний уяаг тайлж бэлдэнэ. • Гэрийн баруун хатавчнаас эхлэн нар зөв тойруулж зүүн талын хатавчны гархинд уяна. • 3 бүслүүрийг уясны дараа сайтар татаж хатавчнаас тохой зайд бэлгэдэлтэй уяагаар уяна. 	
<p>Хаяавч татах</p>	<p>Гэрийг тойруулаад зүүн хатавчинд дээд доод хөвөөний зэлээр уяахыг хаяавч татах гэнэ. Хаяавч бүхэн дээд, доод хөвөөндөө татсан зэлтэй, зэлийн оосроор баруун зүүн хатавчинд бэхэлж уядаг. Хаяавчийг дулаан улиралд бороо хур чийг нойтноос туурганы хормойг хамгаалах зорилгоор татна. Хаяавч нь өвлийн улиралд гэр дулаалах зориулалттай.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Гэрийн хаяавчийг баруун талаас эхлэн бэхэлж нар зөв тойруулна. • Өвлийн улиралд бөс хаяавч туурганы хормойд бариад модон хаяавч наагуур нь зайтай тойруулж гадаслана. • Хоёр хаяавчийн завсраар шороо асгаж хаяа манадаг. 	
	<p>Эсгий гэрийг барьж, бүрээслэн оосор хошлонг татсаны дараа өрхийг голоор нь хөндлөн эвхэж, тонон дээр гаргаад, оосор бүчийг нь гэрийн бүслүүрээс татаж, ханын шийрэнд бэхлэхийг өрх тавих гэнэ. Өрхийг тоононы ар дээр тавих, урагшлуулах, хэлтгий хазгай тавихыг цээрлэдэг. Өрх тавихад тэгш тавихыг их эрхэмлэнэ. Зөрүү хэлтгий тавибал гэрийн малгай хазайжээ гэдэг.</p>	

<p>Өрх тавих</p>	<p>Хойд талын оосрын дээд талын оосрыг дунд бүслүүрээс хөвөрхий уяж, орой болохоор өрхөө бүтээнэ. Үүнийг өрх бүтээнэ гэдэг. Өглөө өрхөө татахдаа гэрийн баруун талаар явж нар зөв даллаж татна. Өрхөө бүтээхдээ гэрийн зүүн талаар буцаж нар зөв даллаж бүтээдэг заншилтай. Өрхийг хойноос нь татаж сөхөхийг цээрлэнэ. Өрхийг татах буюу хариулахдаа буруугаар эргэхийг цээрлэдэг. Учир нь монгол заншилд, үхсэн хүний гэрийн өрхийг буруугаар эргүүлж, татуу хариулах ёстой байснаас болжээ.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Өрх тавихад өрхний хоёр өнцгийг тааруулан гурвалжилж эвхэнэ. • Хоёр өнцгийн давхарласан хошуу талын хойд амыг нь хойш нь харуулж, битүү талыг өмнө тал болгож, өрхөө тавина. • Өрхийг хоёр талын оосор хошлонг ээлжлэн татаж тэнцвэрийг олно. <p>Баруун, зүүн, хойд талын оосор бүчийг гэрийн хошлонд уяж гадаслах свэл хүндрүүлэх мод, чулуу тэргүүтнийг зүүнэ. Салхинаас хамгаалан урт дээсийг тоононы голоор дайруулан 2 тал руу нь татаж хүнд чулуу, мод өлгөдөг.</p>	
<p>Уяа зангилаа</p>	<p>Монголчууд бид ахуй амьдралдаа маш олон төрлийн уяа зангилааг ашигладаг ба гэр барихад олон төрлийн зангидах аргыг хэрэглэнэ. Уяа зангилааг зангидах арга ажиллагаагаар нь хэд хэдэн бүлэг болгон хуваана. Энгийн гоёл чимэглэлийн, уран сэтгэмжийн буюу тоглоомын зангилаа гэж ангилна. Уяа зангилааг энгийн бөс бараа төрөл бүрийн утас, дээс, сурнаас эхлэн төмөр, мод хатуу эдээр зангидан дүрс үүсгэнэ. Уяа зангидах урлал нь нэхмэл сүлжмэлээс ялгаатай бөгөөд уяа зангидах урлалыг нэхмэл сүлжмэлтэй хослуулан урлаж бүтээх нь түгээмэл байдаг учираас нэг урлал гэж андуурах нь элбэг байдаг. Монгол гэр 24 оосор бүчтэй.</p> <p>Хойд дээвэр зургаа, өмнө дээвэр дөрөв, 4 туурганы найм, үүдний хоёр, өрхний 4 уяаг хэрэглэнэ.</p> <p>Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Гэрийн оосор бүчийг нар зөв тааруулан уяна. • Уяаг бат бөх чангалж татах 	

Гэрийг буулгахдаа өрхнөөс буулгах ба эхлэн тооноо нүүх зүглүүгээ гаргах бөгөөд хана унь харшуулж дуугаргахыг цээрлэдэг. Гэрийг буулгахдаа гэрийн тавилга, эд хогшлыг гаргаж дуусгаад гэрийн оосор бүслүүрийг тайлж эвхэнэ. Бүх оосор бүслүүрийг тайлсны дараа гэрийн өрхийг хойш гулсуулан авч сэгсрэн гөвөөд түүний оосрыг эвхэн өрхөө захаас нь эхлээд гол руу нь нугалж эвхдэг. Өрхөө авсаны дараагаар урд хойд дээвэр авч дээврийг хоёр талаас гол руу нь хумин нугалж эвхэнэ. Гэрийн дээврээ авч буулгасны дараагаар гэрийн туургыг баруун хатавчнаас эхлэн авч эвхэнэ. Гэрийн бүрээсийг дараалан авч дуусгасны дараа гэрийн модыг буулгаж эхэлнэ. Гэрийн модыг буулгахдаа хаалганы баруун талын унинаас эхлэн авч тоононы голд хэдэн унь үлдээж гэрийн дотор талд нэг хүн тооноо баганадан түшиж байх зуур униа авч дуусгаад тооноо буулгана. Дараа нь гэрийн хошлонг тайлж гэрийн хаалгаа авч гэрийн ханыг баруун хавтаснаас эхэлж эвхэн буулгана. Монгол гэр барих дарааллын урвуу үйлдлээр гэрийг буулгана.

Хүснэгт №8 Гэр буулгах дараалал

Гэр буулгах дараалал	Гэр буулгах дараалал зураг
<p>Өрхийг авах Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Өрхний гурван талын оосор бүчийг тайлна. • Унь гулсуулан хойш татаж сэгсэрнэ. • Оосрыг эвхэн өрхөө захаас эхлээд гол руу нугалж эвхэнэ. • Ачаа хөсөгт ачна. 	
<p>Хошлон бүслүүрийг тайлах Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Гэрийн бүслүүрүүдийг баруун талаас эхлэн тайлна. • Тайлсан бүслүүрээ гогцоолдож эвхэнэ. 	
<p>Гадуур цагаан бүрээсийг хураах Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Гэрийн бүрээсний тоонд уясан уяаг тайлна. • Нимгэн учраас урагдахаас болгоомжилж зөөлөн хураана. • Ачаа бүтээх цаваг бол баруун захаас зүүн захруу хумиж нугалж эвхэнэ. 	

Дээврийг буулгах

Дэс дараалал:

- Амыг даруулж салхины уруу харуулсан байдаг учраас хойд талын дээврийг эхлэн буулгана.
- Дээврийг буулгаад хавсарч эвхээд модон эдлэлүүдийн завсар хийж ачна.
- Өмнө талын дээврийг буулгана.
- Туургыг авахдаа гэрийнхээ баруун урд туургыг гөвдөггүй учиртай.
- Туургаар туурганы хоолой хэсгийг нугалж, хормой талыг нэгэн адил нугалан авч эвхээд туурганы хоёр үзүүр талаас голд нугалан эвхэнэ.



Туургыг авах

Дэс дараалал:

- Туургыг холбож уясан, зангилааг тайлна.
- Баруун талын туурганаас эхлэн хураана.



Дотуур бүрээсийг авах

Дэс дараалал:

- Цаваг уясан уяануудыг тайлах
- Цаваг баруун талаас тойруулан эвхэж авах



Унь буулгах

Дэс дараалал:

- Унинуудыг салгаж эхэлнэ.
- Баруун талын хавтасны унинаас эхлэн буулгана.
- Тооны голын эргүүлэгний унинуудыг үлдээж хураана.
- Буулгахдаа униа бусад зүйлс дээр тавиж хугалахгүйгээр тавих.
- Тооныг унагахгүйн тулд нэг хүн баганадан түших хэрэгтэй.
- Бүх талын унийг хураан авч туурганд бооно.
- Гадна талаар гэрийн бүслүүрээр боож уяна.



Тооныг буулгах

Дэс дараалал:

- Гэрийн тооныг булгахдаа нүүх зүгрүү хандуулан гэрийн дотор юм уу эсвэл гадагш гаргана.
- Баганыг тоононоос салгана.
- Тооныг ачааны хамгийн дээд талд ачна.
- Ердийн хөсгөнд ачих бол эхний ачаанд ачна.



<p>Дотуур хошлонг тайлж авах Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Дотуур хошлонг баруун талаас эхлэн тайлна. • Ханын дундуур оруулсан хошлонг хамаагүй татаж авахгүй. 	
<p>Хаалга ба хананууд салгах Дэс дараалал:</p> <ul style="list-style-type: none"> • Хошлонг тайлах • Хаалгаа салгах • Хана бүрийн боолтыг салган баруун талаас эхлэн эвхэн тус тусын ханын боолтоор боож эвхэнэ. 	

Жуулчны бус улиралд гэрийг хадгалахдаа дараах санамжийг анхаарах нь зүйтэй.

- Гэр болгоноор нь ялгаж хураах, номерлох,
- Унийг нэг гэрийн иж бүрдэл болох тоо хэмжээгээр нь хоёр хэсэг болгон баглаж, хайрцаглах, боох зэргээр хураана,
- Гэрийн яс мод, гэрийн бусад зүйлсийг холихгүй байх,
- Шувуу, хулгана, шавьж орох боломжтой бол сайтар хулдаж, гялгар уут зэргээр ороох,
- Өндөр газарт байрлуулах, чийг авахаас сэргийлэх,
- Дээврийн эсгий, туурга, цагаан бүрээс сайтар хатааж, сэврээж хийх,
- Шороо, тоос орохооргүй хадгалах,
- Гэрийн модыг механик гэмтэлд өртөхөөргүй, хээ чимэглэл, тоноглол гэмтэж эвдрэхээргүй жийрэглэн ачиж, ус чийг, тоос шорооноос хамгаалсан зориулалт бүхий татлага, бүтээлэгтэй бүх төрлийн тээврийн хэрэгслэлээр тээвэрлэх, хадгалах,
- Гэрийн модыг ус чийг, механик гэмтэл, тоос шорооноос хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр хадгална,
- Хаалгыг хураахдаа гэрийн нүүрний хээ чимэглэлийг гэмтээхгүйгээр хураах,
- Сийлбэртэй гэрийг тусад нь чингэлэгт хадгалж, сийлбэр, хээ чимэглэлийг гэмтээхгүйгээр хадгална,

Дулаан алдах зам нь агаар солилцоо буюу гэрт агаар орох, гарах явц бөгөөд гэрийн хаяа, хатавчаар хүйтэн агаар гэрт орж, харин дулаан агаар тооно болон унины сиймхийгээр гадагшилдаг. Агаар солилцоо тодорхой хэмжээнд байх нь гэр доторх нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулж, дотоод агаарыг сэлбэхэд сайн боловч агаар солилцоо хэтэрвэл дулааныг их хэмжээгээр гадагшлуулна. Монгол гэрийн агаар солилцоог ихдүүлэхгүйгээр шаардлагатай хэмжээнд барьж чадвал дулаан хэмнэхэд чухал нөлөө үзүүлэх хэт улаан

туяаны термографийн ажиглалтын үр дүнд Монгол гэрийн дээвэр, ханаар хамгийн их дулаан алдагддаг тиймээс хавар, намрын сэрүүн үед гэрийн дотоод хэм тогтвортой байх нь амьдарч буй хүмүүсийн эрүүл мэндэд эергээр нөлөөлдөг учраас дулаан алдалтыг багасгах, дулааныг хадгалах шаардлагатай.

3.2

ЭРТ ГАРЧ БОЛЗОШГҮЙ АЮУЛ ОСЛУУД БОЛОН ТЭДГЭЭРЭЭС ХАМГААЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

ЖУУЛЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХАНГУУЛАХ

Жуулчдыг жуулчны баазад байрлаж байх үед дараах аюул бэрхшээлүүд дагаж байдаг.

- Хүнсний аюулгүй байдал
- Хулгай дээрэм
- Байгалийн гамшиг / цас, мөндөр, бороо, аянга цахилгаан, шуурга гэх мэт/
- Хортон шавьж / шумуул, шавьж, хар хорхой болон цагаан эрвээхэйн нүүдэл, мэрэгчид/

“Байгалийн үзэсгэлэн бол үйлчилгээний дутагдлыг нөхөж чаддаг”

Аялын үеэр хадан дээрээс жуулчид хальтрах, бие эрхтэнээ гэмтээх, усанд унах, хад чулууны нурангид даруулах зэргээр болгоомжгүй үйл хөдлөл, хөдөлгөөнтэй холбоотой осол гарч болзошгүй байна. Жуулчны баазын орчимд гарч болох байгалийн болзошгүй өөр нэгэн осол нь газар хөдлөл, аянга, борооны үер зэрэг болно. Жуулчны бааз бүр нь өөрсдийн аюулгүй ажиллагаа ба эрүү ахуйг хариуцсан ажилтантай байх ёстой. ХАБЭА-н ажилтан нь өөрийн ажлын байрны тодорхойлолтонд заасны дагуу хөдөлмөр хамгаалал, техника аюулгүйн ажиллагааны болон эмнэлэгийн анхны тусламжийн мэдлэгтэй байх бөгөөд ХАБЭА ажилтан нь ХАБЭА хуйн талаар ажилтнуудад сургах сургалтын төлөвлөгөөтэй, сургалтын хөтөлбөр нь ХАБЭА хуйн салбарт гарч буй дэвшилтэт технологи, хөдөлмөр хамгаалал, ажлын байран дээрх ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэвэр, хөдөлмөрийн зохистой дадал, эрүүл ахуйн зохистой дадал, аюулын дүн шинжилгээ, зочдын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх агуулгуудыг бүрэн багтаасан байна.

Мөн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд болон зочид жуулчдын эрүүл аюулгүй байдалд анхаарал тавих, урьдчилан сэргийлэх, гарцаагүй үүссэн ослын хор, нөлөөллийг бууруулах ажлыг зохион байгуулахад оролцох, мэдээллийн байдлыг эрхэмлэх, тайлагнах сургалт зөвөлгөө өгөх үүрэгтэй байдаг учир нь заавал тусгай бэлтгэгдсэн хүнээр ХАБЭА ажилтанг сонгох хэрэгтэй.

3.3

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Жуулчны баазын байрлал хаана байгаагаас үл шалтгаалан галд өртөх магадлалтай бөгөөд эрсдэл ихтэй, гал нь тамхи, шүдэнз, цахилгааны гэмтэл, гэрийн зуух болон, гал тогооны хэрэгсэл газан плитка, гэрэлтүүлэг, хуурайшилттай үед гадаа хаясан архи, пиво, ундааны шилнээс гарч болно. Мөн ойт хээр, тал хээрийн бүсэд бусдын санаатай болон санаандгүй үйлдлийн үр дүнд гал гарах магадлалтай.

Гал гарсан тохиолдолд ажилтнууд болон жуулчдынхаа аюулгүй байдлыг хамгийн түрүүнд бодолцох гамшгийн үеийн нөөц төлөвлөгөөтэй байхын зэрэгцээ сургалтыг ажилтнууддаа явуулдаг байх хэрэгтэй. Жуулчны баазад гал гарсан тохиолдолд цугларах цэг байх нь тохиромжтой. Жуулчны баазад гал гарсан тохиолдолд гэр хоорондын зай маш чухал. Гэр хоорондын зайг баримталсан байх нь галыг тархаахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Мөн зарим онцгой нөхцөлд хавар намрын хуурайшилтай үед гарч болох түймрийн нөлөөлөлд өртөж болох бөгөөд нөгөө талаар бааз өөрөө ч гэсэн түймэр үүсгэх нөхцөл бүрдүүлж болохыг анхаарах нь зүйтэй юм. Иймд аянгын үйлчлэлийн аюулаас жуулчны бааз, жуулчдыг хамгаалах талаар анхаарч аянга зайлуулагч хийх хэрэгтэй юм. Ялангуяа цахилгааны холболт хэрэглэж байгаа утаснууд зохих аюулгүй ажиллагааны дүрэм журмын шаардлагыг хангахгүй байдлаар хийхийн зэрэгцээ баазын гэрүүдийн хоорондох зайг цахилгаан хэрэгсэлүүдийн угсралт монтаж, галын аюулгүй ажиллагааны холбогдох журмыг бүрэн хангах байдлаар баримтлах хэрэгтэй

Сайн жишээ:

Хустайн БЦГ-ын бааз Төв аймгийн Онцгой байдлын албатай хамтран гамшгийн үеийн сургалтыг зохион байгуулдаг бөгөөд өмнөх жилийн галын хорыг ашиглан гал унтраах сургалтыг баазын ажилтнуудад хийдэг. Бүх гэрт гал унтраах хэрэгсэл тавьж аюулгүй байдлыг хангадаг.



Зураг №92 Гэрт болон гэрийн гадаа галын хор байрлуулсан байдал

Сайн жишээ:

Монгол Номадик жуулчны бааз гэр болгоны янданд цог баригч хамгаалалт хийсэн.

Жуулчны баазад мөрдөгдөх галын аюулгүй байдлын шаардлага

1. Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын барилга байгууламжид галын аюулгүйн таних тэмдэг бүхий аваарын гарц, галын гарцын схемтэй байна.
2. Зочны байр, гэр, гадна талбайн орчинд галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж тавьсан байна.
3. Гал унтраах хэрэгсэл, элстэй байна. Жуулчны баазууд нь гал унтраах төхөөрөмжөөр тоноглогдсон буюу усан хангамж, элстэй сав, галын хор, хүрз тэдгээрийг ашиглах заавар зэргийг ресторан, гэр бусад байгууламжинд заавал байрлуулсан байх шаардлагатай.
4. Тоног төхөөрөмж, цахилгааны монтажийг галын аюулгүйн болон техникийн ашиглалтын дүрмийн дагуу угсарч суурилуулсан байна.
5. Цахилгаан үүсгүүрийн түлш, шатахууныг техникийн дүрмийн дагуу хадгалах бөгөөд байгаль орчныг бохирдуулахгүй байна.
6. Амралтын газрын барилга байгууламжийн хонгил, шатны эргэх хэсэг, олон нийтийн танхим, зочны байрыг галд тэсвэртэй материалаар хийнэ.
7. Амралтын газар, жуулчны бааз, гэр буудал нь аянга газардуулагчтай байна.
8. Мөн шатдаг бодис, материалыг хадгалах, зайлуулах болон тусгай хувцас хэрэглэлийн эмх цэгцийг хангах арга хэмжээг ажилчдадаа ойлгуулсан байх
9. Шатах хог хаягдлыг хураах, хадгалах, зайлуулах шат дамжлага, ажлын тусгай зориулалтын хувцас хадгалах, цэвэрлэх журамтай байх
10. Ил гал хэрэглэх, галтай ажил явуулах журам, тамхи татах цэгтэй байх
11. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажилтан бүрт галын аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгч, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, гал түймэр гарсан үед аврах зам, гарц ашиглан хүмүүсийг аюулгүй газарт шуурхай нүүлгэн шилжүүлэх мэдлэг, чадвар олгох сургалтад хамруулж, дадлагажуулсан байна.
12. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (утаа зайлуулах систем, галын автомат систем, ус хангамж, галаас хамгаалах хаалт, хаалга, г.м)- ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгана.
13. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед гарах аврах зам, гарцын төлөвлөлтийн зургийг харагдахуйц газар байрлуулсан байна.
14. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэлтэй байна.
15. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байршлыг тухайн барилга байгууламжийн төлөвлөлтийн зурагт тусгасан байна.
16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байнга байрлах барилга байгууламжийг гал түймрийн талаар шуурхай мэдээлэх тусгай (гэрлэн, дуут г.м) техник хэрэгслээр тоногдсон байна. Гэрлэн болон дуут дохионы хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд байрлаж байгаа өрөө бүрт, аврах зам, гарцын дагуу хаалга бүрт байрлуулна.

17. Зоорийн болон хагас зоорийн давхрын аврах зам гарц, шатны хонгил, өрөө, хана, таазны гоёл чимэглэл, зар сурталчилгааны тоног төхөөрөмж нь галд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.
18. Эвдрэл гэмтэлтэй шатдаг хийн тоног төхөөрөмж ашиглах, ахуйн зориулалттай хийн тулга болон тосон дэн, дэнлүү, зул, лаа нь унахааргүй суурьтай, доошоо халах бололцоогүй хийштэй байх бөгөөд модон эдлэл зэрэг шатдаг материалаас хажуу тийш 0.2м, доош 0.7м-ээс илүү зайтай байрлуулахыг хориглоно.
19. Шатах хий, шингэнээр (түлшээр) цэнэглэдэг гэр ахуйн хэрэгслийг ашиглахдаа үйлдвэрээс гаргасан аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрдөнө.
20. Жуулчны баазын гэрт хоол хийх, бусад зорилгоор газан плитка, бусад хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
21. Түлшээр цэнэглэх халаагч, гэрэлтүүлэгч хэрэгслийг өөр төрлийн шатах шингэнээр (бензин, спирт г.м) цэнэглэхийг хориглоно.
22. Жуулчны баазын барилга байгууламжийн ойр орчимд хялбар авалцан асах шатамхай шингэн, шахсан болон шингэрүүлсэн хийн савыг хяналтгүйгээр орхих.
23. Технологийн горимыг нь хэмжих хяналтын төхөөрөмж нь салгаатай, эсхүл эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийг ажиллуулах.

Жуулчны баазад доорх цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үед анхаарах зүйлс:

- Хөндийрүүлэг нь гэмтсэн кабель утас хэрэглэх
- Халаалтанд зориулж гар хийцийн халаагуур хэрэглэх
- Цахилгаан халаагуурыг галд тэсвэртэй суурьгүйгээр хэрэглэх, хянах хүнгүйгээр залгаатай удаан хугацаагаар орхих.
- Гэмтэлтэй ризетка залгуур хэрэглэхийг хориглоно

Жуулчны баазын хүчдэлийн кабельд гал гарвал авах арга хэмжээ:

- Гал гарсан кабелийн хүчдэлийг тасална.
- Кабелийн галыг гал унтраагуур, элс, шороо ашиглаж унтраана.
- Уртын дагуу үзлэг хийнэ.
- Тунель суваг дотуур явсан кабелийн галыг унтраахдаа хорт утааны баг, резин шаахай бээлий хэрэглэнэ.
- Жуулчны баазын цахилгааны монтажыг маш сайтар хийх хэрэгтэй.
- Ажлын явцад ашиглагдах цахилгааны монтаж холболтуудыг зөвхөн эрх бүхий мэргэжлийн цахилгаанчнаар хийж гүйцэтгүүлэн тогтмол засвар үйлчилгээг хийлгэж байх шаардлагатай.
- Зөөврийн болон бусад цахилгаан тоног төхөөрөмжүүдийн цахилгааны утас, холболт нь ажлын үеэр гэмтэх нь элбэг. Тиймээс төхөөрөмжийг ашиглахаасаа өмнө шалгах хуудас ашиглан гэмтэл гарсан эсэхийг шалгаж байх нь зүйтэй.
- Зөөврийн болон түр гэрэлтүүлгүүд нь мөн дулааныг үүсгэдэг бөгөөд ялангуяа өндөр эрчимтэй нь гал асах эх үүсвэр болдог.

- Зөөврийн болон түр гэрэлтүүлгийг бүх тохиолдолд шатах тослох материалын ойролцоо байрлуулж болохгүй. Гэрэлтүүлгийг унахаас сэргийлж найдвартай хөл болон тулгуур, тулаас хийсэн байх.

Жуулчны баазын гэр шатахад 5 минут хангалттай байдаг ба салхи ихтэй үед дараагийн гэрт нөлөөлөх магадлалтай. Тиймээс жуулчны баазын ажилчид гал унтраах аргыг мэддэг байхаас гадна зочдын аюулгүй байдлыг хангаж багийн зохион байгуулалтанд орж ажиллах шаардлагатай. Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолын хавсралт ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН ДҮРЭМ -ийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна. Зочдын гэрт болон бусад газруудад аюулгүй байдлаас урьдчилан сэргийлсэн санамж бичиг болон самбаруудыг монгол, англи хэлээр бичиж, байрлуулах

3.4

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЖУУЛЧДЫН ӨВЧЛӨЛ

Жуулчид хаана ч аялсан хоол хүнснээс шалтгаалсан өвчлөлд өртөх магадлалтай байдаг ба усны аюулгүй байдал хамгийн их тулгардаг байна. Өндөр хөгжилтэй улс орноос ирсэн жуулчид, аялын туршлага багатай хүмүүс өвчинд өртөх магадлал ихтэй байдаг. Бактери буюу бичил биетнийг бүрэн гүйцэд устгасан хоол унд идэж хэвшсэн байдаг. Монголчуудын хувьд илүү их дархлаатай байх магадлалтай.

Жуулчин бүр янз бүрийн замаар халдвар авах магадлалтай. Хоол, хүнстэй холбоотой өвчний дийлэнхи нь өвчин үүсгэгч бактерийн гаралтай байдаг. Хоолны хордлогод өртөгсдийн дийлэнх нь хоолны газрын хоолноос хорддог гэсэн баримт бий. Хүнс, хоолны хангамжийн хэлбэрт гарсан өөрчлөлттэй холбоотой.

- Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний тоо, хэмжээ нэмэгдсэн
- Хөдөө аж ахуйн эрчимжсэн аж ахуй
- Олон улсын худалдаа өргөжсөн
- Хүнсний бүтээгдэхүүний хэрэглэгчид хүрэх зам, хугацаа уртассан

Дараах зөвлөмжийг жуулчны баазад хэвшүүлэх хэрэгтэй.

- Жуулчинд зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттай савалсан цэвэр ус өгөх,
- Ус шүүх төхөөрөмжтэй байна.
- Барилга байгууламж нь бохир ус зайлуулах дотор талын систем болон гадна талын шугам сүлжээтэй байна.
- Жимс, жимсгэнэ, нарийн ногоог сайтар угааж хүнсэнд хэрэглэх,
- Зах, дэлгүүрээс аль болох шинэ хүнсний бүтээгдэхүүн худалдан авах, тогтсон бэлтгэн нийлүүлэгчтэй болох,
- Худалдаж авч буй бүтээгдэхүүний шошгон дээр бичсэн үйлдвэрлэсэн он, сар, өдөр болон улсын стандартын дугаар харах,
- Бүтээгдэхүүний сав, баглааны эвдрэл, гэмтэл, битүүмжлэлийг сайн шалгах,

- Тухайн бүтээгдэхүүний орц найрлагыг харах нь хоолны зохицолдлогоонд чухал тиймээс хоол, ундааны зохишлыг бодож үйлчилгээнд гаргах,
- Болсон болон түүхийн хүнсийг тусгаарлан хадгалах
- Хоол хүнсийг бүрэн гүйцэт болгож хэрэглэх
- Хүнстэй харьцах боловсруулах үе шат олшрох тусам хоол, хүнсний бохирдох эрсдэл ихсэж энэ нь эргээд хүний эрүүл мэндийн нэг сөрөг асуудал болдог.
- Зоогийн газарт ойрхон гар угаах төхөөрөмжийг байрлуулах.
- Ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, ариутгалын бодис заавал байлгах.
- Зоогийн газар, гал тоооны өрөөнд ялаа болон бусад хорхой шавьж байлгахгүйн тулд арга хэмжээ авах, цонхыг торлосон байх.

Жуулчны баазууд ундны усыг хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна. Зөөврийн усан хангамжтай тохиолдолд усыг шаардлага хангасан зориулалтын сав (ган, пластмасс, паалантай)-д хадгалж, савыг 7 хоногт 3-аас доошгүй удаа цэвэрлэж ариутгана. Өдөртөө их халдагаас амархан ус муудах эрсдэлтэй байдаг тул хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд нийтийн хоолны газрын эрүүл ахуйн нийтлэг дүрмийг мөрдөж, хоолноос дээж авч бүртгэл хөтөлнө. Амралтын газар, жуулчны бааз, гэр буудал нь хортон шавжийн устгалыг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын зохих норм дүрмийн дагуу хийнэ. Хоол, хүнс гэмтэж муудах, хүний биед хортой нөлөө үзүүлэх хэдэн шалтгаан байдаг. Үүнд:

1. Хоол хүнсийг буруу горимд хадгалах
2. Өвчин үүсгэгч, хор ялгаруулагч бичил биетнээр бохирдох
3. Хүнс боловсруулахад хэрэглэгдэх химийн нэмэлтүүдийн зохист хэмжээ алдагдах
4. Хоол бэлтгэхэд хэрэглэгдэх сав хэрэгслийн бохирдол, дутуу болгосон хүнс хэрэглэх
5. Хоол бэлтгэж буй хүний хувийн ариун цэвэр хангалтгүй байх зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө.

3.5

ОСОЛ ГЭМТЭЛ

Жуулчны баазын ажилчдын хайнга анхаарал халамж сул, гэмтэл бэртэл, аюул осол гарах магадлалтай. Аливаа гэмтэл бэртлийг бууруулах арга зам нь эрсдэлийн үнэлгээ хийх дасгалуудыг бүх гэр баазад хийвэл зохилтой. Нийт баазын ажилтнуудыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх дасгал сургуулилтанд хамруулж эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагатай. Жишээ нь гэрүүдийн хоорон дахь гэрэлтүүлэг, замын тэгш байдал, гадаргын хэвгий, сандал, ширээны ирмэг, өргөс, шалны халтиргаа, гулгаа, зуухны хурц өнцөг, ор, сандалын бүрэн бүтэн байдал зэргийг сайтар шалгана.

Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх тусламжийн хайрцаг байхаас гадна анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чадвартай мэргэжилтэн байх хэрэгтэй.

Жуулчны баазууд үзүүлдэг үндсэн үйлчилгээний нэг морь, тэмээ, сарлаг, цаа унах, каяак, каное завиар аялахдаа болзошгүй гэмтэл бэртэлээс, ослоос урьдчилан сэргийлэх нь чухал.

Жуулчны баазад зочин байрлаж байх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Жуулчны баазын зохион байгуулалт бүхий схем зургийг гэр, өрөө бүрт зочны нүдэнд ил харагдахуйц газар байрлуулах
2. Зочин гэр, өрөөгөө үргэлж түгжиж байхыг сануулах.
3. Зочны гэрт “Толгойгоо болгоомжил” гэсэн бичгийг бичихийн зэрэгцээ хамгаалалт хийж тавих. /Монгол гэрийн хаалга нам учраас тотгонд толгойгоо цохихоос, босгонд бүдрэхээс болгоомжлохыг үргэлж сануулах/
4. Зочны гэр болон өрөөнд байрлах шилэн болон төмөр эдлэлүүд нь хэт хурц эсвэл иртэй үзүүртэй байхгүй байх. Гар хөлөө эсгэхээс болгоомжлох.
5. Гэр, өрөө болон шүршүүрт үргэлж углааш өмсөхийг сануулж тэдгээрийг байршуулах.
6. Гэр болон өрөөндөө архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж, өөрийгөө гэмтээж бэртээхгүй байх.
7. Нэмэлт хөнжил, дэр хамгаалагдсан байж зочин авах үед нурж орж ирэхгүй байх.
8. Зочин шөнийн болон өдрийн цагаар унтаж амрах үедээ гэр, өрөөгөө заавал дотроос нь түгжих.
9. Зочин өөрөө ус буцалгагч хэрэглэх үедээ болгоомжтой хандах.
10. Зочны гэр, өрөөнд тавих ус буцалгагч, аяга таваг зэрэг нь заавал хамгаалалтын суурь тавиуртай байх.
11. Зочин өөрөө гэрт гал түлэхгүй, тамхи татахгүй, ил гал гаргахгүй байх / зөвшөөрөгдсөн газруудад тамхи татах/
12. Цас, бороотой үед хэрэглэх шүхэр, борооны цув зэргийг зочны нүдэнд ил харагдахуйц гэрт болон зоогийн газрын үүдэнд байрлуулах.
13. Зочин өөрийн бие болон ачаа тээшиндээ хууль бус хар тамхи, мансууруулах бодис зэргийг тээвэрлэн жуулчны баазад авчрахгүй, хэрэглэхгүй байх.
14. Зочин өөрийн хэнэггүй хайхрамжгүй зангаасаа болж эд хогшил, ачаа тээшээ харуул хамгаалалтгүй газар мартажгүй, орхихгүй, хаяж гээхгүй байх. Хэрэв ийм тохиолдолд ямар нэгэн асуудал гарч зочинд хохирол учирвал жуулчны баазын зүгээс хариуцлага хүлээхгүй байх.
15. Зочинтой гэр, өрөөг 2 цаг тутамд эргэж тойрч байх.
16. Гэрүүд галлагаатай үед байнга эргэж тойрч байх, цог үсрэхээс болгоомжлох.

Жуулчны баазын ажилтнуудын эрүүл ахуй, болон ажлын байрны аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа

1. Жуулчны баазын ажилтан бүр жилд 2 удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамрагдах.
2. Жуулчны баазын ажилтан бүр өөрийн ажлын байрны ХАБЭА-н стандарт, дүрэм журмыг мэддэг байх түүнийгээ чандлан мөрддөг байх.
3. Жуулчны баазын ажилтан бүр ХАБЭА-н сургалтанд суусан байх, сар бүр баазын ажилтнуудын нэгдсэн сургалтанд хамрагдах.

4. Жуулчны баазын ажилтан бүр өөрийн ажлын байранд хэрэглэгдэх ажлын хувцас хэрэглэлээ бүрэн гүйцэд, дүрмийн дагуу өмсөж хэвших.
5. Жуулчны баазын ажилтан бүр өөрийн ажлын байранд хэрэглэгддэг тоног төхөөрөмжүүдийг зааврын дагуу зөв хэрэглэж хэвших.
6. Жуулчны баазын ажилтан бүр өөрсдийн ажлын байранд гарч болох аюул эрсдлийг мэддэг байж түүнээсээ үргэлж урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны дүрмээ даган мөрддөг байх.
7. Жуулчны баазын ажилтан бүрийн ажлын байранд дахь эмх цэгц, тоосжилт, агааржилт, дуу шуугиан, гэрэлтүүлэг зэрэгт хяналт тавих. Тохь тухыг эрхэмлэх.
8. Ажлын байрны халуун, хүйтэн хэмийг тохируулж, стандартыг мөрдөх.
9. Зочдод шууд үйлчилдэг үйлчилгээний ажилтнууд хэрэв үүрэгт өдрөө бие нь эвгүйрч, халуурах, царай нь цонхийх, таагүй харагдах зэрэг шинж тэмдэгүүд илэрвэл тэр өдөр нь үүрэгт ажлаас нь чөлөөлж, зохих арга хэмжээг авах, асуудлыг шийдвэрлэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх.
10. Ажилтнуудын зорчих хэсгийн эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байх
11. Ажилтнуудын албан тушаалынх нь дагуу иж бүрэн дүрэмт хувцасаар хангасан байх.
12. Цэвэрлэгээний үед бээлийг гартаа өмсөж, хурууны үзүүр бүрийг бээлийндээ нягт углаж, гарын хөдөлгөөн, ажил гүйцэтгэхэд таатай байх.
13. Сард 2 удаа жуулчны баазын ажилтан бүрт ХАБЭА-н зааварчилгаа өгөх.
14. Ажилтнуудын ажлын байрны онцлогоос хамаарч ажилтан тус бүрт өөр өөр зааварчилгаа өгөх учир тэдгээрт бэлдэх.
15. Жуулчны баазын ажилтнуудад өгөх ХАБЭА-н зааварчилгааг дараах дэс дарааллаар өгөх.

Зочдын гэрт болон бусад газруудад аюулгүй байдлаас урьдчилан сэргийлсэн санамж бичиг болон самбаруудыг монгол, англи хэлээр бичиж, байрлуулах

1. Жуулчны баазад байрлуулах таних тэмдэг, заавар зааварчилгаанууд бүгд шөнийн гэрэлтэй эсвэл шөнө гэрэлтдэг материалаар хийгдсэн байх.
2. Жуулчны баазын эзэмшлийн хаашаан дотор зочин явж болох, болохгүй хэсгийг заасан таних тэмдгийг монгол, англи хэл дээр бичин байрлуулах.
3. Зочны гэр, өрөөнүүдэд зочин хэрэглэх эд хэрэгслийн талаарх хэрэглэх заавар зааварчилгаанууд монгол, англи хэл дээр байх.
4. Зочны гэр, өрөө болон шүршүүрт углааш заавал байрлуулах түүнийг хэрэглэж хальтиргаанаас болгоомжлох ёстой гэсэн аюулгүйн зааварчилгаа монгол, англи хэл дээр байх.
5. Цэвэршүүлээгүй түүхий крантны усыг хэрэглэхгүй байх санамж бичгийг монгол, англи хэл дээр бичин шаардлагатай газруудад байрлуулах.
6. Ариун цэврийн өрөөний угаалтуур болон шүршүүрт хувцас угаахгүй байхыг сануулах бичгийг монгол, англи хэл дээр бичин зочинд харагдахуйц газар байрлуулах.
7. Аюул ослын үед цуглах цэг сонгож, зааварчилгаа бүхий самбарыг монгол, англи хэлээр бэлтгэж тавих

Жуулчны баазад мөрдөгдөх галын аюулгүй ажиллагааны мөрдөх дүрэм, журам

1. Жуулчны баазын барилга байгууламж бүр нь галын аюулгүйн таних тэмдэг бүхий аваарын гарц, галын схемтэй байх.
2. Жуулчны баазын галын аюулгүй байдлыг хангах, шалгах хуудастай байх.
3. Зочны байр, гэр гадна талбайн орчинд галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж тавьсан байх.
4. Цахилгаан, сантехникийн тоног төхөөрөмжүүдтэй зааврын дагуу ажиллах ба эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд мэргэжлийн хүмүүсээр засуулах.
5. Цахилгаан тоног төхөөрөмжүүдийг угааж арчих, нүүлгэн хөдөлгөхдөө заавал тэжээлээс салгах.
6. Жуулчны баазын ажилтнууд өөрсдөө дур мэдэн цахилгаан тоног төхөөрөмжүүдийг засахгүй, оношлохгүй байж, монголчлохгүй байх.
7. Ажил эхлэх, дуусах үед салгасан, залгасан эсэхээ нягталж байх.
8. Бороо, цас, чийгтэй үед аль болох цахилгаан тоног төхөөрөмжүүдийг засаж, янзлахаас зайлсхийх.
9. Ажил эхлэх, дуусах үед салгах шаардлагатай цахилгаан тоног төхөөрөмжнүүдээ салгасан эсэхээ сайтар шалгаж байх.
10. Ажлын байранд болон хүлээн зөвшөөрөгдсөнөөс бусад газарт ил гаргах, тамхи татах зэргийг зочдод болон ажилтнуудад хатуу хориглох.
11. Хогийн цэг дээр ил хог шатаах, гал гаргахыг хатуу хориглох.
12. Зочны гэр болон өрөөнүүдэд галын хорыг ашиглах заавартай нь монгол, англи дээр бичин тавих.
13. Сар бүр галын аюулгүй байдлыг хангах үзлэгийг ХАБЭА ажилтан болон жуулчны баазын менежер хоёр хамтран хийж байх.
14. Жуулчны бааз өөрсдийн галын аюулыг эрсдлийн үнэлгээг хийдэг байх.
15. Галын аюулгүй байдалд болзошгүй үед ажиллуулах ажилтнуудаа сард 2 удаа бэлтгэн сургуулилалт хийдэг байх.
16. Галын аюултай үед эхлээд хүүхэд, өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй зочин болон бусад зочид гэсэн дараалалтайгаар жуулчны баазын ажилтан тус бүр аврах ажиллагаанд гар бие оролцох.
17. Жуулчны баазын ажилтан бүр шаардлагатай тохиолдолд галын хорыг ажиллуулж чаддаг байх. Бүгд анхан шатны галын аюулгүй ажиллагааны сургалтанд суусан байх.
18. Гал унтраах усны крант болон ус хаанаас зөөвөрлөх нь төлөвлөгөөтэй байх.
19. Жуулчны баазын галын дохиоллын системийн ажиллаж буй эсэхийг сар бүр шалгах.
20. Тамхи болон утааны дохиолуудын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах.
21. Аюулгүй гарцууд үргэлж бэлэн байдалд байх, агуулах болгон ашиглах, хаалгыг даран хүнд оврын зүйлс хураан тавихгүй байх.
22. Галын гарцны хажууд хорт хий зайлуулах агааржуулалтын системтэй байх.
23. Галын аюулгүй байдал нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөтэй байх.

24. Галын түймэр гарсан тохиолдолд

- Өөрийн аюулгүй байдлыг эхэлж сайтар хангах.
 - Салхины дээд талаас галыг унтраах
 - Галын ойр орчинд өртөж болохуйц зүйлсийг зөөвөрлөн зайчилж галын өдөөлтийг багасгах.
 - Галын дохиоллын систем 24 цагийн хяналттай байх.
 - Хэн нэгэн галд өртвөл гүйх хэрэггүй нааш цааш өнхөрч галын дөлийг унтрааж нүцгэн гараар хүрэлгүй алчуур норгож унтраах.
 - Галын аюултай үед ус байгаа тохиолдолд алчуур, даавуу, цамц зэргийг норгож утаа болон халууны нөлөөнөөс хамгаалахын тулд толгой дээгүүрээ нөмрөх.
25. Эд зүйлс, хүнс, амтериал хадгалах агуулах амархан дөл авалцан асах шингэн, шатах тослох материал галын болон тэсрэх аюултай бусад бодис хадгалахыг хориглох.
26. Гал унтраагуурыг ажиллуулахад дараах зүйлсийг анхаарах
27. Цахилгаан тоног төхөөрөмжийн гал түймрийг нунтаг гал унтраагуураар унтраах үед нунтагийг 3-5 секундын зайтайгаар өгч унтраах.
28. Гал унтраагуурыг шатаж буй цахилгаан тоног төхөөрөмжийн дэргэд 1 м-ээс бага зайд барьж ажиллуулахыг хориглох.
29. Гал унтраагуурын цэнэгийг зөвхөн салхины дээр байрлаж гаргах.
30. Хөлдөхөөс сэргийлэхийн тулд нүүрсхүчлийн хийн гал унтраагуурыг ажиллуулах үед хошуунаас нь нүцгэн гараар барихыг хориглоно. Гар унтраагуурыг ажиллуулахад гарандаа бээлий өмсөх.
31. Хөндий газар гарсан гал түймрийг дээрээс доош нь чиглүүлж унтраах.
32. Гал унтраагуурыг тухайн ангиллын гал түймэрт тохируулж дараах байдлаар хэрэглэх /зураг .../
33. Галын самбар нь галын дотуур ба гадна усан хангамж, гал унтраах автомат системээр тоноглогдоогүй объект дээр гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлийг байрлуулах.
34. Галын самбар дээр байрлуулах гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн их бүрдлийг холбогдох стандарт, нормын дагуу тогтоох.
35. Гал унтраагуур, галын дотуур ба гадна усан хангамж, галын самбарт хүрэх замыг чөлөөтэй байлгах.
36. Жуулчны баазын ажилтан бүр гал унтраагуурын зориулалт, бүтэц, зохион байгуулалт, ажиллах зарчим, ажиллуулах дараалал, хэрэглээ болон бусад гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хадгалах, ашиглах шаардлагыг мэдэх үүрэгтэй.
37. Зайлшгүй тохиолдолд гал унтраах элсний нөөцтэй байх.
38. Жуулчны баазын олон нитийн танхим, зочны гэр өрөөг галд тэсвэртэй материалаар хийх, хамгаалах.
39. Жуулчны бааз нь аянга газардуулагчтай байх.
40. Авралтын зам гарцыг байнга чөлөөтэй байлгах, түүнд аваарын гэрэлтүүлэг тэмдэг, тэмдэглэгээ тавих.
41. Галын аюулгүй байдлаар хангах зорилгоор гал унтраах дараах хэмжээний усны нөөцтэй байх.

- 15 хүртэлх гэртэй, 5 хүртэлх объекттой галд тэсвэрлэлтийн 3 зэрэг, 5 тн устай.
- 5 хүртэлх объекттой, 30 хүртэлх гэртэй галд тэсвэрлэлтийн 3 зэрэг, 10 тн устай.
- 20 хүртэлх объекттой галд тэсвэрлэлтийн 3 зэрэг 10 тонн устай.

Жуулчны бааз байгалийн давагдашгүй хүчин зүйлсүүдтэй тулгарах үед авах арга хэмжээ

1. Жуулчны баазын эргэн тойрон болон баазад газар хөдлөлт болох үед:
2. Хүн бүр тайван байж үймж сандрахгүй байх.
 - Аюулгүй газар хорогдох, нуувч болон хана, багана гэх мэт халхавч болох газруудад нуугдах
 - Жуулчны баазын ажилтан бүр нуугдавч, хорогдох газар зэргийг хаана багйааг яаж нэвтрэх, гарах зэргийг мэдэх.
 - Гэмтэж, бэртсэн болон дарагдсан зочдод түрүүлж эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх, орогнох байр нуугдавч руу зөөж аюулаас хамгаалах.
3. Зочдыг зөв мэдээллээр хангаж, эмх цэгцтэй яарч сандрахгүй байж зөв заавар, зааварчилгаа өгч, удирдах.
4. Зочдыг нүүлгэн шилжүүлэх, аврах ажиллагааг явуулж буй тохиолдолд төлөвлөгөө гаргаж, зочдыг хэсэг бүлэг болгон хуваан нүүлгэн шилжүүлэх.
5. Гэр болон өрөөндөө байрлаж буй зочдод мэдээлэл хүргэх, гэр орон байраа яаралтай орхиж цуглах цэгт очихыг сануулах
6. Гамшгийн үед зочид өөрийн биед зайлшгүй хэрэгтэй бичиг баримт болон овор багатай нэн шаардлагатай зүйлсээ авч явахыг сануулах.
7. Зочдыг нүүлгэн шилжүүлэх буюу авран хамгаалж буй тохиолдолд нэн шаардлагагүй, овор ихтэй эд зүйлсийг авч явахгүй байхыг сануулах.
8. Гамшгийн үед эхлээд зочдыг дараа нь ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх, тусламж үзүүлэх.
9. Салхи, шуурга болон аянга цахилгаантай бороотой үед
 - Цаг агаарын урьдчилсан мэдээг үргэлж шалгаж, ажилтан бүрт урьдчилан мэдээлж байх
 - Цаг агаарын урьдчилсан мэдээний дагуу бэлтгэл ажлуудыг хийх.
 - Шуургатай, салхитай үед бэлтгэл ажлыг хангах, хангуулах.
 - Гэрийн оосор, бүслүүр, хаяавч, өрх зэргийг сайтар татаж, бөхлөх, шалгах.
 - Гэрийн дээвэр туурганд дуу чимээ их гаргадаг гялгар уут хэрэглэхгүй байх.
 - Гэрийн дээвэр туурганд гялгар уут хэрэглэх нь жуулчны эрүүл ахуйн болон гэрийн агааржуулалтанд маш муу нөлөөтэй.
 - Гэрийн дээвэр, туурга цас, бороо, усны хамгаалалттай байх.
 - Хүчтэй салхи, шуурга, аадар бороотой үед цахилгаан хэрэгслүүдийг ажиллуулахгүй байх.
 - Аянга, цахилгаантай бороотой үед аянганд цохиулахаас болгоомжилж гарахгүй байх.

- Аянга нэргэх аюултай том овортой зүйлс болон метал зүйлсийн хажууд зогсохгүй байх.
- Хүчтэй салхи, шуургатай үед ажиллаж байгаа ажилтнууд өөрсдөө салхинд хийсэх, төөрөхөөс болгоомжилж, тусгайлан бэлтгэсэн уяа бэхэлгээг хэрэглэх, холбоо дохиоллын хэрэгсэл ашиглах.
- Хүчтэй слахи, шуургатай үед гэр, хаашаа нурж эвдэрсэнээс мод, тоосгонд цохиулан гэмтэж бэртэхээс сэргийлж, байрлах газраа зөв сонгох.

10. Цахилгаан тасрах үед

- Цахилгаан тасарсан үед зочдод нэн даруй мэдэгдэх.
- Цахилгаан хэзээ буцаж ирэх тухай тодорхой мэдээллийг зочдод хүргэх.
- Гэр болон өрөөнүүдэд нэмэлтээр нар, салхины хүчээр цэнэглэгддэг гар чийдэн, гэрэл зэргийг нөөцлөн тавих.
- Цахилгаан тасалдсан үед хэрэглэх нөөц мотортой байх. Нөөц мотор ажиллуулахад хэрэглэх түлшний нөөцтэй байх.
- Цахилгаан хэрэв удаан хугацаанд тасрах үед хүнс болон усны нөөцийг зочдыг өрөөнд өгөх.
- Гэр бүрт гал түлэх түлшийг хангалттай бэлдэх.
- Цахилгаан тасалдсан үед бүх цахилгаан хэрэгслүүдээ эх үүсвэрээс нь салгаж аюулгүй байдлыг хангах.
- Цахилгаан буцаж ирсэний дараа цахилгаан хэрэгслүүдээ ээлж дараатайгаар залгах

Жуулчны баазын хүрээлэн буй орчны тохижилтыг хийх, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа / гар зураг оруулах/

1. Нийтийн эзэмшлийн талбай 20- оос доошгүй хувьд ногоон байгууламжтай байх.
2. Гаднах шат, үүдний хэсгийн талбайг хальтиргаа гулгаанаас хамгаалж тусгай зориулалтын дэвсгэр тавих.
3. Жуулчны баазын авто машины зогсоолд хог ялган хаях тусгай зориулалтын тэмдэглэгээтэй хогийн савнууд байрлуулах.
4. Зоогийн газрын орох үүдэнд хогийн сав байрлуулах.
5. Зочны гэр хооронд хогийн сав байрлуулах.
6. Ариун цэврийн өрөө болон шүршүүрийн өрөөний гадаа хогийн сав байрлуулах.
7. Зочны гэр болон өрөөнүүд бүр хаалганы баруун талдаа шөнө гэрэлтдэг материалаар хийсэн дугаарлалттай байх.
8. Нийтийн үйлчилгээний өрөө, танхим ариун цэврийн өрөө нь ердийн ба механик агааржуулалтын төхөөрөмжтэй байх.
9. Шүршүүрийн болон угаалгын өрөөнүүдийн гадаа хальтиргаанаас хамгаалсан гишгэвч тавих.

Ундны усны эрүүл ахуйд анхаарал хяналт тавих, зөөвөрлөх, нөөцлөх зааварчилгаа

Жуулчны баазад ундны усны эрүүл ахуйг чандлан мөрдөж жуулчны болон ажилтны эрүүл ахуйг хамгаалахын тулд доорх дүрэм, журмуудыг дагаж мөрдөх ёстой.

- Ундны усны чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас
 - Эрүүл ахуйн хяналтын хуудас
 - Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ, стандартыг мөрдөж ажиллах шаардлагатай.
1. Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангасан байх.
 2. Ундны ус хангамжийн эх үүсвэрт энгийн хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлсэн байх.
 3. Ундны усны эх үүсвэрийн эргэн тойрны хөрсний бүрэн бүтэн байдал алдагдаагүй, ан цав цууралт үүсээгүй байх.
 4. Ундны ус хадгалах усан сангийн хийцийн материал усны чанар, аюулгүй байдал нөлөө үүсгэхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх.
 5. Ундны усны эх үүсвэрийн худгийн усанд жилд 1 удаа химийн үзүүлэлтээр, сар бүр нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийлгэх.
 6. Ундны ус цэвэршүүлэх, халдваргүйжүүлэхүе шатанд усанд PH үлдэгдэл хлор, булингар, цахилгаан дамжуулах чанарыг тодорхойлох шинжилгээ сард 1 удаа хийлгэх.
 7. Ус халдваргүйжүүлдэг химийн бодисыг зориулалтын тусгай агуулахад хадгалах.
 8. Түүхий ус уухгүй байхыг сайтар сануулах. Цэвэршүүлж тавьсан уснаас бусдыг ууж болохгүйг зочдод анхааруулах. Үүнд: Крантны ус, шүршүүрийн ус, ариун цэврийн гоожуурын ус булаг шанд, гол горхины ус, рашаан зэрэг байгальд ил байдаг бүх төрлийн түүхий, цэвэршүүлээгүй уснууд багтана.
 9. Салхи шуургатай үед тог цахилгаан тасалддаг тул ундны болон зөөврийн усаа нөөцлөх.
 10. Цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цооногийг “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохижуулах журмын дагуу хийх.
 11. Бохир ус зөөвөрлөх үед дүрэм журмыг чандлан дагах.
 12. Зөөврийн усан хангамжтай тохиолдолд усыг шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж, савыг 7 хоногт 3-аас доошгүй удаа цэвэрлэх.
 13. Ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглах зөвшөөрөл авч, усны тоолуу суурилуулсан байх.
 14. Ус шүүх төхөөрөмжтэй байх

Хог хаягдлыг ялгаж ангилах, устгах болон хогийн цэгүүдийн эрүүл ахуйд хяналт тавих зааварчилгаа

1. Олон улсын стандартын дагуу жуулчны бааз бүр хогоо ялган ангилж хаях.
2. Хогийн сав бүр галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх.

3. Хогийн савны хэмжээ, төрөл хэлбэр, өнгийг жуулчны баазын онцлогоос хамаарч хийх.
4. Ангилан ялгах хог хаягдлыг төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах ялгах зориулалтын тэмдэг, тэмдгэлэгээ бүхий байх.
5. Цоорч, гэмтээгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар байх.
6. Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн, нягтаршуулсан, цементэлсэн, зориулалтын хавтан, дэвсгэр дэвссэн байх.
7. Хогийн цэг рүү тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай байх.
8. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцлийг бүрдүүлсэн байх.
9. Жуулчны баазын гадаах орчинд байрлах хогийн савнууд нь салхинд туугдахааргүй бат бөх байх.
10. Шатамхай хог хаягдлыг хадгалах, ашиглах, тээвэрлэх аюулгүй журмыг мөрдөх, ажиллах.
11. Гэр болон өрөө хоорондын дунд байрлах хогийн сав бусад зочдод саад болохгүй дуу чимээ гаргахгүй, үнэр танаргүй үргэлж дүүргэлтгүй байх.
12. Ариун цэврийн өрөөний хогийн сав нь таг, давхар савтай, гарын бус ажиллагаатай байх.
13. Хог хаягдлын цэгийг зочны байр болон гэр барилга байгууламжаас 60м-ээс багагүй зайд салхины доод зүгт байрлуулах.
14. Хог хаягдлын цэг нь байгалийн салхинд хийсэхгүй байхаар зохицуулах.
15. Хатуу хог хаягдлыг ангилан ялгах цэгтэй байх бөгөөд тус цэг нь хог хаягдал гадагшлахаас хамгаалсан битүү тагтай, хөрсөнд шингэхээс хамгаалах.
16. Хог хаягдлыг ангилахдаа:
 - Дахин ашиглах боломжтой хог хаягдал
 - Хүнсний хог хаягдал
 - Бусад хог хаягдал гэж ангилах.
17. Хог хаягдлыг цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр нь цуглуулах.
18. Хог хаягдлыг устгах, булшлахдаа:
 - Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах.
 - Биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцлөөр боловсруулж устгах
 - Том оврын болон бага оврын зууханд байгальд ээлтэй нөхцлөөр боловсруулж устгах.
 - Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах.
 - Байгальд 5-10 жилд хоргүйгээр уусч алга болох хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфилл талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшлах.
 - Байгальд 10- аас дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсгэх хог хаягдлыг булшлахыг хориглох.

Бохирын цооног, нүхэн бие засах газар, угаадасны нүх зэргийн эрүүл ахуйд хяналт тавих зааварчилгаа

1. Бохир усны цооногийг гол, нуурын эргээс 500м-ээс багагүй зайд байрлуулах.
2. Энгийн бие засах газар болон угаадасны нүхийг зочны гэр, өрөөнөөс 50м -ээс багагүй зайд салхины доод зүгт байрлуулах.
3. Эко бие засах газрыг аль болох өргөн хэрэглэх.
4. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологиор хийгдсэн био болон эко бие засах газрыг хэрэглэх.
5. Бохир ус, угаадсыг ил задгай шууд асгахыг хориглох.
6. Ил задгай бие засахыг хориглох.
7. Бохир усыг гол, усан сан, нуур, далай руу задгай асгахыг хатуу хориглох.
8. Бохир ус зайлуулах дотор талын систем болон гадна шугам сүлжээтэй байх.
9. Угаадасны нүх, нүхэн жорлон зэргийг салхины доор барьж байгуулах.
10. Угаадасны нүх, жорлон зэрэг нь аль болох нэг дор байрлах.
11. Нүхэн жорлон, угаадасны нүх зэрэг нь газар доорх усны эх үүсвэр, хөрс агаарыг бохирдуулахгүй байх
12. Нүхэн жорлон нь суурийн нүх, бүхээг, хаяавч, агааржуулалтын хоолойн хэсгээс бүрдэх.
 - Суурийн нүх нь хөрсний уснаас дээш 2м-ээс багагүй түвшинд ухах, суурийн нүхэнд ариун цэврийн хэрэглэл, хог хаягдал хийхийг хориглох.
 - Бүхээгийн шалыг суурийн нүхний амсар дээр ачаалал даах бат бэх материалаар дамнуурга зориулалтаар хийх.
 - Бүхээгийн хана, дээвэр тэдгээрийг уулзвар зай завсаргүй хаалга нь бүрэн онгойж хаагадж байхаар цэвэр өнгө үзэмтжэй байх
 - Бүхээгийн хаалга гадна, дотор талдаа түгжээтэй байх бөгөөд шөнийн цагт гэрэлтүүлэгтэй, бүхээгний хаалган дээр ялаа, шавьж орохоос хамгаалах тор бүхий цонхтой байх.
 - Хаяавч жорлонд цас, борооны ус орохоос хамгаалсан бетон зуурмаг, чулуу тоосго, хайрга зэрэг материалаар жорлонгийн сууринд хаяавч хийх.
 - Жорлон бүр агааржуулалтын хоолойтой байх.
13. Жорлонгийн бүхээг дотор ариутгал цэвэрлэгээний бодис тавих шаардлагатай.
14. Нүхэн жорлон, угаадасны нүх зэрэгт ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийж, үнэрийг дарах био бэлдмэлийг ашиглах.
15. Нүхэн жорлон, угаадасны нүх зэрэгт амьтан шавьж үүрлэж, үржихээс хамгаалж тусгай зориулалтын уусмалаар 7 хоног тутамд устгал, ариутгал хийх хэрэгтэй.

Жуулчны баазад гарах хулгай дээрэм, тонуулаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд авах арга хэмжээ

#Шаардлагатай

- 24 цагийн байнгын харуул хамгаалалт
- 24 цаг байнгын ажиллах камер

1. Зочдын гэр, өрөө бүрт хулгай дээрмээс болгоомжлуулан бичсэн санамж бичиг байрлуулах.
2. Зочдыг гэр болон өрөөгөө эзэнгүй орхих үедээ үргэлж цоожилж явахыг сануулах бичиг тавих.
3. Урт хугацаагаар гэр болон өрөөгөө түгжин явах бол үнэт зүйл, паспорт, их хэмжээний бэлэн мөнгө зэргээ аль болох биедээ авч явах боломжтой бол хадгалуулах.
4. Жуулчны баазын эргэн тойрон болон хүрээлэн буй орчинг байнгын 24 цагийн харуул хамгаалалттай байлгах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих.
5. Жуулчны баазыг бүрэн камержуулах, камерын өрөөг үргэлж хүнтэй байлгаж хянуулж байх.
6. Сэжигтэй тохиолдол ажиглагдвал тэр дор нь шалган хянаж үзэх, арга хэмжээ авах.
7. Жуулчны баазын эргэн тойрон болон үзэгдэх орчин багатай газруудыг шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байлгах, шөнө сайн бичдэг камер байрлуулах.

Хүнсний эрүүл ахуйн буюу гал тогоо, хоолны байдал түүнд тавих шаардлага

Хүнсний эрүүл ахуйн стандартыг дагаж мөрдөх.

- Гал тогооны эрүүл ахуй
 - Гал тогооны авулгүй байдлын заавар зааварчилгаа
 - Шалгах хуудас
 - Хөргөх төхөөрөмж, камер, хөрөгөчний хэмийн бүртгэл
 - Их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл
1. Хурдан хугацаанд мууддаг, хүнсний нарийн ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүнүүдийг их хэмжээгээр нөөцлөхгүй байх
 2. Зочдод аль болох орон нутгийн шинэ ургацын хүнс, ногоо жимс жимсгэнээр үйлчлэх
 3. Хотоос, хол зайнаас зөөх, урт хугацаагаар хадгалах хүнсний бүтээгдэхүүнийг он сар өдрийг шалгаж байх, зөөвөрлөлтийн горимыг сайтар дагаж мөрдөх.
 4. Жижиглэн савласан түүхий мах, сүү, цагаан идээ, өндөг зэрэг бүтээгдэхүүнийг бусад хүнсний бүтээгдэхүүнээс тусад нь хадгалах.
 5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх.
 6. Хүнсний бүтээгдэхүүнийг хурц үнэртэй, хүнсний бус бүтээгдэхүүдтэй хамт хадгалахыг хориглох
 7. Гал тогоонд ус нөөцлөх зориулалтын савтай, өдөрт хэрэглэх ундны болон аяга, таваг болон гар угаах усны хэмжээг тооцоолон хамгийн багадаа 200л-ээс багагүй нөөцтэй байх.
 8. Гал тогооны хог хаягдлыг хуурай, нойтон, дахин ашиглах хог хаягдлаар ялган, битүүмжлэл сайтай саванд хийх.
 9. Гал тогоо руу орох хэсэг нь цардмал зам талбайтай байх.

10. Гал тогооны ажилтан бүр нь эрүүл ахуйн зохистой дадлын шаардлагууд, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих зүрэм, журмыг мөрдөж ажиллах.
11. Гал тогооны халуун боловсруулалтын технологийн шат дамжлагын хэсэг, бэлтгэх хэсгийн өрөөний гэрэлтүүлэг 220 люксээс багагүй байх.
12. Гал тогоо нь цахилгаан тасарсан үед цахилгаанаар хангах эх үүсгүүртэй байх.
13. Гал тогооны ажилтнуудын хувцасны өрөө, шүүгээг ажлын хувцас, гадуур хувцасны шүүгээнээс тусдаа байлгах.
14. Гал тогоонд халуун, хүйтэн хоол, ундааны технологи картыг боловсруулан баталж, мөрдөн ажиллах.
15. Гал тогоонд шөлтэй хоолыг +75 градусаас багагүй температурт, хоёрдугаар хоолыг +63 градусаас багагүй температурт, хүйтэн хоол, зууш салатыг +5 градус температурт 2 цагаас дээшгүй хугацаагаар хадгалж, зочдод олгох.
16. Болгосон хоолыг тасалгааны хэмд хадгалдаг бол 2 цагийн дотор хэрэглэх.
17. Гал тогооны ажилтнууд нь биедээ тохирсон 2- оос доошгүй ээлжийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл мөн үс далдлах зориулалтын малгай, алчуур, нэг удаагийн хэрэглээний бээлий, улавч зэрэг бусад шаардлагатай зүйлээр тасралтгүй хангуулах.
18. Гал тогооны ажилтан бүр хүнстэй ажиллах үе бүртээ гараа гоожуурын усаар тогтмол угаах.
19. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав баглаа боодол хэрэглэх.
20. Хоолны дээжийг журмын дагуу авч зориулалтын хөргөгчинд 40 градус температурт 48 цаг хадгалах, хоолны дээж авалтын бүртгэлийг хөтлөх.
21. Хоолны дээжний савыг ариутгаж хэвших.
22. Гал тогоо буюу хоолны газар нь хоолны хордлого, халдвар гаргахгүй байх асуудлыг бүрэн хариуцах.
23. Хоолны үлдэгдлийг дахин ашиглахыг хатуу хориглох.
24. Зочдын дундаас хэн нэгэн хоолны хордлого авсан тохиолдолд:
 - Жуулчны баазын удирдлагад мэдэгдэх.
 - Яаралтай эмнэлэгийн байгууллагад мэдэгдэх.
 - Үйлчилсэн халуун, хүйтэн хоол, ундаа, зуушны үлдэгдэл, хоолны хэрэглэлийг цэвэрлэж угаалгүйгээр эмч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчдыг ирэх хүртэл хадгалах.
25. Их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлэх

Жуулчныг байрлаж байх үеийн аюулгүй ажиллагааг хангахын тулд жуулчны баазыг камержуулах нь

1. Машины зогсоолыг бүрэн камержуулах.
2. Зоогийн газрыг шаардлагатай цэгүүдийг камержуулах.
3. Нийтийн талбайнуудыг камержуулах.
4. Үзэгдэх орчин муутай гадаах өнцөг булан бүрийг камержуулах.

5. Зочин болон ажилтантай холбоотой маргаан гарч түүнийг үнэн зөвөөр таслахын тулд ХАБЭА ажилтан камер шүүж өгч баримт нотолгоо болгон өгөх.
6. Жуулчны баазад гэмт хэрэг, хулгай дээрэм гарсан тохиолдолд цагдаагийн газрын бичигтэйгээр камерыг шүүн өгөх.

Халдвар хамгааллын дэглэмийг сахиж мөрдөх, мөрдүүлэх зааварчилгаа

Шаардлагатай

- Халуун хэмжигч
 - Гар ариутгагч
 - Нэг удаагийн бээлий
 - Нэг удаагийн маск
 - Гарын шингэн саван
 - Гарын алчуур
 - Хувцас ариутгагч бодис
 - Өрөө ариутгагч бодис
 - Ариутгалын тусгай зориулалтын бодисууд
 - Шүршигч сав
 - Бүртгэлийн хуудас
1. Жуулчны баазын ажилтан тус бүрийг халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиж мөрдүүлэх
 2. Ажилтнууд ажлын дүрэмт хувцсыг өдөр бүр угааж, ариутгаж сольж өмсөж байх үүнд хяналт тавих.
 3. Ажилтан тус бүр өглөө бүр ажил эхлэхээс өмнө халуунаа хэмжүүлж, тэмдэглүүлэх.
 4. Ажилтан тус бүр ажлын байрандаа ирж ажлаа хийж эхлэхийн өмнө гара сайтар савандаж угаах.
 5. Ажилтан тус бүр ажлын байран дээрээ нэг удаагийн маск, нэг удаагийн бээлийг заавал өмсөж зочинд үйлчлэх.
 6. Ажилтан тус бүр нэг удаагийн маскийг 2 цаг тутамд шинэчлэн сольж байх.
 7. Зочдыг жуулчны баазад ирэх үед зочин угтагч халууныг шалгаж зочны халуун хэвийн тохиолдолд үйлчлүүлэхийг зөвшөөрөх.
 8. Зочдын гарыг ариутгах
 9. Нэг удаагийн маск болон нэг удаагийн бээлийг зочдод бэлдэж тавих. Шаардлагатай тохиолдолд хэрэглүүлэх.
 10. Зочдын өрөө болон гэрүүдэд зочны нүдэнд ил харагдахуйц газар гар ариутгагч тавих.
 11. Зоогийн газрын орох хэсэгт зочны нүдэнд ил харагдахуйц газар гар ариутгагч болон гар арчих нойтон салфетка бэлдэж тавих.
 12. Мөн тусгайлан нэгэн ажилтныг томилон үүдэнд зогсоож дээрх үйлчилгээгээр зочдыг хангах.
 13. Зоогийн газар, ариун цэврийн өрөө болон, үйлчилгээний заалуудад зочин хоорондын барих 1,5 метр зайн тэмдэглэгээ хийх.
 14. Зочны өрөө болон гэрүүдэд агаар сэлгэх, агааржуулалтыг боломжтой цаг бүрт хийх.

Жуулчны баазын аюулгүй байдал эрүүл ахуй нь жуулчин байрлаж байх үеийн аюулгүй байдлыг бүрэн хангах ёстой бэлтгэл ажил бөгөөд жуулчинд сайн үзүүл, сэтгэл ханамжтай буцаах гол эх үүсвэр юм. Тиймээс дээрх зүйлсийг сайтар дагаж мөрдөж хэрэгжүүлэхээс гадна доорх хэд хэдэн зүйлсийг мөн хэрэгжүүлэн дагаж мөрдөснөөр таны баазын жуулчиддаа өгөх сайн үйлчилгээ тасалдахгүй байх болно.

- Жуулчны баазын ХАБЭА ажилтны дагаж мөрдөх ХАБЭА дүрэм, журам.
- Жуулчны баазын ажилтнуудын эрүүл ахуй, болон ажлын байрны аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа.
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, анхны тусламжийн нөөцтэй байх.
- Жуулчны баазын дотоод үйл ажиллагааны дүрэм журам боловсруулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих.
- Аюул ослын үед цуглах цэг сонгож, зааварчилгаа бүхий самбарыг монгол, англи хэлээр бэлтгэж тавих.

Шахилгааны аюулгүй байдалд тавигдах шаардлага, заавар зааварчилгаа зэргийг өөрсдийн баазын онцлогт тохируулан гаргаж, дагаж мөрдөх ёстой.

3.6

ЖУУЛЧНЫ БААЗАД АНХААРАХ ЗҮЙЛС

Жуулчны баазад гэр болон өрөөг хуваарилахдаа дараах зүйлсийг анхаарах нь үйлчилгээг илүү сайжруулж, жуулчдын сэтгэлд илүү хүрч чаддагаараа давуу талтай. Үүнд:

- ✓ Гэр болон өрөөний захиалгыг сайтар нягталж эцсийн байдлаар гаргасан байх;
- ✓ Хүндэтгэн үзэх шалтгаантай зочид, жуулчдын захиалгыг анхаарах цэсэнд тэмдэглэх;
- ✓ Гэр бүлээрээ яваа болон өндөр настай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй жуулчдыг ариун цэврийн өрөө, шүршүүр болон зоогийн газар зэрэг газарт ойр, гэрэлтүүлэг сайтай гэрүүдэд хуваарилах;
- ✓ Тусгай захиалгуудыг тэмдэглэн бичих. /Аялын компаниудаас зарим үед тусгай захиалга ирдэг бөгөөд түүнийг захиалга баталгаажуулах үедээ анхаарч тэмдэглэн гэр, өрөө хуваарилах үедээ тусгай захиалгуудыг биелүүлэн гэрийн хуваарийг хийх/;
- ✓ Зочид, жуулчдын ирэх цагийг мэдэж байгаа тохиолдолд түрүүлж ирэх жуулчдыг бэлэн болсон гэрүүдэд хуваарилах;
- ✓ Групп жуулчдыг нэг жигүүрт болон нэг эгнээнд, аль болох ойрхон хөрш зэргэлдээ гэрүүдэд хуваарилах;
- ✓ Ази, Европ жуулчдын онцлогийг харгалзан үзэж аль болох өөр жигүүрт, хол зайтай хуваарилах;
- ✓ Гэр бүлээрээ болон группээрээ аялж яваа залуу жуулчдыг настай жуулчдын гэрээс хол зайтай байрлуулах;
- ✓ Зарим үед жуулчид өөрсдөө хол зайдуу гэрт байрлуулж өгөхийг хүсдэг тул түүнийг ч мөн гэр хуваарилахдаа анхаарах;
- ✓ Нэг аялын компанийн өөр групп болон ганцаарчилсан жуулчдыг нэг эгнээ эсвэл нэг жигүүрт хуваарилахгүй байх;
- ✓ Орчуулагч, хөтөч, жолооч, тогооч нарыг эрэгтэй, эмэгтэйгээр нь хуваарилан өөр өөр гэрт байрлуулах;
- ✓ Нэг компанийн орчуулагч, жолооч нар хэрэв өөрсдөө хүсэлт гарган хамтад нь байрлуулж өгөхийг хүсвэл нэг гэрт байрлуулж болно.
- ✓ Нэг аялын компаниас нэг дор олон аялал ирвэл орчуулагч, хөтөч, жолооч, тогооч нарыг компаниар нь ялгаж эрэгтэй, эмэгтэйгээр тусад нь нэг гэрт байрлуулах;
- ✓ Гадаадын болон дотоодын жуулчдыг аль болох өөр жигүүрт салган хуваарилах;
- ✓ Дотоодын жуулчид ихтэй үед гадаадын жуулчдыг ариун цэврийн өрөө, зоогийн газар, нийтийн талбайгаас хол гэрт хуваарилах;

3.7

ЖУУЛЧНЫ БААЗАД ЗОЧИН УГТАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

Зочны угтан авах үйл ажиллагаа




Зураг №93 Алунгоо жуулчны баазад жуулчин угтаж буй нь

- Жуулчны баазын менежер, зочин хүлээн авагч, ачаа зөөгчийн хамт жуулчдыг авто зогсоол дээр тосно.
- Жуулчидтай мэндэлнэ. “Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая” “ Аян замдаа сайн явж ирэв үү” “.....жуулчны баазад тавтай морилно уу” хэмээн мэндчилнэ.
- Жуулчны баазын менежер захиалгын хуудас болон жуулчдын гэр хувиарлалтын хуудастайгаа жуулчны группын ахлагч болон хөтөчтэй уулзна.



Зураг №94-95 Монгол номапдик жуулчны баазад угталт авч буй нь



Зураг №96 Алунгоо жуулчны баазын план зураг



Зураг №97 Жуулчны баазын таних тэмдэг

- Зочин хүлээн авагч жуулчдыг автобус болон автомашинаас буухад тусална.
- Хөтөч, группын ахлагч, баазын менежер нар жуулчдыг байрлах гэрт хувиарлана.
- Ачаа зөөгч жуулчдын ачаа тээшийг буулгаж, жуулчны хувиарласан гэр рүү хүргэж өгнө.
- Ачаа зөөгч жуулчдыг гэр рүү хүргэж өгөх замдаа жуулчны баазынхаа талаарх мэдээ мэдээлэл бүхий танилцуулагыг хийнэ.

Зочдыг гэрт байрлуулах үйл явц

1. Гэрийн үйлчлэгч жуулчдыг байрлахаар хувиарлагдсан гэрт авчирна. Ингэхдээ дараах зааварчилгааг өгнө. Үүнд:
 - Гэрийн хаалга онгойлгох
 - Хаалгаар баруун хөлөө түрүүлж тавин, толгойгоо тонгойлгож орох
 - Гарахдаа хаалгаа цоожлох, цоожоо түлхүүрдэн онгойлгох гэх мэт зааварчилгааг заавал өгнө.



Зураг №98 Гэрт байрлуулах

Зочинд үйлчлэх /Гэрийн үйлчилгээ



Гэрийн үйлчлэгч зочдоо гэрт байрлуулан, гэрийн салхивч онгойлгох, гал түлэх, гэрлийн унтраалга, цахилгааны разетка хаана байгааг зааж өгнө.

Мөн халуун саванд буцалсан ус савлаж зочдын гэрт байрлуулна, цөөн ажилтантай үед ажил хөнгөвчлөх үүднээс гэрт ус буцалгагч байрлуулж болно.

Зураг №99 Гэрт байрлуулах

2. Зочдын гэрээс гарахаас өмнө зочдоос нэмэлт санал хүсэлт байгаа эсэх талаар лавлаж асууна.
3. Хэрэв нэмэлт санал хүсэлт байвал гэрийн үйлчлэгчид хандахыг зөвлөнө.

ЖУУЛЧНЫ БААЗАД АНХААРАХ ЗҮЙЛС

Жуулчны баазад гэр болон өрөөний хуваарилалтыг хийхдээ доорх зүйлсийг анхаарах нь жуулчдад хүрэх үйлчилгээг илүү сайжруулах төдийгүй жуулчдад илүү хүрч үйлчилсэн үйлчилгээ болж чаддагаараа давуу талтай.

Тиймээс жуулчны баазад гэр болон хуваарилалтыг хийхдээ доорх зүйлсийг анхааран үзэх хэрэгтэй.

- ✓ Гэр болон өрөөний захиалгыг сайтар нягталж эцсийн байдлаар гаргасан байх;
- ✓ Хүндэтгэн үзэх шалтгаантай зочид, жуулчдын захиалгыг анхаарах цэсэнд тэмдэглэн бичих, боломжтой бол гүйцэлдүүлэх;
- ✓ Гэр бүл эсвэл өндөр настай хөгжлийн бэрхшээлтэй жуулчид байвал аль болох ариун цэврийн өрөө, шүршүүр болон зоогийн газар зэрэг газруудад ойр, гэрэлтүүлэг сайтай гэрүүдэд хуваарилах;
- ✓ Тусгай захиалгуудыг тэмдэглэн бичих. /Аялын компаниудаас зарим үед тусгай захиалга ирдэг бөгөөд түүнийг захиалга баталгаажуулах үедээ анхаарч тэмдэглэн гэр, өрөө хуваарилах үедээ тусгай захиалгуудыг биелүүлэн гэрийн хуваарийг хийх/;
- ✓ Зочид жуулчдын ирэх цагийг мэдэж байгаа тохиолдолд түрүүлж ирэх жуулчдыг түрүүнд бэлэн болсон гэрүүдэд хуваарилах;
- ✓ Групп жуулчдыг нэг жигүүрт болон нэг эгнээнд аль болох ойрхон хөрш зэргэлдээ гэрүүдэд хуваарилах;
- ✓ Ази, Европ жуулчдын онцлогыг харгалзан үзэж аль болох өөр жигүүрт, хол зайтай хуваарилах;
- ✓ Гэр бүлээрээ болон группээрээ аялаж яваа залуу жуулчдыг хөгшин жуулчдын гэрээс хол зайтай байрлуулах;
- ✓ Зарим үед жуулчид өөрсдөө хол зайдуу гэрт байрлуулж өгөхийг хүсдэг тул түүнийг ч мөн гэр хуваарилахдаа анхаарах;
- ✓ Нэг аялын компанийн өөр групп болон ганцаарчилсан жуулчдыг нэг эгнээ эсвэл нэг жигүүрт хуваарилахгүй байх;
- ✓ Орчуулагч, хөтөч, жолооч, тогооч нарыг эрэгтэй, эмэгтэйгээр нь хуваарилан өөр гэрүүдэд байрлуулах;
- ✓ Нэг компанийн орчуулагч, жолооч нар хэрэв өөрсдөө хүсэлт гарган нэг гэрт байрлуулж өгөхийг хүсвэл нэг гэрт байрлуулах;
- ✓ Мөн нэг аялын компаниас нэг дор олон аялал ирвэл орчуулагч, хөтөч, жолооч, тогооч нарыг компаниар нь ялгаж эрэгтэй, эмэгтэйгээр нь ялган нэг гэрт байрлуулах;
- ✓ Гадаадын жуулчид, дотоодын жуулчдыг аль болох өөр жигүүрт салган хуваарилах;
- ✓ Дотоодын жуулчид ихтэй үед гадаадын жуулчдыг ариун цэврийн өрөө, зоогийн газар, нийтийн талбайгаас хол гэрт хуваарилах;

Зочин үдэх үйлчилгээ

- ✓ Жуулчны баазын менежер ажиллагсад жуулчдын буцах цагийг мэдээлж, тус бүр ажлыг нь хувиарлана.
- ✓ Жуулчдын ачаа тээшийг ажиллагсад гэрээс авч авто зогсоол руу хүргэнэ
- ✓ Жуулчны баазын бүх ажиллагсад авто машины зогсоол дээр зочдоо үдэж өгөхөөр бэлэн байна.
- ✓ Хөтөч жуулчдаа явахад бэлтгээд авто зогсоол руу явах үед баазын менежер хамт зогсоол руу явна.
- ✓ Зогсоол руу явахдаа менежер жуулчидтай яриа өрнүүлэн хамт явна. Үйлчилгээний чанар, үйлчилгээний ажилтаны ёс зүй, ур чадварын талаар жуулчдад сэтгэл хангалуун байсан талаарх судалгааг жуулчны баазад байрлаж буй үед нь хийж үйлчилгээний доголдол, алдаа дутагдалаа мэднэ.
- ✓ Жуулчдыг авто зогсоол дээр менежер хүлээн авч ажиллагсадын хамт үдэж өгнө.
- ✓ Жуулчдын ачаа тээшийг жуулчдад болон жолоочид хүлээлгэн өгнө.
- ✓ Авто машинд ачаа тээшийг ачаалахад туслана.
- ✓ Жуулчдыг автобус унаанд суухад туслана. Мөн өндөр настай, нэр хүндтэй, бага

- хүүхэдтэй, бие шалтгаантай эмэгтэй зочныг автобус унаанд суулгах.
- ✓ Жуулчдыг хадагтай идээгээ барьж үднэ.
 - ✓ Жуулчдын автобус унаа хөдлөөд жуулчны бааз өнгөртөл баазын бүх ажилчид гараараа далман үдэж өгнө.



Зураг №100 Жуулчдаа үдэж буй ажилчид Монгол Номадик

- ✓ Онцгой хүндтэй зочныг бол унаа хөсгөөр хамт явж хамгийн наад талын дөрөлж, даваа хүртэл гаргаж өгнө.
- ✓ Монголчууд зочныг үдэх үедээ түүнд улам сайхан ааш зангаар хандаж «Таныг морилон ирж биднийгээ гийгүүлсэн явдалд их баярлалаа!», «Та дахин дахин ирж биднийгээ гийгүүлж байгаарай!», «Та аян замдаа сайн яваарай!», «Таны юу санасан есөн хүсэл бүхэн тань сэтгэлчлэн бүтэж байх болтугай» гэхчилэн сайхан үгсийг чин сэтгэлээсээ хэлдэг ёстой.





Зураг №103-104 Жуулчдаа үдэж буй ажилчид Монгол Номадик

04

МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХООЛ, УНДААНЫ СОЁЛ

1. Монгол үндэсний хоол, ундааны соёл
2. Жуулчны баазын хоолны газрын үйлчилгээ
3. Жуулчдад боолтын хоолоор үйлчлэх үйлчилгээ
4. Жуулчны баазын гэр рестораны заал зохион байгуулалт
5. Жуулчны баазад урлагийн тоглолт амжилттайгаар зохион байгуулж жуулчдад хүргэх арга
6. Жуулчны бааз дээр соёлын арга хэмжээнүүд зохион байгуулах








4.1

МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХООЛ ҮНДНЫ СОЁЛ

Монгол хоол нь улирлын чанартай байдаг тул өөр өөрийн гэсэн онцлог, ашиг тустай төдийгүй угсаатны онцлогийг илэрхийлэх олон төрөлтэй.

Хүснэгт №8 Улирлын онцлогт тохирсон монгол хоол

Улирлын онцлог	Бүтээгдэхүүн	Улирлын онцлогт тохирсон бүтээгдэхүүн
<p>Хаврын улиралд зохицсон хоол, ундаа</p>		<ul style="list-style-type: none"> • Шинэхэн сүү • Уураг • Өрөм • Хонины мах хар шөл • Саримстай шөл • Борцтой гурилтай шөл • Хярамцагтай хоол • Шар тостой аарц • Шар тостой арвайн гурил • Хийцтэй будаатай цай <p>Хавар мал төллөдөг учраас цагаан идээ шинээрээ байх үед тухайн жилийн гарцаас нь мөн шалтгаалан дараах бүтээгдэхүүнүүдийг хийн шинээр нь үйлчилж болно.</p>
<p>Зуны улиралд зохицсон хоол, ундаа</p>		<ul style="list-style-type: none"> • Цагаан идээ • Сүү • Тараг • Айраг • Хоормог • Цийдэм <p>Махан төрлийн хоол тослог ихтэй учир тохируулан хэрэглэнэ.</p>

<p>Намрын зохицсон ундаа</p> <p>улиралд хоол,</p>	   	<p>Байгалийн зэрлэг жимс, жимсгэнэ түүж, боловсруулан</p> <ul style="list-style-type: none"> • Гүзээлзгэнэ • Нэрс • Аньс • Чацаргана • Өрөл • Улаалзгана • Долоогоно • Үхрийн нүд • Тошлой • Мойл • Хад • Мөөг • Самар • Сонгино • Таана • Гишүүгэнэ <p>Хөмүүл зэргийг хоол хүнстэйгээ хамт хэрэглэдэг бөгөөд шинэхэн хоол хүнс нь эрүүл мэндэд ач тустай төдийгүй орон нутгийн шинэхэн бүтээгдэхүүнийг амтлах, таашаах боломжийг олгодог.</p> <p>Монгол оронд 60 гаруй зүйлийн зэрлэг жимсгэнэ ургадаг. Монгол орны жимс, жимсгэнийг дотор нь өвслөг ургамлын /гүзээлзгэнэ, аньс, нэрс, шангис/, мод бутлаг ургамлын /хад, бөөрөлзгөнө, тошлой, чацаргана, хармаг/ гэж хоёр ангилах ба орон нутгийн онцлогоос шалтгаалан жимс, жимсгэнээр жуулчны баазад бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх боломжтой.</p>
<p>Өвлийн зохицсон ундаа</p> <p>улиралд хоол,</p>		<ul style="list-style-type: none"> • Өөх тостой хоол идэх • Бүх төрлийн нөөшилсөн мах • Адууны махан хоол • Аарц, аньс, чацаргана буцалгаж уух

4.2

ЖУУЛЧНЫ БААЗЫН ХООЛНЫ ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Жуулчны баазад өглөө, өдөр, оройн хоолоор үйлчлэхэд зориулан ширээ засдаг бөгөөд зарим үед жуулчдын тусгай захиалгын дагуу онцгойлон ширээ засах нь ч бий. Зочдын ширээнд үйлчилгээ үзүүлэхдээ заавал мэргэжлийн зөөгчөөр үйлчлэх бөгөөд зөөгч нь хоол зөөх дэс дарааллыг болон хоолны онцлогт тохирсон халбага, сэрээ болон бусад нэмэлт хэрэгслийг тавих мэргэжлийн ур чадвартай байх ёстой. /Мэргэжлийн ур чадварын сургалтад хамруулсан байх/

Жуулчны баазын хоолны үйлчилгээ

Жуулчны баазад хоол ундааны үйлчилгээ үзүүлэх ресторан, кафе шоп байх нь жуулчдад тав тухтай амрах нөхцөлийг бүрдүүлдэг. Жуулчинд үйлчлэх ресторан нь үндэсний онцлогийг шингээсэн хоол ундыг санал болгодог байх ёстой. Хоолны олон сонголттой байж, орон нутгийнхаа онцлогийг харуулсан байх нь жуулчдад илүү их сонгох сэдлийг төрүүлдэг.

Жуулчны баазад зочдод хоол ундаар үйлчлэхдээ дараах зүйлсийг дэс дараалалтайгаар хэрэгжүүлэх нь зочдод хоол, хүнсний эрүүл аюулгүй байдал болон хоол ундаар үйлчлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх болно.

Хоолны цэс

Жуулчдад хоол ундаагаар үйлчлэх хоолны цэстэй, цэсийг жуулчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан 7, 14 хоног, сар бүр сольж зохиодог байх. Хоолны төлөвлөгөөт цэсэд үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээ, бэлэн болох хугацаа, хийх тогоочийн нэр зэргийг нарийвчлан тусгана.

Технологийн карт тогтмол ашигладаг байх

Цэсэд тусгагдсан хоолны орц, нормыг технологийн картыг ашиглаж гаргана. Жуулчны баазын ресторан нь хоолны цэсэд орж буй хоол бүрдээ технологийн карт мөрдөж ажиллана.

Технологийн карт нь:

- Хоолны түүхий эд материалын орц
- Норм, хэмжээг тооцох
- Хоолны технологи ажиллагаанд хяналт тавих
- Чанарыг нэг түвшинд барих үүрэгтэй. (Б. Цэрэндулам, Б.Оюунжаргал, 2020)

Технологийн картыг мөрдсөнөөр

1. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах;
2. Хоол үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөж ажиллах;
3. Үйлчлүүлэгчдэд амт чанар сайтай хоол ундаагаар үйлчлэх;
4. Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хянах боломжтой. (Б. Цэрэндулам, Б.Оюунжаргал, 2020)

Хоолны илчлэгийг тооцох

Хоол хүнснээс авах энергийг илчлэг гэнэ. Хоол хүнсээр дамжуулан авч байгаа илчлэгийн хэмжээ нь өдөрт зарцуулж байгаа илчлэгийн хэмжээтэй дүйцэж, тэнцвэртэй байх нь эрүүл байхын үндэс болдог. Илчлэгийг тооцоход бидэнд дараах зүйлс шаардлагатай. Илчлэгийн хэмжээг хоолны цэсэд оруулсан байх нь жуулчин хоолоо сонгоход дөхөмтэй.

Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний нэр
- 100 гр хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах шимт бодис болох уураг, өөх тос, нүүрс усны хэмжээ
- Шимт бодисын илчлэг ялгаруулах хэмжээг тооцож үзсэн байх шаардлагатай. (Б. Цэрэндулам, Б.Оюунжаргал, 2020)

Жуулчны баазын өглөөний цайны үйлчилгээ



Зочид ихэнхдээ жуулчны баазад хоноглодог бөгөөд тэдэнд зориулсан өглөөний үйлчилгээ тун чухал. Зочдын өглөөг сэтгэл дүүрэн эхлүүлье гэвэл өглөөний цайны ширээ засалт болон өглөөний цайндаа анхаарах хэрэгтэй.

Жишээлбэл: Ширээн дээр амьд цэцэг тавьсан байх нь жуулчдад аз жаргалтай, өөр орчинд очсон төдийгүй зөвхөн өөрт тусгайлан зориулсан мэт мэдрэмжийг төрүүлдэг.

Зураг №105 Өглөөний цайны ширээ засалт

Өглөөний цайгаар үйлчлэх

Өглөөний цайг сонголттой гаргах боломжтойгоор цэсийг зохионо. / Монгол болон Европ/ Өглөөний цайнд таны анхаарах чухал асуудал бол шинэ бүтээгдэхүүнүүдийг сонголттойгоор өгөх явдал юм. Гэрээт малчнаас авсан бүтээгдэхүүн, хүлэмжээс авсан шинэхэн ногоо, жимс, орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн шинэ бүтээгдэхүүн, нарийн боовны цехдээ боловсруулсан шинэ тараг, өрөм, шинэхэн талх, бин, боорцог, шинэхэн хөөрүүлсэн сүү, масло, бяслаг, цөцгий, жимсний чанамал, гар аргаар хийсэн бяслаг зэргээр үйлчлэх нь чухал юм.



Зураг №106 Алунгоо жуулчны баазын өглөөний цай

Баазын онцлогийг илэрхийлсэн өглөөний брэнд цайтай байх хэрэгтэй. (Халтар арвайтай цай, Хөвсгөлийн жимсний цай, Тайгын цай, буриад талхтай мойлтой цөцгийтэй өглөөний цай гэх мэт)

Өглөөний цайны олон төрлөөс үзүүлбэл

1. Тогтсон цэс бүхий стандарт өглөөний цай.

Кофе, цай, талх, бяслаг, варень, масло, булочка, шарсан талх, өндөг, зайдас, бэйкон, нэмэлтээр төрөл бүрийн зутан шөлийг гаргадаг.

Нийтлэг тогтсон цэс бөгөөд ихэнх бааз энэ цэсээр үйлчилдэг.



2. Өргөтгөсөн өглөөний цай. Стандарт өглөөний цайнаас ялгагдах онцлог нь жуулчид өөрсдийн онцлог болон хүсэл сонирхлын дагуу нэмэлтээр захиалж болдог онцлогтой.

Жишээ нь солонгос жуулчдад өглөөний цайнд будаа, азиуд нэмэлт зутан шөл, европчууд өндөг, бэйкон, жигнэмэг, шинэхэн жимс хэрэглэдэг.



3. Өөртөө үйлчлэх өглөөний цай
Нэрийн бүтээгдэхүүнүүдээс дуртайгаа сонгож өөртөө үйлчлэх өглөөний цай. Энэ нь жуулчинд хамгийн сонирхолтой хувилбар байж болно.

Хүний нөөц бага шаардах, хаягдал бага гаргах, жуулчин хүссэн сонголтоо хийх боломжтой. Халуун, хүйтэн зууш зэргийг хэрэглэх боломжтой. Групп болон масс жуулчинд нэгэн зэрэг богино хугацаанд хурдан үйлчилдгээрээ давуу талтай.



4. Үндэстэн бүрийн онцлогийг харуулсан өглөөний цай
Жуулчдын онцлогт тохирсон өглөөний цай.



Монгол маягийн өглөөний цай:

Шинэ өрөм, тараг, сүүтэй будаа, шинэхэн барьсан талх, бин болон өөрсдийн нутгийн онцлогийг харуулсан цагаан идээний бусад төрөл зүйл байж болно.

Өглөөний цайнд өгвөл тохиромжтой жимс:

Алим, лийр, жүрж, гадил, усан үзэм. Хэрэглэх жимсээ хөргөгчөөс гаргасан бол хүйтнээр нь үйлчилгээнд гаргаж болохгүй, тасалгааны температурт хэсэг байлгаж байж зочдод өгөх. Улирлаар хүнсний ногоо үйлчилгээндээ хэрэглэх нь зочид, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд тустай байдаг. Жишээлбэл:

Хавар: Лууван, хаврын сармис, шар лууван, сонгино, гичний навч

Зун: Залуу төмс, ногоон вандуй, лууван, чихрийн вандуй

Намар: Байцай, төмс, сонгино, лууван, чихрийн вандуй

Өвөл: Байцай, сонгино, өтгөн байцаа, лууван зэргийг хэрэглэх нь зохимжтой.



Зураг №107-108 Өглөөний цайны ширээ засалт, Алунгоо жуулчны бааз



Зураг №109 Өглөөний цайны ширээ засалт, Алунгоо жуулчны бааз

Өглөөний цай өгөхөд анхаарах зүйл, дараалал

- Рестораны ширээ засалт нь өглөөний цайны засалтаар зассан байх;
- Жуулчдыг орж ирэхээс өмнө өглөөний цайг бэлдсэн байх;
- Суух ширээг нь чиглүүлэх;
- Уух зүйлсийг сонголттойгоор санал болгох;
- Жүүс болон ус санал болгох;
- Сүүтэй цайг монголчууд, хөтөч орчуулагч нарт санал болгох;
- Өндөг болон зайдсыг хэр зэрэг шарах, болгох саналыг авах;
- Халуун зууш болон шөлийг жуулчдыг орж ирэхэд нь таваглан олгох;
- Хүйтэн зууш бол орж ирэхээс нь өмнө таваглан тавьсан байх;
- Масло, цөцгийг гэсгээн бэлтгэх;
- Оливын тосыг зохицох ургамал болон бусад амтлагчтай хольж ширээн дээр тавих;
- Кофены шингэн сүүг халуун байлгах;
- Үзэм болон бусад жүүсийг халуунаар өгөхгүй байх;

Буфет хоолны үйлчилгээ

Өглөөний цайг буфет хэлбэрээр олгохдоо олон сонголт бүхий зууш, хоолтой байх ба жуулчид өөрөө өөртөө үйлчилдгээрээ онцлогтой. Тогооч нар буфет үйлчилгээг удирдан зохион байгуулна. Хүйтэн зуушны ширээний дэргэд тогооч нар онцгой үүрэгтэй. Халуун хүйтэн хоолтой үед тогооч нар зарим хоолыг жуулчдын дэргэд шууд бэлэн болгож, зүсэж, жижиглэж порцлон, таваглаж өгдөг.

- Жуулчид өөртөө үйлчлэх боловч тогооч, зөөгч нар ширээн дээрх хоолыг танилцуулж, сонголтод нь зөвлөгөө өгч, таваглахад тусалбал ихэд тааламжтай байдаг.
- Хэрэглэсэн бохир аяга, таваг, хоолны хэрэгслийг бөөгнөрүүлэхгүйн тулд түргэн хурааж зайчилж авах хэрэгтэй. Зөөгчийн ур чадвар ихээхэн чухал.
- Хоосорсон царыг тухай бүр шинэчлэн, дүүргэсэн цараар сольж тавина.
- Хагас зууштай царыг сэлбэж тавина.
- Хоосон царыг авна.
- Цаг хугацаанаас шалтгаалж, дундарч буй цар, таваг, сүмсний гүцний байрлалыг өөрчилж засаж тавина.

Ундаагаар үйлчлэх

Уух зүйлсийг өөртөө үйлчлэх хэлбэрээр байрлуулаагүй бол аягалсан уух зүйлийг санал болгоно. Уух ундаа олон сонголттой байх шаардлагатай.

Буфет ширээг засахдаа хоолны дарааллыг баримтална. Тухайн жуулчдын захиалгын дагуу хоолыг гаргана. Хоолоо таваглан тавихдаа цар тавагт чимэглэж тавина. Царыг ташуу байрлалтай чимэглэн тавих нь жуулчдын сэтгэлийг татахаас гадна хоол идэх дуршлыг төрүүлдэг.

1. Эхэн хэсэгт зууш, хоолыг явах чиглэлийн эхэнд байрлуулна.
2. Төв хэсэгт шарсан мах
3. Төгсгөл хэсэгт амтлаг хоол болон жимс жимсгэнийг байрлуулна.
4. Сүмстэй гүцний доор дийз таваг тавьж, зохицох цар буюу хоолны дэргэд байрлуулна.
5. Хачир, салатыг хүнхэр тавагт хийж тохирох хоолны дэргэд байрлууна.
6. Талх, бүлочкийг буфет ширээний эхэнд тавгуудын дэргэд эсвэл жуулчдын ширээн дээр байрлуулна.
7. Ширээг хэзээ ч, “шавсан”, “чихэлдсэн” байдалтай харагдуулахгүйн тулд зохион байгуулагч нар анхаарах ёстой.



Зураг №110 Буфет ширээг гадаад террас дээр зассан байдал

Буфет үйлчилгээнд ашиглах тоног хэрэгслүүд

Шөлтэй хоолны халуун байлгагчийг байрлуулна.



- Эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэрлэгээ хийгдсэн байна.
- Гадаргууны өнгөлгөө хийсэн байна.
- Аюулгүй ажиллагааг шалгаж тавьсан байна.
- Разеткийг аюулгүй газар байрлуулсан байна.
- Өглөө, өдрийн хоолонд тавина.
- Шөлний халбага дагалдуулна.
- Шөлөнд дүрсэн халбагыг тавих жижиг дийзийг хоол халуун байлгагчийн өмнө байрлуулсан байна.

Өглөө, өдөр, оройн хоолонд зориулан халуун, хүйтэн зуушийг 3-4 төрлөөр савлан тавихаар төлөвлөсөн байна.

- Зууштай хольж идэх соусны савыг тавьсан байна.
- Зуушаа таваглах хавчаарыг байрлуулсан байна.
- Зууш таваглах тавгаа дэргэд нь тавьсан байна.
- Цэвэрлэгээ, ариутгал, өнгөлгөөг хийсэн байна.



- Үндсэн хоолны халуун байлгагчийг өдөр, оройн хоолонд гаргана.
- Дөл болон халуун усыг зохих зааврын дагуу хэрэглэнэ.
- Цэвэрлэгээ, ариутгал, өнгөлгөөг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлсэн байна.
- Хоолоо таваглах хавчаар болон халбагыг жижиг дийзэн дээр байрлуулсан байна.
- Үндсэн хоолны тавгийг байрлуулсан байна.



Зураг №111 Буфет ширээгээр үйлчлүүлж буй зочид

- Гал тогоо нь хоолныхоо дээжийг үргэлж авч, зориулалтын газар 72 цаг хадгалж буй эсэхийг шалгах;
- Зочид жуулчдын хооллох цагийг асууж, гал тогоо болон зоогийн газрын үйлчилгээний албанд мэдэгдэх;
- Хоолны асуудалтай хүн байгаа бол мэдээллийг гал тогоо болон зоогийн газрын үйлчилгээний албанд мэдэгдэх;
- Захиалгын хоолон дээр хоолны асуудалтай хүн эсвэл тусгай захиалга ирвэл гал тогоо болон зоогийн газрын үйлчилгээний албаныханд эрт хэлж бэлдүүлэх;
- Өглөөний цайны цагийг урьд өдрийн оройн хоолны дараа, өдрийн хоолны цагийг өглөөний цайны дараа, оройн хоолны цагийг өдрийн хоолны дараа асууж лавлах, мэдээллийг гал тогоо болон зоогийн газрын үйлчилгээний албаныханд мэдэгдэх
- Өглөөний цайн дээр шинэхэн өрөм, тараг, сүү зэргийг нутгийн малчин айлуудаас авчруулан бэлдүүлэх;
- Өглөөний цай хэрэв буфет бол бэлдсэн хүнс хангалттай эсэхийг шалгах;

Өдрийн хоолонд анхаарах зүйлс:

- Ширээнд салат, нэгдүгээр хоол, хоёрдугаар хоол, амттан гэсэн хоолны хэрэгслүүдийг бэлдэж тавих;
- Өдрийн хоолны ширээн дээр цэвэр ус тавих;
 - Цай кофе сонголтоор тавих
 - Гар ариутгагч болон гарын нойтон салфетка эсвэл гарын нойтон халуун алчуураар үйлчлэх

Оройн хоолонд анхаарах зүйлс

- Ширээнд салат, хоёрдугаар хоол, амттан гэсэн хоолны хэрэгслүүдийг бэлдэж тавих;
- Цай кофе сонголтоор тавих;
- Гар ариутгагч болон гарын нойтон салфетка эсвэл гарын нойтон халуун алчуураар үйлчлэх;

Жуулчны баазад өдөр, оройн хоол нь стандартын дагуу байх бөгөөд үндэсний онцлогт тохирсон хоолоор үйлчилж буй тохиолдолд доорх дүрэм журмуудыг мөрдөнө.



Зураг №112-113 Жуулчны баазын нэрийн хоол

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЗООГОНД ҮНДСЭН ХООЛООР ОРУУЛАХ БОЛОМЖТОЙ ХООЛНУУД:

Үндсэн хоолыг өдөр, оройн хооллолтын үед хэрэглэдэг. Цэсийн дагуу шөлтэй хоолны дараа хэрэглэдэг учир хоёрдугаар хоол ч гэж нэрлэдэг. Үндсэн хоолыг хүнсний олон нэр төрлийн бүтээгдэхүүнээр бэлтгэх тул хүний бие махбодод зайлшгүй шаардлагатай илчлэг, тэжээллэг бодисын эх үүсвэр болж цатгах үйлчилгээ үзүүлдэг гол хоол юм.

Үндсэн хоолны ач холбогдол:

- Хооллох сонирхол төрүүлэх
- Цадах мэдрэмж төрүүлэх
- Биеийн алжаал ядаргааг тайлах, тайвшруулах
- Биед эрч хүч өгөх
- Бие махбодыг хэрэгцээт бодисоор хангаж дархлаа сэргээх
- Бодисын солилцоог сэргээх, сайжруулах

Үндсэн хоолыг боловсруулалтын төрлөөр нь:

1. Чанасан
2. Шарсан
3. Жигнэсэн
4. Битүү шарсан гэж ангилдаг.

/Хоол үйлдвэрлэлийн технологи, УБ.2020 он. 203-р талд /

Үндсэн хоолны төрлүүд

- Дал дөрвөн өндөр / хонины дал, дөрвөн өндөр хавирга, гурил, шар манжин, төмс, лууван, сонгино, лаврын навч, давс, хар чинжүү, хөмүүл /
- Жимбий /Хонины ястай мах, төмс, шар лууван, сонгино, саримс, гурил, исгэгч, давс, зэрлэг гоньд, хар чинжүү, перец /
- Хонины махан ороомог /хонины нуруу, сүвээний мах, шар лууван, шар манжин, давс, хар чинжүү, хөмүүл, оёдлын олсон утас /
- Цагаан шувуу /хонины сүүл, хонины гуяны цул мах, лууван, байцай, амтат чинжүү, сонгино, давс, хар чинжүү, ус /
- Хонины махан шорлог /хонины гуя, далны мах, сонгино, давс, хар чинжүү, шор /
- Шанзалсан цоохор сархинаг / хонины мах, зүрх, элэг, бөөр, уушги, байцаа, лууван, сонгино, монгол бяслаг, цөцгий, халиар, давс, хар чинжүү /
- Хорхог /хонины ястай мах, төмс, лууван, манжин, сонгино, давс, хар чинжүү, чулуу /
- Гурван өндөр /хонины сээр, хонины хавирга, хонины нуруу, лаврын навч, давс, хар чинжүү, төмс, лууван, сонгино, саримс, зуурсан гурил, ясны шөл, сонгино, өргөст хэмх, дарсан өргөст хэмх, дарсан чинжүү /
- Хуушуур /хонь болон үхрийн мах, гурил, сонгино, ургамлын тос, хар чинжүү, давс, ус /
- Халиар хонины сүүлтэй /хуушуур, халгайн гурилтай хуушуур, халиартай хуушуур гэх мэт орц найрлагаасаа хамаараад өөр олон төрлийн хуушуур хийж болно.
- Бууз /хонины мах, гурилан зуурмаг, сонгино, хар чинжүү, давс, ус /
- Шарсан банш /хонины мах, зуурсан гурил, саримс, давс, хар чинжүү, гоньд, цөцгий, цөцгийн тос, ус /

Тураг махан монгол шөлтэй хоолонд:

- Битүү шөл / Хонины мах, гурил, сонгино, давс, хар чинжүү, ясны шөл /
- Халиартай бантан / Хонины мах, гурил, сонгино, хар чинжүү, дарсан халиар, давс, ясны шөл /
- Аарцтай шөл /Аарц, хонины мах, зуурсан гурил, үхрийн чөмөгний яс, сонгино, давс, хар чинжүү, зэрлэг гоньд, ус /
- Олгойтой шөл /Хонины олгой, хонины гол мах, төмс, лууван, сонгино, саримс, юуцай, мөөг, хөмүүл, давс, ясны шөл /

- Банштай хавиргатай шөл /Хонины мах, хонины хавирга, гурилан зуурмаг, сонгино, давс, ясны шөл/
- Борви тойгны шөл /Үхрийн тойг, хонины борви, давс, улаан чавга, ус/
- Халгайтай шөл /Хонины мах, гурил, төмс, лууван, сонгино, манжин, нунтаг халгай, зөөхий, ясны шөл, хар чинжүү, давс/
- Гишүүний амтлаг шөл /Гишүүний бэлэн нухаш, нимбэг, элсэн чихэр, цардуул, ус/
- Бинтэй хар шөл /Хонины мах, сонгино, давс, гурил, халиар/
- Гичгэнэ үхрийн борцтой шөл /Үхрийн борц, гичгэнэ, сонгино, давс, гоньд, ясны шөл/
- Хатаасан бяслагтай шөл /Хонины мах, түүхий сүүний хатаасан бяслаг, сонгино давс, хар чинжүү, гоньд, ясны шөл/

ТОЛГОЙ ШИЙР БОЛОН ТАВАН ЦУЛААР ХИЙХ ХООЛНУУД

Толгой шийрээр хийх хоолны төрлүүд

- Хонины чанасан толгой / хонины толгой, төмс, лууван, манжин, давс, хар чинжүү, лаврын навч/
- Баян ходоод /хонины ходоод, шингэн шинэ цус, сэмж, элэг, өлөн гэдэс, гурил, манжин, лууван, сонгино, давс, хар чинжүү, ус/
- Зайдас /хонины нарийн гэдэс, шингэн цус, гурил, ус, манжин, лууван, сонгино, давс, хар чинжүү, переш/
- Гүзээн хорхог /хонины гүзээ, хонины мах, төмс, лууван, манжин, сонгино, лаврын навч, давс, хар чинжүү, чулуу/
- Шарсан элэг /үхрийн элэг, сонгино, хонины сүүл, сонгино, давс/
- Гүзээн хигдэс /Үхрийн гүзээ, лууван, сонгино, саримсны иш, хөмүүл, давс, хар чинжүү, эвэр чинжүү, ургамлын тос/
- Ороомгон зайдас /Хонины гол мах, хонины элэг, хонины гүзээ, сэмж, нарийн гэдэс, лууван, манжин, төмс, сонгино, цөцгийн тос, давс, хар чинжүү, гоньд, лаврын навч, брокколи, ясны шөл/
- Сүүл хавчуулж шарсан элэг /Элэг, хонины сүүл, цөцгийн тос, брокколи, амтат чинжүү, давс, хар чинжүү, хөмүүл /
- Толгойн махан зууш /Хонины толгой, хонины сүүл, лууван, сонгино, жууцай, таван салаа/
- Цэлцэгнүүр /Үхрийн тагалцаг, хоины сүүл, лууван, сонгино, давс, хар чинжүү, лаврын навч, ус/
- Таван цулын хуурга /Уушги, элэг, гүзээ, зүрх, бөөр, ургамлын тос, сонгино, давс, хар чинжүү/
- Сүмстэй үхрийн хэл /Үхрийн чанасан хэл, төмс, лууван, ясгүй улаан чавга, хулуу, ургамлын тос, давс, хар чинжүү, таван халуун/
- Таван цулын хуушуур /Уушги, элэг, гүзээ, зүрх, бөөр, гурил, сонгино, давс, хар чинжүү/
- Таван цулын бууз /Уушги, элэг, гүзээ, зүрх, бөөр, гурил, сонгино, давс, хар чинжүү/
- Гургалдай /Үхрийн хошного, үхрийн өөхтэй цул мах, гурил, дарсан өргөст хэмх, үрлэн улаан лооль, хар чинжүү, лаврын навч, давс/
- Гүзээн хуурга /Чанасан гүзээ, шар лууван, сонгино, давс, хар чинжүү/
- Чанасан шийр /Богийн шийр, хонины сүүл, бөөрөнхий сонгино, давс, лаврын навч, хар чинжүү/

Дотор махан шөлтэй хоол

- Их тамир /Бөөр, зүрх, элэг, гүзээ, уушги, гурилан зуурмаг, давс, сонгино/
- Таван цулын борц, ямаахайтай шөл / Таван цулын борц, хөц будаа, ямаахайн үндэс, саримс, давс, хар чинжүү, ясны шөл/
- Ямаахайтай таван цулын битүү шөл / Хонины зүрх, хонины уушги, хонины бөөр, хонины гүзээ, хонины ходоод, ямаахай, гурил, сонгино, саримс, давс, гоньд, хар чинжүү/
- Хярамцагтай гурилтай шөл/ Хярамцаг, гурил, сонгино, давс/
- Хөц будаатай хярамцагтай шөл /Хярамцаг, хөц будаа, сонгино, давс, хар чинжүү/

Сүү цагаан идээ, ногоотой хоол

- Аарцтай үзэмтэй будаа /Цагаан будаа, аарц, үзэм, цөцгийн тос, элсэн чихэр/
- Аарцтай будаа /Цагаан будаа, аарц, цөцгийн тос, элсэн чихэр, өтгөрүүлсэн сүү, гурил/
- Бэрээс /Будаа, үзэм, цөцгийн тос, элсэн чихэр ургамлын тос, давс/
- Шар будааны зутан /Шар будаа, сүү, элсэн чихэр, цөцгийн тос, давс/
- Өрөмтэй шар будаа /Шар будаа, шинэ өрөм, элсэн чихэр, давс/
- Цагаан төмсний шөл /Зэрлэг цагаан төмс, лууван, зөөхий, элсэн чихэр, сүү, давс, гурил/
- Буцалгасан аарц /Аарц, шар тос, гурил, элсэн чихэр, давс/
- Сүүний амтлаг зутан /Сүү, гурил, шар тос, элсэн чихэр давс/
- Сүүтэй гурил /Сүү, гурилан зуурмаг, шар тос, давс, шар тос, элсэн чихэр, давс/
- Ингэний буцалгаа /Ингэний хоормог, гурил/





Монгол хоол олгох зарчим

Монголчууд голдуу бүхэл махан, тослог ихтэй хоол хийдэг тул жуулчдад олгохдоо дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Махаа зөөлөн болгосон байна.
- Ястай нь жижиглэн чанасан байна. /Хонины чөмөгний ясыг гурав хувааж чанах/
- Тухайн хоолонд тохирох тавгийг сонгосон байх ба ширээ засалтыг зохион байгуулна.
- Хоолны багаж хэрэгслийг иж бүрнээр нь олгох ба стейкний хутга тавьсан байна. /жич: маханд зориулагдсан учраас тавина/.
- Хоолыг дагалдуулж нэмэлт амтлагчуудыг сонголтоор байрлуулсан байна.
- Хуурай болон нойтон сальфетка тавьсан байна.
- Хоолны бие бүтцийг алдагдуулахгүйгээр чанаж, шарж, жигнэж болгосон байна.
- Нэг хүний порцоор таваглана.
- Тослог болон хурц шөлтэй хоолыг олгохгүй /жич: Хоолонд зохицсон дарс, халуун цай, ундааг санал болгох,/.
- Сонирхол татсан, өнгө үзэмжтэй байдлаар чимэглэн тавагласан байна.
- Хоол бүрд тохирох соусыг олгосон байна.
- Аргуу махан хоолыг олгохгүй байна.
- Удсан хачир, сүмстэй хоолыг олгохгүй байна.
- Үл зохицох хүнсийг холихгүй байх.
- Цагаан будаа, төмс хоёрыг хамтад нь олгохгүй байх /жич: цардуул ихтэй, удаан шингэдэг/
- 2 цагаас дээш хадгалагдсан хоолыг борлуулахгүй ба устгалд оруулах.
- Жуулчдын хүсэлтээр болон сэтгэл хөөрлөөр хорхогны өтгөн тостой шөлөөр үйлчлэхгүй байх.
- Жуулчдад олгох шөлөө тунгалагжуулсан байна.
- Мах ихтэй хоолыг олгохдоо ногооны зууш, саладыг хамт олгоно.

- Монгол хоол хийж буй үйл явцыг жуулчдад харуулах /жич: хорхог хийх үйл явц/.
- Шүүслэг ихтэй хоолоор үйлчлэх тохиолдолд даавуун сальфеткаар үйлчилнэ.
- Монгол хоол нь хүнд төрлийн хоолондоо ордог тул оройн хоолны цагийг эрт өгөхөөр зохион байгуулсан байна.

Хүснэгт №9 Ширээ засах технологи

Ширээ засалтын төрөл	Ширээнд байх бүрдэл	Ширээ засалт
Энгийн ширээ засалт	<ul style="list-style-type: none"> ▪ Суурь таваг ▪ Талхан таваг ▪ Цөцгийн тосны хутга ▪ Үндсэн хоолны сэрээ, хутга ▪ Амтлаг хоолны халбага, сэрээ ▪ Ус ундааны шилэн аяга ▪ Даавуун сальфетка 	 <p>Formal Breakfast Table Setting</p> <ol style="list-style-type: none"> 1. Lunch Plate 2. Bread/Bowl 3. Lunch Fork 4. Napkin 5. Lunch Knife 6. Spoon 7. Drink Plate 8. Water Goblet 9. Coffee Cup 10. Coffee Saucer 11. Cup and Saucer
Өглөөний цайны ширээ засалт:	<ul style="list-style-type: none"> ▪ Суурь таваг ▪ Үндсэн хоолны хутга, сэрээ ▪ Халбага ▪ Талх, цөцгийн тосны таваг ▪ Цөцгийн тосны хутга ▪ Цай кофены суурьтай аяга ▪ Цай кофены халбага ▪ Жүүсний шилэн аяга ▪ Сальфетка 	 <p>Breakfast</p> <ul style="list-style-type: none"> Bread & Butter Plate Water Goblet Coffee Cup & Saucer Butter Knife Dinner Fork Napkin Bowl Dinner Plate Knife Spoon
Өдрийн хоолны ширээ засалт:	<ul style="list-style-type: none"> ▪ Суурь таваг ▪ Үндсэн хоолны хутга, сэрээ ▪ Шөлний халбага ▪ Зуушны хутга, сэрээ ▪ Амтлаг хоолны халбага, сэрээ ▪ Ус ундааны шилэн аяга ▪ Дарсны хундага ▪ Сальфетка 	
Оройн хоолны ширээ засалт	<ul style="list-style-type: none"> ▪ Суурь таваг ▪ Үндсэн хоолны сэрээ, хутга ▪ Зуушны хутга, сэрээ ▪ Амтлаг хоолны сэрээ, халбага ▪ Ус ундааны шилэн аяга ▪ Дарсны хундага ▪ Сальфетка 	

Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах

1. Цэвэрхэн хадгал / Хоол бэлтгэхдээ, 00-д орсны дараа гараа угаа, 1,3 шарх сорвитой бол усны хамгаалалттай лент наах, хоолны бэлтгэл ажлын үед аяга, шанагыг гадар, доторгүй угаах, гал зуухаа гаднын шавж хортноос хамгаал/
2. Түүхий болон бэлэн хүнсийг тусад нь хадгал. /Идэхэд бэлэн хүнсийг түүхий хоолны доор хийж хөргөгчид хадгалж болохгүй, хутга, махны гамбанз нь тус тусдаа байна. Өөр өөрийн гэсэн баглаа боодолтой байна./
3. Хоолыг хийхдээ нарийн зохион байгуулалттайгаар хий. /Улаан мах, өндөг, далайн хүнсийг тус тусад нь ялгаж хий/ Хийгээд үлдсэн хоолыг дахин үйлчилгээнд гаргах гэж байгаа бол 75 градусаас дээш халаахгүй байх, хийсэн хоолоо 2 цагийн дотор гарга./
4. Хоолоо аюулгүй температурын хэмжээнд хадгал. /Хийсэн хоолоо өрөөний температурт 2 цагаас дээш хадгалж болохгүй, хүйтнээр нь өгдөг хоол, зууш, сүү, өндгөн бүтээгдэхүүнийг хөргүүрт хадгалахдаа 4 хэмээс дээшгүй байлгана. Халуунаар үйлчилдэг хоолуудыг үйлчлэхээс өмнө +60 градусаас дээш мармитанд хадгална./
5. Түүхий эд зүйлсэд аюулгүй, эрүүл ус ашиглана. Хүнсний түүхий бүтээгдэхүүнүүдийг нэрхүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн газраас худалдаж ав. Сонгохдоо хамгийн сайныг нь хамгийн шинийг нь сонгож ав. Ундны усаар түүхий ногоогоо угаа. Түүхийгээр нь иддэг жимснүүдийг маш сайн угаа. Хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг битгий хэрэглэ./

Жуулчны баазын рестораны зөөгчийн ажил үүргийн зааварчилгаа

Алхам 1: Зөөгчийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөж ажиллах

Хувийн зохион байгуулалт

- Хувийн ариун цэвэрт анхаарч бэлдэнэ.
- Дүрэмт хувцсаа өмсөнө.
- Ажлын байранд аюулгүй байдлыг мөрдөж ажиллана.
- Үйлчилгээнд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг шалгана.
- Угаалга цэвэрлэгээнд резинэн бээлий өмсөнө.
- Үйлчилгээний багаж хэрэгслийг угаах үед халтирахаас болгоомжлон алчуур болон резинэн шалавч дэвсэнэ.
- Зочны хоолны тавгийг хураасны дараа, хүнсний бүтээгдэхүүн барьсны дараа, хог хаягдал хаясны дараа зэрэг ямар нэгэн бохир зүйлд хүрсний дараа гараа байнга угааж зочинд үйлчилнэ.

Үйлчилгээний заал танхим

- Үйлчилгээний заал танхимын шаланд халтиргаа гулгаа үүссэн эсэхийг шалгана.
- Шалны эвдрэл гэмтлийг шалгах, хэрэв эвдрэл гэмтэлтэй хэсэг байвал инженер техникийн албанд даруй мэдэгдэн үйлчилгээ эхлэхээс өмнө засуулна.
- Үйлчилгээний шаазан болон металл эдлэлийн эвдрэл гэмтлийг шалгах ба солиулна.
- Даавуун эдлэлийн уранхай, цоорхой, толботой эсэхийг шалгах ба солиулах бол угаалгад өгч шинээр солиулна.
- Ширээний гоёл чимэглэлийг угааж арчин үйлчилгээнд бэлдэнэ.

Алхам 2: Ажлаа эхлүүлэхийн өмнө хийгдэх ажлууд:

- Ажил эхлэхээс 15 минутын өмнө ажлын байранд бэлэн байна.
- Хувийн бэлтгэлээ хангана.
- Тогоочоос тухайн өдрийн ажил үүргийн хуваарийг авч танилцана.
- Тухайн өдрийн хоолны цэстэй танилцана.
- Ажил үүргийн хуваарийн дагуу ажлын байраа бэлдэнэ.
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгслүүдийг угааж өнгөлнө.
- Үйлчилгээнд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэн, ашиглалтыг шалгана.
- Заалны шал, цонх, хивс цэвэр байгааг шалгана.
- Заалны ширээ сандалын ариун цэвэр эрүүл аюулгүй байдлыг шалган, арчиж цэвэрлэж, үйлчилгээнд бэлдэнэ.
- Үйлчилгээнд хэрэглэгдэх ус ундаа, хүнсний бүтээгдэхүүнүүдийг бэлдэнэ / савлагдсан ус ундааг арчиж тавина/.
- Групп жуулчдын захиалгын дагуу ширээг засахдаа хоолны цэсний дагуу засна.

Алхам 3: Зочинд хоол олгох үйлчилгээ

- Зочидтой мэндэлнэ.
- Хоол олгохдоо группийн ахлагч болон тус группийн хамгийн ахмад настай эмэгтэйгээс эхэлж баруун гар талаас нь /уучлаарай хадагтай, эрхэм ээ/ хэмээн хэлж олгоно.
- Хоолоо эхний зочинд олгосны дараа цагийн зүүний дагуу нар зөв хоолоо олгоно.
- Хоол олгох зуураа зочдод юу хэрэгцээтэй байгааг ажиглаж мэдэрнэ.
- Хоолыг хоол олгох дараалалаар олгоно /жич: зууш, шөлтэй хоол, үндсэн хоол, амтлаг хоол/.
- Бүх зочинд зууш олгож дууссаны дараа нэмэлт захиалга байгаа эсэхийг асууж, хэрэв байхгүй бол “сайхан хооллоорой та бүхэн” хэмээн хэлээд текний гадна талд зогсоно.
- Европ зочдод өдөр, оройн хоолны ширээн дээр заавал цэвэр ус, талх, масло тавьсан байна.
- Зочин эхний хоолоо идэж дуусахаас өмнө зөөгч гал тогоонд дараагийн хоолыг таваглах дохио хүргэнэ.
- Зочны хоёр дахь хоолыг гал тогооноос авч зочинд олгоно.
- Зочинд хоёр дахь хоолыг олгох зуураа зочны ус ундаа, цай кофены аяга суларч байгааг ажиглан дахин захиалах талаар лавлана.
- Зочдын ширээнээс холдохоос өмнө нэмэлт захиалга байгаа эсэх талаар асуун “сайхан хооллоорой” хэмээн эелдгээр инээмсэглэн хэлнэ.
- Эхний зочин зуушаа идээд дуусмагц зочноос тавгийг авахдаа эелдгээр “Уучлаарай таны тавгийг авч болох уу” хэмээн асууж зүүн гар талаас авна.
- Зочдын хоол идсэн тавгийг хураахдаа хоёр эсвэл гурван тавагны барилтаар хураана.
- Бохир таваг, багаж хэрэгслийг зочдын ширээнээс хураан гал тогооны угаалгын хэсэгт хүргэнэ.
- Зочны хэрэглэсэн тавгийг авах зуураа ширээн дээр хэрэглэсэн сальфетка болон бусад хог, шил шаазан эдлэл, багаж хэрэгсэл байвал бусдад саад болохгүйгээр авна.
- Түрүүлж хоолоо идсэн зочныг хүлээлгэхгүйгээр дараагийн хоолыг зочинд авчирч өгнө.
- Хэрэв зочид зөөгчөөс хоолны орц, түүхий эд, технологийн боловсруулалт, амт чанарын талаар асуувал тогоочийн өмнөөс зочдод эелдэг зөв тайлбарлана.
- Зочдын хоол хүлээгдэхээр бол зөөгч 6-12 минутын хугацаанд гарах талаар зочинд мэдээлэл хүргэнэ.
- Зочинд үндсэн хоол олгогдсоны дараа цай, кофег олгоно, хэрэв зочин хүсвэл үндсэн хоол хүлээхгүйгээр цай, кофег олгоно.
- Зочин бармены үйлчилгээг авч буй тохиолдолд төлбөрийг тооцооны хуудсанд

бичиж зочноор гарын үсэг зуруулж баталгаажуулах ба тооцоогоо бэлнээр хийнэ.

- Зочны захиалгаас хамаарч ширээн дээр зассан шил шаазан эдлэл болон хоолны багаж хэрэглэлийг хураах эсвэл нэмэлт засалт хийнэ.

Алхам 4: Зочинтой төлбөр тооцоо хийх үйл явц

- Зочин хоолны үйлчилгээ авч дуусаад зөөгчтэй тооцоогоо хийхийг хүсдэг. Зөөгч зочинтой төлбөр тооцоо хийхээс өмнө тооцооны хуудсыг сайн нягталж шалгана.
- Зочны тооцооны хуудсан дахь тооцоог зөв гэж үзвэл тооцооны хавтсанд хийж зочинд өгнө.
- Зөөгч зочинтой тооцоо хийх гэж байх үедээ аюулгүй байдлын үүднээс анхаарлаа төвлөрүүлэх ёстой.
- Зочинтой төлбөр тооцоог дараах хэлбэрүүдээр хийж болдог. Үүнд:
 - Бэлэн мөнгөөр
 - Картаар
 - Нэхэмжлэхээр
 - Аяллын болон хувийн чекээр
 - Эрхийн бичиг болон хөнгөлөлтийн картаар гэх мэт
- Зочинтой төлбөр тооцоо хийж дууссаны дараа манай үйлчилгээ тааламжтай байсан эсэх талаар сэтгэл ханамжийг нь асууна.
- Манай жуулчны баазын зоогийн газраар дахин ирж үйлчлүүлэхийг хүснэ.
- Зочныг зөөгч үдэн гаргана.

Алхам 5: Ус ундаагаар үйлчлэх

- Ус ундааны цэсийг зочны баруун гар талаас олгоно.
- Зочны захиалгад зөвлөгөө өгнө.
- Захиалгыг тооцооны хуудсан дээр тэмдэглэн авна.
- Зочинд захиалгыг давтан хэлж баталгаажуулна.
- Зочинд ус ундааг олгохдоо зориулалтын шилэн аяганы 2/3-т хийнэ.

Алхам 6: Цай, кофегаар үйлчлэх

- Цай нь маш олон төрөл байх ба ургамлын, жимсний, тусгай найрлага бүхий химийн гаралтай бүтээгдэхүүний хольцтой цай гэж байдаг. Хүмүүс ихэвчлэн ургамлын гаралтай цайг сонгон хэрэглэдэг.
- Зөөгч нь цайг зочинд санал болгохдоо захиалсан хоолтой нь зохицох халуун ундааг эрүүл мэндийн хувьд ач холбогдолтой талаас нь санал болгоно.
- Цайны ургамлыг 2 төрлөөр ашиглан цайг бэлдэнэ. Үүнд:
 - Ургамлыг задгайгаар нь гүцтэй халуун усанд хийж хандална.
 - Тусгай пакеттай цайг халуун усанд хийж найруулна.
- Цайг хандлан найруулахдаа цайны амт, өнгийг гаргасны дараа зочинд олгоно.
- Зочинд цайг олгохдоо цайны аяга болон аяганы суурь, халбаганы хамт олгоно.
- Цайг сахартай хамт олгох бөгөөд сахарыг тусад нь зориулалтын саванд хийж, сахарын хавчаарын хамт олгоно.
- Зочинд олгож буй цайны аяганы сэнж баруун гар тал руу буюу 5 цагийн байрлалд харсан байдлаар олгоно.

Алхам 7: Дарсаар үйлчлэх

- Зочин хоолны даруулга болгон дарс захиалж байгаа тохиолдолд зочны сонгосон хоолонд зохицох дарсыг санал болгон зөвлөнө.
- Дарсны цэсийг олгохдоо зочны зүүн гар талаас олгоно.
- Зочин ямар ч тохиолдолд дарс захиалж байгаа үед дарсыг сонгуулна.
- Зочны сонгосон дарсыг зочны зүүн гар талаас танилцуулна.
- Зочны захиалсан дарс зөв байвал дарсыг мөстэй хувинд хийнэ.
- Зочин руу дарсны шошгыг харуулан дарсны талаар тайлбарлана.

- Дарсыг зочны дэргэд онгойлгож дарсны амсрыг арчина.
- Зочны сонгосон дарсыг 30-50 мл-ээр хундагалан амталгаа хийлгэнэ.
- Амталгаа хийсний дараа зочинд таалагдвал хамгийн түрүүнд эмэгтэй зочинд эхэлж хундагална.
- Дарсыг эмэгтэй зочноос эхлэн цагийн зүүний дагуу тойрч 120 мл, 150 мл, 180 мл- ээр хундагална.
- Дарсыг хундагалж дууссаны дараа үлдсэн дарсыг ширээн дээр зориулалтын тавиурт болон сагсанд хийж тавина.
- Хэрэв дарс хундагалж дуусаад хоосон лонхыг мөстэй хувинд амсрыг нь доош харуулан хийж, зөөгч хураан авч явна.

Зөөгчийн ажил үйлчилгээндээ баримтлах зарчим

1. Зоогийн газрын зааланд чанга ярихгүй байх;
2. Зааланд байхдаа нүүр, үсээ оролдохгүй, халаасандаа гараа хийж зогсохгүй байх;
3. Бармены тек, хана, сандал, ширээ налж зогсохгүй байх;
4. Зочинд үйлчилж байхдаа нуруугаа харуулж үйлчлэхгүй байх;
5. Зааланд зочны дэргэд гүйхгүй, хэт удаан хөшүүн алхахгүй байх;
6. Бохир таваг хэрэгслийг хураахдаа зочны ширээн дээр поднус тавихгүй, хэт олноор нь таваг хэрэгслийг авч явахгүй байх;
7. Зочдынхоо хэрэгцээг түрүүлж мэдэрч үйлчлэх;
8. Зочдод үйлчилгээ үзүүлэх үедээ бүтээгдэхүүнийхээ талаар тайлбар өгч ярилцахаас өөрөөр хувийн яриа өрнүүлж болохгүй, мөн зочны хоол руу харахгүй нүд рүү нь харж ярих;
9. Зөөгчийн гар алчуурыг зөв хэрэглэх ба цэвэрхэн авч явах;
10. Зочин нэмэлтээр таваг, хэрэгсэл хүсвэл цэвэрхэн байдлыг шалгасны дараа олгох ба жижиг поднус дээр тавьж олгоно;
11. Поднус дээр таваг, хэрэгслийг өрөхдөө хооронд нь харшуулахгүй байх;
12. Ширээнд аяга таваг, хэрэгслээ олгоходоо дуу чимээ гаргахгүй байх;
13. Хоолыг гараараа барьж болохгүйг анхаарах;
14. Таваг, аяга, шилэн аяганы амсар сэтэрхий эмтэрсэн байвал зочинд олгож болохгүй;
15. Зочинд үйлчлэх үедээ хоол, цайг асгахгүйгээр үйлчлэх;
16. Зочин хоолоо идэж дуусаагүй байхад хурааж болохгүй, заавал асууж хураах;
17. Зоогийн газар хаах үед сүүлийн зочин гараагүй бол цэвэрлэгээг эхлүүлж болохгүй;
18. Аяга, таваг хэрэгслийг шалан дээр унагасан тохиолдолд шинийг авчирч өгсний дараа унагасныг хураах;
19. Зочин хооллож буй ширээний бохирыг байнга ажиглаж тухай бүрд нь хурааж байх;
20. Зочдын өмнө үйлчилгээний ажиллагчид хоорондоо сул яриагаар ярих, сугадалцах, инээлдэх, чанга чанга ярилцах, хэт дотно харьцаа болон бүдүүлэг авир харуулж болохгүй;
21. Зочинд хоол олгосны дараа захиалга бүрэн олгогдсон эсэхийг хоол олгож байх зуураа шалгаж харах;
22. Нойтон сальфеткийг хоол олгохоос өмнө өгөх ба гараа цэвэрлэсэн даруйд хураах;
23. Байнгын үйлчлүүлэгчийн дуртай болон дургүй зүйлийг мэддэг байх;
24. Зааланд гарахаасаа өмнө гадаад төрхөө анхаарч байх;
25. Зочны нүдэнд яарч, сандарсан царарй харуулахгүй байх, тайван үйлчлэх;
26. Зочин хоолны цэснээс хоол захиалах бол хоолны орц, найрлага, амт, зохицох ундаа усыг тайлбарлаж чаддаг байх;
27. Зочин хэлээгүй байхад зочинд тооцооны хуудас авчирч болохгүй;
28. Зочны мөнгөний хариулт болон картыг жижиг тавган дээр авчирч өгнө.

4.3

ЖУУЛЧДАД БООЛТЫН ХООЛООР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Жуулчид маргааш өглөөний цайны дараа баазаас хөдлөхдөө эсвэл өдрийн аялал явахдаа боолтын хоол баазаас авч явах захиалга өгсөн бол гал тогоо болон зоогийн газрынханд урьд орой нь мэдэгдэж, бэлдүүлэх хэрэгтэй.

- Боолтын хоолны амт чанар, эрүүл ахуйн байдалд анхаарал, хяналт тавих;
- Боолтын хоол нь зөөвөрлөлт, тээвэрлэлтэд тэсвэртэй амархан муудахгүй байх;
- Боолтын хоол нь хүйтнээр нь идэхэд тохиромжтой байх;
- Боолтын хоолоор үйлчлэх тохиолдолд хоолны асуудалтай жуулчдын хоолыг тусгайлан боож, таних тэмдэг тавих;
- Боолтын хоолонд дагалдах ус, амттан зэрэг нь хадгалалт, зөөвөрлөлтөд тэсвэртэй замын нугачаанд амархан гэмтэж хагарахгүйг шалгах;
- Боолтын хоолонд дагалдах нэг удаагийн аяга, халбага, сэрээ, сальфетка зэрэг нь тоогоороо бүрэн байх, мартажгүй байх;
- Боолтын хоолыг урьд шөнө нь биш, үүрээр шинэхэн бэлтгэдэг байх;
- Хоол бүрийн ариун цэвэр, эрүүл ахуйд хяналт тавих;
- Хоол бүрийн үйлчилгээ болон үйлчлэх нөхцөлд хяналт тавих;
- Хоолон дээр ямар нэгэн асуудал, санал гомдол гарвал тэмдэглэл хөтлөх, асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх;

Зураг №114 Жуулчинд өгөх боолтын хоол



/Тахианы бурито- боолтоор хийхэд хамгийн тохиромжтой, амттай/



Боолтын хоолоо нэг удаагийн эко саванд савлан олгоно.

Жуулчны баазын боолтын хоолонд тавих шаардлага ба эрүүл ахуй

Ямар хоолнуудыг боолтын хоолоор өгвөл зохимжтой вэ?

- Үхэр болон тахианы махаар хийсэн хоолууд.
- Боолтын хоолыг хээр халаах боломжгүй газар иддэг тул амьтны гаралтай өөх болон тос хэрэглэхгүй байх. / Эдгээр нь хурдан царцаж гэдэс дүүргэх аюултай тул/
- Боолтын хоолонд хэрэв та үхрийн мах хэрэглэж байгаа бол хэт их өөх хийхгүй байвал зохистой
- Боолтын хоолны салат болон зуушинд амархан муудаж исэлддэг маойнез болон

бусад амтлагч хэрэглэхгүй байх.

- Боолтын хоолонд дагалдаж ирэх амттан нь халуун наранд халж амархан хайлахааргүй шоколад багатай зүйлс сонгох.
- Боолтын хоолны мах нь сайтар жижиглэсэн, хээр шууд идэхэд тохиромжтой байх.

4.4

ЖУУЛЧНЫ БААЗЫН ГЭР РЕСТОРАНЫ ЗААЛ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол гэр рестораныг ихэнх жуулчны бааз ашигладаг. Учир нь хоол, ундааны үйлчилгээ, орчин нь үндэсний хэв маягийг хадгалсан, онцлогийг илэрхийлсэн байдаг.

Заал зохион байгуулалтын шийдэл нь байгалийн үзэмжийг тольдох цонхтой, тойрч суугаад халуун дулаан уур амьсгалыг бий болгодог, булан зай бүрийг ашигладаг, агааржуулалт сайтай, багана, халхавч байхгүй тул үйлчилгээний ямар ч хэлбэрт тохиромжтой байдаг.



Зураг №115 Жуулчны баазын рестораны зохион байгуулалт



Заалны зохион байгуулалтыг хийж өглөөний цайны ширээг засахдаа гэр рестораны нэг талд засаж нөгөө талд нь зочны ширээг засдаг нь зочид чөлөөтэй зорчих, хоолоо сонгон, цаг хэмнэн, үйлчилгээний ажилтанд байнга шаардахгүй, хүний нөөц цөөтэй үед жуулчинд үйлчилгээг хурдан шуурхай хүргэх давуу талтай.

Зураг №116 Жуулчны баазын өглөөний цайны зохион байгуулалт

Өглөөний цайны орчин: Тухайн өглөөний нөхцөл байдлаас орчин өөр өөр байна. Учир нь өглөөний цайны уур амьсгал нь зочинд онцгой ач холбогдолтой. Өглөөний цай нь зочны сэтгэл санаа, биеийн байдалд өдрийн турш чухал нөлөө үзүүлдэг.

Орчноо хэрхэн яаж бүрдүүлэх вэ?

- Заалны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.
- Цэвэр агаар оруулсан байна. Халуун өдөр кондейшн сэрүүнээр ажиллах, хүйтэн нөхцөлд халуунаар үлээх орчныг бүрдүүлсэн байна.
- Ширээ, сандлын байрлал, зохион байгуулалт эмх цэгцтэй байхаар төлөвлөсөн байна.
- Хоолны цэсний дагуу хоолны хэрэгслүүд тавигдсан байна.

4.5

ЖУУЛЧНЫ БААЗАД УРЛАГИЙН ТОГЛОЛТ АМЖИЛТАЙГАААР ЗОХИОН БАЙГУУЛЖ ЖУУЛЧДАД ХҮРГЭХ АРГУУД

Жуулчны баазад амарч буй жуулчдад Монголын урлагийн тоглолтыг нэмэлтээр чимэг болгон өөрсдийн баазыг болон Монголын урлагийг таниулах, жуулчдын алжаал ядаргааг тайлж, амран тухлахад нь тайвшруулах зорилгоор үзүүлж буй тохиолдолд:

- Өглөөний цайны үеэр
- Оройн хоолны дараа эсвэл хооллох үеэр үзүүлбэл зохимжтой.

Жуулчны бааз дээр тоглогдох урлагийн тоглолт нь хэрэв тусгай үнийн саналтай багц тоглолтын үйлчилгээтэй, тогтмол явагддаг бол тусгайлан зассан урлагийн гэр эсвэл танхимтай байх ёстой бөгөөд түүндээ зориулалтын тайз, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж зэрэгтэй байх ёстой. Жуулчдын зураг авалтад зориулсан зориулалтын гэрэл, тайзын засалт, зохимжтой байвал тохиромжтой.



Зураг №116 Жуулчны баазад зохион байгуулах урлагийн тоглолт



Зураг №117 Жуулчны баазад зохион байгуулах
урлагийн тоглолт

Жуулчны бааз дээр зохиогдох урлагийн тоглолт нь зөвхөн үндэсний уламжлалт урлагийн тоглолтоор хязгаарлагдаад зогсохгүй орчин үеийн амьд хөгжмийн хамтлаг, бүх төрлийн хамтлаг дуучдын урлагийн тоглолт, соёлын арга хэмжээний фестивалиуд орно.

Жуулчны бааз дээр үзүүлэх үндэсний уламжлалт урлагийн тоглолтуудыг дараах байдлаар ангилна.

1. Хэсэгчилсэн /Морин хуур, уртын дуучинтай/
2. Ганцаарчилсан /зөвхөн морин хуурч, хөөмий/
3. Багцалсан /Ардын дуу, уртын дуу, морин хуур, монгол бүжиг, бий биелгээ, уран нугаралт, цамын бүжиг, бөөгийн бүжиг, ерөөл магтаал, хөөмий, үндэсний хөгжмийн цөөхүүл/

Урлагийн тоглолтыг жуулчдад хүргэх өөр нэгэн өвөрмөц шийдэл нь эргэн тойрныхоо байгалийн үзэсгэлэнт газрыг сонгон тэнд нь тусгайлан байгалийн тайз засаж байгалийн гэрлийг ашиглан жуулчдадаа үзүүлэх нь дахин давтагдашгүй өвөрмөц онцгой мэдрэмжийг төрүүлдэг сайн талтай. Ингэхдээ цаг агаарын урьдчилсан мэдээг шалгаж, байгалийн цагийг сайтар тооцох хэрэгтэй.



Зураг №118 Жуулчны баазад зохион байгуулах урлагийн тоглолт

Урлагийн тоглолтыг мөн хоол ундны болон арга хэмжээнүүдийн дундуур чимэг болгон тоглуулдаг бөгөөд ингэхдээ хэт их сунжруулж үндсэн арга хэмжээний утгыг алдагдуулахгүй зохион байгуулах нь тохиромжтой.

Урлагийн тоглолтын үзүүлбэр нь танай баазын үндсэн үйлчилгээнд багтдаг, эсвэл өдөр бүр хуваарьт тоглолт хийдэг бол давтан ирэх жуулчид болон хоёроос дээш хоногтой жуулчдад давтан үзүүлж уйдаахгүйн тулд урлагийн тоглолтын хөтөлбөр нь долоо хоног эсвэл өдөр ээлжлэн солих нөөцтэй байх ёстой.

Урлагийн тоглолт зохион байгуулж, жуулчдад хүргэхдээ анхаарах зүйлс:

- Зориулалтын тайз талбайтай байх;
- Тоглолтын үеэр саад болох гаднын дуу чимээгүй байх;
- Техник, тоног төхөөрөмжүүд нь чанарын шаардлага хангасан байх;
- Понограмм, сиди, бичлэг зэрэг нь чанарын шаардлага хангаж, ажилладаг байх;
- Урлагийн тоглолт үзүүлж буй дуучин, бүжигчин хөөмийч, уран нугараач зэрэг арга хэмжээнд оролцож буй бүх оролцогч авьяас чадвартай байж, аюулгүй байдлаа хангасан байх;
- Хэт өндөр үнэтэй, хийсвэрлэл үнэ зохиохгүй байх;
- Урлагийн тоглолтын арга хэмжээ нь төлбөрийн дүндээ дүйцэхүйц чанартай байх;
- Хэт богино эсвэл хэт урт нуршсан, уйтгартай биш байх;
- Жуулчны бааз дээр болж буй урлагийн тоглолт 25-30 минут үргэлжилбэл зохимжтой;

4.6

ЖУУЛЧНЫ БААЗ ДЭЭР СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД ЗОХИОН БАЙГУУЛАХ

Соёлын арга хэмжээг жуулчдын сонирхол чиглэлээр нь:

- Угсаатны өөр ондоо соёл аж байдлыг харуулсан;
- Хүмүүсийн өдөр тутмын ахуй амьдрал дахь уламжлалт соёл, зан заншлуудыг харуулсан;
- Үйл явдал, арга хэмжээг харуулсан;
- Нутгийн уугуул иргэдийн онцлогийг харуулсан;
- Шашны зан үйлийн;
- Урлагийн;
- Нүүдэлчдийн амьдралыг харуулсан;
- Хот суурин газрын аж ахуйн онцлогийг харуулсан гэж ангилж болдог.

Жуулчны баазад зохион байгуулдаг соёлын арга хэмжээг

1. Дотор /зориулалтын барилга байгууламж, хоолны газрууд/
2. Гадаа /байгалийн сайханд тусгайлан зориулан зассан тайз бүхий /



Зураг №19 Жуулчны баазад зохион байгуулах урлагийн тоглолт



Зураг №20 Жуулчны баазад зохион байгуулах урлагийн тоглолт

Жуулчны бааз дээрээ зохион байгуулж болох соёл болон спортын арга хэмжээнүүдийн зарим жишээ:

- Шөнийн шоу /Оддын доор дарс шимэнгээ үндэсний дуу хөгжим сонсох/
- Спортын арга хэмжээнүүд /мини наадам, спорт тоглоом, цэнгээнт тэмцээн, уралдаан, спортын эвентүүд/
- Үндэсний хөгжмийн цөөнх / зөвхөн морин хуур хөгжмөөр тоглолт хийх гэх мэт/
- Амьд хөгжмийн тоглолт / Рок, поп, ардын, эстрад, Азийн, барууны/ Амьд хөгжмийн тоглолтууд нь үндэстэн, угсаатны болон соёлын хүчин зүйлсээс шалтгаалаад маш олон төрөл байдаг тул та өөрийн бааз дээр голлон ирдэг жуулчид, амрагчдын

зан төлөв, сонирхол, хэрэгцээнд нь тулгуурласан хэрэглэгчийн судалгааг хийх шаардлагатай. Тэд ямар жанрын хөгжим, хамтлаг сонирхож байна вэ?

- Орон нутгийн иргэдийн онцлог соёлд таарсан арга хэмжээ /Хонины найр арга хэмжээ нь Төв аймгийн Алтанбулаг сумын “Баянсонгинот” нөхөрлөл жил бүр зохион байгуулдаг.
- Үндэсний язгуур урлагийн хамтлагуудтай хамтран тоглолт зохион байгуулах. / Жонон, Алтай, Тэнгэр аялгуу, Хөсөгтөн, Домог, Алтан ураг, Алтайн Оргил, Эгшиглэн, Арга билиг, Их Монгол, Загасан Ширээт Тамга гэх мэт/
- Орчин үеийн комедиан шоу зохион байгуулах /Юби комедиан, Комеди Лаб, Клуб Комеди, Комеди Клуб Монголиа гэх мэт/.
- Бүжгийн цэнгүүн зохион байгуулах / Мүүн данс, Хатан туул, Улаан сарнай, Хос уянга, Мастер данс гэх мэт/.
- Загварын үзүүлбэрүүд зохион байгуулах

Зуны цагт жуулчны бааз дээр зохион байгуулагдаж байгаа соёлын арга хэмжээнүүд нь ихэвчлэн үдэш болон шөнийн цагт байгалийн гэрэл гэрэлтүүлгийг зохиомол гэрэлтүүлэгтэй хослуулан хийх нь жуулчдад илүү сэтгэгдэл төрүүлдэг. Тиймээс та соёлын арга хэмжээг бааз дээрээ зохион байгуулахдаа цаг агаарын урьдчилсан байдлыг сайтар шалгаж нарийн төлөвлөх шаардлагатай. Арга хэмжээ болж байх үед цас орох, бороо орох, салхи шуурга зэрэг байгалийн үзэгдлүүд гарах тохиолдолд жуулчдын тоогоор нэмэлтээр өгөх дулаан хөнжил, шүхэр, борооны цув гэх мэт нэмэлт зүйлсийг урьдчилан тооцож бэлдсэн байна.

Соёлын арга хэмжээг жуулчны бааз дээр зохион байгуулахад анхаарах зүйлс:

- Жуулчны баазууд нь хотоос зайдуу хөдөө хээр байрладаг тул соёлын арга хэмжээнд оролцох оролцогч нар нь доод тал нь 2-3 цагийн өмнө ирж арга хэмжээнд биеэ бэлдсэн байх;
- Соёлын арга хэмжээнд оролцогчид нь өөрсдийн урлагийн тоглолттой холбоотой дуу бичлэг болон хэрэглэгдэх хэрэгслүүдээ урьдчилан шалгаж бэлдсэн байх;
- Соёлын арга хэмжээг зохион байгуулах баазууд нь зориулалтын тайз, гэрэлтүүлэг болон тоног төхөөрөмжүүдтэй байх;
- Зориулалтын тайз, гэрэлтүүлэг болон тоног төхөөрөмж муутай үед байгалийн гэрэл ашиглах болон байгалийн өвөрмөц тогтцыг ашиглах;
- Байгалийн өвөрмөц тогтцыг ашиглаж буй тохиолдолд жуулчдын болон оролцогчдын аюулгүй байдлыг хангасан байх;
- Соёлын арга хэмжээг гадаа зохион байгуулж байвал сүүдрэвч бүхий сандал суудлыг бэлдэх. Эдгээр нь жуулчдын аюулгүй байдлыг хангасан байх;Соёлын арга хэмжээний үеэр жуулчинд согтууруулах ундаагаар тохируулж үйлчлэх;
- Соёлын арга хэмжээний үед цахилгаан саатвал нөөц мотортой байх. Моторт хэрэглэгдэх түлшний хангалттай нөөцтэй байх;
- Ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээг сайтар хийх;

05

ЖУУЛЧНЫ БААЗАД МОРЬ, ТЭМЭЭН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Жуулчны баазад морь унуулах
2. Жуулчны баазад тэмээ унах, тэмээ аялал зохион байгуулах тэмээ унах үед жуулчдын анхаарах зүйлс аюулгүй ажиллагаа
3. Жуулчны баазын жуулчдад үзүүлж болох нэмэлт үйлчилгээнүүд
4. Орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах, тэдгээрийг сургалтанд хамруулж жуулчдад үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах
5. Жуулчдын тусгай захиалгыг хүлээн авах, түүнийг хэрэгжүүлэх
6. Жуулчдын аюулгүй байдлыг хангах, байрлаж байх үед нь анхаарал халамж тавих
7. Жуулчны баазад мөрдөх халдвар хамгааллын дэглэм



5.1

ЖУУЛЧНЫ БААЗАД МОРЬ УНУУЛАХ

Адуу нь хамгийн бат бөх ястай амьтанд тооцогддог төдийгүй ясны бүтэц нь хүнийхтэй төстэй болох нь тогтоогджээ. Адуу нь салаа туурайтай амьдтын өвчнөөр өвчилдөггүй, харьцангуй эрүүл амьтан ба гадаадын зарим улс оронд (Жишээ нь: Япончууд) Монгол адууны махыг шууд түүхийгээр нь халуун ногоотой хамт хэрэглэдэг.

- Дэлхийд адууны олон үүлдэр, угшил бий болж хөгжин дэвшиж байгаа ч монгол адуу нь эртний хагас зэрлэг хэлбэртэй, ахуйн тал бүрийн хэрэглээнд ашиглах цогц үүлдэр юм.
- Монгол морь нь хагас зэрлэг хамгийн эртний бөгөөд удамшлын бүтцэд нь огт хүний оролцоо ороогүй дэлхий дээрх цор ганц адуу юм.
- Монгол адуу 45 хэмийн хүйтнээс 45 хэмийн халуунд тэсвэртэй.
- Өвлийн цагт зөвхөн туурайгаараа цас малтан хагдарсан өвс, хагд, навч түүж иддэг, нэмэлт тэжээл шаарддаггүй бэлчээрлэдэг онцлогтой.
- Дэлхийн түүхийг бичилцэж, дэлхийг байлдан дагуулж байсан бүх л үеийг чухам монгол морьгүйгээр төсөөлөхийн аргагүй юм.
- Монгол үүлдрийн адууны араг яс маш бат бөх, нурууны болон чашны яс илүү хөгжилтэй, булчин шөрмөс сайтай, амьсгалын замын эрхтэн сайн хөгжсөн, уушиг нь тайван үедээ 40-50 литрийнх багтаамжтай, минутад 8-16 удаа амьсгалдаг, судасны цохилт 24-44, биеийн халуун 37,5-38,5 хэм байдаг.
- Монгол адуу үрсэн төлсөх, сүрэлэн ижилсэх, бэлчээрээ сонгон нутагших, алс хариас эргэж гүйх, цаг агаарын байдлыг урьдчилан мэдрэх, азарга бүр тодорхой тооны гүү хураах, эхээ гишгэхгүй байх, үр төл, байдсаа сүргээс хасах, сүргээ хамгаалах, дагуулах зэрэг бусад амьтанд байдаггүй хосгүй нандин чанаруудтай.
- Монгол адууны 30.5 хувь нь тал хээрт, 19.3 хувь нь өндөр ууланд, 17.3 хувь нь ойт хээрт, 18.9 хувь нь говьд, 14 хувь нь их нуурын хотгорт байдаг адуу эхээс унасан газар, анх амссан гол усаа ямар ч вед олж ирдэг гайхамшигт чадвартай.
- 350 орчим адууны үүлдрийн 58.000.000 сая адуу байдаг ба дараах улс адуугаар тэргүүлж байна.
 1. АНУ –10 сая,
 2. Мексик - 6.3 сая,
 3. Бразил - 5.9 сая тоо,
 4. Монгол-4.1 сая
 5. Хятад – 3.6 сая,

Нэг хүнд ноогдох адууны тоогоороо Монгол Улс дэлхийд тэргүүлдэг.

МОРИН АЯЛЛЫН ТӨРӨЛ ХЭЛБЭРҮҮД

Аяллын төрөл хэлбэр нь улс болгонд адилгүй байгаа нь тухайн орны байгаль түүх соёлоос ихээхэн хамаарч байгаа юм. Нутаг дэвсгэр болон аялал явагдаж буй арга хэлбэрээр нь бүс нутгуудыг ангилан үзвэл:

Хөдөө хээр зэлүүд газар явагдах аялал	Байгалийн сайханд хот суурин амьдралаас хол зайдуу аялана. Энэ аяллыг голдуу Монгол Испани, Финлянд, Монтана, Аргентин гэх мэт орнуудад ихээр явуулдаг.
Мал хариулж адууны фермд ажиллах аялал	Энэ нь адууны ферм дээр байрлан ойр орчныхоо газраар аялан мал хариулж, адууны аж ахуйтай танилцах амралт жуулчлал юм.
Говь цөлийн морин аялал	Энэ аялал нь гол төлөв хагас цөлийн байдалтай газруудад явагддаг аяллын мал хүнд төрөлд хамрагдах тул тухайн хүн өөрийн тэсвэр хатуужлыг шалгах гэвэл энэ аялал ихээхэн тохиромжтой байдаг.
Үндэсний парк байгалийн цогцолбор газарт явагддаг морин аялал	Ховор амьтныг ойрын зайнаас харах болон зэрлэг байгаль нутгийн уугуул иргэдтэй танилцах журмаар гол төлөв хийгддэг
Холимог аялал	Энэ аялал нь тал хээр, уул, говь цөл, байгалийн цогцолборт газруудыг хослуулах журмаар аяллаа зохион байгуулна.
Уулын морин аялал	Аяллын маршрутын явагдах газрууд нь ихэвчлэн уулаар явагддаг бөгөөд ачааны моринд хүнс тэжээл, майхан сав, аяны хөнжил гэх мэт хэрэгтэй зүйлсээ ачиж аялдаг.

МОРЬ, ТЭМЭЭ УНУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХДЭЭ ЖУУЛЧНЫ БААЗЫН АНХААРАХ ЗҮЙЛС

Ихэнх жуулчны бааз жуулчдад морь, тэмээ унуулах үед өөрсдийн гэсэн зориулалтын тоног төхөөрөмж болон аюулгүй ажиллагааны дүрэм журамгүйгээсээ болоод жуулчид морь, тэмээ унаж байх үедээ осолд орох, төөрч будилах, эд зүйлсээ хаях зэрэг асуудал тулгардаг. Тиймээс жуулчны баазууд морь, тэмээ унуулах зориулалтын тоног хэрэгслүүдийг бэлтгэх, морин аяллын хөтчийн дагаж мөрдөх дүрэм журам, аюулгүй байдал, морь, тэмээ унах жуулчдын дагаж мөрдөх дүрэм журам, аюулгүй ажиллагаа зэргийг нарийвчлан зааж өгч үйлчилгээгээ сайжруулах шаардлагатай.

1. Унаширсан эсвэл эмнэг, хашин морь, тэмээ унуулахгүй байх;
2. Хаврын улиралд морь, тэмээгээ сонгохдоо сайтар анхаарч хэт эцэнхий, туранхай морь, тэмээ сонгохгүй байх;
3. Эмнэг хангал, бүрэн цагаашраагүй морь, тэмээ унуулахгүй байх;
4. Тоног хэрэгсэл, аюулгүй байдлыг хангасан эдлэл хэрэглэл хэрэглүүлэх;
5. Морин аяллын хөтчөөр жуулчдад үйлчилсэн туршлагатай, үйлчилгээний ёс зүйтэй хүн сонгох;

Морь, тэмээ унуулах үйлчилгээ үзүүлдэг жуулчны баазууд нь жуулчдынхаа аюулгүй байдлыг хангахын тулд доорх зүйлсээр жуулчдаа хангах ёстой.

- Европ маягийн жуулчинд зориулсан цэрэг эмээл, хэрэв дотоодын жуулчдад морь унуулах бол нөөц монгол маягийн эмээлтэй байх;
- Гутлын түрүү /ус, бороо, цасны хамгаалалттай чанарын шаардлага хангасан байх шаардлагатай. Размерын сонголттой байх;
- Савхин буюу арьсан бээлий /гарт эвтэйхэн цулбуур, жолоо барихад саадгүй байхаар бэлтгэсэн байх;
- Нөхөрсөг, туршлагатай мэргэжлийн хөтөч тайлбарлагчийг бэлтгэх, жуулчдын тоонд хүрэлцээтэй байхаар шийдэх;
- Хамгаалалтын малгайг жуулчдын тоонд хүрэлцэх хэмжээгээр бэлтгэх, цэвэрхэн, бүрэн бүтэн байлгах;
- Нарны түлэгдэлтээс хамгаалах тосон түрхлэг жуулчны баазад худалдан борлуулах;
- Цэвэр усаар тасралтгүй хангах боломжийг хангах;
- Өвдгөвч зэргийг жуулчдын тоогоор өгөх болон илүү нөөцтэй байх;
- Жуулчдад аяллын хөтөлбөр маршрут болон аяллын үед мөрдөх журамтай байх;
- Гарч болох саад бэрхшээлийг ердийн хөсөг унахаас өмнө сануулж анхааруулах;
- Цаг агаарын тохиромжгүй нөхцөлд аялал уналгыг хойшлуулах;

Хямдрал зарлаж жуулчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх. Тухайлбал:

- 10%-ийн хөнгөлөлт / 6-аас дээш хүнтэй групп/
- 10%-ийн хөнгөлөлт /4-өөс дээш ам бүлтэй гэр бүлд /
- 50%-ийн хөнгөлөлт /1-8 насны хүүхэд /

МОРИН АЯЛЛЫН ҮЕД ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧ НАРЫН АНХААРЧ МӨРДӨХ ЗҮЙЛС

Морин аялал гэдэг нь морь унаж аялал хийх сонирхол дээр үндэслэгдсэн, аяллын явцад тухайн газар орны байгаль – түүх соёлын дурсгалтай танилцаж, орон нутгийн хүмүүстэй харилцаанд орж байдаг тусгай сонирхлын аяллын нэг төрөл бөгөөд жуулчны баазуудын түгээмэл зохион байгуулдаг нэмэлт үйлчилгээ юм.

- Аялагчдад чөлөөт байдлыг мэдрүүлэх боломжийг олгодог.
- Морин аялал нь олон төрлийн аяллын хэв шинжүүдийг өөртөө агуулсан цогц аялал бөгөөд жуулчид Монголын нүүдэлчдийн соёлыг мэдрэх нэгэн боломж нь морь унах юм.
- Аюулгүй байдлыг хангаж найдвартай даатгалд хамруулах, тусгай онцлог бүхий хэрэглэгдэхүүнтэй учраас жуулчны морь унах ур чадвар, биеийн чадамжид тохирсон аяллыг зөвлөх, аюулгүй байдлыг хангасан тоног хэрэгслээр хангах нь чухал.

Хөтөч тайлбарлагчдаас ихээхэн дадлага туршлага шаарддаг бөгөөд хөтчийг сонгохдоо үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүй, архи, тамхины хэрэглээ, орон нутаг дахь нэр хүндийг бодолцон сонгох хэрэгтэй.



Зураг №121 Хишиг морин отог дахь морин хөтчийн үйлчилгээ үзүүлж буй нь

Орон нутагт морин аяллыг зохион байгуулахдаа хоёр янзаар маршрутыг хийж болно. Үүнд:

1. Урьдчилан төлөвлөж, тооцсон хөтөлбөр, эвент арга хэмжээнд жуулчдыг оролцуулах;
2. Жуулчдаас гаргасан санал хүсэлтийн дагуу маршрут зохиож жуулчны баазад зохион байгуулах;

Морин аялал нь нэг талаараа эрсдэл дагуулдаг тул урьдчилж тогтоосон маршрут, хөтөлбөрөөр аяллаа явуулах нь зүйтэй. Маршрутыг гол төлөв бага орон зайд байгалийн олон янзын иж бүрдэл хамруулахаар зохион байгуулах хэрэгтэй. Жишээ нь говьд аялал зохион байгуулах гэж байгаа бол элс, заг, уул, амьтад, ургамал, тал хээр, говийн баян бүрд гэх мэт бүх зүйл хосолсон газар явуулбал аялал илүү сонирхолтой байх юм. Эко аялал явуулж байгаа тул аль болох хүн багатай, зэлүүд газар сонгоно. Хээр явж байгаа хүмүүс маршрутын дагуух сумын төв, бензин түгээгүүр зэргээ сайн тооцоолбол зохино. Томоохон компаниуд алсын зайн холбоог хэрэглэдэг. Учир нь элдэв гэнэтийн аюул осол тохиолдоход яаралтай тусламж үзүүлэх, хүнс тэжээлээ базаах, бензин авах зэрэгт хэрэгтэй. Маршрутад худаг ус, ундааны ус чухал бөгөөд хоол идэхийн өмнө гар нүүрээ угаах, мөн бусад хэрэгцээг хангах зорилгоор машиндаа ус нөөцлөх хэрэгтэй.

Морин аяллыг 3 хэлбэрээр зохион байгуулдаг.


- ✓ **Мориор дагнан аялах аялал / үүргэвч ачаагаа моринд ачиж аялдаг/**

Мориор дагнан аялах аялал нь цэвэр эко аялал бөгөөд ямар нэгэн машин дагуулдаггүй. Аяны хөнжил, майхан, солих хувцас, тогоо, шанага, аяга, хоол хүнсээ бүгдийг авч явах ба энэ тохиолдолд аль болох хөнгөн чанарын хоол хүнс, тогоо шанага авч явдаг, явган аялын бэлтгэлтэй адил бэлтгэл хангаж явна. Ямар нэгэн зам дагах шаардлагагүй. Хүссэн газраараа явж зорьсон газартаа хүрэх бололцоотой.



✓ **Машин дагалдуулж аялах аялал /хоол хүнс ачаагаа машинд ачуулж дагуулдаг/**

Машин дагуулж аялах аялал нь аялагч ойр зуурын хэрэглэл, зургийн аппарат, уух зүйлээ үүргэвчид хийн явдаг. Хоол хүнс, ачааг ачсан машин үдийн буудаллах газар юм уу хоногийн товлосон газарт ирээд хоол ундаа бэлдээд аялагчид ирэхийг хүлээдэг. Групп жуулчид энэ аяллыг ихэвчлэн сонгодог.



✓ **Ачаагаа моринд ачаад явганаар аялах аялал**

Ачаагаа моринд ачаад, явганаар аялах аялал нь мориор дагнан аялах аялалтай төстэй. Явганаар аялагч нь өөрийн ойр зуурын хэрэглэх зүйлс, үдийн цайны зүйлээ жижиг цүнхэнд хийж үүрээд бусад хоол хүнсний зүйл майхан сав, тогоо шанага, гудас, мишок, солих хувцас гэх мэт зүйлсээ моринд ачиж аялдаг.

Аюулгүй байдлыг маш найдвартай хангаж өгөх ба аяллыг хэвийн, таатай явуулахад шаардагдах зүйлсийг урьдаас хөтөлбөртөө тусгасан байхын хэрэгцээ зарим зайлшгүй хэрэглээний зүйлсийг жуулчид мартаж, орхигдуулахаас сэргийлж жуулчны баазууд хангаж үнэнд багтааж өгч сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

Иймд морь, тэмээн аялал явуулахдаа өөрийн хөтөлбөр танилцуулгадаа энэ тухай дурдаж, баазын байгалийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ танилцуулах зүйтэй.

Жуулчид морь, тэмээ унахаас өмнө тус жуулчны баазаас тусгайлан гаргаж бэлдсэн өөрсдийн онцлогт тохирсон морь, тэмээ унах аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцаж гарын үсэг зуруулах зайлшгүй шаардлагатай.

МОРИН АЯЛЛЫН ХӨТӨЧ НАРЫН АНХААРАХ БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ




Хориглоно

- Ø Хазаарыг томдуулахыг хориглоно.
- Ø Морины эмээлийг солихгүй байх зорилгоор морины хазаарын зуузайнаас номер зүүх ба эмээл, тохом мөн номертой байхыг хориглоно.
- Ø Хамгаалалтын малгай, түрийгүйгээр морь унуулахыг хориглоно.
- Ø Жуулчид морь унах туршлагатай байсан ч тэднийг хөөргөн хамт уралдах, давхих эсвэл буруу зүйлс зааж өгөхийг хориглоно.

- ∅ Аяллын үед морин дээр утсаар чанга ярих, хөгжим дуу сонсохыг хориглоно.
- ∅ Морин аяллын үед ажлын байран дээр архидан согтуурахыг хатуу чанга хориглоно.
- ∅ Жуулчдын биед зөвшөөрөлгүй хүрэх, зургийг нь авах, доог тохуу, тоглоом хийж монголоор хэт удаан ярьж, чичлэн зааж инээхийг хориглоно.



Зөвшөөрнө, шаардлагатай



Аялалд оролцож буй бүх хүмүүс заавал хамгаалалтын малгай өмссөн байх

Зураг №122 Морь унах хамгаалалтын малгай, түрий өмсөх

- ✓ Толгой хаялдаг болон ялаархдаг морь жуулчдад унуулж буй тохиолдолд хазаарыг маш сайтар тохируулж өгөх шаардлагатай.
- ✓ Морь малынхаа нэр, хэрэглэдэг үгийг жуулчдад зааж өгөх хэрэгтэй.
- ✓ Маршрутын дагуу аялж явахдаа цувааны өмнө нь нэг морин хөтөч, дунд нь орчуулагч, ард нь мөн нэг хөтөч явбал тохиромжтой.
- ✓ Олон хоног аялсны эцэст морь хагсаж, ямар ч номхон адуу ааштай болдог тул аяллын сүүлийн өдрүүдэд морьдод онцгой анхаарал тавих, жуулчин их ирдэг газруудад нөөц морьдтой байх.
- ✓ Аялалд оролцож буй бүх хүн хамгаалалтын малгай заавал өмссөн байх ёстой.
- ✓ Дөрөөний тэнцвэрийг шалгах, дөрөөний сурын чанар бат бөх байгаа эсэхийг шалгах.
- ✓ Эмээлийн тохмыг зөв тохируулж хэрэглэх. Хэрэв жуулчин хүнд жинтэй бол морины нуруу авахаас сэргийлж давхар тохом хэрэглэх.
- ✓ Морин аялал нь олон хоногоор үргэлжлэх тохиолдолд жуулчдын эмээл болон тохом зэргийг солихгүй байх. Учир нь жуулчин болон морь аль хэдийн өөрийн унаж хэрэглэж буй зүйлстэйгээ зохицсон байдаг.
- ✓ Морин аяллын үед жуулчдын аюулгүй ажиллагааг хангаж, жуулчин бүрд морь унаж байх үед анхаарал халамж тавих, аюулгүй байдлыг нь хангаж байхын тулд 5 жуулчин тутамд 1 морин хөтөчтэй байх шаардлагатай. Зарим жуулчны бааз 1 жуулчинд 1 морин хөтөч байхаар төлөвлөж аяллаа хийж байна.
- ✓ Хамгийн өмнө яваа хөтөч гялгар уут, мал амьтны сэг хог хаягдлыг онцгой

анхаарч зайлуулж явна. Ингэснээр морь мал үргэхээс сэргийлэх ба орон нутгийн орчмыг цэвэрлэх шаардлагатай.

- ✓ Жуулчдыг нэг эгнээнд оруулан, заасан зам харгуйн дагуу явах, явуулах заавар зөвлөгөөг алхам тутамд өгөх шаардлагатай.
- ✓ Морин аяллын хөтөч урд гарч зөв замыг сонгон жуулчдад зам гарган явах шаардлагатай.
- ✓ Жуулчдад монгол адууны ааш араншинг сайтар хэлж өгнө.
- ✓ Морины тоног хэрэглэл, эмээлийн олом зэргийг тогтмол сайтар шалгаж хяналт тавина.
- ✓ Жуулчдыг моринд мордуулахдаа морио морины уяанаас холдуулан зайдуу газар авчран унуулах.
- ✓ Морин аяллын хөтөч та Монголын нүүр царай тул өөрийн гадаад үзэмж болон хувийн ариун цэврээ сайтар сахисан байх хэрэгтэй. /нутгийнхаа онцлогийг илэрхийлсэн үндэсний хувцастай байвал зохино./

МОРИН АЯЛЛЫН ҮЕД ЖУУЛЧДЫН АНХААРАХ ЗҮЙЛС

Морин дээр мордохоос өмнө аюулгүй ажиллагааны дүрэм болон анхаарах зүйлстэй танилцаж гарын үсэг зурсан байна.

ЗӨВШӨӨРӨГДӨХ ЗҮЙЛС	ХОРИГЛОХ ЗҮЙЛС
✓ Морь унахаас өмнө биеийн бэлэн байдлаа хангаж шаардлагатай тохиолдолд нойл орж биеэ засаж бэлэн байдалд байх шаардлагатай.	∅ Монгол адуу үнэрт хэт мэдрэмтгий тул хурц үнэртэй ус болон шумуул, шавжнаас хамгаалах цацлага, тос зэргийг ихдүүлэн хэрэглэхийг хориглоно.
✓ Морин аялалд тохирсон хувцас хэрэглэл өмсөх, хөгжим, утас зэргийг тохирсон энгэрийн халаасанд хийхийг зөвшөөрнө.	∅ Монгол адуу хагас зэрлэг учраас дасаагүй дуу чимээнд мэдрэмтгий тул та гар утасны дуугаа хаах, мөн дуугарч шажигнадаг хувцас өмсөж болохгүй.
✓ Морин аяллын үед шагай давсан зориулалтын гутал өмсөнө.	∅ Арзгар ултай болон гоёлын өсгийтэй гутал өмсөхийг хориглоно.
✓ Морин аяллын үед авч явах цүнх, нүдний шил, борооны цув, усны сав зэргээ бэлдэх, аяллын үед хаяж гээхээс болгоомжилж сайтар баглаж баталгаатай цүнх саванд хийж хаяж гээхээс сэргийлсэн байна.	∅ Морин аяллын үед цүнхэндээ харшиж дуугардаг зүйлсийг нэг дор хийхийг хориглоно.
✓ Моринд мордох болон мориноос буух бүрдээ морин аяллын хөтчийн тусламж авна.	∅ Моринд мордох болон мориноос буухдаа өөрсдөө бие дааж буухгүй.
✓ Моринд мордох болон буух үедээ үргэлж морины зүүн талаас мордох.	∅ Морины хөлөөс хол байхгүй бол өшиглөх аюултай. Морьдын араар ойр гарахаас сэргэмжилнэ. /өшиглөх аюултай/

✓ Морины жолоог зөв барина.	∅ Морь унаж буй үедээ жолоо болон цулбуураа гараараа ороож болохгүй. Хэрэв ямар нэгэн зүйл болох тохиолдолд та цулбуур, жолоогоо шууд хаяж дөрөөгөө хөлнөөсөө мултан буухад бэлэн байх ёстой.
✓ Морин аялын явцад замд гуу жалга болон хог хаягдал төмөр утас, хагархай шил зэрэг таарвал хурдаа багасгаж тойрон гарна.	∅ Гуу, жалга, хог хаягдалтай газраар явахыг хориглоно.
✓ Газрын бартаа, жуулчны ур чадварыг харгалзан богино зайд уралдахыг зөвшөөрнө.	∅ Морин аялын үед жуулчид хоорондоо уралдахыг хориглоно.
✓ Хөтчөөр, орчуулагчаар зураг даруулах.	∅ Морин аялын үед цулбуур жолоогоо хаян ус уух, хувцсаа тайлах, морин дээр зураг дарах зэргийг хатуу хориглоно. Авч давхих юм уу булгих аюултай. Жолоо, цулбуураа тавихгүй, ямагт барьж явах ёстой
✓ Мориноос буусан үед хувцсаа тайлах, цүнхэндээ хийхийг зөвшөөрнө.	∅ Хувцас тайлж элдэв хөдөлгөөн хийхгүй. Морь үргэж бусгана.
✓ Мориноос буусан үед дэргэд нь зогсох, дэл, чих, толгойд хөтчийн зөвшөөрөлтэй хүрэх, илэхийг зөвшөөрнө.	∅ Морин аялын үед морины толгойд хүрэх, дэлнээс татах зулгаахыг хориглоно.
✓ Хэт газрын уруу бол мориноос бууж аюулгүй байдлаа ханган морио хөтлөн бууна.	∅ Газрын уруу явж буй тохиолдолд урд талын мориноос зайтай явж хазуулах, өшиглүүлэхээс болгоомжилно.
✓ Морин аялын үед та дөрөөгөө мөчид дөрөөлөн явах, буухдаа мөчид дөрөөлж буухыг зөвшөөрнө.	∅ Морин аялын үед дөрөөгөө лав хийхийг хориглоно.
✓ Дөрөөлөн мордохдоо эхлээд зүүн хөлийг дөрөөнд хийж баруун хөлөө баруун дөрөөнд хийсний дараа хоёр хөлөөрөө дөрөөн дээр тэнцэн босож хоёр дөрөөнийхөө тэнцвэрийг олж хөдлөхийг зөвшөөрнө.	∅ Тэнцвэрээ олоогүй нөхцөлд морио хөдөлгөхийг хориглоно.
✓ Хэрэв таны дөрөө тэнцвэргүй, урт богино байвал морин аялын хөтөчдөө хэлж тэнцвэр хангаж аялалд оролцоно.	∅ Дөрөө урт, богино бол аялыг үргэлжлүүлэхийг хориглоно.
✓ Морь тань явахгүй байвал “Чү Чү” гэж хэлэн хоёр хөлөөрөө зөөлөн давирна.	∅ Морины толгой, хүзүү рүү ороолгох, хамаагүй давчих зэргийг хориглоно.
✓ Хаврын морь улирлаа дагаад бэлчээрийн шим тэжээлээс шалтгаалаад туранхай байдаг тул хурдан бүдрэх, эцэх, цуцах аюултай тул та биеийн тэнцвэрээ мэдэрч, морины жолоог хоёр гараар сайтар барьж жолоогоо сайн залуурдах хэрэгтэй.	∅ Хамаагүй давхихыг болон хавар морины үс гууждаг тул та хэт их ойрхон байх болон налах хүрэх, илэх зэргийг хориглоно.

✓ Зүүн талаас нь очихыг зөвшөөрнө.	∅ Морины хойгуур ойрхон гарвал өшиглөх, эгц урдаас нь очвол самардах, хүзүүн доогуур нь ойрхон шурган гарвал самардах, хазах аюултайг сануулна.
✓ Хавар морь унаж буй тохиолдолд тод өнгийн, гулсамтгай материалтай хувцас өмсөж, толгойгоо боох эсвэл бүч оосортой малгай өмсөж өөрсдийгөө шалз, хувалз болон хачигнаас хамгаална. Морин аялал дууссаны дараа шууд бүх хувцсаа солин сэгсэрч, усанд орно.	∅ Малгайгүй явах, хувцсаа гөвөхгүй, солихгүй баазын ор дэрэн дээр хэвтэхийг хориглоно.
✓ Хунгар цасыг тойрч явна.	∅ Өвөл морь унаж буй тохиолдолд хунгар цасанд зоогдохоос болгоомжилно.
✓ Голоо гарахдаа зааврыг дагана.	∅ Гол усаар гарахдаа хөтчийн зааврыг дагалгүй явахыг хориглоно.

5.2

ЖУУЛЧНЫ БААЗАД ТЭМЭЭ УНАХ, ТЭМЭЭ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТЭМЭЭ УНАХ ҮЕД ЖУУЛЧДЫН АНХААРАХ ЗҮЙЛС, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Тэмээн аялал нь экотуризмын шилдэг загвар бөгөөд орон нутгийн иргэдийн амьжиргаанд бодитой хөрөнгө оруулдаг, уламжлалт нүүдэлчин, малчин соёлыг дэмжсэн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой аяллын хамгийн тод жишээ болдог. Тэмээн аялал нь өдрийн, 3 хоногийн, 7 хоногийн, заримдаа 2 сар гэх мэт хугацаатай явагддаг. Тэмээн аялал зохион байгуулагчид нь жуулчдын сонирхолд нийцүүлэн аяллын хөтөлбөрийг зохиодог.

Монгол Улс, БНХАУ-ын Өвөрмонгол, Шинжаан Уйгар, ОХУ-ын Халимаг, БНКУ зэрэг улсад хоёр бөхт тэмээ байна. Эдгээр үүлдэр нь хоорондоо ижил төстэй бөгөөд гагцхүү оршин буй нутаг орон байгаль, цаг уур, арчилгаа, тэжээллэгийн байдлаас бага зэрэг тоо толгойн зөрүүтэй. Тэмээ бол элсэн цөлийн амьдрах орчинд тохирсон ажлын амьтан бөгөөд зорчигч, ачаа тээвэрлэх чухал тээврийн хэрэгсэл юм.

Тэмээн аяллын явагдах орчин:

Үндэсний парк, байгалийн цогцолборт газарт явагдах аялал	Байгалийн үзэсгэлэнт газар, ховор ан амьтны энэ төрөл нь Монгол, Австрали, Казахстан, Хятад зэрэг улсад явагддаг.
Хөдөө говь цөлд явагддаг аялал	Энэ төрлийн аялал нь томоохон цөлүүдэд хүнд ширүүн нөхцөлд явагддаг ба тэсвэр хатуужил, хүч чадал сорьсон аялал юм. Энэ нь Хойд Америкийн орнуудад ихэвчлэн явагддаг.
Үндэсний парк соёл, амралтын хүрээлэнд явагддаг аялал	Энэ аялал нь тэмээ унуулж үзүүлдэг. Энд тэмээг унаж зураг авхуулах зэрэг орно.

Тэмээн аяллыг явагдах орчноор нь:

- Тэмээгээр аялах аялал: Говьд тодорхой маршрутын дагуу хөтөч тайлбарлагчтай аялах аялал юм.
- Тэмээ унуулах нэг өдрийн аялал: Ойр орчмын үзэсгэлэнт газруудаар өдөрт тодорхой цагуудаар явагддаг.
- Тэмээн тэргэн аялал: Тэмээн тэргээр ойр орчмын зайд аялах аялал юм.

Тэмээн аяллын хөтөч нь үндэсний дээл хувцас, малгай, гутал зэргийг өмссөн байх шаардлагатай. Богино хугацааны тэмээн аялал үзэх эвент аяллуудын төрөлд доорх төрөл хэлбэрүүд байж болно. Жуулчны баазад түшиглэн тэмээн аялал хийхдээ:

1. Мал маллагааны өвөрмөц зан заншил, арга ажиллагааг үзүүлэх аяллыг жуулчны баазад, гэрээт малчин өрхөд тулгуурлан хийх

Тэмээ маллах арга ажиллагааг улирлын байдлаас шалтгаалан тэмээ буйллах, бурантаглах, сургах, засах, ноослох, ботгоо голсон ингийг ботгыг нь авхуулах, буурын ороо, шаваа, ноцолдоон гэх мэт.

2. Гэр ахуйн ёс заншил, ажил үйлтэй холбоотой зан үйлийг үзүүлэх

Гэр буулган тэмээнд ачиж нүүх, гэр барих, эсгий хийх, арьс шир элдэх, ноос ноолуур ашиглаж эд зүйл хийх, жуулчин оролцох оролцооны аяллыг хөтөлбөртөө оруулах.

3. Хоол унд, хүнс, цагаан идээ бэлтгэх ёс заншил, арга ажиллагааг үзүүлэх

Сүү хөөрүүлж цагаа буцалгах, архи нэрэх, айраг бүлэх, тараг бүрэх, ааруул эззгий, хоормог хийх гэх мэт.

4. Байгалийн үзэгдэлд тулгуурлаж зохион байгуулах эвент аялал

- Нар жаргах үеийн оройн сэрүүнд тэмээ унуулах;
- Байгалийн сонин сайхан тогтоц бүхий газарт ойрын богино хугацааны аялал хийх;
- Өглөө эрт тэмээ хураах, услах гэх мэт сонирхолтой байж болох хөтөлбөрүүдийг зохион байгуулах;
- Өглөө, оройд тэмээтэй зураг авхуулах;



Зураг №23 Тэмээ унах

Жишээ нь буурын ороо, шаваа, цагаан сарын баяр, наадам зэрэг нь байгаль цаг уурын болон бусад хэм хэмнэлтэйгээр урт богино хугацаанд давтагддаг онцлогтой байдаг учир ийм төрлийн үйл явдлуудад тулгуурласан эвент аяллуудыг байнга тасралтгүй зохион байгуулах нь огт боломжгүй ба зарим баяр ёслолыг нь зориудаар зохион байгуулж болох боловч нэлээд төвөгтэй байдаг. Тийм учраас аялын эвент үйл явдлуудын давтагдах хугацааг бөөн, олон дахин зохион байгуулах боломжтой эсэхийг нарийн тогтоож аялынхаа хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах шаардлагатай. Говийн хамгийн үзэсгэлэнтэй, сонирхол татсан газруудаар өглөө 9 цагаас орой 18 цаг хүртэл, өдөрт ойролцоогоор 20-25 км аялж, майхантай хонож, хоол хүнс, майхан хэрэгслээ машинаар авч аялдаг. Гэвч огт машин хэрэглэдэггүй, бүх ачаа, хоол хүнсээ тэмээндээ ачиж орчуулагч, тогооч нар нь ч тэмээ унан аялдаг хөтөлбөр байдаг.

<p>Тэмээн аялын талаарх мэдээллийг жуулчдад сайн өгөх хэрэгтэй</p>	<p>Аялаа танилцуулж, тэмээний онцлог зан ааш, яаж унах ба тэмээ их үргэмтгий амьтан учир янз бүрийн эрээн мяраан унжиж санжсан зүйл авч явахгүй байхыг анхааруулах хэрэгтэй.</p>
<p>Тухайн газрын онцлогоос хамаарч хамгаалалтын хэрэгслүүд шаардлагатайг сануулах</p>	<p>Говьд аялахад хүний арьс түлэгдэх тохиолдол гардаг. Тиймээс түлэгдэлтийг хамгаалах тос, хаалт зэрэг хэрэгтэй зүйлсийг авч явахыг анхааруулах, жуулчны бааздаа тос болон бусад зүйлийг нэмэлтээр зарах, борлуулах боломжтой.</p>
<p>Аялын хэрэглэгдэхүүний чанарыг хангах</p>	<p>Аялалд хэрэглэх тэмээний буйл хугарах, олом, жирэм, буйл зэрэг тасрах гэх мэт бэрхшээлүүд гарах учир дээрх бэрхшээлийг гаргахгүйн тулд хэрэглэгдэхүүнээ сайн шалгаж, бат бөх байлгах шаардлагатай.</p>
<p>Аялалд явах тэмээгээ урьдчилан бэлтгэх</p>	<p>Тэмээг мал эмнэлгийн шинжилгээнд оруулж, халдварт өвчингүй, эрүүл гэсэн баталгааг гаргаж өгөх ёстой. Мөн аялалд унах тэмээ эдэлж унахад төлөв номхон, эдэлгээнд хэрэглэж байсан, дуугүй, орилоогүй, үргэж цочдоггүй байх хэрэгтэй.</p>
<p>Хоол хүнсний ариун цэврийн асуудал</p>	<p>Хээр гадаа боолтын хоол хүнсэнд онцгой анхаарах ёстой. Тухайн аялын нөхцөлд тохирсон чанарын баталгаатай, хүнсний бүтээгдэхүүнийг ашиглах ба халуунд муудахааргүй байх хэрэгтэй. Аялалд оролцож байгаа жуулчдад хоол тэжээл чухлыг анхаарах.</p>
<p>Аялалд явах хөтөч тайлбарлагчийг зөв сонгох.</p>	<p>Жуулчдын аюулгүй байдлыг сайн хангаж чадах туршлагатай хүмүүсийг сонгож авах хэрэгтэй. Тухайн аялал явагдаж буй газрын байгаль, цаг уурын гамшиг, ган үер, усны аялал, халдварт өвчин, гэмт хэргийг харгалзан үзэх хэрэгтэй.</p>

Жуулчны бааз нь аялын өмнө урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээ авах ёстой.

ЖУУЛЧИН ТЭМЭЭН АЯЛАЛД АНХААРАХ НИЙТЛЭГ ЗҮЙЛ:

1. Хөтчөөс тэмээг хэрхэн жолоодох, залж чиглүүлэх, эд хэрэглэлийг ашиглах талаар зөвлөмж авна.
1. Тухайн тэмээг уналгад сургасан эсэхийг лавлаж, эхлээд хөтчид унуулан өөрөө ажиглана.
2. Тэмээнд мордохоос өмнө эдлэл хэрэглэл бүрэн бүтэн байгаа эсэх болон танд тохирч байгаа эсэхийг сайтар шалгана. Хэрвээ эдлэл хэрэглэл нь ямар нэгэн эвдрэл гэмтэлтэй, өнгө үзэмж муутай байвал солиулна.
 - ✓ Аялалд гарахаас өмнө өөрөө тэмээг хэвтүүлэх, босгох дасгал хийнэ.
 - ✓ Тэмээнд мордох, буухдаа заавал хөтчийн тусламж авна.
 - ✓ Аялалд гарахаас өмнө эмээлтэй аялах уу, эсвэл энгийн тохоштой аялах уу гэдгээ хөтөчтэй зөвлөлдөх хэрэгтэй.
3. Хөтчийн тайлбарыг сайн сонсож, зөвлөмжийг биелүүлнэ.
4. Тэмээний явдал морины явдлыг бодвол эв муутай байдаг.
5. Тэмээний буйлаар хамаагүй оролдох эсвэл өмнө нь зогсвол ааш зан гаргадгийг анхаарна.

ТЭМЭЭН АЯЛЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД МӨРДӨХ ДҮРМЭЭС

- ✓ Тэмээнийхээ тоногийг шалгах, тэмээг хэвтүүлэх, босгох, тэмээнд мордох зэргээ байнга хөтчийн хараан дор түүний тусламжтайгаар хийнэ. Тэмээг хэвтүүлэх, босгох зэрэгт “хөөг хөөг” гэж дуудан тэмээг тайвшруулах үйлдлүүдийг сайн хийнэ.
- ✓ Мордохдоо хөтчийн тусламж авахыг зөвлөнө. Тэмээнд мордохын өмнө бурантаг, буйл, эдлэл, хэрэглэлийг сайн шалгана.
- ✓ Хэрвээ эмээлтэй бол олом жирэм нь чанга, сул эсэх, дөрөө холбоос байгаа эсэхийг шалгана.
- ✓ Тэмээнд мордоод явахдаа дөрөөнд зөвхөн өлмийн хэсгийг тулж гишгэхэд боломжтой байдлаар оруулж явна. Хэт лав оруулж гишгэвэл гэнэт тэмээ үргэж туйлах зэрэг санамсаргүй явдал тохиолдож тэмээнээс унах үед хөл дөрөөнөөс мултралгүй чирэгдэх аюултай байдаг.
- ✓ Эмээлтэй тэмээ унаж байгаа бол дөрөөний оосрыг таарсан эсэхийг шалгаж, өөртөө тааруулж аваарай.
- ✓ Хэрвээ эмээлтэй тэмээнд мордох гэж байгаа бол зүүн хөлийг дөрөөнд мөчидхөн / мултрахааргүй/ хүч өгөн гишгэж мордоно.
- ✓ Тэмээнд мордохдоо буйлыг зүүн гартаа эвхэж богиновтор барьсан байвал тохиромжтой .
- ✓ Тэмээнд мордсоны дараа тэмээг босох үед хойш гэдийж дөрөөндөө сайн жийж өгөх хэрэгтэй байдаг. Учир нь тэмээ босохдоо эхлээд арын хоёр хөл дээрээ босож дараа нь урд хоёр хөл дээрээ зогсдог учир урагш нь бөхийлгөж унах аюултай.
- ✓ Тэмээг унаж явахдаа бурантгийг нь богино атгаж, бөхнөөс нь барьж явна.
- ✓ Тэмээ маш үргэмтгий амьтан учир анхаарал сэрэмжтэй байх. Хэрэв гэнэт тэмээ үргэх юм бол бурантгийг маш хурдан богиносгож татах, эсвэл бөхөө даган гулсаж буух, сөөглөн хэвтүүлэх зэрэг арга хэмжээ авна.
- ✓ Тэмээн аялалд тэмээ унаж явах учир, урьд нь тэмээ харж байгаагүй, мал амьтны

талаар төсөөлөлгүй жуулчдад тэмээг унуулж сургах болон тэмээтэй хэрхэн харьцах вэ гэдгийг сайн нарийн хэлж ойлгуулж сануулж байх нь аяллын аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй.

ЖУУЛЧИН ТЭМЭЭНД УНАЖ ЯВАХ ҮЕДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛ:



Хориглоно

- ∅ Тэмээ унаж байх үедээ огцом чангаар хашхирах, фото зураг авах хэрэггүй. Янз бүрийн дуу авианаас тэмээ үргэж давхих аюултай.
- ∅ Тэмээн аялал нь жингийн цуваа мэт цувж явдаг тул тэмээ унаж яваа аль нэг хүн хувцсаа тайлах, гэнэт чанга дуу авиа гаргах, огцом хөдөлгөөн хийх, элдэв үнэр гаргахыг хориглоно.
- ∅ Тэмээгээр дөнгөж алхуулж яваад тэмээ унаад сурчихсан гэж бодох болон сурчихсан байсан ч хөтчийн зөвшөөрөлгүйгээр цуваанаас гарч явах, дураараа байраа солих, гэнэт жонжуулж давхиулахыг хориглоно.
- ∅ Өргөн тавхайтай учраас шавар шавхайтай, намгархаг газраар явахад халтирах аюултай.
- ∅ Гол, горхи гатлахдаа анхааралтай байх хэрэгтэй ба тэмээг шавдуулбал халтирах аюултай.
- ∅ Бурантгийг огцом чанга татах, угзрахыг хориглоно.
- ∅ Тэмээ унаж буй үед хоорондоо уралдахыг нэгнийгээ татаж угзрах болон нэгнийхээ тэмээг илэх, хүрэхийг оролдох зэргийг чанд хориглоно.
- ∅ Тэмээг унахдаа урд бөхнөөс нь сайтар барьж, босоход нь үл ялиг хойш гэдийж, чанга орилж дуу чимээгүй гаргахгүй байна.
- ∅ Тэмээ унаж явах зуураа тэмээний урд бөхийг давж налах, дэрлэхийг хориглоно. Учир нь халуун зунаар тэмээ ялаархаж толгойгоо их савчуулж хөдөлгөдөг ба энэ үедээ толгой нь урд бөхөндөө хүрч байдаг. Мөн уруул хоншоороо бөхөндөө ширвээж үрэх явдал байдаг ба энэ үед нь сандрах хэрэггүй юм.
- ∅ Тэмээний хойгуур ойрхон гарвал тийрэх, урдаас нь хэт ойртвол хазах, сэвсээр булах аюултайг сануулна.



Зөвшөөрнө, шаардлагатай

- ✓ Буйл нь нэг талдаа байдаг болохоор жолоодоход бага зэрэг төвөгтэй байдаг. Сайн сургасан тэмээг биеэрээ болон гараараа чиглүүлэхэд өөрөө чигээ олдог.
- ✓ Тэмээгээр явж байх замд тэмээ мал үргэх, машин тэрэг хажуугаар өнгөрөх үед тэмээгээ энэ зүйлд дасгах зорилгоор жолоогоо бага зэрэг татаж удаан явах хэрэгтэй.
- ✓ Тэмээг ташуурдах нь тийм ч оновчтой арга биш. Хурдан явахыг хүсвэл хөлөөрөө дарвиж өгөх хэрэгтэй.
- ✓ Таны унаж байгаа тэмээ байн байн өвс идээд байвал жолоогоо татасхийн явахыг зөвлөнө.
- ✓ Хөтчийн араас гол горхи гатлах нь хамгийн аюулгүй арга болно.
- ✓ Газрын уруу явахад жолоогоо бага хэмжээгээр татаж явна. Аль болох тэгшэн газрыг сонгож яваарай. Тэмээ хурдлах үед сандарч, хашгирч, орилж болохгүй, бурантгийг татаж зогсоогоорой. Хэрэв хашгирвал тэмээ улам хурдан давхих болно гэдгийг анхааруулна.

- ✓ Тэмээг хурдан явуулахын тулд хөлөөрөө давирдаг бөгөөд “Хөөг, хөж, чүү” гэж хэлнэ.
- ✓ Тэмээ нь харьцангуй өндөр амьтан тул унаж явах үед их найгадаг хөдөлгөөнтэй байдаг тул урд бөхнөөс хоёр гараараа барин, хоёр хөлөөрөө тохмоо хавчин явна.
- ✓ Тэмээ унах болон буухдаа заавал зүүн талаас нь харьцана.
- ✓ Тэмээний ааш араншингийн талаар тэмээний хөтчөөсөө асууж мэднэ.
- ✓ Тэмээ их үргэмтий амьтан тул үргэх үед нь өөрөө чанга дуугаар орилохгүй байж бурантгаар нь татаж зогсоох шаардлагатай.
- ✓ Тэмээ унаж байх үедээ биеэ сул орхиж болохгүй, цэгц сууж, аль болох хэвгий газраар явахыг сануулна. / Шогшуулах, жонжуулах нь танд аюул багатай/

МОРЬ, ТЭМЭЭ УНУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ АНХААРАХ:

Морин аялал, тэмээн аялын үед үйлчилгээнд анхаарах зүйлс:

- ✓ Замдаа малчин айлд орох бол айлаа урьдчилан бэлтгэсэн байвал илүү үр дүнтэй.
- ✓ Хог хаягдлаа тусгай саванд хийж авч явах ба төвлөрсөн хогийн цэгт аваачиж хаяхыг сануулна.
- ✓ Аялын явцад морьд, тэмээ, үхрээ алдахаас сэргийлж, сайн чөдөрлөж аргамжаалах, уях шаардлагатай.
- ✓ Орон нутгийн онцлогийг илэрхийлсэн адуун, тэмээн соёлыг илэрхийлэх тоног хэрэгсэлтэй байх. Бурантаг, цулбуур, жолоо зэрэг нь хүний гар зүсэхгүй, ширүүн биш байхаар хийнэ
- ✓ Хөтөчтэй гэрээ хийхдээ үндэсний онцлогийг илэрхийлсэн дээл, хувцас, эдлэл хэрэглэлтэй байхыг зөвлөж, жуулчны баазын лого, брэндийн илэрхийлсэн хувцас эдлэл хэрэглэнэ.
- ✓ Архи, тамхи, элдэв буруу зуршлыг хэрэглүүлэхгүй ойлгуулах, жуулчинтай хүндэтгэлтэй харьцана.
- ✓ Дахин давтагдашгүй үйлчилгээг жуулчинд хүргэх, тухайлбал боломжтой бол сүйх тэргээр үйлчлэх, ижил зүсмийн хуар морьд, тэмээгээ унуулах, хазаар, ташуур, эмээлийн ганзага, буйл тэргүүтнийг гоёмсгоор сүлжих, жороо, хатирч морьдоор үйлчилгээ үзүүлнэ.
- ✓ Бага насны хүүхдээр хөтөч хийлгэхгүй байх, мэргэжлийн хөтчийн үйлчилгээ үзүүлнэ.
- ✓ Төлбөртөө тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ.
- ✓ Хүндрэлгүй байдлыг бий болгож морь, тэмээг унахад хүлээлгэх, таагүй зүйлтэй учруулахгүй байлгана.
- ✓ Жигд хэмнэлээр ажил үйлчилгээг хүргэх, ажил үйлчилгээний явцад санаачилгатай гэнэтийн зүйл бэлэг барина.
- ✓ Хэрэглэгчдийн хүсэл, дадал, сонирхолд хүлээцтэй, хүндэтгэлтэй хандана.
- ✓ Хэрэгчлэгч бүрд тохируулан хандаж, харьцаж, анхаарал тавьж онцгойлон үйлчилгээг хүргэнэ.
- ✓ Жуулчдад үзүүлэх үйлчилгээ бол гол зорилго биш, харин түүний хэрэгцээг хангах хүсэл гэдгийг мэдрүүлэх, эрх чөлөөт байдлыг мэдрүүлсэн аялал хийх нь чухал.
- ✓ Аялын бүтээгдэхүүнийг бий болгоход оролцож буй бүх ажилчдын анхаарал халамж, үйлчлүүлэгчдэд үнэн сэтгэлээсээ хандах чадвартай байна.
- ✓ Байгаль орчин, амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, ажил үйлчилгээ үзүүлэх

технологийн аюулгүй байдлыг харгалзан жуулчдын ур чадварт тохирсон аялал, хөтөлбөр санал болгоно. Туулах зай, ялангуяа гол горхи, уулс, эгц толгод, хурдны зам гэх мэт саад учруулж болзошгүй газрын талаар мэдээлэл хэрэгтэй.

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэгш хүртээмжтэй байхаар тоног хэрэглэл, хөтчийг бэлтгэж, сургана.
- ✓ Санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, жуулчны ХАБЭА сахин хамгаалах, жижиг зүйлсэд сэтгэл шингэсэн үйлчилгээ үзүүлнэ.
- ✓ Улирлын нөхцөлдөө тохирсон аялал зохион байгуулах, бааз орчмын хог хаягдлыг цэвэрлэх, аюултай гуу, жалга, эрэг, гангатай газар зохион байгуулахаас зайлсхийнэ.
- ✓ Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хийх, зах зээлийн сегментчлэлд таарсан хөтөлбөр, аялал, маршрут бий болгох нь чухал.

ЖУУЛЧНЫ БААЗАД МОРЬ УНУУЛАХАД ӨГДӨГ ЗӨВЛӨМЖ: ХУСТАЙН БЦГ ЖУУЛЧНЫ БААЗ, КЕЙС

WARNINGS FOR HORSE-RIDING IN HUSTAI

The training and behavior of the Mongolian horse is different from methods used in other countries. For the reason you must be aware of the following points before riding in Mongolia.

1. Only ever approach a Mongolian horse from the left side. Before mounting the horse check that the saddle is tight so that it doesn't slip.
2. Before mounting the horse always tighten the reins, make the horse stand still and mount quickly.
3. Don't ever touch the horses around the head. Especially during summer when there are high numbers of flies, the horses can get very agitated.
4. Always ride with a tight rein. The horses can move very quickly when they are frightened by objects, such as paper or wire, and animals e.g. marmots, hares and birds, that appear suddenly whilst in the field.
5. To avoid frightening the horses, never put on or remove clothing while riding horses and do not wear clothes that rustle. Always keep all your belongings secure and out of the horses way.
6. When riding down steep slopes, always dismount and lead the horse down to the bottom.
7. During rain or snow be aware that the horses can slip, especially whilst riding on the hills.
8. To prevent your feet getting caught if you fall off, make sure your shoes fit easily within the stirrups. Also, try to keep the pressure of the stirrup on the ball of your feet.
9. Never wrap the reins around your body when riding, leading or when sitting on the ground.
10. Don't leave the horses alone while you are in the field. If you have ropes then the horses must be tightly hobbled or tied. Ask the horse guide for help if you do not know how do this.
11. Once you have returned from your ride, always tell the ranger you are back.

Please understand that these warnings are for your own safety.
We hope you will enjoy your time here at Hustai.

Hustai National Park Management

5.3

ЖУУЛЧНЫ БААЗААС ЖУУЛЧДАД ҮЗҮҮЛЖ БОЛОХ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Жуулчны баазын нэмэлтээр санал болгож буй бүх зүйл нь жуулчны баазын зүгээс үзүүлж буй нэмэлт үйлчилгээ юм. Жуулчны баазын үйлчилгээ нь биет болон биет бус байдаг. Үйлчилгээний газруудын үйлчилгээ нь хадгалагддаггүй, дахин давтагшгүй мэдрэмж төрүүлдэг төдийгүй тухайн жуулчны хүлээж авч буй байдлаас шалтгаалаад чанар нь олон янз, үйлдвэрлэл хэрэглээний хувьд давхцал ихтэй байдгаараа бусдаас онцлогтой. Жуулчин тодорхой нэг газарт ирэх шийдвэр нь тухайн газарт ямар орон байр байгаа эсэхээс үл хамаарах хэдий ч амрах, алжаал тайлах, сувилуулах, аялах зугаалах, танилцах зэрэг өөр шалтгааныг чухалчилдаг. Монголд ирж буй жуулчдын хувьд өөр нэгэн шалгуур үзүүлэлт нь монгол гэрт хоноглож нэмэлт үйлчилгээ авах хүсэлтэй байдаг нь Монголын аялал жуулчлалын салбарын онцлог юм. Тиймээс жуулчны баазад ирж байрлагчид буюу жуулчдын зорилгыг хэсэгчлэн үзэх нь чухал. Жуулчид зочид буудлын талаар өөрсдийн гэсэн ойлголттой байдаг бөгөөд жуулчны баазын талаар ойлголттой ирэх нь ховор. Анхны сэтгэгдлийг сайтар өгч цааш цаашдынхаа жуулчдыг татахын тулд үндсэн үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнүүддээ анхаарал хандуулах хэрэгтэй.

Жуулчны баазууд нь хаана ямар бүс нутагт байрлаж байгаагаасаа шалтгаалан өөрсдийн гэсэн давуу талуудтай бөгөөд тэдгээртээ тулгуурлаж бүс нутгийнхаа онцлогийг харуулсан нэмэлт үйлчилгээнүүдийг үзүүлбэл зохистой байдаг.

Жуулчны баазын үзүүлэх үйлчилгээг үндсэн ба нэмэлт гэж ангилдаг.

Үндсэн үйлчилгээнд байршуулах, хооллох, ахуйн болон ариун цэврээр хангах зэрэг ордог.

Нэмэлт үйлчилгээ нь чөлөөт цагаа өнгөрөөх, зугаацаж цэнгэх, аялж жуулчлах, төрөл бүрийн арга хэмжээнд оролцох, үзэж сонирхох зэрэг жуулчны хэрэгцээнд тулгуурлан санал болгож буй өвөрмөц хэлбэрийг агуулсан үйлчилгээнүүд багтдаг. Үндсэн ба нэмэлт үйлчилгээнүүд нь хоорондоо уялдаа холбоотой байх ёстой.

Жуулчны баазын нэмэлт үйлчилгээ нь жуулчид болон орон нутгийн иргэдийн хоорондох соёлын харилцааг дэмжихэд чиглэгдэн зохион байгуулагддагаараа онцлогтой. Мөн жуулчны баазын нэмэлт үйлчилгээнүүд нь баазад нэмэлт орлого олох эх үүсвэр учир та аль болох олон янз төрөл зүйлийн нэмэлт үйлчилгээг чанарын өндөр түвшинд жуулчдад санал болгох нь таны бизнест ч мөн ашигтай.

Жишээлбэл: Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг /НИТАЖ/ баазууд ихээхэн хөгжүүлэх болсон нь үүний тод жишээ юм. Энэ утгаараа жуулчны бааз нь байгалийн бүсүүдэд байгаль соёл, түүхийг ойлгох зорилго бүхий жуулчдад хүрээлэн буй орчинд хор уршиг бага үзүүлэх, байгаль хамгааллын эдийн засгийн боломжийг нээж, нутгийн оршин суугчдад эдийн засгийн болон соёлын дэмжлэг үзүүлдгээрээ ээлтэй бизнесийн салбар юм. Энэхүү үүргээ хэрэгжүүлэхийн тулд жуулчдад нутгийн ёс заншил, уламжлалыг таниулах, хүрээлэн буй орчныг танин мэдүүлэх, байгаль орчинд ээлтэй нөхөрсөг хандах хэрэгтэй. Жуулчны баазын нэмэлт үйлчилгээнд байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, хүний эрүүл мэндэд тустай үйлийг бүтээх явдал мөн багтана. Байгалийн аялал жуулчлалын болон соёлын аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг жуулчны баазууд зохион байгуулж хөгжүүлсэн байдаг. Энэ нь тухайн бүс нутгийн аялал жуулчлалыг улам сонирхолтой баялаг болгохоос гадна соёлын үнэт зүйл, язгуурлаг шинжид тулгуурласан хөдөөгийн аялал жуулчлал, хүмүүсийн өдөр тутмын амьдралыг сонирхох аялал жуулчлал болон унаган байгалийн сонирхол татах чадавх дээр суурилсан тусгай сонирхлын жуулчлал зэрэг

аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг хөгжүүлж болно. Эдгээрээс морь унах, явган явах, орчны байгальтай танилцах, загасчлах, тэмээн аялал, орчны түүхийн дурсгалтай танилцах зэрэг байгаль орчинд шууд нөлөөлөх хэлбэрүүд хамгийн олон байгаа нь анхаарал татаж байна. Нэгэн сонирхолтой баримт гэвэл Азийн аялал жуулчлал болон зочлох үйлчилгээ өндөр хөгжсөн орнуудын зочид буудал болон байрлах хэрэгслүүд нь нэмэлт үйлчилгээгээрээ илүү их орлого олдог байна. Жуулчны баазаас үзүүлж болох нэмэлт үйлчилгээнүүдийг жагсаавал:

№	Нэмэлт үйлчилгээнүүд	№	Нэмэлт үйлчилгээнүүд
1	Морь унах	61	Шагайгаар тоглох
2	Явган явах	62	Үндэсний хувцас дээл өмсөж зураг авхуулах
3	Спорт тоглоом тоглох	63	Мото аялал
4	Орчны байгальтай танилцах	64	Мал маллах
5	Загасчлах	65	Цагаан идээ хийж сурах
6	Малчин айлд зочлох	66	Аргал түүх
7	Тэмээн аялал	67	Өвөл цасаар цасан хүн хийх
8	Түүх, соёлын дурсгалт зүйлстэй танилцах	68	Өвөл нохой болон морь чаргаар зугаалах
9	Ардын урлагийн тоглолт үзэх	69	Өвөл цана, чаргаар гулгах
10	Ууланд авиралтын аялал	70	Өвөл мөсөн хадны авиралт хийх
11	Рашаан уух/ орох	71	Морь, мал сургах үзүүлбэр
12	Усан аялал	72	Хавар мал төллөхийг харах
13	Нар мандах, жаргахыг харах	73	Нүүдэллэх ёстой танилцах аялал
14	Цэцэг харах, ажиглах	74	Өвөл мөсөн тоглоомуудаар тоглох
15	Саун, массаж	75	Үхэр, морь, тэмээн тэрэгтэй аялах аялал
16	Тэмээ унах	76	Мөөг түүх аялал
17	Наран шарлага	77	Байгалийн зураг зурах
18	Үхэр тэргэн аялал	78	Ямаа самнах аялал
19	Хүүхдийн мини наадам	79	Мал саах
20	Галын наадам	80	Монгол гэр барих, буулгах, нүүх
21	Бэсрэг наадам	81	Морин хуур заах, суралцах
22	Эрвээхэй ажиглах	82	Төрөл бүрийн сүүтэй цай чанах
23	Элсний чаргаар гулгах	83	Үндэсний язгуур урлагт суралцах
24	Элсэн урлал хийх	84	Гар урлалын зүйлс хийх, суралцах
25	Динозаврын яс үзэх	85	Монгол дээл оёх, урлах
26	Дугуйн аялал	86	Морины соёлд суралцах
27	Монгол Улсын тухай баримтат кинонууд үзэх	87	Морь тусгайлан унаж суралцах
28	Бясалгал хийх	88	Авто машин түрээслэх аялал
29	Эмчилгээ сувилгааны аялал	89	Аялын тоног төхөөрөмжүүдийн түрээсийн үйлчилгээ / загасны уурга, дэгээ/
30	Ном түрээслэх	90	Тэмдэглэлт ойн арга хэмжээнүүд зохион байгуулах
31	Бүжиг зохион байгуулах	91	Орон нутгийн хөтчийн үйлчилгээ
32	Караоке	92	Тусгай ур чадвар шаардсан мэргэжилтнээр үйлчлэх
33	Анхилуун үнэртэй ой мод, цэцэрлэгт зугаалах	93	Хөгжөөнт тоглоомуудаар тоглуулах үйлчилгээ
34	Үндэсний хоол хийж сурах	94	Онъсон тоглоомуудаар тоглох, суралцах
35	Од харах	95	Монгол хэл сурах
36	Урлагийн тоглолт үзэх	96	Монгол ёс заншил, соёлоос суралцах
37	Шувуу ажиглах	97	Каллиграфи бичүүлэх, сурах /уран бичлэг /
38	Мод тарих	98	Эсгий савах, хийх

39	Усан завьтай аялал хийх	99	Хөдөлгөөнт олсон сандлаар зугаалах
40	Од ажиглах	100	Ил захидлын үйлчилгээ
41	Хадны хэлбэр ажиглах, түүнийгээ кадрт буулгаж зурах	101	Нисдэг тэргээр аялах
42	Баазын эргэн тойрон дахь палеонтологийн олдворуудтай танилцах.	102	Унага уралдуулах
43	Агаарын бөмбөлгөөр аялах	103	Шүхрээр буух
44	Далий ягаан цэцгэн дунд суух	104	Зочны хувцас угаалга үйлчилгээ
45	Хүүхдийн сэвлэг үргээх найранд оролцох	105	Хээрийн хоолны үйлчилгээ
46	Овоо тахилгын ёслолд оролцох	106	Бизнесийн уулзалт, семинар зохион байгуулах
47	Хуримын ёслолд оролцох	107	Захиалгат хоол хийх/ хорхог, боодог/
48	Гэр бүлийн уламжлалт зан үйлд оролцох	108	Жуулчны баазын нэрийн / бэлэг дурсгалын/
49	Зэрлэг амьтад ажиглах	109	Өндөр настнуудад зориулсан цэнгээнт бүжиг
50	Жуулчны баазын нэрийн бүтээгдэхүүн амтлах /хүнсний/	110	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай арга хэмжээнүүд
51	Гүний шумбалтын аялал	111	Дарстай аялал
52	Хуримын зураг авалтын үйлчилгээ	112	Гүүний саам уух аялал
53	Үндэсний ухмал сийлбэрт суралцах аялал	113	Цагаан ямааны сүү уух аялал
54	Хээ, угалз зурж будах	114	Сакура цэцэглэх
55	Рафтинг аялал	115	Монос гөлөглөх
56	Алжаал тайлах төв	116	Жимсгэнэ түүх аялал
57	Ууланд алхах	117	Хадлан хадах
58	Буга урамдахыг сонсох аялал	118	Дрон түрээслэх, мэргэжлийн зураг, бичлэг хийх
59	Элсний волейбол	119	Морин тэргээр аялах
60	Гүний шумбалт		

Нэмэлт үйлчилгээнүүддээ захиалга авахдаа дараах зүйлсийг анхаарна:

Жуулчны бааз нь оргил ачааллынхаа үед ажиллах хүчин муу байдагтай холбоотойгоор хэрэв жуулчин нэмэлт үйлчилгээ авахыг хүсвэл доод тал нь 2-24 цагийн өмнө урьдчилж мэдэгдэх шаардлагатай. Морь, тэмээ унах аяллын захиалгыг доод тал нь 1 хоногийн өмнө өгнө.

- ✓ Экстрим аяллын үед жуулчдын туршлагатай үгүйг асууж лавлах, мөн эрүүл мэнд нь тэнцэх эсэхийг шалгах. Эрүүл мэндийн хувьд тэнцсэн жуулчдыг хамруулах.
- ✓ Хэрэв жуулчид ялгаатай соёл, ёс зүй болон зан заншилтай байвал бөөгнүүлж нэг групп болгож нэмэлт үйлчилгээгээ үзүүлж болохгүй. Жишээ нь: Ази жуулчдыг европ, америк, австрали жуулчдаас ялгах.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүндэтгэх шалтгаантай жуулчдад түрүүлж үйлчилгээ үзүүлэх, захиалгыг авах.
- ✓ Нэмэлт үйлчилгээг үзүүлэхдээ авсан захиалгын дарааллын дагуу жуулчдадаа үзүүлэх. /оочер дугаар дайруулахгүй байж тэгш зарчим баримтлах/
- ✓ Орон нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалын нэмэлт үйлчилгээ явуулах гэж буй тохиолдолд жуулчдын аюулгүй байдал болон нутгийн иргэдийн ба бааз хоорондын хоёр талт хамтын ажиллагааг албан ёсоор баталгаажуулах үүднээс

- ✓ гэрээ хийж, орон нутгийн иргэдийг сургалтад хамруулсан байх.
- ✓ Байгалийн аялууд хийх гэж буй тохиолдолд жуулчдын аюулгүй байдлыг сайтар хангах, хангуулах.

Нэмэлт үйлчилгээнүүдээ жуулчдад хүргэж, зарах аргууд

- ✓ Жуулчдыг угтан авч гэрт нь байрлуулахаас өмнө баазын талаар ерөнхий тайлбар мэдээллээ өгдөг. Энэ мэдээллийн дараа та манай баазад байрлаж, амарч байх үедээ ямар нэмэлт үйлчилгээнүүдийг авах боломжтой вэ гэдэг талаар хэлж, таниулна.
- ✓ Жуулчны гэр, өрөө бүрд нэмэлт үйлчилгээний танилцуулга бүхий менюг үнэ, тайлбартайгаар англи, монголоор бичиж байрлуулна.
- ✓ Жуулчдад сэдэл өгнө.
- ✓ Баазын нэмэлт үйлчилгээ болон жуулчдад санал болгож буй зүйлс нь эрүүл аюулгүй, эрсдэлгүй гэдэг итгэл үнэмшлийг жуулчдадаа төрүүлнэ.

Жуулчны баазуудын сонирхолтой үйлчилгээ:

1. HSK Хаан ресорт жуулчны бааз нар мандах, нар жаргах, одод ажиглах аяллыг морь, тэмээтэй хослуулан зохион байгуулдаг.
2. Торгоны замын нууц жуулчны бааз, Онгийн нууц гэсэн жуулчдын баазууд нь нэмэлт үйлчилгээндээ авто машины тос, тосолгооны материал сольж өгөх үйлчилгээ үзүүлдэг.
3. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах Ананд Адвэнчур ХХКомпани нь “Агаарын бөмбөлөг”-өөр аялуулдаг аялал зохион байгуулдгаараа Монголдоо анхдагч билээ. Үүн дээр тулгуурлан энэхүү байгалийн цогцолборт газарт байрладаг баазууд нь тус компанитай гэрээ хийн уг үйлчилгээг нь жуулчдадаа нэмэлтээр үзүүлэх боломжтой.

5.4

ОРОН НУТГИЙН ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ, ТЭДГЭЭРИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛЖ ЖУУЛЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ

- ✓ Жуулчны баазын менежер орон нутгийн иргэдэд түшиглэн уламжлалт ахуй, соёлын арга хэмжээ, эвент, хөтөлбөрүүдийг тогтмол эсвэл захиалгын дагуу зохион байгуулах.
- ✓ Зочдыг баазын зүгээс үзүүлж буй үйлчилгээ, нэмэлт аяллын төрлүүд болон бусад үйлчилгээний мэдээллийг орон нутгийн иргэдэд өгөх, тэдний оролцоог асуух.
- ✓ Жуулчны баазын ойролцоо байдаг орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний нөөц боломжийг ашиглан хамтран ажиллах.
- ✓ Жуулчны баазад ирсэн зочдод нутгийн иргэдийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх, сурталчлах.
- ✓ Морь, тэмээ аяллын захиалга авах, захиалгыг баталгаажуулах, захиалах, цаг тухайд нь хэрэгжүүлэх.

- ✓ Малчин айл болон нутгийн иргэдийн үзүүлдэг аяллын төрлүүд болон үйлчилгээний захиалгад хяналт тавих, цагийн биелэлтийг гүйцэтгэхэд анхаарал хандуулах.
- ✓ Орон нутгийн иргэдийг сургалтад хамруулах, аялал жуулчлалын талаар ойлголт өгөх.
- ✓ Орон нутгийн иргэдэд тулгуурласан аяллын төрлүүдийг гаргаж ирэх, тэдэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулах.
- ✓ Орон нутгийн иргэдийг цагийг нягтлан бариулж, хариуцлагатай аялал жуулчлалыг ойлгуулах, дүрэм журам гаргах түүнийгээ дагаж мөрдүүлэх тал дээр хамтран ажиллах.
- ✓ Монгол үндэсний хоолны хичээл хийх аялал зохиох, гэрийн эзэгтэйгээр хийлгүүлж, заалгуулах.
- ✓ Орон нутгийн онцлогт тохируулан аяллын төрлүүдийг санаачлах, түүнийгээ нутгийн иргэдэд сургалтаар орох зааж зөвлөх, хэрэгжүүлэх.

5.5

ЖУУЛЧДЫН ТУСГАЙ ЗАХИАЛГЫГ ХҮЛЭЭН АВАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- ✓ Жуулчны баазын менежер нь жуулчинтай холбоотой тусгай болон ерөнхий бүх захиалгыг шууд хүлээн авах, хэрэгжүүлэх
- ✓ Аяллын компаниудаас хэрэв хоолны асуудалтай хүний талаар мэдээлэл ирсэн бол түүнийг гал тогоо болон зоогийн газрын үйлчилгээний албаныханд эрт мэдээлж, тэмдэглэгээ хийлгэх.
- ✓ Хүнс хангамжийн албанд мөн мэдэгдэж хүнс татан авалтын тусгай хүнсний листэд оруулах.
- ✓ Жуулчдын гэр болон өрөөнүүдийн хуваарилалтыг аяллын компаниас ирсэн захиалгын дагуу нарийвчлан хийх. Үүнд: гэр, өрөөнд ганцаараа, хосоороо, гурвуулаа, дөрвүүлээ эсвэл гэр бүлээрээ нэмэлт ортой гэсэн захиалгуудыг аяллын компаниудынхан эрт өгдөг тул түүнийг хуваарилахдаа сайн анхаарч алдаа гаргахгүй байж эртнээс бэлдэх.
- ✓ Жуулчны баазын зүгээс зохион байгуулдаг арга хэмжээ, эвентүүдэд урьдчилан захиалга өгсөн тохиолдолд захиалгыг авах, баталгаажуулах
- ✓ Арга хэмжээ, эвентүүдэд оролцдог хүмүүст урьдчилан хэлж бэлэн байдлыг хангах, арга хэмжээнд бэлдүүлэх.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бага насны хүүхэдтэй жуулчдын талаар аяллын компаниудаас урьдчилан мэдээлэл ирдэг бөгөөд ийм тохиолдолд тэднийг аль болох ариун цэврийн өрөө болон зоогийн газартай ойр гэрэлтүүлэг сайтай гэрүүдэд хуваарилах.

5.6

ЖУУЛЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, БАЙРЛАЖ БАЙХ ҮЕД НЬ АНХААРАЛ ХАЛАМЖ ТАВИХ

- ✓ Үнэт эдлэл хадгалах үйлчилгээтэй байх ёстой. Хадгалах сейф нь төрөлжсөн байх.
- ✓ Жуулчин бүр жуулчны баазад буудалласан цагаас хойш тамхи татах цэгийг мэддэг байх, жуулчдыг угтаж авангуутаа зааж өгөх.
- ✓ Жуулчны баазад бүртгэл хийж байрлах нь 10-12 цагийн хооронд байх. Хүлээлгэн өгөх цаг нь 12-13 цагийн хооронд байдаг гэдгийг жуулчдадаа сайн сануулж хэлэх нь урьдчилан гарах асуудлаас сэргийлнэ.
- ✓ Зочдыг жуулчны баазад хүрэлцэн ирсэн цагаас хэрэгтэй мэдээллээр хангах.
- ✓ Жуулчны баазыг маш ойлгомжтой тайлбарлах.
- ✓ Гэр болон өрөөнүүдэд толгойгоо тотгонд цохихоос сэргийлнэ үү гэж бичиг тавих, шаардлагатай бол хамгаалалт хийх.
- ✓ Зочин гэрт орох үед босгонд бүдэрч унах аюултайг анхааруулсан бичиг тавих, босго хэт өндөр бус байх.
- ✓ Зочны гэр болон өрөө бүр жуулчны баазын ХАБЭА-н дүрэм, заавартай байх. Тэдгээр нь монгол, англи хэл дээр байх.
- ✓ Зочны гэр болон өрөөнүүдэд гялгар хулдаас эсвэл халтиргаа ихтэй хивс, дроз зэргийг сонгож тавихгүй байх
- ✓ Зочны гэр болон өрөөнүүд нь сайн цоожтой, бат бөх хаалгатай байх.
- ✓ Зочдод аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол цайгаар үйлчлэх.
- ✓ Зочдын амгалан тайван байдлыг алдагдуулах, цочир дуу чимээг гаргахгүй байх.
- ✓ Зочид жуулчны баазад байрлаж байх үедээ хэрэгцээт үйлчилгээгээ амархан авдаг байх.
- ✓ Зочдыг яаруулж, шахамдуулахгүй, амгалан тайван байлгах үүднээс ажилтан бүр өөрсдөө яарч сандралгүй ажил үүргээ гүйцэтгэх.
- ✓ Хулгай, дээрэм тонуулаас урьдчилан сэргийлж харуул хамгаалалтыг байнгын 24 цаг ажиллуулах.
- ✓ Шөнийн цагт зоогийн газар болон ариун цэврийн өрөө явах зам нь саадгүй, үргэлж гэрэлтүүлэгтэй байх.
- ✓ Зочинд яаралтай үед хөтөч, жолоочийнхоо хаана байрлаж байгааг мэдэх мэдээллээр хангах, мэдэж байх.
- ✓ Зочдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүйн тулд гэнэтийн тохиолдлоор цахилгаан тасарвал мотор ажиллуулахад бэлэн байх.
- ✓ Халуун, хүйтэн ус тасарвал нөөцтэй, бэлэн байдалд байх.
- ✓ Зочид гэр болон өрөөндөө тусгай үйлчилгээ захиалан авсан тохиолдолд тухайн үйлчилгээнүүд нь ХАБ-ын дүрэм, журмыг хангасан байх.
- ✓ Бороотой үед зочдод хүрэлцэхүйц шүхрийг бэлтгэн хангах.
- ✓ Оройн сэрүүн үед зочид гадаа суух үед нэмэлт хөнжил, бүтээлэг, нөмрөг зэргээр үйлчлэх, халамжлах.
- ✓ Зочдын тав тухыг хангах үүднээс зочдыг гэртээ орохоос өмнө шаардлагатай тохиололд гал түлэх. Зочид өөрсдөө түлж болохгүй, галын аюултайг сануулах.
- ✓ Зочдын тав тухыг бодолцон хооллох цагуудыг өөрсдөөс нь асууж хүссэн цаг хугацаанд нь тус үйлчилгээг үзүүлэх.
- ✓ Бороо, цастай өдрүүдэд хальтиргаанаас сэргийлсэн хөлийн гишгүүрүүдийг гэр болон өрөөнүүдийн гадна, дотор тавих.
- ✓ Зочны гэрүүдэд уух халуун ус тавих, түүн дээрээ халуун гэсэн тэмдэглэгээ хийх.

1. Ажилтнуудын бэлэн байдлыг хангаж үйл ажиллагааг эхлүүлэх

Зочлох үйлчилгээний салбар, аж ахуй нэгж үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Юуны түүрүүнд зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд шинэ нөхцөл байдалд үйл ажиллагаагаа хэвийн явуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, шинэ хэвийн байдалд дасан зохицсон ажилтнуудаа бэлтгэсэн байх шаардлагатай.

- Цар тахал, нийтийг хамарсан халдвараас урдчилан сэргийлэх арга хэмжээ / хяналтын хуудас, орон нутгийн эмнэлэг, онцгой байдлын газартай холбогдох утасны дугаар, тусгай ариутгал, цэвэрлэгээ г.м зүйлсийг багтаасан/-ний цогц төлөвлөгөө боловсруулсан байх ба үйл ажиллагааг дахин эхлүүлэхэд шаардагдах хангалттай ажилтантай байх;
- Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг боловсруулах, үүнд, үндэсний хэмжээнд мөрдөж буй зохицуулалтын дагуу ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах заалт оруулах, хэрэв ийм шаардлага байхгүй бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шинж тэмдэгтэй эсвэл өндөр температуртай ажилтныг гэртээ байх журам боловсруулж, мэдээлэх;
- Дотоодын аяллын хөтөч болон тээврийн компаниудын холбогдох дүрэм, журамтай уялдуулсан байх;
- Амрах өрөөнүүдэд нэг дор байх ажилтнуудын тоог хязгаарлах;
- Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хүн хоорондын зай барих шаардлага, удирдамжийг дагаж мөрдөх, боломжтой бол, зочид, ажилтнуудад танигдахаар тодорхой тэмдэг, тэмдэглэгээ хийж жуулчны баазад байрлуулсан байх;
- Боломжтой бол зайнаас төлбөр хийх төхөөрөмж, автомат гар ариутгал гэх мэт автоматжуулсан технологи нэвтрүүлэх, Эрүүл мэндийн яам, ДЭМБ зэрэг байгууллагаас баталгаажуулсан электростатик шүршигч технологи, UVC гэрэл болон ЕРА-д суурилсан агаар шүүгч зэрэг ариутгал, халдваргүйтгэлийн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх боломжийг судалж, шилдэг туршлагыг хуваалцах.
- Ресторан, кофе шоп зэрэг газарт хүнсний аюулгүй байдалтай холбоотой хангамжийн сүлжээний хяналт, хоол, хүнс боловсруулах, бэлдэх, эрүүл ахуй, ариун цэвэр, автоматжуулалт, дарааллын менежмент, гүн цэвэрлэгээ зэрэг асуудлаар дүрэм, журам тогтоож, хэрэгжүүлдэг байх;
- Ажилтнуудад зориулсан дотоод журам, ёс зүйн дүрэм, ажилтнуудын зан төлөвийн болон үйл ажиллагааны зааварчилгаа бэлдсэн байх;
- Халдварыг хянах, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, маск, бээлий хэрэглэх тухай үндэсний хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомж, түүнчлэн илүү нарийвчилсан арга хэмжээ авах талаар жуулчны баазын дотоод журам байгаа бол эдгээр сэдвээр ажилтнуудаа давтан сургах;
- Бүх сургалтад ДЭМБ зэрэг нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн заавар, зөвлөгөөг тусгасан байх;
- Ажилтнуудын эрүүл мэндэд байнгын анхаарал хяналт тавьж, тэднийг Засгийн газар болон ДЭМБ-ын заавар зөвлөмжийг даган мөрдөхөд нь урамшуулан, манлайлж ажиллах.

Зочин угтах хэсгийн халдвар хамгаалал

Ажлын явц

- Бүх ажиллагчид маск, бээлий зэрэг хамгаалалтын хэрэгслийг өмсөж, байнга гараа ариутгана. Зочин угтах хэсгийн ширээний урд гар ариутгагч тавина.
- Тээврийн хэрэгсэл ирэхэд бүх зорчигчийн биеийн температурыг хэмжиж, орох хаалганы хэсэгт гарыг нь ариутгуулна.
- Хаалгаар орж гарах үед нь үйлчлүүлэгч хоорондын тогтсон зайгаа барих талаар зааварчилна. Байнга ашигладаг хаалганы бариулыг тогтмол ариутгана.
- Зочид буудлын ажилтан машин хүлээж авч зогсоолд тавих үйлчилгээг зөвхөн зайлшгүй нөхцөлд үзүүлнэ.
- Нийтийн талбайн тоног төхөөрөмжийн арчилгаа, ариутгал
- Нийтийн талбайн тоног төхөөрөмжийг (жишээлбэл, утасгүй холбоонд хэрэглэдэг төхөөрөмж гэх мэт) тогтмол хуваарьт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн журмын дагуу ашиглах ёстой бөгөөд тухайн ээлж хариуцсан ажилтны ээлжийн үед бүх хэрэгслийг ашиглахын өмнө цэвэрлэж, ариутгах шаардлагатай.

Хүснэгт №9 Ковидтой жуулчин бүртгэх хүснэгт

COVID-19 CHECK LIST			
NAME		PASSPORT NUMBER	
PASSPORT NO.		CONTACT NUMBER	
TEMPERATURE		WEARING MASK (O,X)	
SYMPTOMS YES/NO			(O,X)
<ul style="list-style-type: none">• Do you have cough?• Do you have colds?• Are you having Diarrhea?• Do you have sore throat?• Are you experiencing MYALGIA or body aches?• Do you have a headache?• Do you have fever(Temperature 37.8°C and above)?• Are you having difficulty breathing?• Are you experiencing Fatigue?• Have you traveled recently during the past 14 days?• Do you have a travel history to COVID-19 infected area?• Do you have direct contact or is taking care of a positive COVID-19 patient?			

2. Хариуцлагатай, аюулгүй ажиллагааг үзүүлэх

Зочлох үйлчилгээний салбар, байгууллагууд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхдээ эрүүл ахуйн шилдэг туршлагыг нэвтрүүлж, ажилтнууд болон аялагчдын аюулгүй байдлыг хангахын тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байна:

- Эрчимжүүлсэн ариутгал, халдваргүйжүүлэлт, гүн цэвэрлэгээний арга хэмжээг ойр давтамжтай хийхэд чиглэсэн дүрэм, журам боловсруулсан байна. Эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй халдваргүйтгэлийн бодис ашиглах;
- Зочны өрөө, угаалгын өрөө, хүлээлгийн өрөө зэрэг жуулчны баазын бүх талбайн

цэвэрлэгээний зааврыг шинэчлэхдээ гар болон биеэр хамгийн их хүрэлцэх хэсгүүдийг /өрөөний түлхүүр, карт, гэрлийн унтраалга, хаалганы бариул г.м/ цэвэрлэхэд онцгой анхаарах;

- Онцын шаардлагагүй эд хогшлыг зайчлах;
- Жуулчны баазад бүртгүүлэх, зорчих үед хүн хоорондын зайг баримтлах дүрмийг мөрдүүлэх;
- Үйлчлүүлэгчид чиглэсэн зочдын мэдээлэл, хүн хоорондын зай барих шаардлага зэрэг мэдээллийг багтаасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Хууль тогтоомжийн шаардлагын дагуу зочдын эрүүл мэндийн хяналтыг хэрэгжүүлэх;
- Бүртгэлийн хэсэгт зайнаас харьцах нөхцөлийг дэмжиж, дугаарлаж зогсох нөхцөлийг хязгаарласан байх;
- Эрсдэлд суурилсан хандлагын дагуу шаардлагатай бол маск хэрэглэхийг зөвлөх.
- Ресторанд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах шаардлагыг хангасан байх:
- Буфетын хэсэгт зочдыг өөрсдөөр нь хүнсэнд хүргүүлэхгүй байх;
- Цай, кофены машиныг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
- Цар тахлын халдвараас урдчилан сэргийлэх тохиромжтой шийдэл учир зочдод өрөөний үйлчилгээг санал болгох;
- Зочдыг гармагц ширээг халдваргүйжүүлж, нэн даруй цэвэрлэх;
- Ширээ, зочдын суудал хоорондын зай барих шаардлагыг баримтлах;
- Зочдын ширээн дээр тавих эд зүйлсийн тоог багасгаж, боломжтой бол багцаалж, ариутгасан хэрэгсэл ашиглах.
- Хурал болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээний үед ариун цэвэр, халдваргүйтгэл, хүн хоорондын зай барихад чиглэсэн журмыг хэрэгжүүлсэн байх. Хурал болон олон нийтийг хамарсан бусад арга хэмжээний үеэр эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу суудлын хуваарилалт хийж, цуглах хүний тоонд хязгаар тавих замаар хүн хоорондын зай барих шаардлагыг баримтлах;
- Төхөөрөмж, ариун цэврийн өрөөг тогтмол цэвэрлэх, боломжтой бол үйлчлэгч ажиллуулах;
- Ариутгал, халдваргүйтгэлийн давтамжийг нэмэх;
- Зочдод ус болон уух зүйлстэй холбогдуулан санамж бэлдэх. Хэрэв танхим ус цэвэршүүлэгчтэй бол аль болох зочдыг өөрсдийн усны савтай ирэхийг уриалах эсвэл хуралд зориулан бэлэн байлгах;
- Гаднаас хоол хүнс оруулж буй тохиолдолд түүнийг зохицуулсан журамтай байх.

Үйлчлүүлэгчийн мөрдөх журам

- Сахим регистрийн баталгаажуулалт эсвэл гараар нэвтрэх бүртгэлийг үнэн зөв бөглөнө.
- Хоол идэх зэрэг зайлшгүй тохиолдлоос бусад тохиолдолд маск байнга зүүнэ.
- Биеийн халууныг үзэхэд саад учруулахгүй байх, шинж тэмдэг илэрвэл нэвтрэхгүй байх.
- Үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхдээ хүн хоорондын зайг 2 метр (хамгийн багадаа 1 метр) ба түүнээс дээш байлгах хэрэгтэй.

3. Жуулчин, аялагч хэрэглэгчдийн итгэл хүрсэн маркетинг бий болгох

- Байгууллагын дижитал болон шууд сувгийг ашиглан эрүүл мэнд/эрүүл ахуйн шинэ мэдээллийг зочдод ойлгомжтой, ил тод байдлаар тогтмол хүргэх. Зочидтой байнга харьцдаг зочлох, угтах үйлчилгээний ажилтнуудыг эрүүл мэндийн холбоотой асуултад хариулах чадвартай болгон сургаж бэлтгэх;
- Жуулчны баазын эрчимжүүлсэн цэвэрлэгээ, хүн хоорондын зай барих шаардлагын

- талаар ойлгомжтой тэмдэглэгээнүүдийг зочдод харагдахаар байрлуулсан байх;
- Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу амны хаалт зүүх, гарын ариун цэврийг сахих, хүн хоорондын зай барих зэрэг мэдээллийг агуулсан, зочдод зориулсан гарын авлага бэлтгэж, дүрэм журмыг тогтмол мэдээлэх.

Бизнес эрхлэгчид, ажилчдын мөрдөх журам

- Үйлчлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг хөтлөх.
- Үйлчлүүлэгчдийн биеийн байдлыг шалгаж, сэжигтэй байдал ажиглагдвал нэвтрүүлэхгүй байх.
- Ажил олгогч, ажилчид маск зүүж, үйлчлүүлэгчдийг маск зүүхийг шаардана.
- Ажилчдын биеийн халууныг өдөрт дор хаяж нэг удаа үзэж, шинж тэмдэг илэрвэл гэрт нь явуулах арга хэмжээ авна.
- Халдвар хамгаалал хариуцсан менежер томилно.
- Үйлчилгээний газруудыг нээхийн өмнө, хаасны дараа ариутгал, агааржуулалт хийнэ.
- Хаалганы бариул, хашлага гэх мэт хүний гар их хүрдэг газар, эд зүйлд халдваргүйжүүлэлтийг маш сайн хийнэ.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын үйлчилгээний халдвар, хамгаалал

- Хүнсний материал борлуулж, түгээх ажилчдад халдвараас сэргийлэхэд баримтлах журмын талаар зааж сургана.
- Ажилчид хоол идэх зэрэг зайлшгүй тохиолдлоос бусад үед үргэлж маск зүүх үүрэгтэй.
- Хүнс, ундаа, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, эд хогшилд эрүүл ахуйн хяналт шалгалт хийж хүнс, ундаа, хоол үйлдвэрлэлийн ариун цэврийг сахиулна. Өөрийн халуурч буй эсэхээ хянаж (дулаан мэдрэгч камер, зайнаас дулаан хэмжигч гэх мэтийг ашиглан) тархалтын шинж тэмдгийн тухайд байнга хяналт тавина.
- Маск зүүх үүрэг хүлээх, халдвараас сэргийлэхэд баримтлах журмыг сурталчлан түүнийг дагаж мөрдөх тухай удирдамжийг наана.
- Цахим бүртгэлийн нэвтрэх жагсаалтыг баталгаажуулж эсвэл гар тэмдэглэлийн нэвтрэх бүртгэлийг үнэн зөв бөглөнө.

Аялагч, жуулчдыг хүлээн авах халдвар хамгааллын удирдамж

- Тээврийн хэрэгслээр зорчих үед гар ариутгагч ба халууны шилээр үргэлж хангана. Суусны дараа ярихаас аль болох зайлсхийж, товросон суудлын дагуу зохион байгуулж, замд явж байх үедээ тогтмол агаарын солилцоо хийнэ.
- Хөтөч нь үйлчлүүлэгчдийг хүлээн авахаасаа өмнө өөрийн эрүүл мэндийн байдлыг шалгаж, түүний дараа үйлчлүүлэгчдээ угтан авч ажиллана.
- Хөтөч нь үйлчлүүлэгчдийн ирэх цаг, ирэх орц хаалга мөн явах маршрутыг урьдчилан мэдсэнээр бусад хүнтэй хавьтал болох нөхцөлийг багасгана. Үйлчлүүлэгчээсээ 2 метр ба түүнээс дээш зайтай байх бөгөөд, түүнчлэн үйлчлүүлэгчдэд хоорондын зайгаа барьж, контакт бага үүсгэх талаар зааварлана.
- Үйлчлүүлэгчдийг хүлээн авах үедээ маскаа хэрхэн зөв зүүхийг зааж өгч, КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх анхааруулга, зааврыг танилцуулна.
- Үргэлж маск зүүнэ.
- Гараа урсгал усанд, савангаар дор хаяж 30 секундийн турш угаана.
- Ханиалгахдаа ам, хамраа ханцуйгаараа таглана.
- Хэрэглэсэн маскаа дундуур нь хоёр удаа нугалаад битүүмжилж хаяна.

- Хөдлөх эсвэл хөдөлгөөнгүй байх үедээ бусдаас хоёр гараа алдалсан хэмжээний зай барина.
- Халуурах, амьсгалын замын өвчний шинж тэмдэг байгаа эсэх талаар мөн биеийн байцаалт шалгах, халдваргүйжүүлэлт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд саад учруулахгүй байна.
- Аяллын үеэр Ковид-19 өвчний шинж тэмдэг илэрвэл аяллаа даруй зогсоож, хөтчөдөө мэдэгдэнэ.
- Аяллын үеэр яаралтай аюулт нөхцөлд бэлэн байхын тулд ЭСЯ, консулын газрын яаралтай холбоо барих утасны дугаарыг тэмдэглэн авч баталгаажуулсны дараа аялалдаа гарна.

Аялалд бэлтгэх халдвар хамгааллын удирдамж

- Аялал эхлэхээс өмнө хөтөч нь үйлчлүүлэгчдийн янз бүрийн хандлага, онцлог шинж тэмдгийг нь судалж, соёлын ялгаатай байдлынх нь талаар мэдэж авна. Зарим оронд маск зүүсэн хүмүүсийг гэмт хэрэгтэнд тооцож, хүлээж авдаг гэх мэтчилэн улс орон бүрийн маскны хэрэглээний тухай ойлголт харилцан адилгүй байж болно.
- Аяллын төлөвлөгөө боловсруулахдаа аль болох гадаа ил задгай газар сонгох хэрэгтэй, ил задгай бус аялал жуулчлалын газруудын тухайд хоорондын зайгаа бүрэн барьж, маск зүүж, гараа ариутгаж байж аялна.
- Дотор байдаг үзэсгэлэнгийн зориулалттай байгууламж (музей, уран зургийн галерей г.м.) дотор явах үедээ үзэгчдийн хооронд хоёр гараа алдалсан хэмжээний зайг бариулж, аудио хөтөч ашиглана.
- Туршлага судлах аялал (уламжлалт гар урлал, хоол хүнс гэх мэт) хийх үед туршлага судлагч жуулчид хоорондоо хоёр гараа алдалсан хэмжээний зайг барьж, аяллын өмнө гараа ариутгаж, хоорондоо ярилцахаас зайлсхийнэ.
- Гадаа задгай нөхцөлд байдаг жуулчдын үзмэрийн газруудаар зочлохдоо гар ариутгагч биедээ авч явж, нийтийн хэрэглээний хэрэгслүүдийг түрээслэхээс татгалзана.
- Үйл ажиллагаа болдог газруудаар үйлчлүүлэх үедээ аюулгүй байдлын хэрэгслэл ашиглахаас гадна маск зүүнэ.
- Аялал жуулчлалын баазуудын талаарх урьдчилсан судалгааг хийж, Ковид-19-тэй холбоотойгоор тухайн аялал жуулчлалын бааз ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- Хэрэв батлагдсан өвчтөн байрлаж байсны улмаас аялал жуулчлалын бааз хаагдсан бол батлагдсан өвчтөний явсан маршрутыг судалж аялал жуулчлалын баазаа дахин сонгоно.
- Хөтөч нь аялж буй аялагчдын эрүүл мэндийн байдлыг өдөр бүр өглөө, оройд шалгаж, халуурч байгаа эсэх талаар хяналтын хүснэгтэд тэмдэглэнэ. Түүнчлэн, хувь хүний ариун цэвэрт зориулсан хувийн эмийн сан, зөөврийн зориулалттай гар угаагч болон хувийн усны сав зэргийг үргэлж биедээ авч явах талаар чиглүүлэг зааварчилгааг өгнө.

Үйлчлүүлэгчийн бүртгэл

Огноо	Зочны өрөө	Нэр	Утасны дугаар	Халуурч буй температур	Тэмдэглэл

Гэр, өрөө үйлчилгээний цэвэрлэгээний ариутгалын зөвлөмж

- Жуулчны өрөөнд орохын өмнө болон дараа багадаа 20 секундын турш гараа савантай усаар сайтар угаана. Саван болон ус боломжгүй бол багадаа 60%-ийн спиртийн агууламж бүхий ариутгагчаар гараа сайтар ариутгана.
- Жуулчны баазаас тавьсан болон зочны ганц удаагийн хэрэгслийг хаяна.
- Ширээний бүхий л гадаргуу, гэрлийн унтраалга, тавцангууд, бариулууд, ширээ, бүх төрлийн алсын удирдлагууд, утас, суултуур, суултуурын ус татах товчлуур, банн, хаалганы бариулууд, үзэг бал мөн индүү гэх зэргийг тогтмол байнга цэвэрлэж ариутгана.
- Жуулчны баазын бүх цагаан хэрэглэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу, хамгийн боломжит халуун усаар угаана. Хатаахдаа заавал гүйцэд хатаана.
- Бохир цагаан хэрэглэл болон хогтой харьцахдаа заавал нэг удаагийн бээлий өмсөнө.
- Бохир цагаан хэрэглэл, угаах зүйлсийг сэгсэрч, савчиж хэрхэвч болохгүй.
- Бохир цагаан хэрэглэл болон угаах зүйлс, хогтой харьцсаныхаа дараа заавал гараа сайтар угааж ариутгана.
- Жуулчин өрөөндөө өвчтэй байх, тусгаарлалтад байгаа бол цэвэрлэгээгээ зогсоож, өрөө үйлчилгээний үндсэн үйлчилгээг л үзүүлнэ.



Зураг №125 Жуулчны баазад ариутгал үйлчилгээ хийж буй нь Алунгоо жуулчны бааз

Өвчтэй зочин гарсан гэрийг цэвэрлэхтэй холбогдуулан илүү анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

- Гэрийг битүүмжилнэ.
- 24 цаг хүлээснийхээ дараа гэрт орно. 24 цаг хүлээх боломжгүй бол боломжтой хамгийн удаан хугацаанд хэн ч орохгүй хүлээнэ.
- Боломжтой бол гадаа хаалга, цонхыг нээж агаарын урсгалыг нэмнэ.
- Бүтэн цэвэрлэгээ хийгдсэний дараагаар өрөөг ариутгана.

- Боломжтой бол НЕРА шүүлтүүр бүхий тоос сорогчоор шал, хивсийг цэвэрлэнэ.
- Гүйцэд ариутгал хийгдэж дууссаны дараагаар зочны өрөөг үйлчилгээнд ашиглах боломжтой болно.

Гэр, өрөө үйлчилгээ цэвэрлэгээний ажилтнуудын хувьд:

- Зочны өрөө рүү орохын өмнө болон гарсны дараа зааврын дагуу гараа угаах эсвэл спиртэн суурьтай ариутгагчаар зааврын дагуу бүрэн ариутгана.
- Зочидбуудлаас тавьсан болон зочин өөрөө авчирсан нэг удаагийн хэрэглэлүүдийн хаяж устгана.
- Ширээ, гэрлийн унтраалга, тавцангууд, бариулууд, зурагтын болон бусад алсын зайн удирдлага, утасны аппарат харилцуур, ариун цэврийн өрөө, суултуурын ус татагч, банн, хаалганы бариулууд, үзэг бал болон индүү гэх мэт өндөр эрсдэлтэй зүйлийг үлдээлгүй бүгдийг сайтар цэвэрлэж, ариутгана.
- Хогтой харьцахдаа заавал нэг удаагийн бээлий өмсөнө.
- Хогтой харьцаж дууссаныхаа дараа нэн даруй, багадаа 20 секундийн турш савантай усаар гараа бүрэн угаана.
- Хэрэв зочин өрөөндөө биеийн байдал хэвийн бус, өөрийгөө тусгаарласан нөхцөлтэй байгаа бол цэвэрлэгээг тэр даруй зогсоох ёстой хэдий ч анхан шатны үйлчилгээг үзүүлнэ.
- Өвчтэй эсвэл сэжигтэй байсан жуулчин гэрээс гарсны дараах өрөө үйлчилгээг илүү анхаарал болгоомжтой хийх ёстой.
- Өвчтэй болон өвчний сэжигтэй зочин гарсан өрөө рүү хэнийг ч оруулж болохгүй.
- Багадаа 24 цаг хүлээсний дараа өрөөнд орж болно. 24 цаг хүлээх боломжгүй бол боломжтой цагаараа аль болох удаан хүлээж байгаад өрөөнд нэвтэрнэ.



*Зураг №126 Жуулчны баазын гэрт ариутгал үйлчилгээ хийж буй нь
Алунгоо жуулчны бааз*

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

Монгол гэр

Нутаг сэлгэн нүүдэллэхэд тохиромжтой, ачиж тээхэд хөнгөн, барьж буулгахад авсаархан конус маягийн хэлбэртэй монгол үндэсний орон сууц;

Монгол гэрийн мод

Тус бүрдээ тодорхой үүрэг гүйцэтгэдэг, барьж буулгахад хялбархан гэрийн бүрдэл, араг хийц хэсгүүд;

Багана

Гэрийн тооно өргөх, цөмийж орохоос хамгаалах, гэрийн тогтвор сайжруулах хос тулгуур;

Баганын далбаа

Гол тулгуурын хоёр тал ба тархийг холбосон гоёлтой хийц;

Баганын тархи

Гол тулгуур ба далбааг холбосон, мөөрний дагуу дугуйрсан буюу шулуун сээр;

Тооно

Гэрийн орой хэсэгт унины зэт шургаж холбогдох нүхтэй, тоонолж хэлбэртэй хүрээ бүхий, агаар сэлгэх, гэрэл оруулах үүрэгтэй модон хийц. Тооно нь хорол, хүрд, сархигнаг хэлбэрт чонон голт тооно гэх мэт байна.

Тоононы мөөр

Цамхраа ба даага холбогдож байдаг гадна талын том хүрээ цагираг;

Тоононы цамхраа

Голд огтлолцдог хойд урд ба баруун зүүн, хагас дугуйрсан голууд;

Тоононы даага

Голуудын хооронд гадна ба дотно хүрээг холбодог хагас дугуйрсан туслах голууд;

Хаалга

Гэрийн үүдний хэсэгт дугуйлсан хатавчны ханын амсарыг бэхлэх, хүний гарч орох боломж хангадаг, үл хөдлөх жааз ба хөдөлгөөнт самбараас бүрдэх хийцийн хэсэглэл;

Хаалганы самбар

Нугасны тусламжтайгаар хаалганы хүрээний дотор нээгдэж хаагдах боломжтой, цоож, түгжээ ба дотно, гадна талдаа бариултай хавтас;

Хаалганы босго

Хүмүүсийн гарч ороход зориулагдсан, хаалганы доод хөндлөн яс мод;

Хаалганы тотго

Дээрээ унины бөгс тулах 4,6,8 хагас дугуйлан ухаж хонхойлсон нүхтэй, хаалганы дээд хөндлөн яс мод. Мөн ромбо тоогоор шинээр тааруулан зохиосон гэрт дэс дугаар тавьж өгнө;

Унь

Гэрийн дээврийн налууг бүрдүүлэгч нарийн шургааг хэлбэрийн хийц. Хэмжээ: Урт 2- 2,8 метр, голч 2—4 см. Шинэс, нарс, бургасаар хийдэг;

Унины зэт

Тоононы нүхэнд углах огтлогдсон пирамид хэлбэрийн унины чээжний төгсгөл хэсэг;

Унины чээж

Ихэвчлэн дөрвөн талтай огтлогдсон пирамид хэлбэрийн унины толгойн хэсэг;

Унины сагалдарга

Унины бөгсийг хананы толгойд өлгөх битүү гогцоо;

Үдээр

Гэрийн хана, тур мод үдэхэд голчлон хэрэглэдэг тэмээ, үхрийн ширээр зүсэж хийдэг нарийн сур;

Үдээс

Үдээрээр хана үдсэн хөдөлгөөнтэй холбоос; Гэрийн жинг өөр дээрээ хүлээн авах, гэрийг гадна орчноос тусгаарлах үүрэг бүхий сараалжин хийцтэй, эвхэж хамхих, сунгаж тэлэх боломжтой, өвөрмөц зохиомж бүхий хийц;

Ханын толгой

Унины сагалдарга мушгиж оруулах, хананы тур модыг хэлбэр гарган зассан оройн хэсэг;

Хананы тур мод

Үдээсэн холбоосны тусламжтайгаар ханыг дэлгэх ба эвхэх боломж олгодог гүйцэд урттай тууш мод;

Ханын шийр

Хананд ирэх даралтын бүх ачааллыг нэгэн жигд авч газар буюу шалан дээр тулах хананы доод босоо шулуун хэсэг;

Ханын эрс

Хананы өөрчлөгддөг өндрийн хэмжээг илэрхийлэгч үзүүлэлт;

Хатавч

Хана хаалга хоёрын нийлэх ам;

Хаяавч

Гэрийн хаяагаар салхи, шороо тоос оруулахгүй байх, бас дулаалгын үүрэгтэй, 25- 30 см-ийн урттай шинэсэн савх моднуудыг өргөнөөр нь хэлхэн, хүрээлсэн ханануудын нийт уртад тохируулан хийсэн, эвхэгддэг хаалт;

Шал

Гэрийн дотор талын орчинг газраас тусгаарлах үүрэгтэй хавтгайлжин хийц; Ихэвчлэн шинэс, нарсаар хийдэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол эх сурвалж

1. АЖБХН “Аялал жуулчлал судлал” УБ., 2019 он
2. Г. Алтансүвд, Ж. Батсүх, С. Мөнхжаргал “Гал тогооны ном” УБ 2014.
3. Б. Баатархүү, Д.Одсүрэн “Монгол гэр” тайлбар толь УБ., 2016 он
4. Г.Баатарцхоож “Монголын аялал жуулчлалын баазуудын хөгжил байршил, хэтийн төлөв” бакалаврын ажил МУИС., 1999 он
5. Г. Баатархүү “Монгол гэр” УБ., 2016 он
6. Ц. Баатарсайхан, Г. Мэнд-Ооёо “Монгол нүүдэлчдийн эдийн соёл” УБ., 2009 он
7. Х. Батсайхан Р. Ундрахбаяр “Монгол гэр” УБ, 2015 он
8. Г. Болормаа “Жуулчны баазын менежмент” УБ., 2004 он
9. С. Билэгсайхан ба бусад Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн үндэс., УБ., 2010
10. Р. Дарьхүү бусад “Хоол үйлдвэрлэлийн технологи”, УБ. 2020.
11. Д. Гонгор Халх товчоон : Халх монголчуудын өвөг дээдэс ба халхын хаант улс / VIII-XVII
12. Х. Грюнер “Гал тогооны ном”, УБ., 2014
13. М. Есөнмөнх “Уламжлалт Монгол хоолны 99 жор” УБ.
14. Д.Майдар “Монголын архитектур ба хот байгуулалт” УБ., 1971 он
15. Монголын үндэсний музей “Монгол гэрийн өв соёл” УБ., 2019 он
16. “Монгол гэрийн өв соёл” УБ., 2019 он
17. “Монгол улсын угсаатны зүй 1” боть., УБ., 2010
18. Монгол улсын шинжлэх ухааны академи “Идээний дээж: Эрт, эдүгээ” УБ., 2006 он
19. Я.Цэвэл « Монгол хэлний товч тайлбар толь» УБ., 1966 он
20. С. Нина “Зочид буудал, дэн буудал, жуулчны баазын гарын авлага” УБ., 2014.
21. Б. Цэрэндулам, Б.Оюунжаргал “Хоолны газрын бүртгэл, тооцоолол” УБ., 2020
22. Д.Цэвэгхасүрэн “Монгол цагаан идээ, байгалийн үнэт хүнс III” УБ., 2010 он
23. Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг”УБ., 1980
24. Ж.Өлзий “Монголын дурсгалт уран барилгын түүхээс” УБ.,1992 он
25. Л. Чулуунбаатар “Нүүдэллэхүй ёсон” УБ., 2017 он
26. Ч.Мөнхбаяр “Хуурай салааны амны I чөмүрчөк булшны судалгааны эхний үр дүн” АСТА Historica Mongolici. Tom XI, Fasc 2. УБ., 2010, тал 14
27. Э. Хишигбаяр “Монгол гэрийн үүсэл, хөгжил” УБ., 2009 он
28. Г.Эрэгзэн (эмхэтгэн нийтлүүлсэн). Хүннүгийн өв. (Нүүдэлчдийн анхны төр-Хүннү гүрний соёл). УБ., 2011.
29. MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага
30. ISO 22000:2018 хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

Гадаад эх сурвалж

1. Bremmer, Ian. (2020) "The Best Global Responses to Covid-19 Pandemic."
2. Behaviour: A Perspective Article. Journal of Tourism Management Research, 7, 169-207.
3. Brookings. (2020) "Learning from the Best: Evaluating Africa's Covid-19 Responses."
4. 1962: Nomads and Commissars: Mongolia Revisited. New York: Oxford University Press, 1962. ISBN 9781258191566.
5. Chebli A., & Said, F. B. (2020). The Impact of Covid-19 on Tourist Consumption
6. Chang, Rachel, Jinshan Hong, and Kevin Varley. (2020) "The Covid Resilience
7. The Economic Contribution of Tourism and the Impact of COVID-19
8. Ranking." Bloomberg, [Online] <https://www.bloomberg.com/graphics/covidresilience-ranking/>.
9. <https://www.unwto.org/news/2020-worst-year-in-tourism-history-with-1-billion-fewer-international-arrivals>.
10. WTTC, "Latest Research from WTTC Shows a 50% Increase in Jobs at Risk in Travel & Tourism,"
11. <https://wttc.org/News-Article/Latest-research-from-WTTC-shows-a-50-percentage-increase-in-jobs-at-risk-in-Travel-and-Tourism>.
12. IMF, "World Economic Outlook Update," <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/01/26/2021-world-economic-outlook-update>.
13. <https://time.com/5851633/best-global-responses-covid-19/>.
14. <https://www.brookings.edu/blog/africa-in-focus/2020/07/08/learningfrom-the-best-evaluating-africas-covid-19-responses/>.
15. <https://wttc.org/Portals/0/Documents/Reports/2021/Global%20Economic%20Impact%20and%20Trends%202021.pdf>
16. United Nations Conference on Trade and Development. Covid-19 and tourism, 2021
17. http://tentsver.mn/s/1678?fbclid=IwAR20zo3dSG1psD1mLWRMsDy-K5jvj2x392Us_DbP5qQXzuYgk9cJ42aC1QM
18. http://www.toposophy.com/files/1/2020/ETC_NTO_RECOVERY_STRATEGIES_2020_FINAL.pdf
19. https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Domestic_trade_2018.pdf&ln=Mn
20. <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=khudalmaa2019.pdf&ln=Mn>
21. http://mongolstudy.blogspot.com/2014/04/blog-post_29.html
22. Ц.Төрбат. Бороогийн суурин //Монголын түүхийн тайбар толь. УБ., 2016. <https://mongoltoli.mn/history/h/166>
23. <https://ikon.mn/n/py8>
24. <https://www.yurtinfo.org/yurt-companies>



САЯЗАНЫ НИНА

Аялал жуулчлалын ур чадварын МСҮТ-ийн захирал



БАТЖАРГАЛЫН МӨНХТОГТОХ

Сити их сургуулийн Аялал жуулчлалын багш



ПҮРЭВДОРЖИЙН ОДГЭРЭЛ

Монголын үндэсний их сургуулийн Аялал жуулчлалын багш



РЭНЦЭНДАГВА ЭНХБАЯР

Ашид Номадс ХХК –ны Ink teacher сургалтыг төвийн менежер



**IN COOPERATION WITH TOURISM INDUSTRY DATA
ANALYTICS
LAB, SEJONG UNIVERSITY**

